



ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЯАМ



НИЙГМИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ



# МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ХООЛ ТЭЖЭЭЛИЙН БАЙДАЛ

Үндэсний VI судалгааны тайлан

Улаанбаатар хот

2024 он

## ӨМНӨХ ҮГ /САЙД/

Монгол улсын Засгийн газраас хүн амын хоол тэжээлийн дутлыг бууруулах асуудалд анхаарч ажилласны үр дүнд “Хоол тэжээлийн дуталтай хүн амын тоог 6 дахин бууруулах” хэмээн заасан Мянганы хөгжлийн зорилт бүрэн хангагдаад байна.

Дэлхийн хөгжлийн хандлага, “Тогтвортой хөгжил 2030” хөтөлбөртэй уялдуулан Монгол улсын “Алсын хараа 2050” урт хугацааны бодлого болон “Шинэ сэргэлтийн бодлого” буюу дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг Монгол улсын Их хурлаас баталж, хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн байдлыг сайжруулах, тогтвортой хөдөө аж ахуйг дэмжих зорилтуудыг тусгаж өгсөн билээ.

Монгол улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн өрнөж, УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоол гаргасан бөгөөд 40 орчим төрийн байгууллага хамтран хэрэгжүүлэх юм.

Манай улс 1992 оноос эхлэн Хүн амын хоол тэжээлийн үндэсний 5 удаагийн судалгааг хийж гүйцэтгэсэн. Эдгээр судалгааны үр дүнг үндэслэн Засгийн газраас хоол тэжээлийн талаар баримтлах бодлого, эрх зүйн орчинг бүрдүүлэх, хүн амын хоол тэжээлийн байдлыг сайжруулах төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх гол үндэслэл болсоор ирснийг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Энэ удаад Хүн амын хоол тэжээлийн байдлын 6 дугаар судалгааг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сангийн техникийн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр 2023-2024 онд нийслэлийн 8 дүүргийн 40 хороо, 21 аймгийн 112 сум, ерөнхий боловсролын сургуулийн амыг хамруулан Нийгмийн Эрүүл мэндийн үндэсний төв амжилттай хийж гүйцэтгэн, үр дүнг танилцуулаж байгаад талархалтай байна.

Судалгаагаар Монгол улсын 5 хүртэлх насны хүүхэд, 6-18 насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, төрөх насны эмэгтэйчүүд, 15-49 насны эрэгтэйчүүдийн хоол тэжээлийн байдал, өрхийн хүнсний баталгаат байдал, өрхийн ус болон ариун цэврийн байгууламжийн өнөөгийн байдлыг хот, хөдөөгийн эдийн засгийн 4 бүс, нийслэл Улаанбаатар хот, өрхийн аж байдлын түвшнээр харьцуулан үзүүлсэн нь цаашид хүн амын суурьшил, бүс нутгийн онцлогт тохирсон, нотолгоонд тулгуурласан, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай мэдээлэл болохоор байна.

Түүнчлэн судалгаанд хамрагдсан хүүхэд, эмэгтэйчүүдийн дунд хоол тэжээлийн бичил бодисын дутлын тархалт анхаарал татахуйц өндөр гарсан байна. Тухайлбал, Д аминдэмийн дутал 5 хүртэлх насны хүүхдийн дунд 48.4 хувь, жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд 76.0 хувь байгаа нь жирэмсний хяналтын явцад эмэгтэйчүүдийг Д аминдэмийн оношилгоо, эмчилгээнд хамруулах, өргөн хэрэглээний хүнсийг баяжуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байгааг нотолж байна.

Хүн амын өвчлөл, эндэгдлийн тэргүүлэх шалтгааны гол эрсдэлт хүчин зүйл болсон таргалалт насны бүлэг бүрт өндөр байгаа нь иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлэхийг бидэнд сануулж байна.

Одоо судалгааны тайланг өөрийн мэргэжил, эрхэлж буй ажлын хүрээнд бүтээлчээр ашиглах өргөн боломж та бүхэнд бүрдлээ. Энэхүү судалгааны тайлан монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах гол үндэс болсон хоол тэжээл, хүнсний баталгаат байдлыг сайжруулах үйлсэд үнэтэй хувь нэмэр болох нь дамжиггүй гэдэгт итгэлтэй байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД  
ТОГТМОЛЫН МӨНХСАЙХАН

## ТАЛАРХАЛ /ЗАХИРАЛ/

Монгол улсын хүн амын хоол тэжээлийн байдлыг үнэлж цаашид хүн амын хоол тэжээлийн байдлыг сайжруулах, эрүүл хооллолтыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж боловсруулах зорилгоор Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв хамтран НҮБ-ын Хүүхдийн Сангийн санхүү, техникийн дэмжлэгээр “Хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний VI судалгааг 2023 онд Монгол улсын эдийн засгийн 4 бүс, 21 аймгийн 112 сум, нийслэлийн 8 дүүрэгт санамсаргүй түүвэрлэлтээр сонгогдсон судалгааны анхан шатны 140 түүврийн нэгжид амжилттай зохион байгууллаа.

Судалгаанд хоол тэжээлийн дуталд өртөмтгий, эрсдэлт бүлэг болох 5 хүртэлх насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, төрөх насны эмэгтэйчүүдээр төлөөлүүлэн хүн амын хоол тэжээлийн байдлыг үнэлдэг олон улсын жишиг аргачлалыг ашиглахын зэрэгцээ, ЕБС-ийн 6–18 насны сурагчид, өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулан жиших зорилгоор 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн 15–49 насны эрэгтэйчүүдийг тус тус хамруулсан. Үүнд, 0-59 сартай хүүхэдтэй өрх 2791; 0-59 сартай хүүхэд 2786, ерөнхий боловсролын сургуулийн 1-12-р ангийн 4864 хүүхэд, нөхөн үржихүйн насны эмэгтэй 2513, жирэмсэн эмэгтэй 2788, 15-49 насны эрэгтэй 2789; нийт 2791 өрх, 14.833 хүн хамрагдсан ба 2017 онд хийгдсэн хоол тэжээлийн үндэсний V судалгаанаас өрхийн тоо 542 өрх, хүний тоо 5279 хүнээр тус тус их байлаа.

Энэхүү судалгааг хийж гүйцэтгэхэд санхүү, техникийн болон удирдлагын дэмжлэг тусалцаа үзүүлсэн Монгол улсын Эрүүл мэндийн яам, НҮБ-ын Хүүхдийн Сан, Судалгааны удирдах зөвлөлийн гишүүд, судалгааны багийг орон нутагт ажиллахад дэмжиж тусалсан аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, сум, дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төв, мэдээлэл цуглуулах, мэдээллийг цахим хэлбэрт оруулах, мэдээллийн баазын SSPS программ, статистик боловсруулалт, үр дүнг баталгаажуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн судалгааны багийн бүх гишүүд, лабораторийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн Холбооны Бүгд Найрамдах Герман улсын ВитМин лабораторийн дарга, доктор Юурген Эрхард, Монгол улсын “Гялс ХХК –ийн гүйцэтгэх захирал, АУ-ы доктор, дэд профессор Н.Наранболд, хүнсний баталгаат байдал болон хүн амын хоол тэжээлийн хомсдлын тархалтыг тооцоход мэргэжил арга зүйгээр дэмжиж тусалсан НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын, доктор Абдул Сатар, НҮБ-ын Хүүхдийн Сангийн мэргэжилтэн Л.Мөнхжаргал, Д.Хүрэлмаа болон судалгааны бүх үе шатад оролцсон Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн хамт олондоо чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Монголчуудын хоол тэжээлийн байдал сайжирч, хүн ам нь эрүүл энх байхын ерөөлийг өргөн дэвшүүлье.

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ,

ХУ-НЫ ДОКТОР, ДЭД ПРОФЕССОР

С.ӨНӨРСАЙХАН

## ГАРЧИГ

### ОРШИЛ

Өмнөх үг  
Талархал  
Гарчиг  
Товчилсон үгсийн тайлбар  
Судалгааны баг  
Нэр томъёоны тодорхойлолт  
Хүснэгтийн жагсаалт  
Зургийн жагсаалт  
Үндсэн үр дүн

### СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО

Удиртгал  
Судалгааг зохион байгуулах шаардлага, үндэслэл  
Судалгааны зорилго, ба зорилтууд  
Судалгааны ёс зүйн асуудал

### СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны хамрах хүрээ, хүн ам  
Судалгааны түүврийн загвар  
Судалгааны түүврийн хэмжээ тооцсон аргачлал  
Судлаач бэлтгэх сургалт  
Судалгааны мэдээлэл цуглуулалт  
Биологийн сорьц, давсны дээж цуглуулалт  
Биохимийн шинжилгээний арга  
Судалгааны мэдээллийн шивэлт, цэвэрлэгээ  
Судалгааны мэдээллийн боловсруулалт  
Судалгааны арга зүйн хязгаарлагдмал байдал

### СУДАЛГААНЫ ҮР ДҮН

#### ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ӨРХ

Түүврийн хамрагдалт, хүн ам  
Өрхийн шинж байдал

Аж байдлын түвшин  
Ундны ус, ариун цэврийн байгууламж  
Иоджуулсан давсны хэрэглээ  
Хэлцэмж  
Дүгнэлт

#### ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭД

Түүврийн шинж байдал  
Нялх, бага насны хүүхдийн хооллолт  
Бага жинтэй төрөлт  
Хоол тэжээлийн байдал  
Бичил тэжээлийн байдал  
Бичил тэжээлийн бэлдмэлийн хамнгамж, хэрэглээ  
Өвчтэй хүүхдийн асаргаа  
Хэлцэмж  
Дүгнэлт

#### ТӨРӨХ НАСНЫ ЭХЧҮҮД

Түүврийн шинж байдал  
Хооллолтын чанар  
Хоол тэжээлийн байдал  
Бичил тэжээлийн байдал  
Бичил тэжээлийн бэлдмэлийн хангамж, хэрэглээ  
Жирэмсэн үеийн эрүүл мэндийн тусламжийн хамрагдалт  
Нялх, бага насны хүүхдийн хооллолтын талаарх мэдлэг  
Хэлцэмж  
Дүгнэлт

#### ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙ

Түүврийн шинж байдал  
Хооллолтын чанар  
Хоол тэжээлийн байдал  
Бичил тэжээлийн байдал  
Бичил тэжээлийн бэлдмэлийн хангамж, хэрэглээ  
Жирэмсэн үеийн эрүүл мэндийн тусламжийн хамрагдалт  
Нялх, бага насны хүүхдийн хооллолтын талаарх мэдлэг  
Хэлцэмж

Дүгнэлт

#### ЭРЭГТЭЙЧҮҮД

Түүврийн шинж байдал

Хооллолтын чанар

Хоол тэжээлийн байдал

Хэлцэмж

Дүгнэлт

#### ЕБС-ИЙН СУРАЛЦАГЧИД

Түүврийн шинж байдал

Хооллолтын дадал

Хоол тэжээлийн байдал

Бичил тэжээлийн байдал

Хооллолт, хоол тэжээлийн талаарх мэдлэг, хандлага, дадал

Хэлцэмж

Дүгнэлт

#### ӨРХИЙН ХҮНСНИЙ БАТАЛГААТ БАЙДАЛ

Түүврийн шинж байдал

Хүнсний баталгаат байдлын алдагдал

Хүнсний хомсдол

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

БЖИ	Биеийн жингийн индекс
БН	Бүс нутаг
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ДХХ	Дэлхийн хүнсний хөтөлбөр
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИДЭ	Иод дутлын эмгэг
ИХ	Итгэх хязгаар
ЖҮЭМТ	Жирэмсэн үеийн эрүүл мэндийн тусламж
НБНХХ	Нялх, бага насны хүүхдийн хооллолт
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХАС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн Амын Сан
НҮБХС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан
НХ	Нэмэгдэл хооллолт
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
ОНБТБ	Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл
ОНБТХ	Олон найрлагат бичил тэжээлийн холимог
ОҮТС	Олон үзүүлэлтэт түүвэр судалгаа
ӨНЭЗС	Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа
ӨХД	Өсөлтийн хяналт, дэмжлэг
ТАШН	Түүврийн анхан шатны нэгж
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ТББ	Төрийн бус байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХББА	Хүнсний баталгаат байдлын алдагдал
ХХААБ	Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ХСХАБА	Хоол судлал, хүнсний аюулгүй байдлын алба
ХТҮС	Хоол тэжээлийн үндэсний судалгаа
ЭМА	Эрүүл мэндийн ажилтан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭСХ	Эхийн сүүгээр хооллолт
ЭХЭМД	Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр

ЭША	Эрдэм шинжилгээний ажилтан
ЭШАА	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан
ЭШТА	Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан



## СУДАЛГААНЫ БАГ

### СУДАЛГААНЫ УДИРДАГЧ

С.Өнөрсайхан	ХУ-ны доктор, Дэд профессор, НЭМҮТ-ийн захирал
Ж.Баясгалан	ХЗУ-ны доктор, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭШАА

### СУДАЛГААНЫ ЗОХИЦУУЛАГЧ

Н.Болормаа	АУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
------------	----------------------------------------

### СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ЗӨВЛӨХ

Ж.Батжаргал	АУ-ны доктор, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны зөвлөх
-------------	------------------------------------------

### СУДАЛГААНЫ ТАЙЛАН БИЧСЭН

Н.Болормаа	АУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Д.Дэлгэрмаа	АУ-ны доктор, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Б.Түвшинбаяр	ХЗУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Д.Оюундэлгэр	АУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Б.Туул	ХЗУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Б.Амарсанаа	НЭМ-ийн магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Т.Ганзориг	БУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША

### ТАЙЛАНГ ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН

С.Өнөрсайхан	ХУ-ны доктор, НЭМҮТ-ийн захирал
Ж.Батжаргал	АУ-ны доктор, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны зөвлөх
Ж.Баясгалан	ХЗУ-ны доктор, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭШАА

### СТАТИСТИК ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ БАГ

Амбул Саттар	Доктор, Профессор, НҮБ-ын ХХААБ-ын мэргэжилтэн
Н.Болормаа	АУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Б.Түвшинбаяр	ХЗУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Д.Оюундэлгэр	АУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Б.Туул	ХЗУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Б.Амарсанаа	НЭМ-ийн магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Т.Ганзориг	БУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША

## СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЛИЙН ШИВЭЛТ, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БАГ

Д.Отгонжаргал	АУ-ны доктор, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭШАА
Д.Дэлгэрмаа	АУ-ны доктор, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Н.Болормаа	АУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Д.Оюундэлгэр	АУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Б. Байгалмаа	АУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Б.Түвшинбаяр	ХЗУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
М.Даваасүрэн	ТУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Б.Амарсанаа	НЭМ-ийн магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Б.Туул	ХЗУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Д.Ганболор	БУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
З.Цолмон	Эрүүл ахуйч, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША
Т.Ганзориг	БУ-ны магистр, НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭША

## ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАГ

Юурген Эрхард	Доктор, ХБНГУ-ын ВитМин лабораторийн дарга
Г.Оч	АУ-ны магистр, НЭМҮТ-ийн НЭМҮЛЛ-ийн дарга
Д.Хишигбуян	БУ-ны магистр, НЭМҮТ-ийн НЭМҮЛЛ-ийн нэгжийн ахлагч
П. Гантуяа	ХУ-ны магистр, НЭМҮТ-ийн НЭМҮЛЛ-ийн чанарын менежер
Б.Содномцэрэн	НЭМҮТ-ийн НЭМҮЛЛ-ийн биохимич
О.Анужин	НЭМҮТ-ийн НЭМҮЛЛ-ийн биохимич
Д.Ганбилэг	НЭМҮТ-ийн НЭМҮЛЛ-ийн химич
Н.Наранбат	АУ-ы доктор, дэд профессор, Гялс ХХК-ийн ТУЗ дарга
Н.Наранболд	БУ-ын магистр, вирус судлаач, Гялс ХХК-ийн гүйцэтгэх захирал
Б.Индра	ШУ-ы магистр, Гялс ХХК-ийн Клиник лабораторийн албаны дарга
Ж.Золчимэг	БУ-ын магистр, Гялс ХХК-ийн КҮБГ-ын эрхлэгч
М.Мөнх-Эрдэнэ	Био-Анагаахын мэргэшсэн мэргэжилтэн, Гялс ХХК-ийн иммунологич
Б.Ууганцэцэг	Гялс ХХК-ийн иммунологич

## СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛСАН БАГ

### **Нэгдүгээр баг**

Пүрэвдорж	Мөнхцэцэг	Хүний их эмч, Багийн ахлагч
Сэсээр	Лхагвасүрэн	Эмч
Пүүгүүз	Байгалмаа	Лаборатори/Сувилагч
Болдбаатар	Мөнхзул	Асуулга авагч/ хэмжигч
Давааням	Хулан	Асуулга авагч/ хэмжигч

### **Хоёрдугаар баг**

Нямаанямбуу	Нарантуяа	АУ-ны доктор, Багийн ахлагч
Мэндбаатар	Мядагмаа	Сувилагч
Жамцаа	Орлого	Эмч
Төмөрхуяг	Ганзориг	Асуулга авагч/ хэмжигч
Ванчиндэлэг	Батцэцэг	Асуулга авагч/ хэмжигч

### **Гуравдугаар баг**

Дэндэв	Оюунчимэг	Хүний их эмч, Багийн Ахлагч
Бадрууш	Түвшинбат	Хүний их эмч
Дүгэрсүрэн	Ням-Осор	Асуулга авагч/ хэмжигч
Чимэдбат	Чингэрэл	Асуулга авагч/ хэмжигч
Буд	Цэндрулам	Лаборант

### **Дөрөвдүгээр баг**

Бавуужав	Байгалмаа	ХСХАБА-ны ЭША, Багийн ахлагч
Хүрэлбаатар	Бадамсүрэн	Хүний их эмч
Баасайхүү	Гэрэл	Сувилагч
Лувсандорж	Уянга	Асуулга авагч/ хэмжигч
Наранбат	Энхнаран	Асуулга авагч/ хэмжигч

### **Тавдугаар баг**

Даваахүү	Хишигбуян	НЭМҮЛЛ-ийн биохимич, Багийн ахлагч
Пүрвээ	Ану	Хүний их эмч
Дугарсүрэн	Оюунчимэг	Лаборант
Хишигт	Бямбасүрэн	Асуулга авагч/ хэмжигч
Отгонбаатар	Анужин	Асуулга авагч/ хэмжигч

### **Зургаадугаар баг**

Батжаргал	Батдорж	НЭМҮТ-ийн ЭША, Багийн ахлагч
Цэрэн	Ариунжаргал	Хүний их эмч
Дэмиддгагвий	Эрдэнэцагаан	Сувилагч
Авгайхүү	Төмөр-Очир	Асуулга авагч/ хэмжигч
Чимэддамба	Оюун	Асуулга авагч/ хэмжигч

### **Долоодугаар баг**

Отгонгэрэл	Сарангэрэл	НЭМҮТ-ийн ЭША, Багийн ахлагч
Даваасүрэн	Цэлмэг	Хүний их эмч
Бадрах	Мөнхсумьяа	Сувилагч
Батбаяр	Хулан	Асуулга авагч/ хэмжигч
Батжаргал	Анударь	Асуулга авагч/ хэмжигч

**Наймдугаар баг**

Мөнх-Эрдэнэ	Даваасүрэн	ХСХАБА-ны ЭША, Багийн ахлагч
Бадарч	Алимаа	Хүний их эмч
Готов	Оюунгэрэл	Сувилагч
Дэмбэрэл	Отгонбаяр	Асуулга авагч/ хэмжигч
Гэндэндорж	Хаш-Эрдэнэ	Асуулга авагч/ хэмжигч

**Есдүгээр баг**

Дэчинжамц	Оюундэлгэр	ХСХАБА-ны ЭША, Багийн ахлагч
Хаянхярваа	Энхмэнд	Хүний их эмч
Дэчинлхүндэв	Буянхишиг	Сувилагч
Батаа	Алтангэрэл	Асуулга авагч/ хэмжигч
Мөнхбаатар	Мөнхтамир	Асуулга авагч/ хэмжигч

**Аравдугаар баг**

Бямбаа	Даваадулам	Багийн ахлагч
Далх	Мөнхжаргал	Хүний их эмч
Далай	Дуламсүрэн	Сувилагч
Дашзэвэг	Ганболор	Асуулга авагч/ хэмжигч
Раднаа	Энхбат	Асуулга авагч/ хэмжигч

**Арван нэгдүгээр баг**

Дашзэвэг	Дэлгэрмаа	ХСХАБА-ны ЭША, Багийн ахлагч
Бямбасүрэн	Хоролгарав	Асуулга авагч/ хэмжигч
Вандандорж	Янжиндолгор	Хүний их эмч
Халтар	Цэцэгмаа	Лаборант
Хасчулуу	Жавхлан	Асуулга авагч/ хэмжигч

**Арван хоёрдугаар баг**

Баяраа	Түвшинбаяр	ХСХАБА-ны ЭША, Багийн ахлагч
Наранцэцэг	Эрдэнэчимэг	Хүний их эмч
Дандар	Оюундэлгэр	Сувилагч
Гантулга	Номин	Асуулга авагч/ хэмжигч
Санжаа	Дагиймаа	Асуулга авагч/ хэмжигч

## Нэр томьёоны тодорхойлолт

**Бага жинтэй төрөлт:** Нярайн төрөх үеийн биеийн жин 2500 граммаас бага байх тохиолдол;

**Баяжуулсан хүнс:** Аминдэм, эрдэс бодисыг дангаар эсвэл холимог хэлбэрээр үйлдвэрийн аргаар нэмж үйлдвэрлэсэн хүнсийг

**Биеийн жингийн индекс (БЖИ):** Хүний килограммаар илэрхийлсэн биеийн жинг метрээр илэрхийлсэн өндрийн квадрат утгад харьцуулсан үзүүлэлт;

**Бичил тэжээл:** Хүний бие махбодод бага хэмжээгээр шаардагддаг аминдэм, эрдэс бодисыг;

**Бичил тэжээлийн бэлдмэлээр хангах:** Шахмал, капсул, сироп, нунтаг хэлбэрийн бичил тэжээлийн бэлдмэл өгөх;

**Бичил тэжээлийн дутал:** Аминдэм, эрдэс бодисын хэрэглээ, шимэгдэлт, шингээлт багассаны улмаас үүссэн хоол тэжээлийн дутал;

**Гемоглобин:** Цусны улаан эсэд агуулагддаг, хүчилтөрөгчийг уушгинаас зөөвөрлөх биеийн эд, эсэд хүргэх үүрэгтэй уураг;

**Зохистой хооллолтын хамгийн бага шаардлага:** Эхийн сүүгээр хооллодог эсвэл хооллодоггүй 6-23 сартай хүүхэд өдөрт хамгийн багадаа 2 удаа сүү уухын зэрэгцээ 7 нэр төрлийн хүнснээс 4 ба түүнээс олон нэр төрлийн бүтээгдэхүүнийг насандаа тохирсон давтамжаар идэх;

**Ийлдэс дэх ферритин:** Гэдэсний салст бүрхүүл, дэлүү, элгэнд үүсдэг төмөр агуулсан уураг;

**Илүүдэл жин:** 5 хүртэлх насны хүүхдийн биеийн жин–урт/өндрийн үзүүлэлт нь ДЭМБ-ын Хүүхдийн өсөлтийн стандарт голчоос +2 стандарт хазайлтаар дээгүүр байвал “илүүдэл жин”-тэй гэж тодорхойлдог. 5-19 насны хүүхдийн БЖИ–Насны үзүүлэлт нь ДЭМБ-ын Өсөлтийн лавлагаа дундаж голчоос +1 стандарт хазайлтаар дээгүүр байвал “илүүдэл жин”-тэй гэж үнэлдэг. Насанд хүрэгчдийн БЖИ $\geq$ 25 кг/м<sup>2</sup>

байвал “илүүдэл жин”-тэй гэж тодорхойлно;

**Иод дутлын эмгэг:** Иод дутлын улмаас үүссэн оюун ухааны чадамж буурах, бамбай булчирхай томрох, кретин зэрэг сөрөг илрэлийг нэгтгэн иод дутлын эмгэг гэнэ;

**Насандаа тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллолт:** 0-5 сартай хүүхдийг зөвхөн эхийн сүүгээр хооллох, 6-23 сартай хүүхдийг эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ өтгөн, өтгөвтөр, шингэн хоол, хүнсийг нэмэлтээр өгөхийг хэлнэ;

**Нэг нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллолт:** Насандаа тохирсон байдлаар нэмэгдэл хоолоор хооллож байгаа 12-15 сартай хүүхэд эхийн сүүгээр үргэлжлүүлэх хооллохыг;

**Нэмэгдэл хооллолт:** Хүүхдийг эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ тэдний насанд тохирсон, аюулгүй, өтгөн, өтгөвтөр хоол хүнсийг нэмэлтээр өгөхийг.

Хүүхдэд 6 сартайгаас эхлэн нэмэгдэл хоол өгч эхэлнэ. Зургаан сар хүрээгүй хүүхдэд өтгөн, өтгөвтөр, эхийн сүүнээс бусад шингэн хоол хүнс өгөхийг зөвлөдөггүй.

**Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл (ОНБТБ):** Нэмэгдэл хоолны чанарыг сайжруулах зорилгоор хүүхдийн хоолонд нэмж хэрэглэдэг нэн шаардлагатай аминдэм, эрдэс бодисын холимог;

**Өрхийн хүнсний баталгаат байдлын алдагдлын хэмжээ:** Сүүлийн 30 хоногийн хугацаанд өрхийн хүнсний баталгаат байдлын алдагдлын хэмжээг үнэлэхэд ашигладаг судалгааны хэрэгсэл юм. Судалгаагаар өрхөд байгаа хоол хүнсний хэмжээ, чанар, хязгаарлагдмал нөөцийн улмаас тэдний хүнсний хэрэглээний шинж байдал өөрчлөгдсөн эсэхийг үнэлдэг;

**Өсөлт хоцролт:** Урт хугацааны туршид

үүсдэг (Хоол тэжээлийн архаг дутал) өсөлт удаашрах эмгэг. Тав хүртэлх болон 5-19 насны хүүхдийн биеийн урт/өндөр–насны үзүүлэлт нь ДЭМБ-ын Хүүхдийн өсөлтийн стандарт эсвэл өсөлтийн лавлагаа Стандарт дундаж голчоос –2 стандарт хазайлтаар доогуур байвал “Өсөлт хоцролт”-той гэж үнэлдэг. Хүүхдийн биеийн урт/өндөр–насны үзүүлэлт нь ДЭМБ-ын Хүүхдийн өсөлтийн Стандарт дундаж голчоос –3 стандарт хазайлтаар доогуур байвал “Хүнд өсөлт хоцролт”-той гэж тодорхойлно;

**Таргалалт:** 5-19 насны хүүхдийн БЖИ–Насны үзүүлэлт нь ДЭМБ-ын өсөлтийн лавлагаа дундаж голчоос +2 стандарт хазайлтаар дээгүүр байвал “таргалалт”-тай гэж үнэлдэг. Насанд хүрэгчдийн БЖИ $\geq$ 30 кг/м<sup>2</sup> байвал “таргалалт” гэж тодорхойлдог;

**Тархалт:** Тодорхой хугацаанд эмгэг байдал эсвэл өвөрмөц шинж илэрсэн хүмүүсийн нийт хүн амд эзлэх хувь, өөрөөр хэлбэл, тухайн цаг хугацаанд үүссэн шинэ тохиолдлын тоо;

**Төмөр дутлын цус багадалт:** Цусны улаан эсийн нөхөн төлжилтөд шаардлагатай бие махбодын төмрийн нөөц шавхагдаж, улмаар гемоглобины хэмжээ багасах эмгэг;

**Төмрийн дутал:** Төмрийн хэрэгцээ нэмэгдэх, хоол хүнсээр авах төмрийн хэмжээ хангалтгүй эсвэл шимэгдэлт буурах, халдварын улмаас төмөр алдагдах зэрэг шалтгааны улмаас бие махбодын төмрийн нөөц шавхагдахыг хэлнэ. Төмөр дутлыг ийлдэс дэх ферритин эсвэл уусдаг трансферрин рецепторын хэмжээгээр үнэлдэг;

**Тураал:** Тав хүртэлх насны хүүхдийн биеийн жин–насны үзүүлэлт нь ДЭМБ-ын Хүүхдийн өсөлтийн стандарт дундаж голчоос –2 стандарт хазайлтаар доогуур байвал “Тураал”-тай гэж үнэлнэ. Хүүхдийн биеийн жин–насны үзүүлэлт нь ДЭМБ-ын Хүүхдийн өсөлтийн стандарт дундаж голчоос –3 стандарт хазайлтаар доогуур байвал “Хүнд тураал”-тай гэж тодорхойлно. Насанд хүрсэн хүний БЖИ < 18.5 кг/м<sup>2</sup>

байвал тураалтай гэж үнэлнэ;

**Туранхай:** 5-19 насны хүүхдийн биеийн БЖИ– Насны үзүүлэлт нь ДЭМБ-ын өсөлтийн лавлагаа стандарт дундаж голчоос –2 стандарт хазайлтаар доогуур байвал “Туранхай” гэж үнэлнэ. Хүүхдийн биеийн БЖИ–Насны үзүүлэлт нь ДЭМБ-ын Хүүхдийн өсөлтийн стандарт дундаж голчоос –3 стандарт хазайлтаар доогуур байвал “хүнд туранхай” гэж тодорхойлно;

**Туранхай:** Хоол тэжээлийн цочмог дутал. Тав хүртэлх насны хүүхдийн биеийн Жин–Урт/ Өндрийн үзүүлэлт нь ДЭМБ-ын Хүүхдийн өсөлтийн стандарт дундаж голчоос –2 стандарт хазайлтаар доогуур байвал “Туранхай” гэж үнэлнэ. Хүүхдийн биеийн жин–урт/өндрийн үзүүлэлт нь ДЭМБ-ын Хүүхдийн өсөлтийн стандарт дундаж голчоос –3 стандарт хазайлтаар доогуур байвал “Хүнд туранхай” гэж тодорхойлно. Мөн хүүхдийн гарын бугалганы дундаж хэсгийн тойргийг хэмжиж туранхайг тодорхойлдог;

**Үрэвсэл:** Эмгэг төрүүлэгч нян, вирус эсвэл гэмтлийн эсрэг бие махбодын дархлааны тогтолцооны хариу урвал. Үрэвслийг ихэвчлэн С-идэвхт уураг,  $\alpha$ –1–ацидгликопротеины хэмжээгээр үнэлдэг;

**Эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллолт:** Насандаа тохирсон байдлаар нэмэгдэл хоол идэхийн зэрэгцээ 12–23 сартай хүүхэд эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллохыг;

**Хоол тэжээлийн дутал:** Хоол хүнсээр авах уураг, илчлэг, бичил тэжээлийн хэмжээ нь хангалтгүй эсвэл шимэгдэлт тааруу байсны улмаас үүсдэг хоол тэжээлийн дутлын эмгэг;

**Хоол тэжээлээс хамааралт эмгэг:** Уураг илчлэг дутал болон илүүдлийн эмгэгүүд, бичил тэжээлийн дутлыг нэгтгэн хэлнэ. Уураг илчлэг дутал болон илүүдлийн эмгэгт өсөлт хоцролт, туранхай, тураал, болон илүүдэл жин, таргалалт багтана.

**Хүнсний баталгаат байдал:** Хүн бүхий л цаг хугацаанд эрүүл, идэвхтэй амьдрахад шаардлагатай

аюулгүй, тэжээллэг, хэрэглэхийг хүссэн хоол хүнсээ хангалттай хэмжээгээр, тэгш хүртээмжтэй хэрэглэх бие махбодын болон нийгэм, эдийн засгийн чадамжтай байх нөхцөл;

**Хүнсний нэр төрлийн хамгийн бага шаардлага:** Хоногт 6-23 сартай хүүхэд 8 нэр төрлийн хүнснээс 5 ба түүнээс олон бүтээгдэхүүн хэрэглэхийг зөвлөдөг. Насанд хүрсэн хүн хоногт 10 нэр төрлийн хүнснээс 5 ба түүнээс олон төрлийн бүтээгдэхүүн хэрэглэх;

**Цус багадалт:** Цусны нэгж эзэлхүүн дэх гемоглобины агууламж багасах

эмгэг. Тав хүртэлх насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйн гемоглобины хэмжээ <110 г/л, насанд хүрсэн эмэгтэй, эрэгтэй хүний гемоглобин агууламж 120 г/л ба 130 г/л-ээс бага байвал цус багадалт гэж үнэлнэ;

**Эрт амлуулалт:** Хүүхдийг төрмөгц 1 цагийн дотор ангир уургаар амлуулах;

**Эхийн сүүгээр дагнан хооллолт:** 0-5 сартай хүүхдэд эхийн сүүнээс өөр хоол, шингэн өгөхгүйгээр зөвхөн эхийн сүүгээр хооллохыг хэлнэ. Хүүхдэд аминдэм, эрдсийн бэлдмэл, дусаалга, эм, шингэн сэлбэх уусмал өгч болно.

## УДИРТГАЛ

Дэлхийн Хүнсний Дээд Хэмжээний Чуулга Уулзалт (Итали улс, Ром хот, 1996)-аас “хүн бүр амьдралынхаа туршид чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсийг улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, газарзүйн байршлаас үл хамааран тогтвортой, хүртээмжтэй сонгон хэрэглэх боломж бүрдсэн байх ёстой” гэж тунхагласан. Гэвч дэлхийн хэмжээнд 3.1 тэрбум хүн эрүүл шим тэжээллэг хоол хүнс хэрэглэж чадахгүй байна [1].

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулган 2015 онд хуралдан “Тогтвортой хөгжлийн 17 зорилго”-ыг баталж, Зорилго 2-д “Өлсгөлөнг зогсоох”, 2.1-д 2030 он гэхэд ядуурлыг эцэс болгож, хүн бүрийг, ялангуяа ядуу болон эмзэг бүлгийн хүмүүс, түүний дотор нялхсыг эрүүл, шим тэжээллэг, хүрэлцэхүйц хоол хүнсийг жилийн турш авах боломжоор хангах зорилт дэвшүүлсэн [2-4].

“Монгол улсын хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний VI судалгаагаар хоол тэжээлээс хамааралт эмгэгт өртөмтгий хүн амын бүлэг болох хүүхэд, эмэгтэйчүүдийн хооллолт, хоол тэжээлийн байдлыг үнэлж, үндэсний болон бүс нутгийн түвшинд төлөөлөх чадвартай тоон үзүүлэлтүүдийг гаргасан болно. Мөн судалгааны явцад 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн аж байдлын түвшин, ариун цэвэр, усан хангамж, хүнсний баталгаат байдлыг үнэлж, өрхийн гишүүдийн хооллолт, хоол тэжээлийн байдалд хэрхэн нөлөөлж байгааг судлав. Судалгааны явцад 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн нийгэм, эдийн засгийн шинж байдал, хүнсний баталгаат байдал (ХББ), иоджуулсан давсны хэрэглээг үнэлж, бүс нутаг, байршлаар харьцуулан дүгнэв.

Судалгааны тайланд хүний амьдралын мөчлөгийг харгалзан дараах зорилтот бүлэгт хувааж, тэдний хоол тэжээлийн байдлын үнэлгээний дүнг багтаасан болно. Үүнд:

- Тав хүртэлх насны хүүхэд,
- Ерөнхий боловсролын сургуулийн 6-18 насны хүүхэд,
- Жирэмсэн эмэгтэй,
- Тав хүртэлх насны хүүхдийн эхчүүд,
- Тав хүртэлх насны хүүхэдтэй өрхийн 15-49 насны эрэгтэйчүүд

“Хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний VI судалгааны үндсэн ач холбогдол нь хоол тэжээлийн бүхий л үзүүлэлтийг бүс нутаг, хүн амын байршил, нас, хүйсээр харьцуулан үнэлж, хооллолтын чанарт анх удаа үнэлгээ өгсөнд оршино. Энэхүү судалгаагаар хүн амын хоол тэжээлийн байдалд тулгамдаж буй томоохон асуудал болох төмөр, А, Д аминдэм, иод дутал, илүүдэл жин ба таргалалтын тархалт, өрхийн ХББ-ын алдагдах байдалд дүн шинжилгээ хийж, тэдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд өнөөгийн бодлого, хөтөлбөрт оруулбал зохих өөрчлөлт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон бодлогын зөвлөмж боловсрууллаа. Мөн бүс нутгаар харьцуулан гаргасан хоол тэжээлийн аливаа үзүүлэлт нь



нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах, илүү их нөөц шаардлагатай орон нутгийг тодорхойлоход шийдвэрлэх ач холбогдолтой юм.

Хоол тэжээлийн үндэсний VI судалгааны тайланд Монгол улсын хүн амын хоол тэжээлийн өнөөгийн байдлыг илтгэх хамгийн сүүлийн үеийн баримт, нотолгоог багтаасан бөгөөд 2017 онд хийгдсэн “Хоол тэжээлийн үндэсний V судалгаа”-ны зарим үр дүнтэй харьцуулан жишиж, ахиц дэвшил, алдаа дутагдлыг илрүүлж, холбогдох дүн шинжилгээ хийв. Өнөөдөр Монгол Улс хоол тэжээлийн дутал болон илүүдлээс үүдэлтэй “хоол тэжээлээс хамааралт эмгэг”-ийн гурван давхар дарамттай тулгарсан хэвээр байна.

Судалгааны явцад жирэмсэн эмэгтэй, 5 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүд, 15-49 насны эрэгтэйчүүдийн хооллолтын чанарыг олон улсын түвшинд баталгаажсан стандарт асуулга ашиглан үнэлсэн. Хооллолтын чанарын үнэлгээгээр хоногт хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг тогтоож, халдварт бус өвчин (ХБӨ)-өөр өвчлөх эсвэл бичил тэжээлийн дуталд өртөхөд нөлөөлж болзошгүй шалтгааныг тодорхойлоход үнэтэй хувь нэмэр оруулсан гэж дүгнэж байна.

Эцэст нь хоол тэжээлийн үндэсний VI судалгаагаар Монгол улсад хоол тэжээлээс хамааралт эмгэгийн дарамт өндөр хэвээр байгааг тогтоосон. Тухайлбал, эхийн сүүгээр дагнан хооллолт хангалтгүй, хоногт хэрэглэдэг хүнсний нэр төрөл цөөн, бичил тэжээлийн дутлын тархалт харьцангуй түгээмэл, нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал хэвээр, өрхийн ХББ алдагдсан, илүүдэл жин ба таргалалтын асуудал нийгмийн эрүүл мэндэд ноцтой сөрөг үр дагавар учруулж байна. Илүүдэл жин ба таргалалтын тархалт нь бүс нутаг, амьжиргааны түвшин үл харгалзан, бүх насны хүн ам, ялангуяа насанд хүрэгчдийн дунд маш өндөр, хүүхдийн дунд нэмэгдэж байгаа нь онцгойлон анхаарвал зохих асуудал хэвээр байна. Илчлэг ихтэй, эрүүл бус хүнс хэрэглэдэг хүн амын тоо нэмэгдэж, идэвхтэй хөдөлгөөн бага хийдэг болох нь ирээдүйд хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж буй халдварт бус өвчин (ХБӨ)-ий тархалт нэмэгдэхэд хүргэдэг [5].

Хоол тэжээлийн байдал нь харьцангуй сайн хүн ам улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжилд шийдвэрлэх үүрэгтэй байдаг. Энэхүү тайлан нь Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад шийдвэрлэх ач холбогдолтой хүүхэд, эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах цогц арга хэмжээний хүртээмжийг сайжруулах, хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр нэмэлт хөрөнгө оруулах асуудалд бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдын анхаарлыг хандуулах, дэмжлэгийг эрчимжүүлэхэд чиглэсэн юм.

## СУДАЛГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын “Хүнсний тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлийн 1.1-д хүн амын хоол тэжээлийн үндэсний судалгааг 5 жил тутамд хийж, дүнг холбогдох төрийн байгууллага болон нийтэд мэдээлэх; “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 4.1-д сургуулийн хүүхдийн хоол тэжээлийн байдлын судалгааг 5 жил тутамд хийж, үр дүнг холбогдох төрийн байгууллага болон олон нийтэд мэдээлэх гэж тус тус заасан. Мөн Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2.1.5-д “Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах” гэж тус тус заасан [6, 7, 8].

“Монгол улсын хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний V судалгааг 7 жилийн өмнө буюу хамтран гүйцэтгэсэн. Судалгаагаар манай улсын 5 хүртэлх насны хүүхэд, эмэгтэйчүүдийн дунд уураг илчлэг дутлын тархалт буурсан хэдий ч, илүүдэл жин, таргалалт нэмэгдэхийн зэрэгцээ, цус багадалт, Д аминдэм, төмөр дутлын тархалт буураагүй байгааг судлаж тогтоосон.

Энэхүү судалгааны үр дүн, дүгнэлтэд үндэслэн хүн амын хоол тэжээлийн байдлыг сайжруулах эрх зүйн орчин бүрдүүлэх, салбар дундын хамтын ажиллагаа, тэжээллэг хүнсний хангамж, хэрэглээг дэмжих, мэдээлэл харилцаа; хяналт шинжилгээ, үнэлгээг эрчимжүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг улс, орон нутгийн төсөв, олон улсын хандивлагч байгууллагын санхүү, техникийн дэмжлэгээр хэрэгжүүлсэн. Тухайлбал, эхийн сүүгээр хооллолтыг дэмжих, хамгаалах зорилгоор 1992 оноос “Хүүхдэд ээлтэй эмнэлэг” санаачилга өрнүүлж, “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай хууль”-ийг 2005–2017 онд, “Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль”-ийг 2017 оноос, эдгээртэй холбогдон гарсан дараах журам, зааврыг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Нялх, балчир хүүхдийг хооллох заавар, ЭМС, 2018.11.27, А/481 тоот тушаал
2. Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих “Арван алхам”-г хэрэгжүүлэх заавар, ЭМС, 2019.06.13 А/290 тоот тушаал
3. Нялхсын болон хүүхдийн сүүн тэжээл, нэмэгдэл хоол, хооллох хэрэгслийн сав, баглаа боодол, шошгын тухай журам, ЭМС 2019.07.05 А/328 тоот тушаал
4. Эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх журам, МХЕГ/ЭМС, 2020.08.18 86/А/400 тоот тушаал
5. Хүнсний сав, баглаа, боодол шошгын Хяналтын зөвлөл, НЭМҮТ, 2023 оны 5 дугаар сарын 5-ны А/32 тоот тушаал

Мөн эх, хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээлийн байдлыг сайжруулах чиглэлээр дараах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль”, УИХ, 2019
2. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр, 2020-2025, Засгийн газрын тогтоол #207
3. Хүн амын хоол тэжээл, Үндэсний хөтөлбөр 2016-2025, Засгийн газрын тогтоол #447, 2015.11.16 (2021 он хүртэл хэрэгжсэн)
4. Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратеги 2015-2025, Засгийн газрын тогтоол#353, 2015 (2021 он хүртэл хэрэгжсэн)
5. “Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ” ЭМС, 2017.02.23, А/74 тоот тушаал
6. Хүүхдэд чиглэсэн хүнсний зар сурталчилгааг зохицуулах удирдамж, ЭМС, 2018.08.28 А/346 тоот тушаал
7. “Хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутлын эмнэлзүйн заавар” ЭМС, 2021.06.17, А/379 тоот тушаал
8. Цэцэрлэг, ЕБС-ын хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг батлах тухай, ЭМС/БШУЯ/СЯ, 2020.12.02, А/166, А/559, 222 тоот тушаал
9. Хоол эмчилгээний удирдамж, ЭМС, 2023.12.12, А/440 тоот тушаал
10. Ерөнхий боловсролын сургуулийн “Эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөр”, БШУЯ/ЭМС, 2018.07.04, А/453 тоот тушаал
11. Хүн амын эрүүл хооллолтын “Гэр зөвлөмж, ЭМС, 2020.04.01, А/215 тоот тушаал
12. Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалт, ЭМС, 2021.06.15, А/370

Хүүхэд, эмэгтэйчүүдийн дунд бичил тэжээлийн дутлаас сэргийлэх, хянах чиглэлээр “Давс иоджуулж, иод дутлаас сэргийлэх тухай хууль”-ийг 2003–2018 онд, “Баяжуулсан хүнсний тухай хууль”-ийг 2019 оноос, ЭМС-ын 2020 оны А/490 тушаалаар батлагдсан “Аминдэм эрдсийн бэлдмэлийг хэрэглэх заавар”-ыг тус тус хэрэгжүүлж байна. НҮБ-ын Статистикийн комиссын 48 дугаар чуулган (2017 оны 3 сар) тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-ын 244 шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, “Өлсгөлөнг зогсоох” зорилгын 2.1-ийн зорилтын хэрэгжилтийг “хоол тэжээлийн дутагдлын тархалт” (2.1.1), “хүнсний баталгаат байдлын алдагдал” (2.1.2)-ын шалгуур үзүүлэлтээр гаргахаар заасан байдаг. НҮБ-ын ХХААБ нь хүнсний баталгаат байдал нь алдагдсан өрхийн тархалт (FIES)-ыг тогтооход 8 асуулт бүхий стандарт асуулгыг өрхөд суурилсан судалгаанд ашиглахыг дэлхийн улс орнуудад зөвлөсөн билээ [1, 2, 9, 10, 11].

Ийнхүү хүн ам, ялангуяа бага насны хүүхэд, эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах чиглэлээр 2017 оноос хойш хэрэгжүүлсэн бодлого, холбогдох хөтөлбөр, төслийн үр дүнг үнэлэх; хүн амын хоол тэжээлийн байдалд цар тахал, ядуурал, эдийн

засгийн хямралын нөлөөг судлах, “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх үеийн хоол тэжээлийн зарим үзүүлэлтийг тодорхойлох, хүн амын дундах хүнсний баталгаат байдлын алдагдлын тархалт, хоол тэжээлийн хомсдолын тархалтыг судлах зорилгоор “Монгол улсын хүн амын амын хоол тэжээлийн байдал” үндэсний VI судалгааг зохион байгуулах зайлшгүй шаардлага тулгамдаж байна.

Эдгээр шаардлагын улмаас 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн хүнсний баталгаат бус байдал, аж байдлын түвшнийг зорилтот бүлгийн хүн амын хооллолтын чанар, хоол тэжээлийн байдалтай холбон судлах “Монгол улсын хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний VI судалгааг НЭМҮТ нь НҮБ-ын Хүүхдийн Сан (НҮБХС)-гийн санхүү, техникийн дэмжлэгээр 2023-2024 онд зохион байгуулав.

Энэхүү судалгааг Монгол улсын хүн амын хоол тэжээлийн өнөөгийн байдлыг илтгэх, төлөөлөх чадвар бүхий тоо баримт, нотолгоог бий болгох зорилгоор гүйцэтгэв. Судалгаагаар Засгийн газраас хэрэгжүүлсэн хоол тэжээлийн бодлого, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг үнэлэх, тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, өнөөгийн нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүн амын хооллолтын дадлыг харгалзан холбогдох бодлого, хөтөлбөрт өөрчлөлт оруулах санал, зөвлөмж боловсруулахад чиглэсэн болно.

## **СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЁС ЗҮЙН АСУУДАЛ**

### **Зорилго**

Монгол улсын хүн амын хоол тэжээлийн өнөөгийн байдлыг үнэлж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний чиг хандлага, зөвлөмж боловсруулахад судалгааны зорилго оршино.

### **Зорилтууд**

Судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

ав хүртэлх насны хүүхэдтэй өрхийн усан хангамж, ариун цэвэр, аж байдлын түвшин, хүнсний баталгаат бус байдал, иоджуулсан давсны хэрэглээг үнэлэх,

ав хүртэлх насны хүүхдийн хооллолт, хоол тэжээлийн байдлыг судлан, хоол тэжээлээс хамааралт эмгэгийн тархалтыг өрхийн шинж байдал, эхийн хоол тэжээлийн байдалтай холбон судлах,

рөнхий боловсролын сургуулийн 6-18 насны хүүхдийн хоол тэжээлийн байдлыг судлан, хоол тэжээлээс хамааралт зарим эмгэгийн тархалтын түвшинг тогтоож, тэдний хоол тэжээлийн талаарх мэдлэг, хандлага, дадал, “Үдийн хоол”-ны талаарх сэтгэл ханамжийн байдлыг үнэлэх,

ирэмсэн эмэгтэйчүүдийн хооллолт, хоол тэжээлийн байдлыг судлан хоол тэжээлээс хамааралт эмгэгийн тархалтын түвшин, бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглээг үнэлэх,

өхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хооллолт, хүүхдийн хооллолтын талаарх мэдлэг, бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглээг үнэлж, хоол тэжээлээс хамааралт эмгэгийн тархалтыг судлах,

ав хүртэлх насны хүүхэдтэй өрхийн 15-49 насны эрэгтэйчүүдийн хооллолт, хоол тэжээлийн байдлыг судлан, хоол тэжээлээс хамааралт эмгэгийн тархалтыг судлах, үн амын хүнсний баталгаат байдлын алдагдал, хоол тэжээлийн хомсдолын тархалтыг судлах,

### **Судалгааны ёс зүйн асуудал**

Судалгааны аргачлалыг НЭМҮТ-ийн Эрдмийн зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд эрдмийн зөвлөлийн гишүүдийн санал, зөвлөмжийг үндэслэн нэмэлт өөрчлөлт оруулсан тул 2023 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хурлаар дахин хэлэлцүүлж, батлуулсан. Хоол тэжээлийн үндэсний VI судалгааны ёс зүйн асуудлыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Анагаах ухааны Ёс зүйн хяналтын хорооны 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, судалгааг зохион байгуулах зөвшөөрөл авсан болно.

Түүврийн аргаар сонгогдсон бүх өрх, хүмүүс тус судалгаанд сайн дураараа оролцсон бөгөөд тэднээс амаар болон бичгээр зөвшөөрөл авсан. Судалгааны мэдээлэл цуглуулах, мэдээллийн санд шивж оруулах, статистик боловсруулалт хийх, үр дүнг танилцуулах явцад оролцогчдын мэдээллийн нууцыг чанд хадгалж, мэдээллийг хувь хүний нэрээр бус тусгай дугаараар тэмдэглэсэн бөгөөд өөр зориулалтаар ашиглаагүй болно.

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд 5 хүртэлх насны хүүхэд, эмэгтэйчүүдээс цуглуулсан цусны ийлдэсний дээжийг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын “ВитМин” лабораторид илгээн шинжилгээ хийлгэх асуудлаар Анагаах ухааны Ёс зүйн хяналтын хорооны 2023 оны 10 дугаар сарын 13 өдрийн хурлаар дахин хэлэлцүүлж, зөвшөөрөл авсан (Хавсралт 1. Ёс зүйн хорооны тогтоол №23/017, №24/011).

## **Дөрөв. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ**

### **4.1 Судалгааны хамрах хүрээ, хүн ам**

Хоол тэжээлийн дуталд өртөмтгий, эрсдэлт бүлэг болох 5 хүртэлх насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, төрөх насны эмэгтэйчүүдээр төлөөлүүлэн тухайн улсын хүн амын хоол тэжээлийн байдлыг үнэлдэг олон улсын жишиг аргачлалыг ашиглахын зэрэгцээ, ЕБС-д суралцагч 6–18 насны хүүхэд, өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулан жиших зорилгоор 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн 15–49 насны эрэгтэйчүүдийг тус тус хамруулахаар төлөвлөсөн. Ийнхүү “Монгол улсын хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний VI судалгаанд дараах зорилтот бүлгийн хүн амыг хамруулан судалсан. Үүнд:

ав хүртэлх насны хүүхэд

БС-ийн 6–18 насны хүүхэд

ирэмсэн эмэгтэйчүүд

өхөн үржихүйн насны эмэгтэйчүүд (эхчүүд)

5–49 насны эрэгтэйчүүд

МУ-ын нийгэм, эдийн засгийн 4 бүс, Улаанбаатар хотоос тус бүр 5 хүртэлх насны 560 хүүхдийг санамсаргүй, магадлалт түүврийн аргаар сонгож, тухайн хүүхэд амьдарч буй өрхийн 15–49 насны хүмүүсийг сонгон судалсан. Судалгаанд сонгогдсон түүврийн анхан шатны нэгжид байрлах Ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн 1–12 дугаар ангийн сургалцагчдыг судалгаанд хамруулсан бөгөөд тус нэгжид байрлах сум, өрхийн ЭМТ-ийн бүртгэлийг ашиглан жирэмсэн эмэгтэйчүүдийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан болно.

### **Судалгааны түүврийн загвар**

“МУ-ын хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний VI судалгаагаар тогтоох үндсэн үзүүлэлтүүдийг статистикийн хувьд ач холбогдолтой байхаар үндэсний түвшинд тооцохын зэрэгцээ, хүн амын байршил, түүврийн бүлэг буюу эдийн засгийн бүс, амьжиргааны түвшнээр тус тус харьцуулан үнэлэх зорилгоор түүврийн загварыг боловсруулсан. Судалгааны түүвэрлэлтийн зорилго нь зорилтот хүн амын хооллолт, хоол тэжээлийн үзүүлэлт, өрхийн хүнсний баталгаат бус байдал, насанд хүрсэн хүн амын дундах хоол тэжээлийн хомсдолын тархалтыг үндэсний, бүс нутгийн болон байршил (хот хөдөө)-аар харьцуулан тогтооход чиглэсэн.

Судалгаа нь МУ-ын нийгэм, эдийн засгийн 4 бүс буюу “Баруун”, “Хангай”, “Төв”, “Зүүн” болон “Улаанбаатар хот” гэсэн түүврийн 5 бүлэг (Sampling strata)-тэй бөгөөд түүвэрлэлтийг 2 шатлалт бүлэглэн түүвэрлэх аргаар гүйцэтгэсэн. Судалгааны түүврийн хэмжээг түүврийн бүлэгт бүрд 560 өрх, үндэсний түвшинд нийт 2800 өрх байхаар тодорхойлж, түүврийн бүлэг бүрээс сонгох түүврийн тоог тэгш хуваарилсан болно.

Судалгааны түүврийн анхан шатны нэгж (ТАШН) нь хөдөөд “баг”, Улаанбаатар хотод “хороо”, түүврийн 2 дахь шатны нэгж нь 5 хүртэлх насны хүүхэдтэй өрх, ЕБС-ийн 1–12 дугаар ангийн хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд байна. ТАШН-ээс сонгогдох өрхийн тоо, түүврийн загвар, төсвийн боломжит байдал, мэдээлэл цуглуулах нэг баг, судалгааны нэг нэгжид ажиллах хугацааг харгалзан түүврийн бүлэг бүрт 40 нэгж, нийт 200 нэгжийг сонгохоор төлөвлөж, нэг нэгжид 5 хүртэлх насны хүүхэдтэй 14 өрх байв.

### 4.3 Судалгааны түүврийн хэмжээ тооцсон арга

Түүврийн хэмжээг тогтоохдоо хүүхэд, эмэгтэйчүүдэд “цус багадалт, төмөр, А, Д аминдэм дутал”, сургуулийн насны хүүхэд, эрэгтэйчүүдэд “илүүдэл жин ба таргалалт”-ын тархалтыг түлхүүр үзүүлэлтээр сонгон, дараах томъёог ашиглан тооцсон болно. Ингэхдээ судалгаанд сонгогдсон өрхийн хамрагдалтыг 98% гэж тооцсон бөгөөд энэ нь хоол тэжээлийн үндэсний 90%, биохимийн шинжилгээний хамрагдалтыг 85% байхаар тус тус тооцсон.

Түүврийн хэмжээг тогтоохдоо алдааны харьцангуй хязгаар (Relative margin of error)–ыг тухайн үзүүлэлтийн үр дүнг тооцоход шаардлагатай нарийвчлал (precision) болгон ашигласан. Бүлгийн түүвэр судалгаанд аливаа үзүүлэлтийн алдааны харьцангуй хязгаарыг 0.12 буюу тухайн үзүүлэлтийн хэлбэлзэх утга  $\pm 12\%$  байхыг зөвлөдөг. Тухайлбал, 5 хүртэлх насны хүүхдийн дунд цус багадалтын тархалт 26.6% гэж үзвэл тухайн үзүүлэлтийн бодит утга нь 24.6% ба 31.4% хооронд хэлбэлзэж байна. Алдааны харьцангуй хязгаарыг 0.12 гэж авах нь судалгааны үр дүнгийн нарийвчлал үндэсний болон бүс нутгийн түвшинд маш өндөр буюу 95 хувийн итгэх хязгаарт байх боломж олгоно.

Түүврийн хэмжээг судалгааны зорилтот бүлэг тус бүрийн түлхүүр үзүүлэлтэд тулгуурлан дараах томъёог ашиглан тогтоосон.

$$\frac{\{4 * r * (1 - r) * deff\}}{(RME * r)^2 * pb * AveSize * RR}$$

Энд:

- $r$  = Түлхүүр үзүүлэлтийн утга (хувиар илэрхийлэгдэнэ)
- $deff$  = Design effect – Түүврийн загварын нөлөө – 1.5
- $RME$  = Relative margin of error – Алдааны харьцангуй хязгаар – 0.12
- $Pb$  = Зорилтот бүлгийн хүн амын эзлэх хувь
- $AveSize$  = Өрхийн ам бүлийн дундаж тоо 3.7
- $RR$  = Response rate for the survey – Судалгааны хамрагдалтын хувь

МУ-ын нэг өрхийн ам бүлийн дундаж тоо 2023 оны жилийн эцсийн байдлаар 3.54 байгаа бөгөөд үүний 0.89 нь 15–49 насны эрэгтэй, 0.9 нь 15–49 насны эмэгтэй, 0.36 нь 5 хүртэлх



насны хүүхэд байгаа тооцоог үндэслэн, судалгааны түүврийн хэмжээг дараах байдлаар урьдчилан тооцсон[12] (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдвал зохих зорилтот бүлгийн хүн амын тоо

Зорилтот бүлэг, хоол тэжээлийн дутал	Тархалт	Алдааны харьцангуй хязгаар (RME)	Түүврийн загварын нөлөө	Хамралтын хувь	Бүлэгт хамрагдвал зохих тоо
<b>Өрх</b>					
Иоджуулсан давс	%	0.05		98%	
<b>Хүүхэд 0-59 сар (0.41/Өрх)</b>					
Цус багадалт (<11.0г/дл)	%	0.12		85%	
Төмөр дутал	2	0.12		85%	
А аминдэм дутал	%	0.12		85%	
Д аминдэм дутал	%	0.12		85%	
Өсөлт хоцролт	%	0.12		90%	
Илүүдэл жин	10.5%	0.12		90%	
Бага жинтэй төрөлт		0.12			
<b>Сургуулийн хүүхэд 6 – 18 нас</b>					
Иод дутал					
Д аминдэм дутал					
Өсөлт хоцролт		0.12			
Илүүдэл жин (БЖИ-нас≥1.0)		0.12			
<b>Төрөх насны эмэгтэй болон эхчүүд (0.93/өрх)</b>					
Цус багадалт	%	0.12		85%	
Төмөр дутал		0.12		85%	
Д аминдэм дутал		0.12		85%	
Илүүдэл жин (БЖИ≥25)	%	0.12		90%	510
Тураал					
<b>Эрэгтэй 15 – 49 нас (0.94/өрх)</b>					
Цус багадалт	%	0.12		85%	
Илүүдэл жин (БЖИ≥25)	%	0.12		85%	
Д аминдэм дутал	%	0.12		85%	
<b>Жирэмсэн эмэгтэй*</b>					
Цус багадалт	%	0.12		%	
Тураал		0.12		%	
Төмөр дутал	%	0.12		%	534
А аминдэм дутал	%	0.12		%	
Д аминдэм дутал	%	0.12		%	

Жирэмсэн эмэгтэй, сургуулийн хүүхдийг судалгаанд сонгогдсон ТАШН-ийн сум, өрхийн ЭМТ-ийн жирэмсний хяналтын бүртгэл, ЕБС-ийн 1–12 ангийн суралцагчдын ирцийн бүртгэлд тулгуурлан сонгосон.

Эцэст нь дээр дурдсан түлхүүр үзүүлэлт болон судалгааны үр дүнгийн нарийвчлал, итгэх хязгаарыг харгалзан түүврийн хэмжээг судалгааны хүн амын зорилтот бүлэг тус бүрээр тогтоосон. Ингэхдээ судалгааны үр дүнгийн итгэх хязгаар 95%, нарийвчлал (precision) нь бүх үзүүлэлтэд  $\pm 5\%$  ба түүнээс бага байхаар тооцсон болно (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Судалгааны түүврийн хэмжээ, зорилтот бүлгээр

Зорилтот бүлэг	Түүврийн нэгжид ногдох тоо	Бүлэгт ногдох түүврийн тоо	Түүврийн бүлгийн тоо	Нийт түүврийн хэмжээ
Хүүхэд, 0 – 59 сар			5	
Эмэгтэйчүүд, 15-49 нас			5	
Эрэгтэйчүүд, 15-49 нас				
Жирэмсэн эмэгтэй		0	5	
Сургуулийн хүүхэд, 6-18 нас				
<b>БҮГД</b>				

Тогтоосон түүврийн хэмжээ нь судалгааны түлхүүр үзүүлэлт бүрийн үр дүнг бүс нутаг, хүн амын байршил (хот, хөдөөгөөр), амьжиргааны түвшнээр харьцуулан өндөр нарийвчлалтайгаар үнэлэх боломжийг олгосон болно. Мөн ЕБС--ийн суралцагчдын хооллолт, хоол тэжээлийн талаарх мэдлэг, хандлага, дадал, хоол тэжээлийн байдлыг үндэсний түвшинд болон түүврийн 2 бүлэг (76 сургууль/хот; 76 сургууль/хөдөө), насны 4, хүйсийн 2, нийт 8 бүлгээр тооцоход хангалттай төлөөлөлтэй байхаар тооцсон.

Бичил тэжээлийн байдлыг үнэлэх биохимийн шинжилгээнд хамрагдах зорилтот хүн амын тоог үндэсний болон байршил (хот, хөдөө)-аар төлөөлөх чадвартай байхаар тооцон түүврийн тоог тогтоосон. Тодруулбал, захын цусны гемоглобины агуулгыг тодорхойлох шинжилгээнд сонгогдсон 5 хүртэлх насны хүүхэд, жирэмсэн эмэгтэй, төрөх насны эмэгтэйчүүдийг бүрэн хамруулахаар, харин 15-49 насны эрэгтэйчүүд, сургуулийн хүүхдийг үндэсний түвшинд төлөөлөхүйц төлөөлөлтэй байхаар тооцон, түүврийн анхан шатны нэгж бүрээс 2 эрэгтэй, ЕБС-ийн 8 хүүхдийг сонгон судалсан. Мөн төмөр, А ба Д аминдэм дутлыг илрүүлэх шинжилгээнд 2 хүүхэд, эмэгтэй тутмын нэгийг, шээсний иодын агуулга тодорхойлох шинжилгээнд түүвэрт сонгогдсон ЕБС-ийн 6–11 насны хүүхдийг бүрэн хамруулсан болно. Судалгаанд сонгогдсон 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийг давсны дээжид иод тодорхойлох шинжилгээнд бүрэн хамруулахаар тогтоов.

“Монгол улсын хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний VI судалгаагаар тодорхойлох үзүүлэлтүүд, тэдгээрийн түүврийн бүлэг (Sampling strata)-ийг хүн амын зорилтот бүлэг тус бүрээр тоймлон, дараах хүснэгтэд харуулав (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Судалгаагаар тодорхойлох үзүүлэлтүүд, түүний түүвэрлэлт

№	Үзүүлэлт	Өрх	5 хүртэлх насны хүүхэд	15 – 49 насны эмэгтэй	15–49 насны эрэгтэй	ЕБС-ийн хүүхэд	Жирэмсэн эмэгтэй
<b>Биохимийн үзүүлэлт</b>							
	Гемоглобин (цус багадалт)	-	Ү / БН	Ү / БН	Ү	Ү/Байршил	Ү / БН
	Ферритин: Төмөр дутал	-	Ү / Байршил	Ү / Байршил	-	-	Ү / Байршил
	Уусдаг трансферрин: Төмөр дутал	-	Ү / Байршил	Ү / Байршил	-	-	Ү / Байршил
	Ретинол холбогч уураг: А аминдэм	-	Ү / Байршил	Ү / Байршил	-	-	Ү / Байршил
	[ОН] Д аминдэм	-	Ү / Байршил	Ү / Байршил	-	Ү/Байршил	Ү / Байршил
	С идэвхт уураг	-	Ү / Байршил	Ү / Байршил	-	-	Ү / Байршил
	Альфа–1–ацид гликопротеин	-	Ү / Байршил	Ү / Байршил	-	-	Ү / Байршил
	Шээсний иод: Иод дутал	-	-	-	-	Ү / БН	Ү / БН
<b>Бие махбодын үзүүлэлт</b>							
	Илүүдэл жин/таргалалт	-	Ү / БН	Ү / БН	Ү / БН	Ү / БН	
	Тураал	-	Ү / БН			Ү / БН	
	Өсөлт хоцролт / хэт намхан	-	Ү / БН	Ү / БН		Ү / БН	Ү / БН
	Туранхай	-	Ү / БН	Ү / БН	Ү / БН	Ү / БН	Ү / БН
<b>Өрх, хувь хүний үзүүлэлт</b>							
	Давсны иодын агууламж 7	Ү / БН	-	-	-	-	-
	Хоол, хүнсний хэрэглээ: 24 цагийн эргэн санах асуулга		Ү / БН 0-23 сар	-	-	-	-
	Хүнсний хэрэглээ: 14 хоногийн хүнсийг бүртгэх	Ү / БН					
	Хүнсний баталгаат бус байдал	Ү / БН					
	Хоол, хүнсний хэрэглээ: давтамж, нэр төрөл		Ү / БН	Ү / БН	Ү / БН		Ү / БН
	Хооллолт: эрүүл бус хүнсний хэрэглээ	-	-	-	-	Ү / БН	-
	Бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглээ		Ү / БН	Ү / БН			Ү / БН
	Аж байдлын түвшин	Ү / БН					
	Хүн ам зүйн үзүүлэлт	Ү / БН		Ү / БН	Ү / БН		Ү / БН
	Өвчлөл		Ү / БН				
	НБНХХ-ын талаарх мэдлэг			Ү / БН			Ү / БН
	Жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээ			Ү / БН			Ү / БН
	Өрхийн усан хангамж, ариун цэврийн байгууламж	Ү / БН					

Ү – үндэсний, БН – бүс нутаг, Байршил – Хот, Хөдөө

#### **4.4 Судлаач бэлтгэх сургалт**

Хоол тэжээлийн үндэсний VI судалгааны судлаач бэлтгэх сургалтыг 2023 оны 9 дүгээр сарын 11–15 өдрүүдэд нийт 70 оролцогчийг хамруулан зохион байгуулсан. Сургалтын явцад ярилцлага авах арга зүй, асуулгын хуудас дахь асуулт бүрийг танилцуулж, асуулга авах дадлага, бие махбодын хэмжилт хийх арга зүйн дадлага хичээл орсон. Судлаачид 5 хүртэлх насны хүүхдийн биеийн жин, урт/өндөр, жирэмсэн эмэгтэйчүүдийн бугалганы тойрог хэмжих 2 өдрийн дадлага хийсэн. Сургалтын дараа судлаачид Улаанбаатар хотод 2023 оны 9 дүгээр сарын 18–24-ны өдрүүдэд зохион байгуулсан туршилт судалгаанд оролцож, судалгаагаар гүйцэтгэх бүх ажилбарыг биечлэн гүйцэтгэж, мэдээлэл цуглуулах ур чадвараа баталгаажуулсан болно. Судалгааны багийн ахлагчаар НЭМҮТ-ийн мэргэшсэн судлаачид ажилласан бөгөөд тэдэнд багийн ахлагчийн үүрэг, хариуцлага, мэдээлэл цуглуулалтыг орон нутагт хэрхэн зохион байгуулах, ТАШН-ээс өрх, жирэмсэн эмэгтэйчүүд, ЕБС-ийн суралцагчдыг хэрхэн сонгох талаар нэмэлт сургалтыг зохион байгуулсан.

#### **4.5 Судалгааны мэдээлэл цуглуулалт**

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 21 аймгийн Эрүүл мэндийн газар, Нийслэлийн ЭМГ, 8 дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран НЭМҮТ-ийн судалгааны техникийн ажлын хэсэг удирдан зохион байгуулсан. Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2023 оны 9–11 дүгээр сард гүйцэтгэсэн бөгөөд энэ нь “Хоол тэжээлийн үндэсний V судалгаа”-ны мэдээлэл цуглуулсан хугацаа (2016 оны 9-11 дүгээр сар)-тай ижил байв.

МУ-ын нийгэм, эдийн засгийн 4 бүсийн 21 аймаг, Улаанбаатар хотын 8 дүүргээс сонгогдсон 200 түүврийн нэгжээс мэдээлэл цуглуулах ажлыг судалгааны арга зүйн сургалтад хамрагдаж, зохих мэдлэг, ур чадвар эзэмшсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй 12 баг гүйцэтгэсэн. Судалгааны баг нь багийн ахлагч, хүний их эмч/хүүхдийн эмч, лабораторийн ажилтан/сувилагч, ярилцлага авагч / хэмжигчээс бүрдсэн.

Улаанбаатар хотод мэдээлэл цуглуулах ажлыг 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн 8 хоногийн хугацаанд гүйцэтгэсэн. Харин Багануур дүүрэг, 21 аймгаас сонгогдсон түүврийн нэгжээс мэдээлэл цуглуулах ажлыг 10 дугаар эхний 7 хоногоос эхлэн 11 дүгээр сарын 14-ны хооронд гүйцэтгэсэн болно.

Судалгааны мэдээлэл цуглуулалт нь асуулга, антропометрийн хэмжилт, эмнэл зүйн үзлэг болон зорилтот бүлгийн хүн амаас биологийн сорьц (цус, шээсний дээж) цуглуулах ажилбараас бүрдсэн. Судалгааны асуулгын хуудсыг судалгааны зорилго, зорилт, хамрах хүрээг харгалзан ДЭМБ, НҮБ-ын ХХААБ-ын боловсруулсан олон улсын түвшинд өргөн ашиглаж буй баталгаажсан стандарт асуултуудыг өөрийн орны нөхцөлд тохируулан боловсруулсан. Мөн өмнө хийгдсэн хоол тэжээлийн судалгаагаар туршигдан баталгаажсан

уламжлалт асуулт, түүгээр тодорхойлох үзүүлэлтийг тогтоохдоо бусад судалгааны үр дүн болон олон улсын түвшинд харьцуулагдах боломжийг алдагдуулахгүй байх зарчмыг баримталсан болно. Судалгаанд 7 төрлийн асуулгын хуудас хэрэглэсэн. Үүнд:

1. Өрхийн асуулга
2. Тав хүртэлх насны хүүхдийн асуулга
3. ЕБС-ийн хүүхдийн асуулга, 6–11 нас
4. ЕБС-ийн хүүхдийн асуулга, 12–18 нас
5. Жирэмсэн эмэгтэйн асуулга
6. Төрөх насны эмэгтэйн асуулга
7. 15-49 насны эрэгтэйн асуулга

Судалгааны мэдээлэл цуглуулах баг нь асуулга авахаас гадна оролцогчийн биеийн жин, өндөр, бугалганы тойрог (БТ)-ийг хэмжих, 0-59 сартай хүүхдэд рахитын өвөрмөц шинжүүд, хоол тэжээлийн цочмог дутлын шалтгаант хаван илрүүлэх эмнэл зүйн үзлэг хийж, биохимийн шинжилгээнд цус, шээсний дээж цуглуулсан тул эдгээр үйлдлийн үр дүнг тэмдэглэх асуултыг асуулгын хуудасны холбогдох бүлэгт багтаасан болно.

“Дэлхийн хооллолтын чанар” төслийн хүрээнд боловсруулсан “Хооллолтын чанарын асуулга” ашиглан хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг үнэлэх шинэчилсэн удирдамжийг ашиглан төрөх насны эхчүүд, жирэмсэн эмэгтэйчүүд [8] болон эрэгтэйчүүдийн хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг үнэлсэн.[13]

Мөн ХХААБ-ын шинжээчдийн боловсруулсан өрхийн хүнсний баталгаат бус байдлыг илрүүлэх 8 асуулт бүхий “Хүнсний баталгаат бус байдлын хэмжүүр” стандарт асуулгыг ашиглан хувь хүний туршлага, мэдрэмжид тулгуурлан хүнсний баталгаат бус байдал, түүний гүнзгийрлийн түвшнийг үнэлсэн [14].

Мөн ЕБС-ийн суралцагчдын эрүүл бус хүнс (түргэн хоол, хийжүүлсэн болон чихэртэй ундаа) болон эрүүл мэндэд тустай зарим төрлийн хүнс (сүү, цагаан идээ, жимс, хүнсний ногоо)–ний хэрэглээ, хөдөлгөөний хомсдолыг үнэлэх зорилгоор ДЭМБ-ын шинжээчдийн боловсруулсан, эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг илрүүлэх 76 стандарт асуултаас хоол тэжээл, хөдөлгөөний талаарх бүлэг асуултыг өөрийн орны нөхцөлд тохируулан ашиглав [15].

Судалгаанд оролцсон 0-59 сартай хүүхэд, ЕБС-ийн 1–12 дугаар ангийн суралцагчид, төрөх насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн биеийн жин, урт/өндрийн хэмжилтийн дүн, жирэмсэн эмэгтэйчүүдийн бугалганы дунд хэсгийн тойргийн хэмжээг үндэслэн тэдний хоол тэжээлийн байдлыг үнэлэв. Хүүхэд, насанд хүрэгчдийн биеийн жинг 100 граммын нарийвчлал бүхий электрон жинлүүрийг ашиглан хэмжсэн. Мөн судалгаанд оролцсон 0-23 сартай хүүхдийн

биеийн уртыг хэвтээ, 24 сар түүнээс дээш настай хүүхдийн биеийн өндрийг босоо байдлаар 1 миллиметрийн нарийвчлал бүхий модон өндөр хэмжигч ашиглан хэмжсэн. Сургуулийн сурагчид, насанд хүрэгчдийн биеийн өндрийг “In Lab S50” дижитал өндөр хэмжигч, 1 миллиметрийн нарийвчлал бүхий стадиометр ашиглан хэмжсэн. Жирэмсэн эмэгтэйн зүүн гарын бугалганы дунд хэсгийн тойргийн хэмжээг тогтоохдоо насанд хүрэгчдэд зориулсан зориулалтын туузан хэмжигчийг ашигласан болно.

Цусны гемоглобин, ийлдсийн ферритин, уусдаг трансферрин рецептор (sTfR), ретинол холбогч уураг (РХУ), 25-гидрооксид Д аминдэм [25(OH)D], альфа–1 ацидгликопротеин (АГП), шээсний иодын агууламж тодорхойлох сорилыг ашиглан бичил тэжээлийн дутлыг үнэлсэн. Эдгээр сорилын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг “Биохимийн шинжилгээний арга” хэсэгт тусгав. Судалгаагаар тодорхойлсон хоол тэжээлийн үзүүлэлтүүд, тэдгээрийг үнэлэхэд ашигласан аргыг нэгтгэн 4-р хүснэгтэд тоймлон үзүүлэв.

Хүснэгт 4. Хоол тэжээлийн үндсэн үзүүлэлт, тэдгээрийг үнэлсэн арга

Зорилтот бүлэг	Хоол тэжээлийн үзүүлэлт	Үнэлгээний арга
Өрх	Хүнсний баталгаат байдал	Асуулга
	Нийгэм эдийн засаг, амжиргааны түвшин	Асуулга
	Ус, ариун цэвэр	Асуулга
	Иоджуулсан давсны хэрэглээ	Давс дахь иодын агууламжийг титрийн аргаар тодорхойлсон.
5 хүртэлх насны хүүхэд	НБНХХ-ын дадал <ul style="list-style-type: none"> <li>Эхийн сүүгээр хооллолт</li> <li>Нэмэгдэл хооллолт</li> </ul>	Асуулга/24 цагийн эргэн дурсах арга
	Хоол тэжээлийн байдал <ul style="list-style-type: none"> <li>Туранхай</li> <li>Тураал</li> <li>Өсөлт хоцролт</li> <li>Илүүдэл жин</li> </ul>	Нас, хүйс, биеийн жин, урт/өндрийг хэмжилт
	Рахитын тархалт	Эмнэлзүйн үзлэг
	Аминдэм, эрдэсийн бэлдмэлийн хэрэглээ <ul style="list-style-type: none"> <li>А аминдэм</li> <li>Д аминдэм</li> <li>Төмөр</li> <li>Олон найрлагат бичил тэжээлийн холимог</li> <li>Бусад бичил тэжээл</li> </ul>	Асуулга
	Цус багадалт	Гемокью–301 фотометр ашиглан судалгааны талбарт захын цусны гемоглобины хэмжээг тодорхойлсон.
6-59 сартай хүүхэд	Бичил тэжээлийн дутал <ul style="list-style-type: none"> <li>Төмөр</li> <li>А аминдэм</li> <li>Д аминдэм</li> </ul>	Ийлдэс дэх ферритин, sTfR, РХУ, 25(OH)D, СИУ, АГП тодорхойлсон.
ЕБС-ийн 1–12 дугаар ангийн суралцагчид	Хоол тэжээлийн байдал <ul style="list-style-type: none"> <li>Туранхай</li> <li>Өсөлт хоцролт</li> <li>Илүүдэл жин</li> <li>Таргалалт</li> </ul>	Нас, хүйс, биеийн жин, урт/өндрийг хэмжсэн

	Иодын дутал (6- 11 нас)	Шээсэн дэх иодын агууламжийг хэмжсэн
	Иод дутал, иоджуулсан давсны талаарх ойлголт	Асуулга
	Эрүүл бус хүнсний хэрэглээ	Асуулга
	ЕБС-ийн бага ангийн суралцагчдын үдийн хоолны талаарх сэтгэл ханамж	Асуулга
	Хөдөлгөөний идэвх	Асуулга
Жирэмсэн эмэгтэй	Хоол тэжээлийн байдал <ul style="list-style-type: none"> <li>Туранхай</li> </ul>	Зүүн гарын бугалганы дунд хэсгийн тойргийг хэмжсэн
	<ul style="list-style-type: none"> <li>Хэт намхан</li> </ul>	Биеийн өндрийг хэмжсэн.
	Цус багадалт	Гемокью–301 фотометр ашиглан судалгааны талбарт захын цусны гемоглобины хэмжээг тодорхойлсон.
	Бичил тэжээлийн дутал <ul style="list-style-type: none"> <li>Төмөр</li> <li>А аминдэм</li> <li>Д аминдэм</li> <li>Иод</li> </ul>	Ийлдэс дэх ферритин, sTfR, PXY, 25(OH)D, СИУ, АГП; шээсэн дэх иодын агууламжийг тодорхойлсон.
	Аминдэм, эрдэсийн бэлдмэлийн хэрэглээ <ul style="list-style-type: none"> <li>Д аминдэм</li> <li>Төмөр, фолийн хүчил</li> <li>Олон найрлагат тэжээлийн бэлдмэл</li> <li>Бусад бичил тэжээл</li> </ul>	Асуулга
	Иод дутал, иоджуулсан давсны талаарх ойлголт	Асуулга
	Хооллолтын чанар, хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Асуулга (DQQ) / 24 цагийн эргэн дурсах арга
	НБНХХ-ын талаарх мэдлэг	Асуулга
	ЖҮЭМТ-д хамрагдалт	Асуулга
Төрөх насны эмэгтэйчүүд (эхчүүд)	Хоол тэжээлийн байдал <ul style="list-style-type: none"> <li>Тураал</li> <li>Илүүдэл жин</li> <li>Таргалалт</li> <li>Хэт намхан</li> </ul>	Биеийн жин, өндрийг хэмжсэн.
	Цус багадалт	Гемокью–301 фотометр ашиглан судалгааны талбарт захын цусны гемоглобины хэмжээг тодорхойлсон.
	Аминдэм, эрдэсийн бэлдмэлийн хэрэглээ	Асуулга
	Хооллолтын чанар, хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Асуулга (DQQ) / 24 цагийн эргэн дурсах арга
	НБНХХ-ын талаарх мэдлэг, дадал	Асуулга
	ТӨЭМТ-д хамрагдалт	Асуулга
15-49 насны эрэгтэйчүүд	Хоол тэжээлийн байдал <ul style="list-style-type: none"> <li>Тураал</li> <li>Илүүдэл жин</li> <li>Таргалалт</li> </ul>	Биеийн жин, өндрийг хэмжсэн.
	Цус багадалт	Гемокью–301 фотометр ашиглан судалгааны талбарт захын цусны гемоглобины хэмжээг тодорхойлсон.
	Бичил тэжээлийн дутал <ul style="list-style-type: none"> <li>Төмөр</li> <li>А аминдэм</li> <li>Д аминдэм</li> </ul>	Ийлдэс дэх ферритин, sTfR, PXY, 25(OH)D, СИУ-ийн агууламжийг тодорхойлсон.
	Хооллолтын чанар, хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Асуулга (DQQ) / 24 цагийн эргэн дурсах арга

#### 4.6 Биологийн сорьц, давсны дээж цуглуулалт

Судалгаанд хамрагдсан 6–59 сартай хүүхэд, тэдний эхчүүд, жирэмсэн эмэгтэйчүүдийн хураагуур судасыг хатгаж, шинжилгээнд цус авах стандарт үйлдэлд сургагдсан лабораторийн ажилтан (сувилахуйн эрх бүхий сувилагч)-ууд 6-59 сартай хүүхэд (цус багадалтыг илрүүлэх зорилгоор 2-59 сартай хүүхдийн захын судаснаас цусны дээж авсан), жирэмсэн эмэгтэй, төрөх насны эхчүүд, сургуулийн хүүхдээс цусны дээж авсан. Хольцгүй вакуум сорогч ашиглан 4-5 мл цус авч, нарны шууд тусгалаас далд, зориулалтын тусгай саванд хийж сум болон өрхийн ЭМТ хүртэл тээвэрлэсэн. Цусны дээжийг хурилдуулж, ийлдсийг ялган нэг удаагийн хэрэглээний хуванцар соруул ашиглан 2 бичил хуруу шилэнд хуваан хийж хөлдөөсөн бөгөөд  $-20^{\circ}\text{C}$  нөхцөлд тээвэрлэн НЭМҮТ-д, улмаар ХБНГУ-ын “ВитМин”, Улаанбаатар хот дахь “Гялс” анагаах ухааны төвийн лабораторид тус тус хүргэсэн.

Лабораторийн ажилтан судалгаанд оролцогчдоос шээсний дээж цуглуулж, нэг удаагийн хэрэглээний хуванцар соруул ашиглан бичил хуруу шилэнд таслан авч, гэрлээс далд сэрүүн нөхцөлд тээвэрлэн НЭМҮТ-ийн лабораторид хүргэсэн. Судалгааны өрхөөс цуглуулсан давсны дээж (30 г)-ийг нийлэг уутанд хийж, гэрлээс далд нөхцөлд тээвэрлэн НЭМҮТ-ийн лабораторид хүргэн, шинжилгээ хийсэн. Судалгаагаар цуглуулсан биологийн сорьц болон өрхийн давсны дээжтэй харьцсан ажилбарыг тоймлон 5-р хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5. Биологийн сорьц болон өрхийн давсны дээж цуглуулах ажилбар

Биологийн сорьц	Хоол тэжээлийн үзүүлэлт	Биомаркер	Сорьцтой харьцах ажилбар
Захын цус	Цус багадалт	Гемоглобин	Судалгааны талбарт шинжилгээ хийсэн.
Хураагуурын цус: ийлдэс	Төмөр дутал	Ферритин	Цусны дээжийг хурилдуулж, ийлдсийг ялган авч хөлдөөсөн. Ийлдсийг хайлахаас сэргийлж, $-20^{\circ}\text{C}$ хадгалсан.
		Уусдаг трансферрин рецептор	
	А аминдэм дутал	Ретинол холбогч уураг	
	Д аминдэм дутал	25-гидрооксид Д аминдэм (25[ОН] D)	
Үрэвслийн үзүүлэлт	С – илэвхт уураг	Альфа-1 ацид гликопротеин	
Шээс	Иод дутал	Иод	Нэг удаагийн шээснээс 1.5–2.0 мл-ыг бичил хуруу шилэнд таслан авч, хадгалсан. Шээсний дээжийг тээвэрлэхэд тусгай шаардлага тавихгүй.
Давс	Иодын хангамж	Иод	Хуурай, нийлэг уутад хийж, гэрлээс далд хадгалсан. Давсны дээжийг



			тээвэрлэхэд тусгай шаардлага тавихгүй.
--	--	--	----------------------------------------

#### 4.7 Биохимийн шинжилгээний арга

Жирэмсэн эмэгтэй, 6-59 сартай хүүхэд, төрөх насны эмэгтэйчүүдийн ийлдэст ферритин, уусдаг трансферрин рецептор (sTfR), C-идэвхт уураг (СИУ), альфа-1-ацид гликопротеин (АГП), ретинол холбогч уураг (РХУ)-ын агууламжийг тодорхойлох шинжилгээг ХБНГУ-ын “ВитМин” лабораторид 5 баганат фермент холбоот дархлааны урвал (ФХДУ)-ын аргаар гүйцэтгэсэн[16]. Судалгаагаар тодорхойлсон СИУ, АГП нь үрэвслийн биомаркерууд бөгөөд тэдний геометрийн дундаж үзүүлэлтээр өвчний далд үе, эдгэрэлтийн эрт болон хожуу үеийг тодорхойлж, жирэмсэн эмэгтэй, 6-59 сартай хүүхэд, эмэгтэйчүүдийн ийлдэс дэх ферритин, РХУ-ын хэмжээнд тохируулга хийхэд ашигласан [17, 18].

Цус багадалтыг илрүүлэх зорилгоор Гемокью® Hb 301 фотометр (HemoCue AB, Sweden) багаж ашиглан жирэмсэн эмэгтэй, төрөх насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, 2-59 сартай хүүхэд, ЕБС-ийн суралцагчдын захын цусны гемоглобины агууламжийг судалгааны талбарт шууд тодорхойлсон. Цус багадалтыг тодорхойлохын тулд цусан дахь гемоглобины агууламжийг тухайн орон нутгийн далайн түвшнээс дээш өргөгдсөн хэмжээ, тамхины хэрэглээг харгалзан тохируулга хийв [20].

Жирэмсэн эмэгтэй, төрөх насны эхчүүд, 6-59 сартай хүүхэд, ЕБС-ийн хүүхдийн ийлдэст Д аминдэм тодорхойлох шинжилгээг “Гялс” анагаах ухааны төвийн лабораторид гүйцэтгэсэн. Франц Улсын “MINI VIDAS® анализатор” (BioMerieux, France) ашиглан фермент холбоот дархан туяарах аргаар ийлдэс дэх 25(OH) Д аминдэмийн агууламжийг тодорхойлсон.

Жирэмсэн эмэгтэй, ЕБС-ийн 6-11 насны хүүхдийн шээс дэх иодын агууламж тодорхойлох шинжилгээг НЭМҮТ-ийн лабораторид гүйцэтгэсэн [21]. Энэхүү шинжилгээг Сандэл-Колтоффийн урвалд үндэслэн, фермент холбоот дархлааны урвалын аргаар Япон Улсын “Immuno Mini NJ2300” бичил самбар уншигчийг ашиглан гүйцэтгэсэн бөгөөд үр дүнг 405 нм-т хэмжсэн. Шинжилгээний аргын мэдрэг чанар 10 мкг/л байв. Сөрөг үр дүн илэрсэн шинжилгээний дээжийг статистик боловсруулалтаас хассан болно.

Давсны иодын агууламж тодорхойлох шинжилгээг НЭМҮТ-ийн лабораторид титрийн аргаар гүйцэтгэсэн бөгөөд уг аргын мэдрэг чанар 1.1 мг/кг байв [22]. Давсыг иоджуулахдаа ашигласан кали иодат (KIO<sub>3</sub>)-ын иодын агууламжийг тодорхойлохдоо урвуу титрийн аргыг ашигласан. Давсны иодын агуулгыг хэмжихдээ хүчиллэг орчин (хүхрийн хүчил)-д иодатаас иодын ионыг салгах, улмаар ялгарсан чөлөөт иодыг натрийн тиосульфатаар титрлэх зарчмыг ашигласан. Титрлэхэд ашигласан натрийн тиосульфатын хэмжээ нь уг давсны дээж дэх иодын агууламжтай тэнцүү байдаг.

#### **4.8 Судалгааны мэдээллийн шивэлт, цэвэрлэгээ**

Судалгааны мэдээлэл цуглуулсан 7 төрлийн асуулга (5 хүртэлх насны хүүхэдтэй өрх, 0-59 сартай хүүхэд, жирэмсэн эмэгтэй, 15-49 насны эхчүүд, 15-49 насны эрэгтэйчүүд, ЕБС-ийн 6–11 нас, 12–18 насны хүүхэд)-ын хуудас дахь мэдээллийг “EpiData 3.1” программын орчинд үүсгэсэн мэдээллийн баазад давтан шивэлтээр шивж оруулсан. Судалгааны мэдээллийн алдааг шууд илрүүлэх, залруулах боломжтой EpiData программыг ашиглан мэдээллийн чанарыг баталгаажуулах дараах 2 аргыг ашигласан. Үүнд:

удалгааны мэдээллийг шивэхийн өмнө түүнийг идэвхтэй шалгах механизмыг мэдээллийн программд урьдчилан суулгасан. Өөрөөр хэлбэл, мэдээлэл орхигдохоос сэргийлж тухайн хувьсагчийн мэдээллийг заавал оруулах, программд шивж оруулах тоон мэдээлэл нь тодорхой хязгаартай байх (жишээ: хүүхдийн насыг сараар, программд оруулах тоон хязгаар нь 0-59 байх), мэдээлэл оруулах дарааллыг баримтлан, алгасах зарчмыг программын орчинд урьдчилан суулгасан юм. Түүнчлэн, боломжтой тохиолдолд зөвхөн асуулгын хуудас дахь хариултын хувилбарын тоон мэдээллийг оруулах хязгаарлалт хийсэн.

удалгааны бүх мэдээллийг 2 удаагийн давтан шивэлтээр мэдээллийн баазад оруулсан бөгөөд EpiData программыг ашиглан асуулт тус бүрийг баталгаажуулах хяналт хийсэн болно. Судалгааны мэдээллийн 2 файлыг харьцуулан шалгаж, ялгаатай хувилбарыг илрүүлэн асуулгын хуудас дахь эх мэдээлэлтэй харьцуулан жишиж, шаардлагатай тохиолдолд залруулга хийсэн.

EpiData программын орчинд үүсгэж, баталгаажуулсан мэдээллийг “SPSS–26” программд хөрвүүлж, нэмэлт цэвэрлэгээ (хязгаарын болон утгын) болон баталгаажуулалтыг давтан гүйцэтгэсэн. Ингэхдээ мэдээллийн бааз дахь хувьсагч тус бүрийн давтамжийн тархцыг шалгаж, хэвийн бус утга, зохих хязгаараас хэтэрсэн тохиолдол, илэрхий буруу хариултын хувилбарыг илрүүлж, цэвэрлэгээ хийв.

Илэрхий буруу утгыг асуулгын хуудас дахь эх мэдээлэлтэй харьцуулан шалгасан. Бүх үзүүлэлтийн тархалтын түвшнийг тооцохдоо зорилтот бүлэг (өрх, 5 хүртэлх насны хүүхдүүд, 15-49 насны эхчүүд, ЕБС-ийн 1–5 дугаар анги, 6–12 дугаар ангийн суралцагчид, жирэмсэн эмэгтэйчүүд, 15-49 насны эрэгтэйчүүд)-ийн түүврийн жинг тооцсон. Хоол тэжээлийн үндэсний VI судалгааны үр дүнгийн боловсруулалт хийхдээ түүврийн жинг ашигласан болно.

#### **4.9 Судалгаа мэдээлэл боловсруулалт**

Судалгааны мэдээллийг “SPSS for Windows” программын 26 дахь хувилбарыг ашиглан 3 шатлалаар боловсруулсан. Эхний шатанд бичил тэжээлийн дутлыг илрүүлэх судалгааны протокол (Micronutrient survey manual)[23] -ыг ашиглан түүврийн жинг тооцоолж, мэдээллийн

баазад нэгтгэх ажлыг гүйцэтгэсэн болно. Энэ шатанд хувьсагч бүрийн вариацийн коэффициентийг тооцоолж, тэдгээрийн дугаарлалт (recode), хувиргалт (transformation) болон тооцооллыг баталгаажуулах хяналт хийсэн. Хоёр дахь шатанд, судалгааны бүх үзүүлэлтийн тойм (descriptive) дүн шинжилгээг хийж, тархалтын түвшинг тогтооход шаардлагатай тоон харьцаа (proportions), дундаж болон голч хэмжээг тооцсон. Үндэсний түвшинд тархалтын хэмжээг тооцохдоо түүврийн 5 бүлэг дэх түүврийн нэгжийн сонгогдох магадлал харилцан адилгүй байгааг харгалзан түүврийн жинг ашигласан. Иймд судалгааны үр дүнгийн хүснэгтэд жинлэсэн хувь болон жинлээгүй тоон үзүүлэлтийг тусгасан. Статистик боловсруулалтын 3 дахь шатанд 2 хувьсагч (bivariate)-ийн дүн шинжилгээ (chi-square, t-test)-г гүйцэтгэж, үндсэн хамаарах хувьсагч (key dependent variables) болон нөлөөлж буй үл хамаарах хувьсагч (influencing independent variables) хоорондын хамаарлыг судалсан. Бүх үзүүлэлтийн статистик нарийвчлалыг “нийлмэл бүлэглэсэн түүвэр судалгааны загвар (complex stratified cluster sampling design)”-т ашигладаг 95 хувийн итгэх хязгаараар үнэлсэн. Зорилтот хүн амын дунд тодорхойлсон нийгэм, хүн ам зүй, антропометрийн болон биомаркерийн үндсэн үзүүлэлтийг тодорхойлоход ашигласан арга зүйг 6 ба 7 дугаар хүснэгтэд нэгтгэн харуулав.

#### Хүснэгт 6. Өрхийн аж байдал, хооллолт, антропометрийн үзүүлэлтийн ангилал

Үзүүлэлт	Ангилах арга
Өрхийн аж байдлын индекс [24]	“Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-нд өрхийн аж байдлын индексийг тооцсон синтаксийг ашигласан.
Өрхийн хүнсний баталгаат байдлын алдагдлын хэмжээ (FIES) [25]	НҮБ-ын ХХААБ-ын хүнсний баталгаат байдлын алдагдал (FIES)-ыг тооцох 8 стандарт асуултыг ашиглан тодорхойлсон.
Хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, ХБӨ-өөс сэргийлэх ба ХБӨ-ний эрсдэлийн оноо [26]	Хооллолтын чанарын асуулга (ХЧА)-ыг хувь хүний хооллолтын дадлыг хялбаршуулсан байдлаар хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлөөр үнэлэхээр зохиосон болно. Хүнсний бүтээгдэхүүнийг нийт 29 бүлэгт ангилж, бүлэг тус бүрд шим, тэжээллэг чанар, биологийн болон хүнсний шинж байдлаар ижил төстэй багц бүтээгдэхүүнийг багтаасан юм.
Эрүүл бус хүнсний хэрэглээ [27]	МУ-д 2010 онд зохион байгуулсан “Дэлхийн сурагчдын эрүүл мэндийн судалгаа”-ны асуулга, үзүүлэлтийг ашигласан.
Нялх, бага насны хүүхдийн хооллолтын үзүүлэлтүүд [28]	ДЭМБ-аас боловсруулсан НБНХХ-ыг үнэлэх үзүүлэлтийг ашиглав.
0-59 сартай хүүхдийн антропометрийн хэмжилт[29]	Хүүхдийн өсөлтийн ДЭМБ-ын стандартыг ашиглан “ANTHRO” программаар тооцоолж, дараах шалгуураар үнэлсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Туранхай: &lt; -2 СХ Жин – Өндөр Z оноо</li> <li>• Өсөлт хоцролт: &lt; -2 СХ Өндөр – Нас Z оноо</li> <li>• Тураал: &lt; -2 СХ Жин – Нас Z оноо</li> <li>• Илүүдэл жин: &gt; +2 СХ Жин – Өндөр Z оноо</li> </ul>
6–18 настай хүүхдийн антропометрийн хэмжилт[30]	ДЭМБ-аас зөвлөсөн 5–19 насны хүүхдийн өсөлтийн лавлагаа хэмжээг ашиглан “AntroPlus” программаар тооцоолж, дараах шалгуураар үнэлсэн. <ul style="list-style-type: none"> <li>• Туранхай &lt; - 2 СХ БЖИ – Нас Z оноо</li> <li>• Өсөлт хоцролт &lt; -2 СХ Өндөр – Нас Z оноо</li> <li>• Илүүдэл жин &gt; +1 СХ БЖИ – Нас Z оноо</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• Таргалалт &gt; +2 СХ БЖИ – Нас Z оноо</li> </ul>
Эхчүүд, эрэгтэйчүүдийн антропометрийн хэмжилт[31]	<p>БЖИ-ийг тооцоолж, дараах шалгуураар үнэлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Тураал: &lt; 18.5 кг/м<sup>2</sup></li> <li>• Хэвийн жин: 18.5-24.9 кг/м<sup>2</sup></li> <li>• Илүүдэл жин: 25.0-29.9 кг/м<sup>2</sup></li> <li>• Таргалалт: ≥ 30.0 кг/м<sup>2</sup></li> </ul> <p>Намхан эмэгтэй: биеийн өндөр &lt; 145 см Намхавтар эмэгтэй: биеийн өндөр &lt; 150 см</p>

ХЧА-аар цуглуулсан мэдээлэлд “Дэлхийн хооллолтын чанар” төслийн багийн боловсруулсан шалгуурууд, түүнийг тооцох удирдамжийг ашиглан дүн шинжилгээ хийж, дараах үзүүлэлтийг төрөх насны эхчүүд, жирэмсэн эмэгтэйчүүд, 15–49 насны эрэгтэйчүүдийн дунд тодорхойлсон болно (Хүснэгт 7) [32].

#### Хүснэгт 7. Хооллолтын чанарын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Тодорхойлолт
5 нэр төрлийн хүнс хэрэглэсэн хүн амын хувь (All–5)	Жимс; Ногоо; Шош, буурцаг, самар үр; Мал амьтны гаралтай хүнс; Цардууллаг хүнс хэрэглэсэн ≥15 насны хүн амын хувь
ХБӨ-өөс сэргийлэх оноо (NCD–Protect)	<p>ДЭМБ-ын эрүүл хооллолтын зөвлөмжид заасан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг илэрхийлэх шалгуур үзүүлэлт юм.</p> <p>ХЧА-д багтсан 9 бүлэг хүнсний бүтээгдэхүүний хэрэглээгээр уг шалгуурыг 0–9 оноогоор тооцож, үнэлнэ.</p> <p>Оноо их байвал эрүүл хооллож ХБӨ-өөс сэргийлэх боломж их байгааг илтгэнэ.</p>
ХБӨ-ний эрсдэлийн оноо (NCD–Risk)	<p>ХБӨ-өөс сэргийлэхэд чиглэсэн ДЭМБ, Хавдар судлалын олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжид тусгасан эрүүл бус хүнсний хэрэглээг илэрхийлэх шалгуур үзүүлэлт юм.</p> <p>ХЧА-д багтсан 8 бүлэг хүнсний бүтээгдэхүүний хэрэглээгээр уг шалгуурыг 0–9 оноогоор тооцож, үнэлнэ.</p> <p>Оноо их байвал ХБӨ-өөр өвчлөх эрсдэл их байгааг илтгэнэ.</p>
Эрүүл хооллолтын оноо (Global Dietary Recommendation score–GDR score)	<p>ДЭМБ-ын эрүүл хооллолтын зөвлөмжийн хэрэгжилтийг илтгэх шалгуур үзүүлэлт юм.</p> <p>ХЧА-аар тогтоосон ХБӨ-өөс сэргийлэх оноо болон ХБӨ-ний эрсдэлийн онооны ялгааг тодорхойлж, 0–18 оноогоор үнэлнэ.</p> <p>Оноо их байх нь сайн үзүүлэлт болно.</p>
Ногоо, эсвэл жимс огт хэрэглээгүй хүн ам	Судалгааны өмнөх 24 цагт хүнсний ногоо эсвэл жимс огт хэрэглээгүй ≥15 насны хүн амын хувь
Чихэрлэг, хийжүүлсэн ундааны хэрэглээ	Судалгааны өмнөх 24 цагийн хугацаанд чихэр нэмсэн, хийжүүлсэн, энергийн ундаа хэрэглэсэн ≥15 насны хүн амын хувь
Хоногт хэрэглэвэл зохих хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан хүн ам	Судалгааны өмнөх 24 цагт 10 бүлэг <sup>a</sup> хүнсний бүтээгдэхүүнээс ≥5 нэр төрлийн хүнс хэрэглэсэн ≥15 насны хүн амын хувь

<sup>a</sup> Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл буюу 10 бүлэг хүнс: i) Цардууллаг хүнс – үр тариа, булцуут үндэст ургамал; ii) буурцагт ургамал – шош, вандуй; iii) самар ба үр; iv) сүү, цагаан идээ; v) малын мах, тахиа, загас; vi) өндөг; vii) гүн ногоон навчит ногоо; viii) А аминдэмээр баялаг ногоо, жимс, ix. Бусад ногоо; x) Бусад жимс.

Хоногт хэрэглэсэн хүнсний нэр төрлийн оноо	Судалгааны өмнөх 24 цагт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг илтгэх тоон үзүүлэлт
--------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------

### Хүснэгт 8. “Биомаркер” үзүүлэлтийн босго хэмжээ, эмнэлзүйн ангилал

Үзүүлэлт		Лавлагаа хэмжээ		
<b>Гемоглобин<sup>[20]</sup></b>		<b>Хөнгөн цус багадалт</b>	<b>Хүндэвтэр цус багадалт</b>	<b>Хүнд цус багадалт</b>
Хүүхэд <5 нас <sup>b</sup>		100-109 г/л	70-99 г/л	< 70 г/л
Эхчүүд, 15-49 нас <sup>2,c,dd</sup>		110-119 г/л	80-109 г/л	< 80 г/л
Жирэмсэн эмэгтэй <sup>2,3</sup>		100-109 г/л	70-99 г/л	< 70 г/л
Эрэгтэйчүүд, 15-49 нас <sup>2</sup>		110-129 г/л	80-109 г/л	< 80 г/л
<b>Ферритин<sup>[18]</sup></b>		<b>Төмөр дутал</b>	<b>Төмөр хангалттай</b>	<b>Төмрийн илүүдэл</b>
Хүүхэд, < 5 нас <sup>e</sup>		< 12 мкг/л		
Жирэмсэн, төрөх насны эмэгтэйчүүд <sup>f</sup>		< 15 мкг/л	5-200 мкг/л	> 200 мкг/л
<b>Уусдаг трансферрин рецептор<sup>f</sup></b>		<b>Төмөр дутал</b>		
Хүүхэд, < 5 нас		> 8.3 мг/л		
Жирэмсэн эмэгтэйчүүд		> 8.3 мг/л		
Эрэгтэйчүүд, 15-49 нас		> 8.3 мг/л		
<b>Төмрийн нөөц<sup>[33]</sup></b>		<b>T</b>		
<b>Ретинол холбогч уураг<sup>[18]</sup></b>		<b>A аминдэм дутал</b>	<b>A аминдэмийн нөөц бага</b>	<b>A аминдэм хангалттай</b>
Хүүхэд, < 5 нас <sup>g</sup>		< 0.7 мкмол/л	≥ 0.7 ба ≤ 1.05	> 1.05 мкмол/л
Жирэмсэн эмэгтэй <sup>g</sup>		< 0.7 мкмол/л	≥ 0.7 ба ≤ 1.05	> 1.05 мкмол/л
Төрөх насны эмэгтэй <sup>g</sup>		< 0.7 мкмол/л	≥ 0.7 ба ≤ 1.05	> 1.05 мкмол/л
<b>25(OH) D<sup>h</sup></b>	<b>D аминдэм дутал</b>	<b>D аминдэмийн нөөц дутмаг</b>	<b>D аминдэм хангалттай</b>	<b>D аминдэмийн хордлого</b>
Хүүхэд, < 5 нас	< 20 нг/мл	20-29 нг/мл	30-100 нг/мл	> 100 нг/мл
Жирэмсэн эмэгтэйчүүд	< 20 нг/мл	20-29 нг/мл	30-100 нг/мл	> 100 нг/мл
Эрэгтэйчүүд, 15-49 нас	< 20 нг/мл	20-29 нг/мл	30-100 нг/мл	> 100 нг/мл
<b>Шээс дэх иодын голч хэмжээ<sup>g</sup></b>	<b>Иод дуталтай</b>	<b>Иод хангалттай</b>	<b>Иодын илүүдэл</b>	
Хүүхэд, 6-11 нас	< 100 мкг/л	100-299 мкг/л	≥ 300 мкг/л	
Жирэмсэн эмэгтэйчүүд		1	≥ 500 мкг/л	

<sup>b</sup> Altitude (metres above sea level) haemoglobin adjustment (r/n): < 1000 m: 0; 1000 m: -2; 1500 m: -5; 2000 m: -8; 2500 m: -13; 3000 m: -19; 3500 m: -27; 4000 m: -35; 4500 m: -45.

<sup>c</sup> Smoking haemoglobin adjustment (r/n): non-smoker: 0; smoker (all): -0.3; ½ to 1 packet/day: -0.3; 1-2 packets/day: -0.5.

<sup>d</sup> Only mothers 15-49 who were not pregnant were included in the analysis.

<sup>e</sup> Serum ferritin values were adjusted for inflammation in pregnant women and men (0.77, 0.53, 0.75) and for children 6-59 months of age (0.798, 0.62, 0.98) for the incubation, early, and late convalescent groups, respectively.

<sup>f</sup> There is no generally agreed upon threshold for soluble transferrin receptor, but the most commonly used commercial assay (Ramco) suggests the cut-offs indicated.

<sup>g</sup> RBP values were adjusted for inflammation in pregnant women and men (1.13, 1.24, 1.11) and for children 6-59 months of age (1.15, 1.45, 1.11) for the incubation, early, and late convalescent groups, respectively<sup>g,9</sup> No established thresholds have been developed for RBP; however, RBP was corrected by a multiplication of 1.15 for good correlation between RBP and serum retinol.

<sup>h</sup> No common definition exists for adequate vitamin D status measured as 25(OH)D serum concentration. Cut-offs provided are based on Holick et al. Evaluation, treatment, and prevention of vitamin D deficiency: An Endocrine Society clinical practice guideline, J Clin Endocrinol Metab 2011;96(7):1911-30.

<b>α1-ацид-гликопротеин<sup>1</sup></b>	
Хүүхэд, < 5 нас	> 1 г/л
Жирэмсэн эмэгтэйчүүд	> 1 г/л
Төрөх насны эмэгтэйчүүд	> 1 г/л
<b>С-идэвхт уураг<sup>[34]</sup></b>	
Хүүхэд, < 5 нас	> 5 мг/л
Жирэмсэн эмэгтэйчүүд	> 5 мг/л
Төрөх насны эмэгтэйчүүд	> 5 мг/л

#### **4.10 Судалгааны арга зүйн хязгаарлагдмал байдал**

“Монгол улсын Хүн Амын Хоол Тэжээлийн Байдал” үндэсний VI судалгааг тархвар зүйн судалгааны агшны аргаар гүйцэтгэсэн тул тархвар зүйн бусад судалгааны адил зарим хязгаарлагдмал байдалтай болно. Хамгийн гол хязгаарлагдмал асуудал нь судалгаагаар тооцсон хувьсагч хоорондын хамаарлын талаар шалтгаан зүйн дүгнэлт гаргах боломжгүй байна. Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг намрын сүүлч, өвлийн эхэн үе буюу 2023 оны 9-11 дүгээр сард гүйцэтгэсэн тул судалгаанаас гарах үр дүнд улирлын хамаарал, ялгааг тусгах боломжгүй болно. Мөн судалгаанд зөвхөн 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийг хамруулсан тул судалгаагаар тогтоосон өрхийн үзүүлэлтүүд нь МУ-ын нийт өрхийн шинж байдлыг илэрхийлж чадахгүй юм.

Энэхүү судалгаанд 5 хүртэлх насны хүүхэд, ЕБС-ийн суралцагчид хамрагдсан тул судалгааны үр дүн нь бусад насны хүүхэд, сургууль завсардсан хүүхдийн хооллолт, хоол тэжээлийн байдлыг илтгэх боломжгүй юм. Орон нутгийн засаг захиргааны нэгж, сум, өрхийн ЭМТ-өөс ирүүлсэн өрх, 5 хүртэлх насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийн бүртгэлийг ашиглан судалгаанд оролцогчийг сонгосон тул бүртгэлгүй өрх, сургууль завсардсан хүүхдийн судалгаанд хамрагдах боломж хязгаарлагдмал байв.

## Тав. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

### ӨРХИЙН СУДАЛГАА

#### Түүвэрлэлт, хамралт болон өрх, хүн амын шинж байдал

Хоол тэжээлийн үндэсний VI судалгааг Монгол улсын эдийн засгийн 4 бүс, Улаанбаатар хотын зорилтот бүлгийн хүн амыг хамруулан өргөн хүрээнд зохион байгуулав. Санамсаргүй түүвэрлэлтээр 2800 (0-59 сартай хүүхэдтэй) өрх сонгогдсоноос 2791 өрх судалгаанд бүрэн хамрагдаж, хамрагдалтын түвшин 99.7% байв (Хүснэгт НН.1а). Судалгаанд хамрагдсан өрхүүдэд ярилцлага өгвөл зохих 15-49 насны 2789 эхчүүд байснаас 2513 эх судалгаанд бүрэн хамрагдаж, хамрагдалтын түвшин 90.1% байв. Өрхийн судалгааны дэд бүлэг болгож, 15-49 насны 2789 эрэгтэйг судалгаанд хамруулахаар төлөвлөснөөс 1950 эрэгтэй судалгаанд хамрагдсан тул хамрагдалтын түвшин 69.9% байв. Судалгаанд хамрагдсан өрхүүдээс 11 өрх судалгаанд хамрагдахаас татгалзаж, 2789 өрхийн нийт 0-59 сартай 2786 хүүхдийг судалгаанд хамруулж, хамрагдалтын түвшин 99.5% байлаа. Сургуулийн 1-12 ангийн 4864 суралцагчид, 2800 жирэмсэн эмэгтэйг сонгосноос 4742 хүүхэд (хамрагдалтын түвшин 97.5%), 2796 жирэмсэн эмэгтэй (хамрагдалтын түвшин 99.8%) бүрэн хамрагдсан болно.

Хүснэгт НН.1а. Өрх, 0-59 сартай хүүхэд, 15-49 насны эхчүүд, 15-49 насны эрэгтэй, ЕБС-ийн 1–12 ангийн суралцагчид, жирэмсэн эмэгтэйн судалгааны үр дүн

Үзүүлэлтүүд	Үндэсний түвшинд	Бүсийн түвшинд				
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
<b>Өрх</b>						
Түүвэрт сонгогдсон		2800	560	560	560	560
Хамрагдсан		2	5	560	5	557
Хамрагдалтын түвшин (хувь)		9	9	100.0		99.5
<b>Тав хүртэлх насны хүүхэд</b>						
Хамрагдвал зохих		560	560	560	560	560
Бүрэн хамрагдсан	2786	557	553	560	556	560
Хамрагдалтын түвшин (хувь)	99.5	99.5	98.8	100.0	99.5	100.0
<b>Төрөх насны эхчүүд</b>						
Хамрагдвал зохих	2789	557	560	559	557	556
Бүрэн хамрагдсан	2513	516	483	524	489	501
Хамрагдалтын түвшин (хувь)	90.1	92.6	86.3	93.7	87.8	90.1
<b>15-49 насны эрэгтэй</b>						
Хамрагдвал зохих			560			
Бүрэн хамрагдсан		377	371	444	370	388
Хамрагдалтын түвшин (хувь)		67.7	66.3	79.4	66.4	69.8
<b>ЕБС-ийн 1–12 ангийн суралцагч</b>						
Хамрагдвал зохих						
Бүрэн хамрагдсан						
Хамрагдалтын түвшин (хувь)						
<b>Жирэмсэн эмэгтэй</b>						

Хамрагдвал зохих		560	560	560	560	560
Бүрэн хамрагдсан			560	560	560	
Хамрагдалтын түвшин (хувь)						

Хоол тэжээлийн үндэсний VI судалгаагаар цус багадалт, шээсэн дэх иодын агууламж тодорхойлоход эдийн засгийн 4 бүс, хүн амын бүлэг тус бүрийг төлөөлөхүйц, хангалттай хэмжээний сорьц цуглуулсан болно. Цус багадалтын шинжилгээний хамрагдалтын түвшин 5 хүртэлх насны хүүхдийн 96.6%, 1-12 дугаар ангийн суралцагчдын 99.7%, 15-49 насны эхчүүдийн 89.2%, жирэмсэн эмэгтэйчүүдийн 99.5%, 15-49 насны эрэгтэйчүүдийн 99.7% хамрагдсан. (Хүснэгт НН.1b). Шээсэн дэх иод болон натрийн агууламж тодорхойлох шинжилгээнд сургуулийн 6-11 насны суралцагчдын 91.8%, жирэмсэн эмэгтэйчүүдийн 98.7% нь тус тус хамрагдсан.

Хүснэгт НН.1b. Тав хүртэлх насны хүүхэд, ЕБС-ийн суралцагч, жирэмсэн эмэгтэй, төрөх насны эмэгтэй болон эхчүүд, 15-49 насны эрэгтэйчүүдийн цус багадалт, бичил тэжээлийн шинжилгээ, шээсний иодын агууламжийн үр дүн

Үзүүлэлтүүд	Үндэсний түвшинд	Бүсээр				
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
<b>Тав хүртэлх насны хүүхэд, Цус багадалтын шинжилгээ</b>						
Хамрагдвал зохих						
Хамрагдсан						
Хамрагдалтын түвшин (хувь)	96.6	97.3	95.0	97.5	95.0	93.5
<b>Тав хүртэлх насны хүүхэд, Бичил бодисын шинжилгээ</b>						
Хамрагдвал зохих						
Хамрагдсан						
Хамрагдалтын түвшин (хувь)	97.4	98.9	93.2	98.9	98.2	97.8
<b>ЕБС-ийн 1–12 дугаар ангийн суралцагч, Цус багадалтын шинжилгээ</b>						
Хамрагдвал зохих	3	240	240	240	240	252
Хамрагдсан	1213	242	229	238	271	233
Хамрагдалтын түвшин (хувь)	99.7	100.8	95.4	99.1	112.9	92.4
<b>ЕБС-ийн 1–12 дугаар ангийн суралцагч, Бичил бодисын шинжилгээ</b>						
Хамрагдвал зохих	608	120	120	120	120	128
Хамрагдсан	581	115	118	115	120	113
Хамрагдалтын түвшин (хувь)	95.5	95.8	98.3	95.8	100.0	88.3
<b>ЕБС-ийн 1–6 дугаар ангийн суралцагч, Шээсэнд иод тодорхойлох шинжилгээ</b>						
Хамрагдвал зохих	2432	480	480	480	480	512
Хамрагдсан	2232	465	445	459	416	447
Хамрагдалтын түвшин (хувь)	91.8	96.9	92.9	95.6	86.6	87.3
<b>Жирэмсэн эмэгтэй, Цус багадалтын шинжилгээ</b>						
Хамрагдвал зохих						
Хамрагдсан	2786	559	547	558	566	556
Хамрагдалтын түвшин (хувь)	99.5	99.8	97.7	99.6	101.7	99.3
<b>Жирэмсэн эмэгтэй, Бичил бодисын шинжилгээ</b>						
Төлөвлөсөн						
Хамрагдсан	1384	276	277	278	282	271
Хамрагдалтын түвшин (хувь)	98.8	98.6	98.9	99.3	100.7	96.8
<b>Жирэмсэн эмэгтэй, Шээсэнд иод тодорхойлох шинжилгээ</b>						
Төлөвлөсөн						
Хамрагдсан	2763	560	536	559	560	548
Хамрагдалтын түвшин (хувь)	98.7	100.0	95.7	99.8	100.0	97.8
<b>Төрөх насны эмэгтэй болон эхчүүд, Цус багадалтын шинжилгээ</b>						
Төлөвлөсөн	2789	557	560	559	557	556
Хамрагдсан	2488	512	478	521	483	494



Хамрагдалтын түвшин (хувь)	89.2	91.9	85.3	93.2	86.7	88.8
<b>Төрөх насны эмэгтэй болон эхчүүд, Бичил бодисын шинжилгээ</b>						
Төлөвлөсөн						
Хамрагдсан	1331	275	252	266	268	270
Хамрагдалтын түвшин (хувь)	95.1	98.2	90.0	95.0	95.7	96.4
<b>15-49 насны эрэгтэй, Цус багадалтын шинжилгээ</b>						
Төлөвлөсөн	400	80	80	80	80	80
Хамрагдсан	399	82	81	65	81	90
Хамрагдалтын түвшин (хувь)	99.7	102.5	101.2	85.0	101.2	112.5

## Орон сууцны нөхцөл, өрхийн хөрөнгө, эд зүйлс, аж байдлын түвшин

Өрхийн шинж байдлыг үндэсний түвшинд Хүснэгт НН.2а-д, хот, хөдөө болон бүсээр Хүснэгт НН.2б-д тус тус харуулав. Үндэсний түвшинд өрхийн ам бүлийн гишүүдийн дундаж тоо 4.8, эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь 3.7% байна. Бүсээр авч үзвэл Улаанбаатар хотод эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрх бусад бүстэй харьцуулахад их хувьтай байлаа (Хүснэгт

Хүснэгт НН. 2а. Өрхийн шинж байдал (Үндэсний түвшинд)

Үзүүлэлтүүд	%	Өрхийн тоо, %			Жинлээгүй тоо
		Стандарт алдаа	95% ИХ		
			Доод	Дээд	
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>2788</b>
<b>Өрхийн тэргүүний хүйс</b>					
Эрэгтэй		0.5	95.2	97.2	2686
Эмэгтэй		0.5	2.8	4.8	102
<b>Бүсээр</b>					
Баруун	11.3	0.3	10.8	11.9	556
Хангай	18.2	0.2	17.9	18.6	560
Төв	15.9	0.2	15.5	16.4	559
Зүүн	7.2	0.1	7.0	7.4	557
Улаанбаатар	47.2	0.4	46.4	48.1	556
<b>Хот, хөдөөгөөр</b>					
Хот	68.8	2.2	64.3	73.0	1478
Хөдөө	31.2	2.2	27.0	35.7	1310
<b>Байршлаар</b>					
Нийслэл	47.3	0.4	46.4	48.1	556
Аймгийн төв	21.5	2.2	17.6	26.1	922
Сум/ Баг	31.2	2.2	27.0	35.7	1310
<b>Өрхийн ам бүлийн тоо</b>					
	1.3	0.3	0.8	2.0	33
	15.2	1.2	13.0	17.7	385
	26.0	1.0	24.0	28.1	711
	29.5	1.1	27.3	31.7	822
	18.0	0.8	16.4	19.6	555
	6.6	0.7	5.4	8.1	190
	2.3	0.3	1.7	3.1	60
	1.2	0.3	0.7	1.8	32
Өрхийн ам бүлийн дундаж тоо	.8	0.4	4.7	4.9	2788
<b>Өрхийн тэргүүний шашин шүтлэг</b>					
Буддын шашин	30.2	1.3	27.6	32.9	776
Христийн шашин	1.0	0.3	0.6	1.6	19

Лалын шашин	2.9	0.6	1.9	4.4	173
Бөө, мөргөл	4.1	0.6	3.1	5.5	91
Шүтдэггүй	61.2	1.6	58.0	64.2	1716
Бусад	0.6	0.2	0.3	1.1	13
<b>Өрхийн тэргүүний нас</b>					
< 20 нас	1.4	0.4	0.8	2.4	30
20-29 нас	25.2	1.3	22.7	27.8	717
30-39 нас	54.0	1.3	51.4	56.7	1499
40-49 нас	16.6	0.9	14.8	18.5	472
> 49 нас	2.8	0.4	2.1	3.8	70
<b>Өрхийн орон байрны төрөл</b>					
Гэр	30.6	2.0	27.0	34.8	1057
Орон сууц	34.9	3.4	28.6	41.9	671
Хувийн тохилог сууц	1.9	0.4	1.3	2.8	89
Хашаа байшин	31.7	2.5	27.0	36.9	949
Нийтийн байр	0.6	0.2	0.3	1.1	22
<b>Өрхийн тэргүүний үндэс угсаа</b>					
Халх	83.2	1.3	80.6	85.5	2129
Казак	3.3	0.6	2.3	4.9	183
Дөрвөд	3.0	0.6	2.0	4.3	90
Буриад	1.8	0.4	1.2	2.6	68
Баяд	2.2	0.5	1.4	3.5	68
Дарьганга	0.6	0.2	0.3	1.2	39
Бусад	6.0	0.8	4.5	7.8	211

Төв, Зүүн, Хангай болон Баруун бүсээс судалгаанд хамрагдсан нийт өрхийн 50-иас дээш хувийг хөдөөгийн өрх, сум болон багт амьдардаг өрх Баруун бүсэд хамгийн их буюу 63.4%, Зүүн бүсийн өрхүүдийн 47.4% гэрт амьдарч байна (Хүснэгт НН.2b).

Хүснэгт НН.2b: Өрхийн шинж байдал (Үндэсний түвшинд)

Шинж байдал	Жин-лэсэн хувь	Хот, хөдөө, %		Бүс, %					Жин-лээгүй тоо
		Хот	Хөдөө	Баруун	Хангай	Төв	Зүүн	УБ	
<b>Бүгд</b>		100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	
<b>Өрхийн тэргүүний хүйс</b>									
Эрэгтэй	97.6	.9	97.2	97.6	95.7	96.5	95.6	96.3	2686
Эмэгтэй	3.7	4.1	2.8	2.4	4.3	3.5	4.4	3.7	102
<b>Хот, хөдөөгөөр</b>									
Хот	68.8	100.0	-	36.5	39.4	46.2	39.4	100.0	1478
Хөдөө	31.2	-	100.0	63.4	60.6	53.8	60.6	-	1310
<b>Байршлаар</b>									
Нийслэл	47.3	68.7	-	-	-	-	-	100.0	556
Аймгийн төв	21.5	31.3	-	36.5	39.4	46.2	39.4	-	922
Сум/ Баг	31.2	-	100.0	63.4	60.6	53.8	60.6	-	1310
<b>Өрхийн ам бүлийн тоо</b>									
	1.3	1.4	0.9	0.5	2.7	1.1	0.5	1.1	33
	15.2	15.4	14.8	10.7	18.4	14.7	9.7	16.1	385
	26.0	26.0	26.0	26.0	26.5	26.5	22.3	26.3	711
	29.5	29.8	28.8	28.7	26.5	30.5	32.5	30.0	822
	18.0	16.9	20.3	23.2	18.6	18.3	23.5	15.6	555
	6.6	6.4	7.1	8.0	4.5	5.8	8.2	7.1	190
	2.3	2.7	1.3	1.9	1.2	2.3	2.1	2.8	60
≥9	1.2	1.4	0.7	1.0	1.6	0.8	1.2	1.1	32

Ам бүлийн дундаж тоо	4.8	4.8	4.8	5.0	4	4.8	5	4.8	2788
<b>Өрхийн тэргүүний шашин шүтлэг</b>									
Будда	30.2	30.8	28.9	27.5	34.5	21.4	24.8	33.1	776
Христ	1.0	1.1	0.5	0.3	0.5	0.9	0.2	1.4	19
Лалын шашин	2.9	1.6	6.0	24.4	-	1.1	0.2	-	173
Бөө, мөргөл	4.1	4.8	2.6	0.4	3.0	3.5	4.0	5.7	91
Шүтдэггүй	61.2	61.1	61.3	46.8	61.6	72.3	70.8	59.2	1716
Бусад	0.6	0.5	0.6	0.6	0.4	0.9	-	0.6	13
<b>Өрхийн тэргүүний нас</b>									
< 20 нас	1.4	1.7	0.5	-	.4	0.7	1.2	1.9	30
20-29 нас	25.2	24.3	27.1	24.2	24.5	31.3	25.6	23.6	717
30-39 нас	54.0	54.3	53.4	59.0	54.3	47.8	52.7	55.0	1499
40-49 нас	16.6	16.4	17.0	15.0	15.2	19.2	18.5	16.4	472
> 49 нас	2.8	3.2	1.9	15.0	15.2	19.2	18.5	16.4	
<b>Өрхийн сууцны төрөл</b>									
Гэр	30.8	21.8	50.5	46.0	45.1	38.5	47.4	16.4	1057
Орон сууц	34.9	47.5	7.2	9.6	10.6	23.5	20.0	56.5	671
Хувийн тохилог сууц	1.9	1.3	3.3	12.0	0.5	0.2	1.8	0.7	89
Хашаа байшин	31.7	28.8	38.2	32.2	43.0	37.0	29.0	26.0	949
Нийтийн байр	0.6	0.5	0.9	0.2	0.7	0.9	1.8	0.4	22
<b>Өрхийн тэргүүний үндэс угсаа</b>									
Халх	83.2	85.8	77.4	.			.		
Казак	3.3	2.0	6.2	24.7	-	1.4	0.6	0.6	183
Дөрвөд	3.0	3.1	2.8	10.7	0.7	1.9	0.4	2.7	90
Буриад	1.8	1.9	1.5	0.2	0.4	0.7	8.8	2.0	68
Баяд	2.2	2.0	2.5	7.6	0.4	2.6	-	1.8	68
Дарьганга	0.6	0.4	1.1				6.1	0.3	39
Бусад		4.8	8.5	15.2	9.9	3.0	5.6	3.3	211

Өрхийн хөрөнгө, эд зүйлс болон тэдгээрийн өмчлөлийн талаарх мэдээллийг Хүснэгт НН.3-т харуулав. Эдийн засгийн аль бүсэд амьдарч байгаагаас үл хамааран, нийт өрхийн 90 гаруй хувь нь телевизортэй, харин өрхийн гишүүдийн 80-аас дээш хувь нь ухаалаг гар утастай байв. Газар тариалангийн газар эзэмшдэг өрхийн эзлэх хувь эдийн засгийн бүх бүсэд нийтлэг бага байсан ба Зүүн бүсэд хамгийн бага (5.5%), Баруун бүсэд хамгийн их (15.4%) байв. Мал, туслах аж ахуйн бусад амьтан (гахай, тахиа, шувуу)-тай өрхийн эзлэх хувь Зүүн бүс, Хангайн бүс, Баруун бүсэд ойролцоо 60 гаруй хувьтай, Төвийн бүсэд 37.2%, Улаанбаатар хотод хамгийн бага (13.5%) байв. Амьдарч буй газар болон орон байраа хувьдаа эзэмшдэг өрхийн эзлэх хувь эдийн засгийн бүх бүсэд их (Баруун 95.8%; Хангай өрхийн 97.4% нь банкинд данстай байсан.

Хүснэгт НН. 3. Өрхийн хөрөнгө, эд зүйлс

Эд зүйлс	Жинлэсэн хувь	Жинлээгүй тоо	Хот, хөдөөгөөр				Бүсээр									
			Хот		Хөдөө		Баруун		Хангай		Төв		Зүүн		Улаанбаатар	
			%	n	%	n	%	n	%	n	%	n	%	n	%	n
<b>Өрхийн эзэмшлийн эд зүйлс</b>																
Суурин утас	5.9	128	6.7	81	4.1	47	4.5	27	6.9	39	1.6	9	1.6	9	7.9	44
Радио	2.3	86	1.5	26	4.1	60	7.3	48	2.0	11	1.8	10	1.5	8	1.6	9
Буйдан	80.9	2124	86.2	1221	69.2	903	83.1	463	71.2	399	71.8	400	65.9	366	89.5	496
Хувцасны шүүгээ	93.4	2578	94.7	1390	90.4	1188	94.4	521	87.7	491	94.0	525	91.6	511	95.4	530
Унтлагын ор	84.2	2350	82.8	1214	87.2	1136	94.6	527	90.1	504	73.6	413	79.6	442	83.7	464
Телевизор	97.8	2701	98.2	1449	96.9	1252	97.3	529	97.3	543	98.0	548	96.2	535	98.3	546
Хөргөгч	89.7	2361	95.3	1368	77.1	993	84.0	455	77.8	435	89.1	498	77.2	431	97.7	542
Хөлдөөгч	66.5	1896	64.6	983	70.9	913	75.4	407	72.3	402	67.5	376	65.5	366	62.1	366
Тоос сорогч	53.2	1298	59.6	805	39.0	493	52.5	285	44.5	248	39.6	220	34.6	190	64.1	355
Богино долгионы зуух	39.0	957	42.9	565	30.3	392	34.7	197	28.4	158	34.3	192	26.7	148	47.5	262
Шарах шүүгээ	54.1	1323	61.5	834	37.8	489	52.1	292	39.4	220	42.2	236	37.3	204	66.9	371
Индүү	87.7	2304	92.2	1315	77.9	989	84.8	457	81.0	452	82.8	459	74.2	410	94.7	526
Холигч	44.8	1089	50.5	675	32.1	414	38.9	211	38.0	212	31.7	178	33.6	184	55.0	304
Халуун тогоо	48.2	1502	42.9	724	59.9	778	67.3	362	53.4	298	57.8	325	55.7	310	37.3	207
Будаа агшаагч	81.7	2112	86.8	1215	70.3	897	73.8	391	72.8	406	75.8	422	70.1	389	90.8	504
Хагас автомат угаалгын машин	66.1	2020	59.2	979	81.4	1041	80.1	432	81.1	451	76.8	429	75.1	418	52.1	290
Унадаг дугуй	38.2	1026	39.7	553	35.0	473	38.8	213	27.2	195	27.2	151	42.1	233	42.4	234
Мотоцикл	20.7	842	5.5	128	54.5	714	50.8	276	46.5	259	20.0	110	33.9	187	1.8	10
Суудлын машин	70.3	1911	72.2	1052	66.2	859	66.3	361	67.1	375	70.0	389	68.4	380	72.9	406
Интернэт	66.6	1573	77.5	1013	42.8	560	47.5	262	51.7	290	46.0	255	52.4	288	86.1	478
Банкны данс	97.4	2720	97.4	1443	97.4	1277	96.4	536	96.7	542	99.3	555	98.1	547	97.2	540
<b>Өрхийн эзэмшлийн газар, мал, амьтан</b>																
Тариалангийн газар	6.0	214	3.9	72	10.7	142	13.4	80	6.5	36	8.9	50	5.5	31	-	-
Мал/амьтан	35.8	1332	-	-	-	-	65.5	363	62.8	350	37.2	206	60.8	338	13.5	75
<b>Өрхийн гишүүний эд зүйлс</b>																
Бугуйн цаг	55.3	1316	62.5	806	39.4	510	50.4	278	44.7	251	36.2	200	36.1	197	69.9	390
Компьютер	47.8	1141	54.0	700	34.1	441	43.2	239	39.7	222	31.7	175	31.6	174	60.0	331
Ухаалаг гар утас	89.4	2466	91.2	1353	85.4	1113	81.8	459	89.4	500	90.7	508	88.4	493	91.0	506
<b>Өрхийн сууцны өмчлөл</b>																
Хувийн эзэмшил	88.3	2524	85.7	1294	93.8	1230	95.8	532	92.7	519	88.7	496	91.2	509	84.1	468
Түрээсийн	5.1	98	6.5	75	1.9	23	1.5	8	1.9	11	4.2	23	2.4	13	7.9	43
Түрээсийн бус / бусад	6.7	166	7.7	109	4.4	57	2.7	16	5.4	30	7.1	40	6.3	35	8.0	45

Өрхийн шинж байдлыг аж байдлын түвшнээр харьцуулан үнэлж, НН.4 хүснэгтэд үзүүлэв. Тухайн өрхийн эзэмшдэг эд хөрөнгийн нэр төрөл болон тоог харгалзан оноо өгөх байдлаар, багц шалгуур үзүүлэлтийг ашиглан “өрхийн аж байдлын түвшин”-г тогтоосон болно. Тав хүртэлх насны хүүхэдтэй нийт өрхийн 19.4% аж байдлын хамгийн доод түвшин буюу “ядуу”, 20.1% дунджаас доогуур түвшинд багтаж байна. Аж байдлын хамгийн доод түвшин буюу “ядуу” ангилалд багтаж буй өрх Хангай (33.5%) болон Зүүн (35.9%) бүсэд хамгийн их, харин Улаанбаатар хотод (5.9%) хамгийн бага байв. Аж байдлын түвшнээр “чинээлэг” болон “дунджаас дээгүүр” ангилалд багтаж буй өрх Улаанбаатар хотод их (37.4% ба 25.2%) байв ( $p < 0.0001$ ). Ядуу өрхийн тархалтыг өрхийн тэргүүний үндэс угсаагаар харьцуулан үнэлэхэд үндэстэн ястны цөөнх буюу бусад ястны дунд (23.3%) харьцангуй илүү байна ( $p = 0.04$ ). Ядуу өрхийн талаас илүү хувь (51.2%), аж байдлын түвшнээр дунджаас доогуур 3 өрх тутмын 1-ээс илүү хувь (35.2%) гэрт амьдарч байгааг дараах хүснэгтээс харж болно. Харин орон сууцад амьдардаг 10 өрх тутмын 9 орчим нь аж байдлын түвшнээр “чинээлэг” эсвэл “дунджаас дээгүүр” (56.9%, 41.9%) ангилалд багтаж байв ( $p < 0.0001$ ).

Хүснэгт НН.4. Өрхийн аж байдлын түвшин

Үзүүлэлт	Жинлээгүй тоо	Ядуу		Дунджаас доогуур		Дундаж		Дунджаас дээгүүр		Чинээлэг	
		%	п	%	п	%	п	%	п	%	п
<b>Бүгд</b>	<b>2789</b>	<b>19.4</b>	<b>742</b>	<b>20.1</b>	<b>636</b>	<b>19.9</b>	<b>594</b>	<b>20.1</b>	<b>493</b>	<b>20.6</b>	<b>324</b>
<b>Хот, хөдөөгөөр</b>											
Хот	1478	11.1	214	18.6	340	16.6	234	23.8	341	29.9	322
Хөдөө	1311	37.6	501	23.2	296	27.3	360	11.8	152	0.2	2
<b>Байршлаар</b>											
Нийслэл	556	5.9	33	14.5	81	17.0	94	25.2	142	37.4	206
Аймгийн төв	922	22.7	208	27.7	259	15.7	140	20.7	199	13.2	116
Сум/ баг	1311	37.6	501	23.2	296	27.3	360	11.8	152	0.2	2
<b>Бүсээр</b>											
Баруун	557	25.1	139	29.8	163	29.9	168	11.8	67	3.5	20
Хангай	560	33.5	188	26.8	15	23.1	128	10.0	56	6.6	38
Төв	559	31.8	10	20.3	112	18.8	104	22.	128	6.2	35
Зүүн	557	35.9	202	23.	130	18.0	100	18.3	100	4.4	25
Улаанбаатар	556	5.9	33	14.5	81	17.0	94	25.2	142	37.4	206
<b>Өрхийн тэргүүний шашин шүтлэг</b>											
Будда	779	17.1	194	19.0	172	20.3	175	22.3	135	21.3	100
Христ	19	16.7	4	15.6	5	2.9	1	12.7	3	52.1	6
Лалын шашин	173	22.3	39	23.9	43	36.5	63	14.7	24	2.6	4
Бөө, мөргөл	91	16.9	25	22.5	19	23.8	18	19.1	18	17.6	11
Шүтдэггүй	1717	20.6	478	20.4	395	18.7	332	19.5	312	20.8	200
<b>Сууцны төрөл</b>											
Гэр	1057	51.2	612	35.2	337	12.9	105	0.7	3	0.0	0.0
Орон сууц	670	0.1	1	0.0	0.0	1.1	20	41.9	339	56.9	310
Хувийн тохилог сууц	89	6.2	7	15.7	16	40.7	39	28.7	22	8.7	5
Хашаа байшин	951	10.8	120	27.5	278	46.0	422	14.0	123	1.7	8
Нийтийн байр	22	4.5	2	13.4	5	24.9	8	36.4	6	2.0	1
<b>Өрхийн тэргүүний үндэс угсаа</b>											
Халх	2130	18.8	563	20.2	493	19.5	430	20.4	383	21.1	261
Казак	183	17.1	35	25.3	47	33.0	65	20.4	32	4.2	4
Бусад	476	23.3	144	18.1	96	1.0	99	17.8	78	21.8	59
<b>Өрхийн тэргүүний хүйс</b>											
Эрэгтэй	2687	19.1	709	196	600	20.1	580	20.1	478	21.2	320
Эмэгтэй	102	26.8	33	32.9	36	16.0	14	19.6	15	4.8	4
<b>Өрхийн тэргүүний нас</b>											
< 20 нас	30	14.0	5	44.2	10	9.8	4	17.8	8	14.2	3
20-29 нас	718	21.4	212	23.3	189	19.5	136	20.8	119	15.1	62

30-39 нас	1499	18.6	377	19.4	332	19.7	33	19.8	272	22.5	187
40-49 нас	472	20.4	135	13.5	83	22.6	107	19.9	82	23.6	65
> 49 нас	70	11.9	13	31.3	22	17.9	16	20.3	12	18.8	7

## Ундны усны эх үүсвэр, ариун цэврийн байгууламж

Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаагүй усны үүсвэр, ариун цэврийн байгууламж хэрэглэх нь хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, аливаа халдвар, өвчлөлд байнга өртөх гол эх үүсвэр болдог. Төвлөрсөн усан хангамжийн систем болох хамгаалагдсан гүний худаг, хамгаалалттай гар худаг, хамгаалалттай булаг шанд, төвлөрсөн байгууламжид холбогдсон нийтийн ус түгээх байр зэрэг сайжруулсан ундны усны эх үүсвэртэй хүн амын тархалтыг Хүснэгт НН.5-д үзүүлэв.

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 96.0% нь сайжруулсан эх үүсвэрийн ус хэрэглэдэг боловч, хэрэглээ нь хот, хөдөөгөөр ялгаатай байна. Хотын бараг бүх өрх буюу 99.3% нь сайжруулсан эх үүсвэрийн ундны ус хэрэглэдэг бол тус үзүүлэлт хөдөөгийн өрхүүдийн дунд 88.7% байв. Бүсээр авч үзвэл, Хангай (88.1%) болон Зүүн (88.2%) бүсэд хамгийн бага хувьтай байна. Өрхийн аж байдлын түвшний дунджаас доогуур, дундаж, дунджаас дээгүүр болон чинээлэг түвшинд амьдарч буй өрхийн 95.8% дээш хувь нь сайжруулсан ундны усны эх үүсвэрийн ус ашигладаг бол ядуу өрхийн 86.2% ийм эх үүсвэртэй байна. Түүнчлэн, гэрт амьдардаг өрхийн сайжруулсан ундны усны эх үүсвэрийн ашиглалт бусад төрлийн сууцанд амьдардаг өрхийн үзүүлэлтээс харьцангуй бага буюу 91.2% байв (Хүснэгт НН.5).

### Хүснэгт НН.5. Сайжруулсан ундны усны хэрэглээ

Үзүүлэлтүүд	Сайжруулсан ундны ус			
	Жинлэсэн хувь	95% ИХ		Жинлээгүй тоо
		Доод	Дээд	
<b>Нийт</b>				
<b>Хот, хөдөөгөөр</b>				
Хот	99.3	98.5	99.7	1478
Хөдөө	88.7	83.0	92.7	1311
<b>Байршлаар</b>				
Нийслэл	99.8	98.7	100.0	556
Аймгийн төв	.2	96.0	99.2	922
Сум/ баг	88.7	83.0	92.7	1311
<b>Бүсээр</b>				
Баруун	.1	83.1	97.4	557
Хангай	88.1	79.3	93.5	560
Төв	99.3	95.2	99.9	559
Зүүн	88.2	80.3	93.2	557
Улаанбаатар	99.8	98.7	100.0	556
<b>Өрхийн тэргүүний шашин шүтлэг</b>				
Будда	98.7	95.1	97.8	776
Христ	94.5	78.6	98.8	19
Лалын шашин	96.2	90.3	98.5	173
Бөө, мөргөл	92.6	78.0	97.8	91



Шүтдэггүй	95.9	93.6	97.4	1717
Бусад	100.0	100.0	100.0	13
<b>Орон сууцны төрөл</b>				
Гэр	91.2	87.6	93.8	1057
Орон сууц	100.0	100.0	100.0	671
Хувийн тохилог сууц	93.0	80.7	97.7	89
Хашаа байшин	96.4	91.8	98.5	950
Нийтийн байр	100.0	100.0	100.0	22
<b>Өрхийн тэргүүний үндэс угсаа</b>				
Халх	96.7	95.2	97.7	2130
Казак	96.6	91.3	98.7	183
Бусад	91.6	82.5	96.2	476
<b>Өрхийн тэргүүний хүйс</b>				
Эрэгтэй	95.9	94.0	97.2	2687
Эмэгтэй	98.4	94.4	99.6	102
<b>Өрхийн тэргүүний нас</b>				
< 20 нас	.0	100.0	100.0	30
20-29 нас	95.5	92.7	97.4	718
30-39 нас	96.1	93.9	97.5	1499
40-49 нас	95.7	93.6	97.0	472
> 49 нас	98.7	91.5	99.8	70
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>				
Ядуу	86.2	81.3	90.0	742
Дундажаас доогуур	95.8	92.2	97.8	636
Дундаж	97.6	94.3	99.0	594
Дундажаас дээгүүр	100.0	100.0	100.0	493
Чинээлэг	100.0	100.0	100.0	324

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 96.0% нь сайжруулсан ундны усны эх үүсвэрийн ус хэрэглэдэг боловч тэдгээр өрхийн 42.2% тус эх үүсвэрийг хувьдаа эзэмшдэг байв (Хүснэгт НН.6). Өөрийн эзэмшлийн сайжруулсан ундны усны эх үүсвэртэй өрхийн үзүүлэлтийг хот, хөдөөгөөр авч үзэхэд хөдөөд 19.7%, хотод 52.5% байна. Бүсээр авч үзэхэд хувийн эзэмшлийн сайжруулсан ундны эх үүсвэртэй өрх Улаанбаатар хотод хамгийн их буюу 58.7%, Хангайн бүсэд хамгийн бага буюу 16.3% байв. Өрхийн аж байдлын түвшин дээшлэх тутам өөрийн эзэмшлийн ундны усны сайжруулсан эх үүсвэртэй байх тохиолдол шууд хамааралтай нэмэгдэж байгааг НН.6 дугаар хүснэгтээс харж болно ( $p < 0.0001$ ).

Хүснэгт НН.6. Өөрийн эзэмшлийн ундны усны сайжруулсан эх үүсвэртэй өрх

Үзүүлэлтүүд	Өөрийн эзэмшлийн ундны усны эх үүсвэртэй			
	Жинлэсэн хувь	95% ИХ		Жинлээгүй тоо
		Доод	Дээд	
<b>Нийт</b>	<b>.2</b>	<b>35.6</b>	<b>49.1</b>	<b>2789</b>
<b>Хот, хөдөөгөөр</b>				
Хот	52.5	42.9	61.9	
Хөдөө	19.7	15.4	24.7	
<b>Байршлаар</b>				
Нийслэл	58.7	45.0	71.2	
Аймгийн төв	38.7	30.9	47.1	
Сум/ Баг	19.7	15.4	24.7	
<b>Бүсээр</b>				
Баруун	33.5	25.1	43.2	
Хангай	16.3	10.0	25.5	
Төв	35.6	26.7	45.7	
Зүүн	27.7	19.9	37.2	
Улаанбаатар	58.7	45.0	71.2	
<b>Өрхийн тэргүүний шашин шүтлэг</b>				
Будда	42.8	35.2	50.7	
Христ	70.6	44.4	87.8	
Лалын шашин	62.0	46.0	75.8	
Бөө, мөргөл	35.5	21.3	52.7	
Шүтдэггүй	41.1	34.2	48.4	
Бусад	33.2	11.3	65.9	
<b>Орон сууцны төрөл</b>				
Гэр	6.4	4.7	8.7	
Орон сууц	96.2	92.2	98.2	
Хувийн тохилог сууц	43.6	28.1	60.5	
Хашаа байшин	17.1	12.4	23.1	
Нийтийн байр	59.6	30.0	83.6	
<b>Өрхийн тэргүүний үндэс угсаа</b>				
Халх	41.2	34.2	48.5	
Казак	65.0	49.9	77.6	
Дөрвөд	49.6	33.9	65.4	
Буриад	42.5	25.6	61.3	
Баяд	46.9	27.1	67.7	
Дарьганга	23.2	6.9	55.2	
Бусад	40.5	29.2	52.8	
<b>Өрхийн тэргүүний хүйс</b>				

Эрэгтэй	42.7	36.0	49.6	
Эмэгтэй	30.6	19.8	44.0	
<b>Өрхийн тэргүүний нас</b>				
< 20 нас	20.2	7.3	44.7	
20-29 нас	36.8	28.7	45.7	
30-39 нас	43.5	36.6	50.6	
40-49 нас	47.1	4.3	38.7	
> 49 нас	49.5	32.6	66.4	
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>				
Ядуу	5.7	3.9	8.1	
Дундажаас доогуур	8.7	6.0	12.6	
Дундаж	13.0	9.5	17.4	
Дундажаас дээгүүр	81.5	74.3	87.0	
Чинээлэг	99.2	97.1	99.8	

Сайжруулсан ариун цэврийн байгууламж буюу төвлөрсөн ус зайлуулах байгууламжид холбогдсон, ус хуримтлуулагчтай болон зөөврийн устай, эсвэл соруулдаг жорлон, нүхэн жорлон, агааржуулагчтай сайжруулсан нүхэн жорлон, бетон суурьтай нүхэн жорлон, эсвэл био жорлон ашиглах нь хүний ялгадсыг хүний амьдрах орчноос бүрэн тусгаарлах ач холбогдолтой. Хүснэгт НН.7-д харуулснаар, нийт өрхийн 45.2% нь сайжруулсан ариун цэврийн байгууламж ашигладаг байв. Тус үзүүлэлтийг хот, хөдөөгөөр харьцуулахад хотод 59.8%, хөдөөд 12.8%-тай байлаа. Харин Баруун бүсийн өрхийн 14.0% нь сайжруулсан ариун цэвийн байгууламж ашиглаж буй нь бусад бүстэй харьцуулахад хамгийн доогуур үзүүлэлттэй байна. Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрхийн хувь аж байдлын түвшин дээгүүр буюу чинээлэг өрхийн дунд 100% байхад ядуу өрхийн дунд дөнгөж 3.9% байгаа нь анхаарал татаж байна. Сайжруулсан ариун цэврийн байгууламжийн ашиглалт гэрт амьдардаг өрхүүдийн дунд хамгийн бага (9.7%) байв. Мөн нийт өрхийн 1.8% ил задгай бие засдаг байгаа нь өмнөх судалгааны үзүүлэлт (3.5%)-ээс буурсан байв [35]. Энэхүү үзүүлэлт нь хотод 0.2%, хөдөөд 5.4% байгаа бол Хангайн бүсэд 4.5%, Зүүн бүсэд 5.9% байгаа нь эдгээр бүсийн өрхүүдэд түгээмэл тохиолдож байна (Хүснэгт НН.7).

Хүснэгт НН.7: Сайжруулсан ариун цэврийн байгууламж ашиглалт, ил задгай бие засдаг байдал

Үзүүлэлтүүд	Сайжруулсан ариун цэврийн байгууламж				Ил задгай бие засдаг			
	%	95% ИХ		Жинлээгүй тоо	%	95% ИХ		Жинлээгүй тоо
		Доод	Дээд			Доод	Дээд	
<b>Нийт</b>	<b>45.2</b>	<b>39.6</b>	<b>50.8</b>	<b>2789</b>	<b>1.8</b>	<b>1.3</b>	<b>2.5</b>	<b>2789</b>
<b>Хот, хөдөөгөөр</b>								
Хот	59.8	51.6	67.5	1478	0.2	0.1	0.5	1478

Хөдөө	12.8	9.6	16.9	1311	5.4	3.8	7.6	1311
<b>Байршлаар</b>								
Нийслэл	70.3	58.2	80.0	556	-	-	-	556
Аймгийн төв	36.8	30.0	44.2	922	0.6	0.2	1.4	922
Сум/ Баг	12.8	9.6	16.9	1311	5.4	3.8	7.6	1311
<b>Бүсээр</b>								
Баруун	14.0	9.2	20.9	557	3.0	1.2	7.0	557
Хангай	17.6	11.2	26.4	560	4.5	2.7	7.2	560
Төв	32.1	24.1	41.2	559	1.4	0.4	4.9	559
Зүүн	28.1	20.2	37.6	557	5.9	3.5	9.7	557
Улаанбаатар	70.0	58.2	80.0	556	-	-	-	556
<b>Өрхийн тэргүүний шашин шүтлэг</b>								
Будда	47.2	40.2	54.4	776	1.8	1.1	3.2	776
Христ	66.9	41.0	85.4	19	-	-	-	19
Лалын шашин	11.4	6.3	19.8	173	3.3	0.8	12.3	173
Бөө, мөргөл	48.4	31.9	65.3	91	0.6	0.2	2.6	91
Шүтдэггүй	45.4	39.5	51.4	1717	1.8	1.2	2.8	1717
Бусад	27.1	39.5	51.4	13	-	-	-	13
<b>Орон сууцны төрөл</b>								
Гэр	9.7	6.4	14.4	1057	5.4	3.8	7.5	1057
Орон сууц	100.0	100.0	100.0	671	-	-	-	671
Хашаа байшин	32.6	19.7	48.6	89	-	-	-	89
Хувийн байшин	19.9	15.6	25.0	950	0.5	0.2	1.3	950
Нийтийн байр	49.3	24.4	74.5	22	-	-	-	22
<b>Өрхийн тэргүүний үндэс угсаа</b>								
Халх	47.1	41.1	53.1	2130	1.5	1.1	2.2	2130
Казак	19.3	11.0	31.7	183	2.9	0.7	11.0	183
Дөрвөд	47.0	30.1	64.7	90	0.9	0.2	3.7	90
Буриад	38.3	21.9	58.0	68	1.5	0.4	5.4	68
Баяд	43.5	22.9	66.7	68	8.6	2.8	23.5	68
Дарьганга	27.2	8.8	59.1	39	6.0	2.0	16.3	39
Бусад	36.2	25.9	47.8	211	2.7	0.6	9.3	211
<b>Өрхийн тэргүүний хүйс</b>								
Эрэгтэй	45.6	40.0	51.3	2687	1.9	1.3	2.6	2687
Эмэгтэй	34.0	22.4	47.8	102	-	-	-	102
<b>Өрхийн тэргүүний нас</b>								
< 20 нас	30.4	13.8	54.4	30	3.3	0.7	14.4	30
20-29 нас	40.6	33.1	48.5	718	1.8	1.1	3.1	718
30-39 нас	47.5	41.7	53.4	1499	2.0	1.3	3.0	1499
40-49 нас	45.8	37.9	54.0	472	1.3	0.7	2.6	472
> 49 нас	43.8	28.6	60.3	70	-	-	-	70
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>								
Ядуу	.9	2.1	7.0		9.1	6.6	12.3	
Дундажаас доогуур	8.8	5.1	14.9		0.2	0.0	1.1	
Дундаж	20.3	14.7	27.3		0.0	0.0	0.0	

Дундажаас дээгүүр	89.7	85.3	92.9		0.0	0.0	0.0	
Чинээлэг	100.0	100.0	100.0		0.0	0.0	0.0	

Хүснэгт НН.8-д үзүүлсэн үр дүнгээс ажиглахад, 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн 45.0% сайжруулсан ундны усны эх үүсвэр болон ариун цэврийн байгууламж ашиглаж байна. Байршил, аж байдлын түвшин, орон сууцны төрлөөр харьцуулан судлахад хотын, чинээлэг өрх, орон сууц, нийтийн байранд амьдардаг өрхүүдийн хувьд сайжруулсан ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмж илүү сайн байв. Харин бүсээр харьцуулбал Баруун бүсэд хамгийн бага буюу 13.9% байна. Аж байдлын түвшин нь “дундажаас дээгүүр” болон “чинээлэг” өрхийн сайжруулсан ундны усны эх үүсвэр болон ариун цэврийн байгууламж ашиглах (89.7% ба 100.0%) байдал эрс нэмэгдэж байгааг дараах хүснэгтээс харж болно ( $p < 0.0001$ ).

Хүснэгт НН.8: Сайжруулсан ундны ус болон ариун цэврийн байгууламж ашиглалт

Үзүүлэлтүүд	Сайжруулсан ундны ус болон ариун цэврийн байгууламжтай өрх			
		95% ИХ		Жинлээгүй тоо
		доод	дээд	
<b>Нийт</b>				
<b>Хот, хөдөөгөөр</b>				
Хот	59.8	51.6	67.5	1478
Хөдөө	12.4	9.2	16.5	1311
<b>Байршлаар</b>				
Нийслэл	70.3	58.2	80.0	556
Аймгийн төв	36.8	29.9	44.1	922
Сум/ баг	12.4	9.2	16.5	1311
<b>Бүсээр</b>				
Баруун	.9	9.0	20.8	557
Хангай	17.4	11.1	26.3	560
Төв	32.1	24.1	41.2	559
Зүүн	26.6	18.6	36.4	557
Улаанбаатар	70.3	58.2	80.0	556
<b>Өрхийн тэргүүний шашин шүтлэг</b>				
Будда	47.1	40.0	54.3	776
Христ	64.8	39.1	84.1	19
Лалын шашин	11.4	6.3	19.8	173
Бөө, мөргөл	48.4	31.9	65.3	91
Шүтдэггүй	45.2	39.3	51.2	1717
Бусад	27.1	7.2	63.9	13
<b>Орон сууцны төрөл</b>				
Гэр	9.3	6.0	14.0	1057
Орон сууц	100.0	100.0	100.0	671
Хашаа байшин	32.6	19.7	48.6	89
Хувийн байшин	19.8	15.5	24.9	950

Нийтийн байр	49.3	13.9	24.4	22
<b>Өрхийн тэргүүний үндэс угсаа</b>				
Халх	46.9	41.0	53.0	2130
Казак	19.3	11.0	31.7	183
Дөрвөд	47.0	30.1	64.7	90
Буриад	38.3	21.9	58.0	68
Баяд	43.5	22.9	66.7	68
Дарьганга	25.2	8.0	56.6	39
Бусад	35.6	25.2	47.7	211
<b>Өрхийн тэргүүний хүйс</b>				
Эрэгтэй	45.4	39.8	51.2	2687
Эмэгтэй	34.0	22.4	47.8	102
<b>Өрхийн тэргүүний нас</b>				
< 20 нас	30.4	13.8	54.4	30
20-29 нас	40.4	33.0	48.3	718
30-39 нас	47.3	41.5	53.2	1499
40-49 нас	45.7	37.8	53.9	472
> 49 нас	43.8	28.6	60.3	70
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>				
Ядуу	3.4	1.7	6.5	
Дундажаас доогуур	8.6	4.9	14.8	
Дундаж	20.1	14.6	27.1	
Дундажаас дээгүүр	89.7	85.3	92.9	
Чинээлэг	100.0	100.0	100.0	


### Өрхийн хүнсний баталгаат байдал

Хүнсний баталгаат байдал гэж хүн бүхий л цаг хугацаанд идэвхтэй амьдрахад шаардлагатай шим тэжээллэг, аюулгүй, хүссэн хоол хүнсээ хангалттай хэмжээгээр, хэрэглэх бие махбодын болон нийгэм, эдийн засгийн боломжтой байх нөхцөлийг хэлдэг. НҮБ-ын ХХААБ-аас хүнсний баталгаат байдлыг хангах зарчимд 1) хүнсний бэлэн байдал, 2) хүнсний хүртээмж, 3) аюулгүй, шим тэжээллэг хэрэглээ, 4) хүнсний тогтвортой байдал гэсэн үндсэн 4 ойлголтыг авч үздэг. Хүн бүр аюулгүй, шим тэжээллэг хоол хүнсээр хангагдах эрхтэй бөгөөд идэвхтэй амьдрахад шаардлагатай, хэрэгцээт хоол хүнс хангалттай хэмжээтэй, бэлэн байх нөхцөл бүрдсэн үед “хүнсний баталгаат байдал” хангагдсан гэж үздэг. Хүнсний баталгаат байдал (ХББ)-д нийгэм, улс төрийн хямрал, дайн дажин, байгалийн гамшиг (ган, зуд), эдийн засгийн хямрал, хүнсний үнийн өсөлт зэрэг гадаад, дотоод олон хүчин зүйл нөлөөлдөг. Илчлэг, шим тэжээллэг, олон нэр төрлийн хоол хүнсний хүртээмж хангалтгүй байхыг “хүнсний баталгаат байдлын алдагдал” гэж тооцдог. ХББ-ын алдагдах нь хоол тэжээлийн дутлын эмгэгүүд үүсэх шалтгаан, нөхцөл болдог [36].

Сүүлийн жилүүдэд дэлхийн олон улс орнууд хувь хүн, өрхийн түвшинд хүнсний аюулгүй байдлыг хянах зорилгоор туршлагад суурилсан хүнсний баталгаат бус байдлын хэмжүүр (FIES)-ийг ашиглан ТХЗ-ын 2.1.2 шалгуур үзүүлэлтийг тооцох, үр дүнг үндэсний хүнсний аюулгүй байдлын бодлогод тусган ажиллаж байна. НҮБ-ын ХХААБ нь хүнсний баталгаат байдлын дунд болон хүнд хэлбэрийн алдагдалд өртсөн хүн амын тархалт (FIES)-ыг 8 багц асуултын тусламжтайгаар өрхөд суурилсан судалгаанд тусган судлахыг 2020 онд дэлхийн улс орнуудад зөвлөсөн байдаг. Иймд энэхүү судалгааны өрхийн асуулгад эдгээр 8 асуултыг оруулж, 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн хүнсний баталгаат байдлыг Үндэсний сататистикийн хорооны даргын 2023 оны А/165 тушаалаар батлагдсан “Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал” -д зааснаар дараах түвшнээр ангилан үнэлэв [37]. Үүнд:

1. ХББ хангагдсан эсвэл хөнгөн зэргийн алдагдалтай,
2. Дунд болон хүнд зэргийн (ноцтой) алдагдсан,
3. ХББ нь ноцтой алдагдсан,

Тав хүртэлх насны хүүхэдтэй өрхийн 75.2% ХББ хангагдсан эсвэл хөнгөн зэргийн алдагдалтай, 18.9% ХББ дунд зэрэг алдагдсан, 2.7% ХББ хүнд буюу ноцтой алдагдсан байна (Зураг НН.1).



Зураг НН.1: Өрхийн хүнсний баталгаат байдал, бүсээр

Тав хүртэлх насны хүүхэдтэй өрхийн ХББ-ын алдагдлыг тооцон, НН.9 хүснэгтэд нэгтгэн харуулав. Нийт өрхийн 21.6% нь ХББ дунд зэрэг болон ноцтой алдагдсан байна. ХББ дунд зэрэг болон ноцтой алдагдсан өрхийн тархалтыг сонгосон үзүүлэлтээр харьцуулан үнэлэхэд байршил, өрхийн тэргүүний хүйс болон насны бүлэг, өрхийн сууцны төрлөөр тус тус ялгаатай

байв. ХББ дунд болон ноцтой алдагдсан өрхийн хувь хот суурин газар (23.9%), хөдөөгөөс ба түүнээс дээш насны (45.0%, 32.6%) өрхийн тэргүүнтэй өрхийн ХББ алдагдах магадлал харьцангуй өндөр байв ( $p < 0.0001$ ,  $p = 0.004$ ). Түүнчлэн гэрт (27.1%), хашаа байшинд (24.8%) амьдардаг өрхийн дунд ХББ-ын алдагдал харьцангуй илүү ( $p = 0.002$ ) байгааг НН.9 хүснэгтээс харж болно.

Хүснэгт НН.9: Тав хүртэлх насны хүүхэдтэй өрхийн хүнсний баталгаат бус байдал

Үзүүлэлтүүд	Жинлээгүй тоо	ХББ дунд болон ноцтой байдлаар алдагдсан			ХББ дунд зэрэг алдагдсан			ХББ ноцтой алдагдсан		
		%	95% ИХ		%	95% ИХ		%	95% ИХ	
			доод	дээд		доод	дээд		доод	дээд
<b>Нийт</b>	<b>2742</b>				<b>18.9</b>	<b>16.5</b>	<b>21.5</b>	<b>2.7</b>	<b>2.0</b>	<b>3.7</b>
<b>Хот, хөдөөгөөр</b>										
Хот	1449	23.9	20.2	28.1	21.3	18.0	24.9	2.6	1.7	4.0
Хөдөө	1293	16.6	14.6	18.8	13.7	11.9	15.9	2.8	1.9	4.2
<b>Байршлаар</b>										
Нийслэл	537	22.4	17.3	28.4	19.4	15.4	24.9	2.7	1.5	4.7
Аймгийн төв	912	27.1	23.3	31.4	24.6	20.8	28.8	2.6	1.6	4.0
Сум/баг	1293	16.6	14.6	18.8	13.7	11.9	15.9	2.8	1.9	4.2
<b>Бүсээр</b>										
Баруун	553	24.8	20.7	29.3	23.1	19.2	27.5	1.6	0.9	3.1
Хангай	552	19.7	15.8	24.3	17.2	13.4	21.9	2.5	1.4	4.4
Төв	550	19.1	14.9	24.1	15.1	11.4	19.9	4.0	2.5	6.3
Зүүн	550	21.5	17.7	25.8	19.2	15.4	23.6	2.3	1.1	4.6
Улаанбаатар	537	22.4	17.3	28.4	19.7	15.4	24.9	2.7	1.5	4.7
<b>Өрхийн тэргүүний шашин шүтлэг</b>										
Будда	755	17.9	14.8	21.6	17.0	13.9	20.6	1.0	0.5	1.8
Христ	19	15.9	4.8	41.8	13.6	3.5	40.3	2.4	0.3	16.0
Лалын шашин	172	23.2	16.3	31.9	22.3	15.7	30.5	0.9	0.2	3.5
Бөө, мөргөл	90	28.7	16.8	44.5	18.4	9.6	32.4	10.3	3.7	25.3
Шүтдэггүй	1695	22.9	19.4	26.8	19.8	16.7	23.4	3.1	2.3	4.3
<b>Сууцны төрөл</b>										
Гэр	1041	27.1	23.4	31.2	23.3	19.8	27.2	3.8	2.5	5.9
Орон сууц	653	15.4	11.2	20.7	13.7	10.1	18.2	1.7	0.8	3.8
Хашаа байшин	89	24.8	15.7	36.9	24.8	15.7	36.9	-	-	-
Хувийн байшин	937	22.8	18.5	27.9	20.0	16.1	24.7	2.8	1.6	4.9
Нийтийн байр	22	17.1	6.7	37.0	11.8	4.0	29.8	5.3	0.7	31.5
<b>Өрхийн тэргүүний үндэс угсаа</b>										
Халх	2090	22.0	18.9	25.3	19.0	16.3	21.9	3.0	2.2	4.1
Казак	181	22.9	16.0	31.6	21.3	14.7	29.7	1.6	0.5	5.1
Бусад	471	19.1	14.6	24.6	17.8	13.3	23.3	1.3	0.6	2.7
<b>Өрхийн тэргүүний хүйс</b>										
Эрэгтэй	2641	20.9	18.2	24.0	18.4	16.0	21.1	2.5	1.8	3.5



Эмэгтэй	101	40.5	30.0	52.0	32.1	22.3	43.8	8.5	4.1	16.5
<b>Өрхийн тэргүүний нас</b>										
< 20 нас	30	45.9	28.1	64.8	35.9	19.5	56.3	10.0	1.8	40.6
20-29 нас	707	18.3	14.5	22.9	16.7	12.9	21.3	1.6	0.8	3.2
30-39 нас	1478	21.1	18.0	24.7	18.6	15.7	21.9	2.5	1.6	3.9
40-49 нас	459	23.0	18.7	28.0	19.1	15.0	24.0	3.9	2.2	6.9
> 49 нас	68	32.6	20.7	47.2	29.7	18.4	44.3	2.9	0.9	9.2
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>										
Ядуу		.2	31.1	41.7	28.8	24.3	33.8	7.4	5.2	10.5
Дунджаас доогуур		28.7	23.8	34.1	26.5	21.8	31.8	2.2	1.1	4.3
Дундаж		15.2	11.6	19.5	13.9	10.5	18.2	1.2	0.4	3.6
Дунджаас дээгүүр		17.9	13.0	24.2	15.2	11.1	20.5	2.7	1.2	6.0
Чинээлэг		9.9	6.1	15.7	9.9	6.1	15.7	-	-	-

ХББ ноцтой алдагдсан өрхийн тархалт 2.7% байна. ХББ ноцтой алдагдсан өрхийн тархалтыг өрхийн шинж байдлаар харьцуулан үнэлэхэд өрхийн тэргүүний хүйс ( $p=0.01$ ), шашин шүтлэгээр ( $p<0.0001$ ) стататистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсан болно. Эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрхийн ХББ ноцтой алдагдах магадлал эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрхөөс 3.4 дахин өндөр, өрхийн тэргүүн нь бөөгийн шашин шүтдэг өрхийн ХББ ноцтой алдагдсан (10.3%) байдал харьцангуй түгээмэл байна.

Өрхийн аж байдлын түвшинтэй ХББ алдагдал урвуу хамааралтай, аж байдлын түвшин дээшлэхэд ХББ алдагдал буурах магадлалтай байна ( $p<0.0001$ ). Тодруулбал, ХББ дунд болон ноцтой алдагдсан өрхийн тархалт ядуу (36.2%), дунджаас доогуур (28.7%) өрхийн дунд хамгийн түгээмэл байна. Мөн ХББ ноцтой алдагдсан өрхийн (7.4%) тархалт ядуу өрхийн дунд хамгийн өндөр байв.

#### **Хоол тэжээлийн хомсдолын тархалт**

Хоол тэжээлийн үндэсний VI судалгаанд хамрагдсан 2789 өрхийн мэдээлэл, 5 хүртэлх насны 2786 хүүхэд, төрөх насны 2513 эмэгтэй, 15–49 насны 1950 эрэгтэйчүүдийн бие махбодын хэмжилтийн дүн, хоол тэжээлийн байдлын үзүүлэлтийг харгалзан хоол тэжээлийн дутал (тураал, туранхай)-тай хүн амын тархалтыг тооцсон болно. Өрхийн 1 гишүүн тураалтай, эсвэл туранхай байгаа тохиолдолд тухайн өрхийг хоол тэжээлийн дуталтай бүлэгт хамруулсан тул үндэсний хэмжээний бодит үзүүлэлтээс зөрүүтэй байх магадлалыг анхаарвал зохино.

Нийт 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн 4.9% хоол тэжээлийн дуталтай байна. Тус судалгааны зорилтот бүлэг нь 0-5 хүртэлх насны хүүхэдтэй өрх тул энэхүү тархалтын үзүүлэлт нь үндэсний түвшний хоол тэжээлийн дуталтай хүн амын тархалтыг илэрхийлэхгүй болно. Гэсэн хэдий ч тус судалгаагаар тооцоолсон ХББ дунд зэрэг болон ноцтой алдагдсан хүн амын тархалтын

үзүүлэлттэй тураалтай буюу хоол тэжээлийн дуталтай хүн амын тархалт ойролцоо түвшинд байна (Хүснэгт НН.10).

Хүснэгт НН.10: Хоол тэжээлийн дуталтай болон ХХБ дунд болон ноцтой алдагдсан хүн ам

Үзүүлэлт	Жинлэсэн Хувь	СХ	90% ИХ		Өрхийн тоо (жинлээгүй)
			Доод	Дээд	
Хоол тэжээлийн дуталтай, %	4.9	0.67	4.2	5	2
ХББ дунд зэрэг болон ноцтой алдагдсан хүн ам, %	3.6	1.19	2.4	4.8	2

### Иоджуулсан давсны хэрэглээ

Давсыг иоджуулж, иод дутлын эмгэгээс сэргийлэх стратегийг Монгол улс урт хугацааны турш баримталсаар ирсэн ба иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн тоо сүүлийн жилүүдэд нэлээд өссөн. Монгол улсын хүнсний зориулалтын давсны стандартад давсыг 30±5 мг/кг хэмжээгээр иоджуулахыг заасан бөгөөд олон улсын түвшинд айл өрхийн хүнсний давс дахь иодын агууламжийг 15 мг/кг-аас багагүй байхыг зөвлөсөн байдаг [38]. Давс дахь иодын агууламжийг тодорхойлох зорилгоор нийт өрх (N=2789)-ийн 98.4% судалгааны өмнөх өдөр цай, хоолондоо хэрэглэсэн давнаас дээжийг цуглуулсан болно (Хүснэгт НН.10). Өрхөөс цуглуулсан давсны дээжид иодын агууламж тодорхойлох шинжилгээний дүнгээр 5 хүртэлх насны хүүхэдтэй нийт өрхийн 47.4% зохистой хэмжээнд иоджуулсан ( $\geq 15$  мг/кг), 10.5% хангалтгүй хэмжээгээр иоджуулсан ( $> 0$  ба  $< 15$  мг/кг), 42.2% огт иоджуулаагүй давс хэрэглэж байв. Хөдөөгийн өрхтэй (48.3%) харьцуулахад зохистой түвшинд иоджуулагдсан давс хэрэглээ хотод бага (46.9%) байна. Зохистой хэмжээнд иоджуулсан давс хэрэглэж буй өрхийн тархалтыг бүс нутгаар харьцуулан судлахад Баруун (39.6%) болон Хангайн (42.2%) бүс, Улаанбаатарт (43.9%) хамгийн бага, Зүүн (50.4%) болон Төвийн бүсэд (68.3%) харьцангуй их байна. Зохистой түвшинд иоджуулсан давсны хэрэглээ нь өрхийн аж байдлын түвшнээр ялгаатай бус байв. Огт иоджуулаагүй давсны хэрэглээг өрхийн тэргүүний үндэс угсаагаар харьцуулахад Дөрвөд үндэстэн 55.9%, Баяд үндэстэн 58.2% байгаа нь бусад үндэстэн, ястнаас илүү байв.

Хүснэгт НН.10: Иоджуулсан давсны хэрэглээ

Үзүүлэлтүүд	Давсаа шинжлүүлсэн өрх (%)	Жинлээгүй тоо	Өрхийн хэрэглээ, хувиар			
			Давсгүй	Давсны шинжилгээний үр дүн, %		
				Иоджуулаагүй (0 мг/кг)	Хангалтгүй түвшинд иоджуулсан (0.1-14.9 мг/кг)	Зохистой түвшинд иодуулсан ( $\geq 15$ мг/кг)
<b>Нийт</b>						
<b>Хот, хөдөөгөөр</b>						
Хот				42.2	46.9	
Хөдөө				42.1	48.3	

<b>Бүсээр</b>						
Баруун	2.0	557	0.2	45.3		39.6
Хангай	100.0	560	-	48.3		42.2
Төв	99.8	559		26.8		68.3
Зүүн	99.8	557	0.2	42.4		50.4
Улаанбаатар	99.1	556		44.1		43.9
<b>Байршлаар</b>						
Нийслэл			-	44.1		43.9
Аймгийн төв				38.0		53.4
Сум/баг				42.1		48.3
<b>Өрхийн тэргүүний үндэс угсаа</b>						
Халх				42.0	10.1	47.9
Казак				25.6	12.1	62.3
Дөрвөд				55.9	10.4	33.7
Буриад				32.8	18.2	49.0
Баяд				58.2	10.3	31.5
Дарьганга				27.9	4.1	68.0
Бусад				45.9	13.0	41.1
<b>Өрхийн тэргүүний шашин шүтлэг</b>						
Будда		776		46.4	10.7	42.8
Христ		19		54.7	8.1	37.2
Лалын шашин		173		28.3	13.8	58.0
Бөө, мөргөл		91		40.0	6.1	53.9
Шүтдэггүй		1717		40.8	10.3	48.9
Бусад		13		31.1	37.7	31.1
<b>Орон сууцны төрөл</b>						
Гэр				43.3		49.1
Орон сууц				42.8		45.2
Хашаа байшин				34.4		47.8
Хувийн байшин				40.8		47.9
Нийтийн байр				44.1		51.5
<b>Өрхийн тэргүүний хүйс</b>						
Эрэгтэй				.2	10.4	47.5
Эмэгтэй				42.1	14.0	44.0
<b>Өрхийн тэргүүний нас</b>						
< 20 нас				37.9	8.7	53.4
20-29 нас				40.6	11.0	48.4
30-39 нас				42.8	9.7	47.5
40-49 нас				41.1	12.1	46.8
> 49 нас				50.9	12.7	36.4
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>						
Ядуу		742	0.2	.6	5.4	52.0

Дундажаас доогуур	98.2	636	-	38.6	8.7	52.7
Дундаж	98.6	594	-	43.2	11.8	45.1
Дундажаас дээгүүр	97.7	493	-	43.7	13.6	42.7
Чинээлэг	99.5	324	-	42.4	12.0	45.6

Давсны иодын агууламжийн дундаж голч 14.6 мг/кг байгаа бөгөөд хөдөө орон нутагт хот, суурин газраас илүү байв (Хүснэгт НН.11). Иоджуулсан давсны иодын агууламж Баруун бүсэд хамгийн бага буюу 12.9 мг/кг, Төвийн бүсэд хамгийн өндөр буюу 20.6 мг/кг байлаа. Энэхүү үзүүлэлтийг байршлаар авч үзвэл аймгийн төвд 16.4 мг/кг буюу хамгийн их байв.

Хүснэгт НН.11: Иоджуулсан давсны иодын агууламж, мг/кг


Үзүүлэлтүүд	Иодын голч хэмжээ	СХ	95% ИХ		Жинлээгүй тоо
			доод	дээд	
<b>Нийт</b>		<b>14.5</b>			
<b>Хот, хөдөөгөөр</b>					
Хот		14.5			1437
Хөдөө		14.9			1274
<b>Бүсээр</b>					
Баруун		.4			
Хангай		14.8			
Төв		13.9			
Зүүн		14.7			
Улаанбаатар		14.2			
<b>Байршлаар</b>					
Нийслэл					
Аймгийн төв					
Сум/баг					

## Хэлцэмж

### Өрхийн аж байдлын түвшин

Өрхийн амьжиргааны түвшинг шууд илэрхийлэх, орлогын талаарх мэдээлэл эсвэл бодитой үнэлэх арга, аргачлал байхгүй үед эдгээрийг орлохуйц үзүүлэлтүүдийг ашиглан өрхийн аж байдлын түвшнийг үнэлэх зорилгоор орлогыг орлуулан тооцох аргыг ашигладаг. ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын зохион байгуулсан “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа–2023”-д ашигласан өрхийн аж байдлын түвшинг тооцох арга зүйг [39] ашиглан, НҮБ-ын Хүүхдийн Сангийн төв байгууллагын “Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа”-ны багийн техник, арга зүйн дэмжлэгтэйгээр Хоол тэжээлийн үндэсний VI судалгаанд хамрагдсан 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн аж байдлын түвшнийг тооцсон. Өрхийн эзэмшлийн хөрөнгө, эд зүйлс, мал аж ахуй, газар тариалан эрхлэлт, орон байрны төрөл, хийц, хана, шал, дээвэр, туургын хийц материал, усан хангамж, ариун цэврийн байгууламж, тухайн өрхийн эд хөрөнгийн нэр төрөл болон тоог тухайн өрхийн оршин суугаа байршил (хот, хөдөө)-ыг харгалзан оноо өгч, багц шалгуур үзүүлэлтийг ашиглан өрхийн аж байдлыг 5 түвшнээр үнэлсэн. Хот болон хөдөөгийн өрхийн амьжиргааны эх үүсвэр харилцан адилгүй тул аж байдлын түвшнийг тооцох шалгуур үзүүлэлт нь ялгаатай байдаг. Иймд судалгаанд хамрагдсан өрхийн аж байдлын түвшнийг хот, хөдөөгөөр тусгайлан тооцсон.


Тав хүртэлх насны хүүхэдтэй нийт өрхийн аж байдлын түвшнийг 2017 оны хоол тэжээлийн үндэсний V судалгааны дүнтэй харьцуулан үнэлэхэд төдийлөн ялгаа ажиглагдахгүй байгаа хэдий ч, байршлаар харьцуулан үзвэл ядуу, дундаж өрхийн үзүүлэлтэд ялгаа илэрсэн. Тодруулбал, хотод 5 хүртэлх насны хүүхэдтэй аж байдлын түвшин доогуур буюу ядуу өрхийн хувь бага зэрэг өссөн, харин аж байдлын түвшин дундаж өрхийн хувь 2.1 пунктээр буурсан байна (Зураг НН.2).



Зураг НН.2: Хотын 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн аж байдлын түвшин, судалгааны оноор

Хөдөөгийн өрхийн аж байдлын түвшнийг 2 судалгааны дүнгээр харьцуулан үзвэл 2023 оны байдлаар хөдөөгийн чинээлэг өрхийн хувь буурахын зэрэгцээ ядуу өрхийн үзүүлэлт 5.2

пунктээр багассан байв. Мөн дунджаас доогуур болон дундаж аж байдлын түвшинд байгаа өрхийн тархалт 2017 оны түвшнээс нэмэгдсэн байгааг дараах үр дүнгээс харагдаж байна (Зураг НН.3).



Зураг НН.3: Хөдөөгийн 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн аж байдлын түвшин, судалгааны оноор

### Ундны усны болон ариун цэврийн байгууламж

Сайжруулсан ундны усны эх үүсвэрт төвлөрсөн, төвлөрсөн бус системд холбогдсон орон сууцны хоолой болон нийтийн ус түгээх байр, гүний худаг, хамгаалагдсан энгийн худаг болон цэвэршүүлж, савласан ус зэрэг багтана. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 96.0 хувь нь сайжруулсан ундны усны эх үүсвэр ашиглаж байгаа нь “Хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний тавдугаар судалгаа (92.8%)-ны дүнтэй харьцуулахад 4.2%-иар өссөн үзүүлэлттэй эерэг үзүүлэлттэй байна.

Судалгаагаар нийт өрхийн 45.2% нь сайжруулсан ариун цэврийн байгууламжтай, 1.8% нь ил задгай бие засах газар ашиглаж байна. Энэхүү үзүүлэлтийг бүсээр харьцуулахад Баруун бүсэд сайжруулсан ариун цэврийн байгууламж ашигладаг өрх хамгийн бага (14.0%) байхад ил задгай бие засдаг өрх Зүүн бүсэд хамгийн их (5.9%) хувьтай байна. Сум, багийн түвшинд ил задгай бие засдаг өрхийн эзлэх хувь бусад байршилтай харьцуулахад их байв. Сайжруулсан ариун цэврийн байгууламж ашигладаг өрхийн эзлэх хувь 2017 онд хийсэн судалгаагаар 67.6% байсан бол энэ удаагийн судалгаагаар буурсан үзүүлэлттэй байгаа нь ариун цэврийн байгууламжийг сайжруулах талаар засаг, захиргааны нэгж тус бүртээ дорвитой арга хэмжээ авч ажиллах шаардлагатайг харуулж байна.

### Өрхийн хүнсний баталгаат байдал

Энэ удаагийн судалгаанд НҮБ-ын ХХААБ-аас зөвлөсөн хувь хүн, өрхийн түвшинд хүнсний аюулгүй байдлыг хянах туршлагад суурилсан хүнсний баталгаат бус байдлын хэмжүүр (FIES)-


ийг ашиглан 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн ХББ-ын алдагдлыг үнэлсэн болно. Харин хоол тэжээлийн үндэсний V судалгаагаар “Өрхийн хүнсний баталгаат байдлын алдагдлын хэмжээ” (ӨХББАХ) [40] -г тооцох аргаар 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн хүнсний баталгаат байдлыг судалсан байдаг. Ийнхүү одоогийн судалгаа болон 2017 оны судалгаанд ашигласан арга зүйн зөрүүтэй байдлыг харгалзан ХББ алдагдлын тархалтыг харьцуулан жиших боломжгүй гэж үзлээ.

Энэ удаагийн судалгаагаар 5 хүртэлх насны хүүхэдтэй нийт өрхийн 21.6% ХББ дунд зэрэг болон ноцтой алдагдсан байгааг илрүүлсэн болно. Өрхийн ХББ ноцтой алдагдсан өрхийн тархалт харьцангуй бага буюу 2.7% байна. ҮСХ-ны зохион байгуулдаг “Өрхийн нийгэм эдийн засгийн байдал” судалгаанд хамрагдсан өрхийн ХББ алдагдлыг тооцсон бөгөөд нийт өрхийн 2.7% ХББ дунд зэрэг болон ноцтой алдагдсан байгааг тогтоосон [41]. Энэхүү судалгаанд хамрагдсан өрхийн шинж байдал нь хоол тэжээлийн үндэсний VI судалгааны өрхөөс ялгаатай тул эдгээр судалгааны дүнг харьцуулан үнэлэх боломжгүй байна.

### **Иоджуулсан давсны хэрэглээ**


Иодын дутал нь хүний, ялангуяа бага насны хүүхэд, өсвөр үеийнхний бие бялдар, оюун ухааны хөгжилд сөргөөр нөлөөлж, оюуны чадамжийг 10-15 хувиар бууруулдаг болохыг олон оронд хийсэн судалгаа, шинжилгээний дүн нотолдог. НҮБ, ДЭМБ-аас 2000 онд дэлхий нийтээр иод дутлын эмгэгээс ангижрах зорилтыг дэвшүүлсэн бөгөөд манай улсын хувьд “Иод дутлын эмгэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг 3 удаа амжилттай хэрэгжүүлсэн. Мөн иод дутлаас хамааралтай бамбай булчирхайн өвчлөл 3 хүн тутмын 2 (71.0%), насны ангилалаар үзвэл 40-49 насанд хамгийн их буюу 65.2% байгаа бөгөөд уг өвчлөл нь нийт бамбай булчирхайн эмгэгийн 5.5%-ийг эзэлж байна [42].

Монгол улсын Засгийн газар иод дутлын эмгэгээс сэргийлэх, түүнийг бууруулах чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн үеэс 2010 он хүртэл иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн эзлэх хувь тасралтгүй өссөн үзүүлэлттэй байсан бол 2017 оноос хойш энэхүү үзүүлэлт буурч, иод дутлаас хамааралт эмгэгийн тоо ихсэх хандлага ажиглагдаж байна.



Зураг НН.4: Өрхийн иоджуулсан давсны хэрэглээ, судалгааны оноор

Өрхийн давсны хэрэглээг иоджуулаагүй (00 мг/кг), иодын агууламж бага буюу хангалтгүй түвшинд иоджуулсан (<15мг/кг), зохистой түвшинд иоджуулсан (15-30мг/кг) давс гэсэн 3 бүлэгт ангилж, үнэлсэн болно. Тав хүртэлх насны хүүхэдтэй өрхийн 47.4% зохистой түвшинд иоджуулагдсан давс хэрэглэж байв. Өрхийн давсны дээж дэх иодын дундаж хэмжээ 14.6 мг/кг байгаа нь өмнөх 2017 оны судалгааны үзүүлэлтээс буурсан байна. Уг үзүүлэлтийг бүсээр харьцуулан үзвэл Баруун 12.9 мг/кг, Хангай 13.4 мг/кг, Төв 20.5 мг/кг, Зүүн 15.5мг/кг, Улаанбаатар буурсан байв (Зураг НН.5).




Зураг НН.5: Өрхийн давсны дээжид агуулагдах иодын голч хэмжээ, бүсээр

Монгол улс 1990 оноос эхлэн хүн амын дундах иод дутлын эмгэгийг тархалтыг тандах, хянах, сэргийлэх асуудалд онцгой анхаарч, дотоодын давсны үйлдвэрлэлийг дэмжих, давсыг иоджуулж хэрэглэх чиглэлээр олон талт бодлого шийдвэр гаргаж, эрх зүйн орчныг бий болгон



ажилласан билээ. Гэвч сүүлийн жилүүдэд иод дутлын эмгэгтэй тэмцэх талаар төрийн бодлогын хэрэгжилт алдагдаж, ялангуяа иоджуулсан давсны дотоодын үйлдвэрлэл ихээхэн багасаж, улмаар айл өрх, хүн амын иоджуулсан давсны хэрэглээ буурч байгааг судалгааны дүн харуулж байна.

Энэ удаагийн судалгаагаар иоджуулсан давсны хэрэглээг судалгаанд хамрагдсан өрхийн давсны дээжинд агуулагдах иодын хэмжээгээр авч үзэхэд зохистой түвшинд иоджуулсан давс хэрэглэж байгаа өрх 2017 онд 78.9% байсан бол 2023 онд 47.4% болж буурсан. Мөн иоджуулаагүй давс хэрэглэдэг өрх 2017 оны түвшнээс 24.9%-иар нэмэгдэж байгаа нь цаашид иоджуулсан давсны хэрэглээг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах зайлшгүй шаардлагатай байна (Зураг НН.6).



Зураг НН.6: Өрхийн давсны хэрэглээ, иодын агууламжаар

Иоджуулаагүй болон хангалтгүй түвшинд иоджуулсан давсны хэрэглээ өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад хот, хөдөө, бүс, байршил ялгаагүй өссөн үзүүлэлттэй байна. Зохистой түвшинд иоджуулсан давсны хэрэглээ Төвийн бүсэд хамгийн их байна (Хүснэгт НН.12). Гэсэн хэдий ч 2017 оны судалгаатай харьцуулахад Баруун бүс 20.8%, Хангай 28.4%, Төв 12.1%, Зүүн

Хүснэгт НН.12: Иоджуулаагүй, хангалтгүй иоджуулсан давсны хэрэглээ, оноор

Үзүүлэлтүүд	Өрх, хувиар								
	Иоджуулаагүй [0 мг/кг]			Хангалтгүй түвшинд иоджуулсан (0.1-14.9 мг/кг)			Зохистой түвшинд иоджуулсан (≥15мг/кг)		
	2010 он	2017 он	2023 он	2010 он	2017 он	2023 он	2010 он	2017 он	2023 он
<b>Хот, хөдөөгөөр</b>									
Хот	8.1	14.5	42.2	5.6	2.6	10.9	78.4	81.6	46.9
Хөдөө	15.9	22.7	42.1	6.9	2.7	9.5	71.0	73.7	48.3

Бүсээр									
Баруун	41.0	31.1	45.3	9.8	8.3	15.2	41.0	60.4	39.6
Хангай	10.3	28.3	48.3	5.7	0.9	9.5	75.9	70.6	42.2
Төв	6.2	18.9	26.8	9.3	0.2	4.9	80.9	80.4	68.3
Зүүн	2.9	4.1	42.4	8.1	0.7	7.2	73.6	92.4	50.4
Улаанбаатар	5.9	10.5	44.1	3.2	2.9	12.0	83.4	85.0	43.9

## ДҮГНЭЛТ

1. Монгол улсын тав хүртэлх насны хүүхэдтэй 5 өрх тутмын 1 нь аж байдлын түвшин доогуур буюу ядуу бүлэгт багтаж байна. Аж байдлын түвшин доогуур өрхийн тархалт хөдөөд буюу ялангуяа сумын төв, багийн түвшинд харьцангуй түгээмэл (37.6%) байна. Аж байдлын түвшин доогуур өрхийн тархалт Хангай (33.5%) болон Зүүн (35.9%) бүсэд харьцангуй түгээмэл, Улаанбаатар хотод (5.9%) бага байв.
2. Тав хүртэлх насны хүүхэдтэй нийт өрхийн 96.0% сайжруулсан ундны усны эх үүсвэрийн ус ашиглаж байна. Сайжруулсан ундны усны эх үүсвэр ашигладаг өрхийн үзүүлэлт хотод хөдөөгөөс илүү байгаа бөгөөд нийт өрхийн 42.2% өөрийн эзэмшлийн ундны усны эх үүсвэртэй байв. Сайжруулсан ундны усны эх үүсвэр ашигладаг ядуу өрх (86.2%)-ийн үзүүлэлт 2017 оны судалгааны дүн (74.7%)-гээс өссөн байна.
3. Нийт өрхийн 45.2% сайжруулсан ариун цэврийн байгууламж ашиглаж байна. Ил задгай бие засдаг өрхийн тархалт үндэсний түвшинд харьцангуй бага (1.3%), харин хөдөө орон нутаг (5.4%), Зүүн ба Хангайн (5.9%, 4.5%) бүсэд харьцангуй илүү байв. Ариун цэврийн байгууламжгүй буюу ил задгай бие засдаг өрхийн үзүүлэлт хоол тэжээлийн үндэсний V судалгааны дүнгээс буурсан эерэг үзүүлэлт гарсан байна.
4. Монгол улсын тав хүртэлх насны хүүхэдтэй өрхийн 75.2% хүнсний баталгаат байдал нь хангагдсан эсвэл хөнгөн зэргийн алдагдалтай, 18.9% ХББ дунд зэрэг, 2.7% ХББ хүнд буюу ноцтой алдагдсан байна. ХББ нь ноцтой алдагдсан өрхийн тархалт Төвийн бүс (4.0%)-д харьцангуй их, Баруун бүс (1.8%) хамгийн бага байв. Мөн эмэгтэй өрхийн тэргүүнтэй (40.5%), аж байдлын түвшин доогуур өрхийн ХББ алдагдах магадлал харьцангуй илүү байгааг илрүүлэв. Тав хүртэлх насны хүүхэдтэй өрхийн гишүүдийн 4.9% хоол тэжээлийн дуталтай бүлэгт хамаарч байна.
5. Тав хүртэлх насны хүүхэдтэй өрхийн 47.4% зохистой хэмжээнд иоджуулсан давс, 10.5% хангалтгүй түвшинд иоджуулсан давс, 42.2% огт иоджуулаагүй давс хэрэглэж байв. Зохистой түвшинд иоджуулсан давсны хэрэглээ Баруун (39.6%) болон Хангайн (42.2%) бүс, Улаанбаатарт (43.9%) хамгийн бага, Зүүн (50.4%) болон Төвийн бүсэд (68.3%) харьцангуй түгээмэл байна. Үндэсний болон бүс нутгийн түвшинд зохистой хэмжээнд иоджуулагдсан давсны хэрэглээ 2017 оны судалгааны дүнгээс буурсан байгаа нь иод дутлаас сэргийлэх, хянах бодлогыг хэрэгжилтийг эрчимжүүлэх, иоджуулсан давсны дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатайг илтгэж байна.

## ТҮҮВРИЙН ШИНЖ БАЙДАЛ

Үндэсний түвшинд судалгаанд хамрагдсан 0-59 сартай хүүхдийн ерөнхий мэдээллийг UF.1,2 хүснэгтэд нэгтгэн харуулав. Нийт хүүхдийн 38.4% нь 2 хүртэлх насны хүүхэд байна. Судалгаанд хамрагдсан 5 хүртэлх насны хүүхдийн хүйсийн төлөөлөл харьцангуй жигд (охид 48.7%, хөвгүүд бусад угсаатан ястны цөөнх Баруун (64.6%) бүсэд, Зүүн (22.2%) бүсээс харьцангуй илүү байна.

Хүснэгт UF.1: Судалгаанд хамрагдсан 5 хүртэлх насны хүүхэд (Үндэсний түвшинд)

Үзүүлэлт	Жинлэсэн Хувь	СХ	9		Жинлээгүй тоо
			Доод	Дээд	
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>2786</b>
<b>Бүсээр</b>					
Баруун	13.2	0.1	13.0	13.4	557
Хангай	17.0	0.2	16.6	17.5	553
Төв	14.6	0.2	14.2	15.0	560
Зүүн	6.9	0.1	6.8	7.0	556
Улаанбаатар	48.3	0.3	47.7	48.9	560
<b>Хот, хөдөөгөөр</b>					
Хот	69.7	2.1	65.4	73.7	1480
Хөдөө	30.3	2.1	26.3	34.6	1306
<b>Байршлаар</b>					
Нийслэл	48.3	0.3	47.7	48.9	560
Аймгийн төв	21.4	2.1	17.5	25.9	920
Сумын төв / баг	30.3	2.1	26.3	34.6	1306
<b>Эхийн нас</b>					
< 20 нас	0.7	0.2	0.3	1.3	19
20-29 нас	32.6	1.1	30.6	34.7	896
30-39 нас	54.8	1.3	52.3	57.3	1453
40-49 нас	11.9	0.8	10.3	13.6	295
<b>Эхийн гэрлэлтийн байдал</b>					
Гэрлээгүй	76.4	1.4	73.5	79.0	2092
Гэрлэсэн	5.5	0.7	4.3	7.0	138
Хамтран амьдардаг	18.2	1.1	16.0	20.5	433
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>					
Халх	81.3	1.4	78.5	83.8	2116
Казак	4.6	0.9	3.1	6.8	183
Бусад	14.1	1.3	11.7	16.9	476
<b>Эхийн боловсролын түвшин</b>					

Боловсролгүй	1.3	0.2	1.0	1.7	54
Бага / суурь	4.5	0.5	3.6	5.7	147
Дунд	33.6	1.7	30.3	37.0	1004
Дээд	60.6	1.9	56.9	64.2	1458
<b>Хүүхдийн нас</b>					
0-5 сар	6.7	0.7	5.4	8.3	172
6-11 сар	11.0	0.9	9.4	13.0	307
12-23 сар	20.7	1.1	18.6	23.0	590
24-35 сар	22.7	1.0	20.8	24.8	656
36-59 сар	38.8	1.4	36.0	41.7	1061
<b>Хүүхдийн хүйс</b>					
Эрэгтэй	51.3	1.1	49.1	53.4	1428
Эмэгтэй	48.7	1.1	46.6	50.9	1358
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>					
Ядуу	19.1	1.2	16.9	21.7	739
Дунджаас доогуур	20.1	1.5	17.3	23.2	634
Дундаж	19.8	1.7	16.7	23.5	589
Дунджаас дээгүүр	20.2	1.6	17.3	23.4	491
Чинээлэг	20.7	2.5	16.2	26.2	323

Хүснэгт UF.2: Судалгаанд хамрагдсан 5 хүртэлх насны хүүхэд (Бүсийн түвшинд)

Үзүүлэлт	Жинлэсэн хувь	Бүс					Жинлээгүй тоо
		Баруун	Хангай	Төв	Зүүн	УБ	
Нийт	100.0	13.2					
<b>Хот, хөдөөгөөр</b>							
Хот	69.7	37.7	40.2	47.2	39.2	100.0	1480
Хөдөө	30.3	62.3	59.8	52.8	60.8	0.0	1306
<b>Байршлаар</b>							
Нийслэл	48.3	0.0	0.0	0.0	0.0	100.0	560
Аймгийн төв	21.4	37.7	40.2	47.2	39.2	0.0	920
Сум/Баг	30.3	62.3	59.8	52.8	60.8	0.0	1306
<b>Эхийн нас</b>							
< 20 нас	0.7	0.5	0.8	0.9	0.8	0.6	19
20-29 нас	32.6	31.4	35.8	37.7	33.3	30.1	896
30-39 нас	54.8	57.6	55.0	50.7	54.0	55.4	1453
40-49 нас	11.9	10.4	8.4	10.7	11.9	13.8	295
<b>Эхийн гэрлэлтийн байдал</b>							
Гэрлээгүй	76.4	93.1	81.0	70.6	75.9	71.8	2092
Гэрлэсэн	5.5	3.4	5.2	4.2	6.8	6.3	138
Хамтран амьдардаг	18.2	3.4	13.8	25.1	17.3	21.9	433
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>							
Халх	81.3	35.4	88.5	90.1	77.9	89.3	2116

Казак	4.6	30.8	0.0	1.4	0.6	0.6	183
Бусад	14.1	33.8	11.5	8.5	21.6	10.2	476
<b>Эхийн боловсрол</b>							
Боловсролгүй	1.3	3.3	2.5	1.4	2.8	0.0	54
Бага	4.5	6.1	6.8	4.5	7.4	2.9	147
Дунд	33.6	31.2	40.2	42.7	46.9	27.0	1004
Дээд	60.6	59.4	50.4	51.4	43.0	70.1	1458
<b>Хүүхдийн нас</b>							
0-5 сар	6.7	6.0	6.5	6.8	4.7	7.3	172
6-11 сар	11.0	12.1	10.0	10.3	11.3	11.3	307
12-23 сар	20.7	21.8	20.7	22.3	21.8	19.8	590
24-35 сар	22.7	21.4	21.8	26.3	26.3	21.8	656
36-59 сар	38.8	38.8	41.1	34.3	35.9	39.7	1061
<b>Хүүхдийн хүйс</b>							
Эрэгтэй	48.7	49.4	47.4	48.8	49.7	48.9	1358
Эмэгтэй	51.3	50.6	52.6	51.2	50.3	51.1	1428
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>							
Ядуу	19.1	25.0	33.9	31.7	36.5	5.9	739
Дунджаас доогуур	20.1	29.4	26.9	20.2	23.2	14.6	634
Дундаж	19.8	30.1	22.5	18.6	18.0	16.7	589
Дунджаас дээгүүр	20.2	11.9	9.8	23.2	17.8	25.6	491
Чинээлэг	20.7	3.6	6.8	6.3	4.5	37.2	323

ДЭМБ-ын удирдамжид нярай хүүхдийн төрөх үеийн биеийн жин нь 2500 граммаас бага байвал “бага жинтэй төрөлт”, харин 4000 граммаас их бол “том жинтэй төрөлт” гэж заасан байдаг. Нярай хүүхдийн биеийн жинг төрсний дараах 1 цагийн дотор хэмжихийг зөвлөдөг. Бага жинтэй төрөлт нь хүүхдийн эрүүл мэнд, эсэн мэнд амьдрахад олон эрсдэл дагуулдаг бөгөөд нярайн өвчлөл, эндэгдлийн суурь шалтгааны нэг болдог. Хүүхдийн төрөх үеийн биеийн жин бага байх нь тэдний бие махбодын өсөлт хөгжил, уураг тархины хөгжилд сөрөг нөлөө учруулахын зэрэгцээ насанд хүрсэн үед халдварт бус өвчнөөр өвчлөх эрсдэлийг нэмэгдүүлдэг байна [43].

Тав хүртэлх насны хүүхдийн 99.4% төрөх үедээ жинлэгдсэн байв. Төрөх үед нь жинлэсэн хүүхдийн хувь судалгаанд сонгосон үзүүлэлтээр төдийлөн ялгаатай бус, харьцангуй жигд өндөр байна. Нийт хүүхдийн 3.9% бага жинтэй, 11.8% том жинтэй төрсөн байв. Төрөх үеийн биеийн жинг хүүхдийн хүйсээр харьцуулан үзвэл, бага жинтэй бүлэгт хүйсийн ялгаа илрээгүй боловч, том жинтэй төрөлт хөвгүүдийн (14.2%) дунд охидоос (9.2%) илүү байв. Бага жинтэй төрөлт Баруун бүсэд (7.2%) хамгийн их байгаа бол том жинтэй төрөлт Зүүн бүсэд (16.2%) харьцангуй илүү байна. Бага жинтэй төрөлтийн тархалт Казак үндэстний дунд халх болон бусад ястны үзүүлэлтээс 3.7–4.0 дахин их байгааг судалгаагаар илрүүлэв ( $p < 0.0001$ ). Мөн эхийн нас, биеийн жин нэмэгдэх тутам том жинтэй төрөлтийн тархалт нэмэгдэх статистик ач холбогдол бүхий ялгаатай байна. Тодруулбал, туранхай эхчүүдийн дунд том жинтэй төрөлт

2.3% байгаа бол тарган эхээс төрсөн хүүхдүүдийн 20.4% том жинтэй төржээ ( $p < 0.0001$ ). Мөн 5 хүртэлх насны хүүхдийн төрөх үеийн биеийн жин нь тэдний эхийн боловсролын түвшнээр ялгаатай, боловсролын түвшин дээшлэх тутам бага жинтэй төрөлт багасаж, харин том жинтэй төрөлтийн хувь ихсэж ( $p = 0.003$ ) байна (Хүснэгт UF.3).

Хүснэгт UF.3: Тав хүртэлх насны хүүхдийн төрөх үеийн биеийн жин

Үзүүлэлт	Бага жинтэй төрөлт (< 2500 г)			Том жинтэй төрөлт ( $\geq 4000$ г)			Төрөх үед жинлэгдсэн %	Жинлээгүй тоо
	%	95% ИХ		%	95% ИХ			
		доод	дээд		доод	дээд		
<b>Бүгд</b>	<b>3.9</b>	<b>3.1</b>	<b>4.9</b>	<b>11.8</b>	<b>10.3</b>	<b>13.5</b>	<b>99.4</b>	<b>2786</b>
<b>Хүүхдийн хүйс</b>								
Эрэгтэй	3.9	2.8	5.4	9.2	7.2	11.7	99.2	1349
Эмэгтэй	3.9	2.8	5.3	14.2	12.1	16.7	99.6	1425
<b>Насаар</b>								
0 – 5 сар	2.4	0.7	7.6	8.9	5.6	14.0	100.0	172
6 – 11 сар	4.8	2.5	9.0	14.1	10.5	18.8	100.0	307
12 – 23 сар	5.8	3.8	8.8	12.0	8.6	16.6	99.3	587
24 – 35 сар	3.2	2.0	5.0	12.1	9.2	15.9	99.4	653
36 – 59 сар	3.3	2.3	4.8	11.3	9.3	13.6	99.1	1055
<b>Бүсээр</b>								
Баруун	7.2	5.4	9.5	8.7	6.5	11.5	99.3	557
Хангай	3.0	1.8	5.0	9.9	7.5	13.0	100.0	553
Төв	3.5	2.4	5.2	12.9	10.2	16.2	99.6	560
Зүүн	5.3	3.7	7.6	16.2	13.3	19.6	99.8	556
Улаанбаатар	3.2	1.9	5.2	12.3	9.7	15.5	99.1	560
<b>Хот, хөдөөгөөр</b>								
Хот	3.7	2.7	5.1	12.0	10.0	14.2	99.3	1474
Хөдөө	4.2	3.2	5.6	11.4	9.4	13.7	99.6	1300
<b>Байршлаар</b>								
Нийслэл	3.2	1.9	5.2	12.3	9.7	15.5	99.1	555
Аймгийн төв	5.0	3.8	6.5	11.2	9.4	13.2	99.9	919
Сумын төв / баг	4.2	3.2	5.6	11.4	9.4	13.7	99.6	1300
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>								
Ядуу	4.4	3.0	6.5	10.1	7.9	12.7	99.6	739
Дунджаас доогуур	4.8	3.2	7.1	11.3	8.5	14.7	98.5	634
Дундаж	4.0	2.7	5.9	9.9	7.7	12.5	99.6	589
Дунджаас дээгүүр	2.7	1.5	5.0	13.2	10.0	17.3	99.8	491
Чинээлэг	3.7	8.0	6.8	13.8	10.3	18.1	99.6	323
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>								
Халх	3.5	2.6	4.7	11.9	10.2	13.9	99.5	2110
Казак	12.8	8.8	18.2	5.4	3.1	9.2	98.4	180
Бусад	3.2	1.8	5.6	13.0	9.9	17.0	99.1	473
<b>Эхийн нас</b>								
16-29 нас	2.9	2.0	4.2	8.4	6.5	10.7	99.7	915
30-39 нас	4.3	3.2	5.7	13.8	11.9	16.1	99.6	1449
40-49 нас	4.7	2.5	8.5	12.7	8.9	18.0	99.8	294
<b>Эхийн хоол тэжээлийн байдал</b>								
Туранхай	6.0	2.1	16.2	2.3	0.7	7.1	100.0	81
Хэвийн жинтэй	3.3	2.4	4.7	9.4	7.5	11.8	99.4	1095
Илүүдэл жинтэй	3.0	2.0	4.5	11.8	9.4	14.8	99.9	852
Тарган	6.4	3.9	10.2	20.4	16.0	25.7	99.9	494
<b>Эхийн ажил эрхлэлт</b>								
Ажилтай	3.2	2.4	4.1	12.4	10.6	14.4	99.5	1765

Ажилгүй	5.0	3.6	7.0	11.0	8.4	14.2	99.9	898
<b>Эхийн гэрлэлтийн байдал</b>								
Гэрлэсэн	4.0	3.1	5.2	12.5	10.6	14.6	98.0	2092
Гэрлээгүй	1.9	0.7	5.2	7.8	3.5	16.6	97.9	138
Хамтран амьдардаг	3.6	2.1	6.1	10.5	7.2	15.1	99.5	433
<b>Эхийн боловсролын түвшин</b>								
Боловсролгүй	5.3	1.1	22.2	9.3	3.6	22.0	98.0	54
Бага / суурь	5.4	2.8	9.9	4.7	2.3	9.4	97.9	147
Дунд	4.9	3.4	7.1	9.2	7.1	11.8	99.5	1004
Дээд	3.2	2.2	4.4	13.9	11.8	16.3	99.9	1458

## Хоол тэжээлийн байдал

Хоол тэжээлийн дутал нь жил бүр 2.7 сая хүүхдийн эндэгдлийн суурь шалтгаан болж, хүүхдийн эндэгдлийн 45% хоол тэжээлийн дуталтай холбоотой байгааг ДЭМБ-аас мэдээлсэн байдаг. Дэлхий дахинд 2022 оны байдлаар 5 хүртэлх насны 149 сая хүүхэд өсөлт хоцролттой (өндөр-насны үзүүлэлт бага), 45 сая хүүхэд туранхай (жин-өндрийн үзүүлэлт бага), 37 сая хүүхэд (жин-өндрийн үзүүлэлт их) илүүдэл жинтэй байна [44].

Нялх, бага насны хүүхдийн хооллолт нь тэдний өсөлт, хөгжил хэвийн явагдах, эрүүл чийрэг эсэн мэнд амьдрахад нөлөөлдөг суурь хүчин зүйл юм. Ялангуяа амьдралын эхний 2 жилд шим тэжээллэг хоол хүнс хэрэглэж чадвал өвчлөл, нас баралт, ирээдүйд халдварт бус өвчнөөр өвчлөх эрсдэлийг бууруулдаг.

Жин-насны үзүүлэлтээр насандаа тохирохгүй бага жинтэй буюу тураалтай хүүхдийг илрүүлдэг. Тураалтай хүүхэд нь өсөлтийн хоцролттой, туранхай эсвэл хоёул хавсарсан байдлаар илэрч болно. ДЭМБ-ын 5 хүртэлх насны хүүхдийн биеийн жин – насны үзүүлэлтийн дундаж голчоос 2 стандарт хазайлт (СХ)-аас доогуур хүүхдийг хүндэвтэр тураалтай, 3 СХ-аас доош байвал хүнд тураалтай гэж оношилдог.

Өндөр-насны үзүүлэлт нь хүүхдийн өсөлтийг хэмждэг гол хэмжигдэхүүн юм. Өсөлт хоцролт нь архаг, урт хугацааны хоол тэжээлийн дутлаас үүдэлтэй эмгэг бөгөөд ихэвчлэн амьжиргааны түвшин доогуур, эхийн эрүүл мэнд, хоол тэжээлийн байдал тааруу, хүүхэд ойр ойрхон өвчлөх, хооллолтын дадал тааруу зэргээс шалтгаалан илэрдэг хоол тэжээлийн архаг дутал юм. Тав хүртэлх насны хүүхдийн өсөлтийн стандартын дундаж голчоос 2 стандарт хазайлт доогуур хүүхдийг хүндэвтэр, 3 СХ-аас доош хүүхдийг хүнд хэлбэрийн өсөлт хоцролттой гэж үнэлдэг.

Биеийн жин-өндрийн үзүүлэлтийг туранхай болон илүүдэл жинтэй хүүхдийг илрүүлэхэд ашигладаг. Туранхай байдал нь богино хугацаанд огцом жин алдсан хүүхдийг тодорхойлохын зэрэгцээ, урт хугацаанд биеийн өндөртөө тохирохгүй бага жинтэй (туранхай) байсан тохиолдлыг ч илэрхийлнэ. Туранхай байдал нь хүүхэд тэжээллэг хоол, хүнсийг хангалттай хэмжээгээр хэрэглэж чадаагүй, эсвэл өвчний улмаас огцом жингээ алдах үед тохиолддог. Яаралтай эмчлээгүй тохиолдолд туранхай хүүхэд эндэх өндөр эрсдэлтэй байдаг. Биеийн жин–

өндрийн стандарт үзүүлэлтийн дундаж голчоос 2 стандарт хазайлт доогуур хүүхдийг хүндэвтэр, 3 СХ-аас доош хүүхдийг хүнд туранхай гэж үнэлсэн бөгөөд 2 стандарт хазайлтаас дээгүүр хүүхдийг илүүдэл жинтэй хэмээн тус тус үнэлсэн болно.

Тав хүртэлх насны хүүхдийн антропометрийн хэмжилтийн дүнгээр тодорхойлсон хүүхдийн *Жин-Нас, Өндөр-Нас, Жин-Урт / өндрийн* үзүүлэлтийг UF.4, UF.5, UF.6 дугаар хүснэгтэд нэгтгэн харуулав. Мөн эдгээр антропометрийн хэмжилтийн Z-онооны дундаж хэмжээг харгалзах хүснэгтэд нэгтгэн үзүүлсэн болно.

Хүүхдийн биеийн жин–насны үзүүлэлтээр тодорхойлсон тураалын тархалт бага буюу нийт хүүхдийн 1.5% тураалтай байна (Хүснэгт UF.4). Бага жинтэй төрсөн хүүхдийн (10.9%) дунд хэвийн жинтэй (тураал 0.3%) ба том жинтэй төрсөн (тураал 0.0%) хүүхэдтэй харьцуулахад тураалын тархалт өндөр байв ( $p < 0.0001$ ).

Хүснэгт UF.4: Тав хүртэлх насны хүүхдийн биеийн жин–насны үзүүлэлт

Үзүүлэлт	Тураал						Дундаж Z Оноо (СХ) <sup>c</sup>	Жинлээгүй Тоо
	Хүндэвтэр болон хүнд (< -2 СХ <sup>a</sup> )			Хүнд (< -3 СХ <sup>b</sup> )				
	95% ИХ		Доод	95% ИХ		Доод		
Доод	Дээд	Доод		Дээд				
<b>Нийт</b>								<b>2767</b>
<b>Хүүхдийн хүйс</b>								
Эмэгтэй	1.1	.6	1.9	.6	.2	1.6	.28	1348
Эрэгтэй	1.9	1.3	2.9	.3	.1	.8	.34	1417
<b>Хүүхдийн нас</b>								
0-5 сар	3.0	1.0	8.5	2.0	.5	8.2	.60	171
6-11 сар	.9	.2	5.1				.88	306
12-23 сар	2.4	1.2	4.6	.7	.2	2.5	.45	5
24-35 сар	1.0	.5	2.1	.4	.1	1.6	.23	651
36-59 сар	1.2	.7	2.2	.2	.1	.8	.07	1055
<b>Хүүхдийн төрөх үеийн жин</b>								
Бага жинтэй	13.1	6.6	24.4	2.3	.3	15.0	-	119
Хэвийн жинтэй	1.2	.8	1.9	.4	.2	.9	.28	2265
Том жинтэй	.2	.0	1.4	.2	-	1.4	.83	328
<b>Бүсээр</b>								
Баруун	2.8	1.7	4.8	.9	.3	2.4	.04	557
Хангай	1.7	0.9	3.0	.2		1.3	.31	543
Төв	1.4	.5	3.6	.8	.2	3.7	.32	558
Зүүн	1.3	.6	2.5	.4	.1	1.4	.28	551
Улаанбаатар	1.1	.5	2.4	.4	.1	1.5	.39	556
<b>Хот, хөдөөгөөр</b>								
Хот	1.4	.9	2.3	.5	.2	1.2	.34	1468



Хөдөө	1.7	1.0	2.6	.4	.1	1.1	.25	1297
<b>Байршлаар</b>								
Нийслэл	1.1	.5	2.4	.4	.1	1.5	.39	556
Аймгийн төв	2.1	1.3	3.5	.8	.2	2.4	.23	912
Сум/баг	1.7	1.0	2.6	.4	.1	1.1	.25	1297
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>								
Ядуу	2.2	1.1	4.4	1.2	0.4	3.6	0.14	734
Дунджаас доогуур	1.4	0.6	3.1	0.3	0.1	1.1	0.27	632
Дундаж	1.7	0.9	3.2	0.4	0.1	1.5	0.21	584
Дунджаас дээгүүр	1.7	0.7	4.3	0.5	0.1	3.2	0.31	484
Чинээлэг	0.6	0.1	2.6	0.1	0.0	0.4	0.59	323
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>								
Халх	1.2	.8	1.9	.4	.2	1.1	.33	2108
Казак	6.7	3.1	13.9	2.0	.7	6.0	-	183
Бусад	1.6	.6	3.9	.1	.0	.7	.33	476
<b>Эхийн нас</b>								
< 20 нас					-	-	-	19
20-29 нас	1.2	.6	2.6	.4	.1	1.9	.35	889
30-39 нас	1.6	1.0	2.5	.5	.2	1.3	.31	1441
40-49 нас	1.0	.5	2.4	.4	.1	1.7	.20	294
<b>Эхийн хоол тэжээлийн байдал</b>								
Тураалтай	1.8	.4	7.3	-	-	-	.25	80
Хэвийн жинтэй	1.9	1.1	3.2	.6	.2	1.7	.21	1089
Илүүдэл жинтэй	1.4	.7	2.8	.6	.2	1.8	.37	847
Тарган	.9	.4	1.9	.1	.0	1.0	.45	486
<b>Эхийн ажил эрхлэлт</b>								
Ажилтай	1.3	.8	2.2	.5	.2	1.2	.27	1755
Ажилгүй	1.7	1.0	2.9	.5	.1	1.5	.36	888
<b>Эхийн гэрлэлтийн байдал</b>								
Гэрлэсэн	1.4	1.0	2.1	0.30	0.10	0.7	.29	2075
Гэрлээгүй	2.4	.5	10.4	1.80	0.20	11.6	.24	138
Хамтран амьдардаг	1.5	.5	4.1	0.80	0.20	3.0	.39	430
<b>Эхийн боловсрол</b>								
Боловсролгүй	5.8	1.9	16.6	3.8	.9	14.3	-	54
Бага / суурь	2.6	1.0	6.4	.0			.16	147
Дунд	2.4	1.3	4.1	1.1	.4	2.7	.15	993
Дээд	.8	.4	1.5	.1		.5	.41	1449
(-) Жинлээгүй тоон үзүүлэлт нь 25-аас бага тохиолдлыг хассан.								

Мөн 5 хүртэлх насны хүүхдийн дундах тураалын тархалт эхийн боловсролын түвшин ( $p=0.003$ ), насны бүлэг ( $p=0.006$ ), өрхийн тэргүүний үндэс ( $p<0.0001$ ) угсаагаар ялгаатай, залуу, боловсролгүй эхийн хүүхдүүд, Казак үндэстний дунд харьцангуй илүү байгааг судалгаагаар илрүүлэв (Хүснэгт UF.4).

Судалгаагаар 5 хүртэлх насны нийт хүүхдийн 8.4% өсөлт хоцролттой, 2.8% хүнд хэлбэрийн өсөлт хоцролттой байгааг тогтоов. Хөвгүүдийн 9.3% өсөлт хоцролттой байгаа нь охидтой (7.5%) харьцуулахад ялимгүй илүү байна. Бага жинтэй төрсөн хүүхдүүд (23.9%) нь хэвийн жинтэй харьцангуй их байв ( $p < 0.0001$ ). Өсөлт хоцролтын тархалтыг сонгосон үзүүлэлтээр харьцуулан үнэлэхэд, хөдөөд хотоос илүү ( $p = 0.004$ ), Баруун болон Хангайн бүсэд Зүүн бүс, Улаанбаатар хотоос илүү байна ( $p = 0.002$ ). Мөн Казак үндэстэн хүүхдийн дунд (13.1%) өсөлт хоцролтын тархалт Халх ястан (5.7%)-аас 2 дахин илүү ( $p < 0.0001$ ), эхийн боловсролын түвшин бага байх нь хүүхдийн өсөлт хоцролтын эрсдэлийг нэмэгдүүлж ( $p < 0.0001$ ) байв. Аж байдлын түвшин доогуур өрхийн хүүхдийн дунд (13.1%) өсөлт хоцролтын тархалт чинээлэг өрхийн хүүхэдтэй (3.9%) харьцуулахад 3.4 дахин ( $p = 0.001$ ), өрхийн ХББ ноцтой алдагдсан өрхийн 5 хүртэлх насны хүүхдийн дунд өсөлт хоцролтын тархалт 2.1 дахин илүү байгааг ( $p = 0.02$ ) судалгаагаар илрүүлэв. Хүнд хэлбэрийн өсөлт хоцролтын тархалт нь хүүхдийн нас, төрөх үеийн биеийн жин, эхийн хоол тэжээлийн байдал, өрхийн тэргүүний үндэс угсаагаар ялгаатай байв. Тодруулбал, бага жинтэй төрсөн хүүхэд, Казак үндэстэн, хэвийн жинтэй эхийн хүүхдийн дунд хүнд хэлбэрийн өсөлт хоцролтын тархалт илүү түгээмэл байгааг UF.5 хүснэгтээс харж болно.

Хүснэгт UF.5: Тав хүртэлх насны хүүхдийн биеийн урт / өндөр – насны үзүүлэлт

Үзүүлэлтүүд	Өсөлт хоцролт						Дундаж Z Оноо (СХ) <sup>c</sup>	Жинлээгүй тоо
	Хүндэвтэр ба хүнд (< -2 СХ)			Хүнд (< -3 СХ)				
	95% ИХ			95% ИХ				
	Доод	Дээд		Доод	Дээд			
<b>Нийт</b>		.2						
<b>Хүүхдийн хүйс</b>								
Эрэгтэй	9.3	7.7	11.3	3.1	2.2	4.2	-	1
Эмэгтэй	7.5	5.9	9.4	2.5	1.6	3.8	-	1
<b>Хүүхдийн нас</b>								
0-5 сар	10.5	6.0	17.7	2.7	1.3	5.6	0.17	
6-11 сар	7.4	4.7	11.6	3.8	2.0	7.0	0.19	3
12-23 сар	11.7	8.9	15.2	4.5	2.9	7.0	-0.47	
24-35 сар	8.5	6.3	11.2	3.0	1.8	4.8	-0.46	
36-59 сар	6.6	5.2	8.5	1.5	0.8	2.7	-0.46	
<b>Хүүхдийн төрөх үеийн жин</b>								
Бага жинтэй	29.6	19.9	41.5	12.2	5.7	24.5	-1.20	1
Хэвийн жинтэй	8.3	7.0	9.9	2.7	2.0	3.7	-0.37	2
Жин ихтэй	3.4	1.7	6.5	0.5	0.1	2.0	0.12	3
<b>Бүсээр</b>								
Баруун	11.2	8.6	14.6	3.0	1.7	5.1	-0.54	5
Хангай	11.9	9.3	15.0	3.8	2.5	5.9	-0.62	549

Төв	10.0	7.4	13.3	4.4	2.7	7.0	-0.40	5
Зүүн	7.4	5.5	9.8	1.5	.7	3.0	-0.48	5
Улаанбаатар	6.1	4.3	8.7	2.0	1.2	3.6	-0.16	5
<b>Хот, хөдөөгөөр</b>								
Хот	7.2	5.8	9.0	2.6	1.8	3.6	-0.26	1
Хөдөө	11.2	9.1	13.6	3.3	2.2	4.8	-0.54	1
<b>Байршлаар</b>								
Нийслэл	6.1	4.3	8.7	2.0	1.2	3.6	-0.16	5
Аймгийн төв	9.7	8.0	11.8	3.7	2.6	5.3	-0.48	9
Сум/баг	11.2	9.1	13.6	3.3	2.2	4.8	-0.54	1
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>								
Ядуу	13.1	10.1	16.8	4.3	2.7	6.7	-0.69	731
Дунджаас доогуур	10.1	7.7	13.3	3.7	2.3	6.0	-0.49	632
Дундаж	8.1	5.8	11.3	1.9	1.0	3.7	-0.45	581
Дунджаас дээгүүр	7.5	4.8	11.6	2.2	1.0	4.7	-0.23	479
Чинээлэг	3.9	2.2	6.8	1.9	0.8	4.3	0.11	319
<b>Өрхийн хүнсний баталгаат байдал</b>								
ХББ хангагдсан	7.9	6.6	9.4	2.9	2.1	3.9	-0.27	
ХББ дунд зэрэг алдагдсан	10.7	7.9	14.3	2.5	1.4	4.6	-0.59	
ХББ ноцтой алдагдсан	16.6	8.9	29.0	4.5	1.7	11.8	-0.79	
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>								
Халх	8.4	7.0	10.1	2.6	1.9	3.6	-0.32	2087
Казак	17.3	11.7	24.8	6.9	3.3	13.8	-0.73	178
Бусад	6.1	4.5	8.3	2.6	1.4	4.8	-0.38	468
<b>Эхийн нас</b>								
< 20 нас							-1.53	19
20-29 нас	8.2	6.4	10.4	2.7	1.8	4.2	-0.35	890
30-39 нас	8.8	7.3	10.6	2.8	2.0	4.0	-0.34	1426
40-49 нас	7.0	4.4	11.0	2.0	0.6	5.9	-0.39	289
<b>Эхийн хоол тэжээлийн байдал</b>								
Тураалтай	6.1	2.9	12.3	0.8	0.1	5.9	-0.45	81
Хэвийн жинтэй	9.9	8.0	12.2	3.7	2.6	5.3	-0.37	1080
Илүүдэл жинтэй	8.2	6.3	10.6	2.8	1.8	4.4	-0.31	839
Тарган	6.9	4.8	9.7	1.0	0.4	2.6	-0.38	484
<b>Эхийн ажил эрхлэлт</b>								
Ажилтай	8.5	6.9	10.3	2.9	2.1	4.0	-0.41	1739
Ажилгүй	8.9	6.9	11.5	2.5	1.5	4.2	-0.26	885
<b>Эхийн гэрлэлтийн байдал</b>								
Гэрлэсэн	8.4	7.0	10.0	2.8	2.1	3.8	-0.35	2059
Гэрлээгүй	8.9	4.4	17.2	1.1	0.3	4.4	-0.39	136
Хамтран амьдардаг	9.7	6.5	14.1	3.1	1.7	5.8	-0.38	429
<b>Эхийн боловсрол</b>								
Боловсролгүй	17.2	8.9	30.5	2.1	0.3	13.6	-0.65	52
/ суурь	16.0	10.4	24.0	3.1	1.3	7.1	-0.65	146
Дунд	10.6	8.7	12.9	3.9	2.6	5.6	-0.58	987

Дээд	6.8	5.4	8.6	2.2	1.4	3.3	-0.21	1439
(-) Жинлээгүй тоон үзүүлэлт нь 25-аас бага тохиолдлыг хассан.								

Тав хүртэлх насны хүүхдийн биеийн жин–урт / өндрийн үзүүлэлтийг хоол тэжээлийн цочмог дутал буюу туранхай, илүүдэл жин ба таргалалтыг тодорхойлоход ашигладаг. МУ-ын 5 хүртэлх насны нийт хүүхдийн 1.3% туранхай (WHZ < -2 SD), 0.4% хүнд хэлбэрийн хоол тэжээлийн цочмог дуталтай (WHZ < -3 SD) байгаа нь тархалтын харьцангуй бага үзүүлэлт юм (Хүснэгт UF.6). Тураал болон өсөлт хоцролтын нэгэн адил бага жинтэй төрсөн хүүхэд (3.5%)-ийн дунд хэвийн (1.4%) болон том жинтэй (0.4%) төрсөн хүүхэдтэй харьцуулахад туранхай байгаа тохиолдол илүү түгээмэл байв. Нийт 5 хүртэлх насны хүүхдийн 11.3% нь жин-өндрийн үзүүлэлт өндөртэй (WHZ > +2 CX) буюу илүүдэл жинтэй байна. Илүүдэл жинтэй хүүхдийн тархалт Хангайн бүсэд 13.5%, Төвийн бүсэд 15.8% байгаа бөгөөд 2 хүртэлх насны хүүхэд болон том жинтэй төрсөн хүүхдийн дунд харьцангуй түгээмэл илэрсэн болно. Мөн хөвгүүдийн дунд жинтэй байх магадлал ихсэж, 12 сар хүртэлх насны 5 хүүхэд тутмын 1 нь илүүдэл жинтэй байгаа бөгөөд том жинтэй төрсөн 5 хүүхэд тутмын 1 орчим нь илүүдэл жинтэй байна (Хүснэгт

Хүснэгт УФ.6: Тав хүртэлх насны хүүхдийн жин–урт / өндрийн үзүүлэлт

Үзүүлэлтүүд	Биеийн жин – урт / өндрийн үзүүлэлт												Дундаж Z-Оноо (СХ) <sup>d</sup>	Жинлээгүй тоо
	Хүндэвтэр ба хүнд туранхай (< -2 СХ)			Хүнд туранхай (< -3 СХ)			Илүүдэл жин (> +2 СХ)			Таргалалт (> +3 СХ)				
	%	95% ИХ		%	95% ИХ		%	95% ИХ		%	95% ИХ			
доод		дээд	доод		дээд	доод		дээд	доод		дээд			
<b>Нийт</b>	<b>1.3</b>	<b>0.3</b>	<b>0.9</b>	<b>0.6</b>	<b>0.4</b>	<b>1.0</b>	<b>11.3</b>	<b>9.9</b>	<b>12.9</b>	<b>2.3</b>	<b>1.7</b>	<b>3.0</b>	<b>0.69</b>	<b>2722</b>
<b>Хүүхдийн хүйс</b>														
Эрэгтэй	1.5	0.9	2.5	0.8	0.4	1.5	12.5	10.6	14.5	2.7	1.9	3.7	0.63	1392
Эмэгтэй	1.2	0.7	2.1	0.5	0.3	0.9	10.2	8.3	12.5	1.9	1.1	3.1	0.75	1330
<b>Хүүхдийн нас</b>														
0-5 сар	3.7	1.7	7.7	2.5	1.1	5.5	19.7	13.6	27.8	8.3	4.3	15.6	0.76	165
6-11 сар	2.3	0.9	5.4	0.5	0.2	1.7	19.6	14.4	26.0	3.2	1.6	6.2	1.07	303
12-23 сар	1.9	0.9	4.1	0.8	0.3	2.5	16.1	12.5	20.4	3.2	1.9	5.4	0.86	575
24-35 сар	0.6	0.2	1.3	0.4	0.1	1.1	9.3	6.8	12.6	1.2	0.6	2.7	0.65	639
36-59 сар	0.8	0.4	1.8	0.3	0.1	0.9	6.2	4.5	8.5	1.1	0.6	2.1	0.50	1040
<b>Хүүхдийн төрөх үеийн жин</b>														
Бага жинтэй	3.5	0.9	12.5	3.5	0.9	12.5	5.4	2.0	13.5	0.7	0.1	4.8	0.01	119
Хэвийн жинтэй	1.4	0.9	2.1	0.6	0.3	1.0	10.7	9.3	12.3	2.1	1.5	2.9	0.68	2231
Том жинтэй	0.4	0.1	1.4	0.1	0.0	0.8	18.7	14.0	24.4	4.5	2.4	8.0	1.05	321
<b>Бүсээр</b>														
Баруун	2.9	1.6	5.0	1.8	0.9	3.6	9.6	7.4	12.3	1.8	1.0	3.4	0.50	545
Хангай	1.0	0.4	2.2	0.2	0.0	1.3	13.5	10.9	16.7	2.2	1.4	3.6	0.88	537
Төв	1.9	0.8	4.4	1.5	0.6	3.7	15.8	12.8	19.2	4.1	2.5	6.7	0.70	551
Зүүн	0.9	0.4	2.1	0.4	0.1	1.5	8.3	6.1	11.0	2.0	0.9	4.5	0.73	544
Улаанбаатар	0.9	0.4	2.2	0.2	0.0	1.3	10.2	7.8	13.3	1.9	1.1	3.2	0.66	545
<b>Хот, хөдөөгөөр</b>														
Хот	1.1	0.6	1.9	0.4	0.2	1.0	10.8	9.0	13.0	2.0	1.3	3.0	0.67	1445
Хөдөө	2.0	1.3	3.2	1.1	0.6	2.1	12.5	10.8	14.4	2.8	2.1	3.9	0.73	1277
<b>Байршлаар</b>														
Нийслэл	0.9	0.4	2.2	0.2	-	1.3	10.2	7.8	13.3	1.9	1.1	3.2	0.66	545
Аймгийн төв	1.3	0.6	2.7	0.9	0.4	2.1	12.2	9.8	15.1	0.7	1.3	4.2	0.69	900
Сум / баг	2.0	1.3	3.2	1.1	0.6	2.1	12.5	10.8	14.4	2.8	2.1	3.9	0.73	1277
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>														
Ядуу	1.2	0.6	2.4	0.9	0.4	2.2	12.4	10.0	15.4	2.5	1.4	4.3	0.75	726
Дунджаас доогуур	1.8	0.9	3.4	1.3	0.6	2.9	12.1	9.6	15.2	3.6	2.2	5.9	0.69	627
Дундаж	2.2	1.1	4.2	0.5	0.2	1.2	9.3	6.6	12.9	1.2	0.6	2.3	0.66	568
Дунджаас дээгүүр	0.6	0.3	1.5	0.4	0.1	1.2	11.9	8.8	15.9	1.6	0.8	3.4	0.63	474

Чинээлэг	1.0	0.3	3.3	0.0	-	-	10.9	7.7	15.2	2.5	1.3	4.8	0.71	317
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>														
Халх	1.2	0.7	1.9	0.6	0.3	1.1	11.5	9.8	13.5	2.3	1.7	3.1	0.70	2080
Казак	5.3	2.1	12.8	2.2	0.7	6.6	10.1	7.1	14.1	1.1	0.3	4.0	0.32	175
Бусад	1.2	0.5	2.7	0.3	0.1	1.3	10.8	7.7	14.8	2.7	1.4	4.9	0.71	467
<b>Эхийн нас</b>														
< 20 нас	-	-	-	-	-	-	-	-	-	0.0	-	-	-	19
20-29 нас	2.0	1.1	3.7	0.8	0.4	1.7	13.4	11.1	16.2	2.4	1.5	3.9	0.74	884
30-39 нас	1.2	0.7	2.1	0.6	0.3	1.3	11.1	9.1	13.3	2.5	1.7	3.7	0.67	1412
40-49 нас	0.6	0.2	2.0	0.2	-	1.6	7.5	4.9	11.4	1.8	0.7	4.7	0.63	288
<b>Эхийн хоол тэжээлийн байдал</b>														
Тураалтай	-	-	-	-	-	-	12.2	6.1	22.9	0.8	0.1	5.9	0.68	80
Хэвийн жинтэй	1.8	1.1	3.0	0.5	0.2	1.1	9.8	7.9	12.1	2.5	1.6	3.9	0.59	1073
Илүүдэл жинтэй	1.2	0.6	2.5	0.8	0.4	1.7	12.5	9.9	15.8	2.2	1.2	3.7	0.75	833
Тарган	1.1	0.4	3.2	0.9	0.2	3.2	13.0	9.8	16.9	2.5	1.4	4.5	0.85	477
<b>Эхийн ажил эрхлэлт</b>														
Ажилтай	1.1	0.7	1.8	0.6	0.3	1.0	11.6	9.9	13.6	2.3	1.6	3.3	0.69	1725
Ажилгүй	1.9	1.0	3.4	0.8	0.3	1.9	11.1	8.5	14.5	2.5	1.5	4.1	0.69	878
<b>Эхийн гэрлэлтийн байдал</b>														
Гэрлэсэн	1.3	0.8	2.0	0.6	0.3	1.1	10.3	8.7	12.2	1.9	1.4	2.7	0.65	2041
Гэрлээгүй	0.6	0.1	4.1	-	-	-	12.6	7.3	20.8	0.6	0.1	3.9	0.74	136
Хамтран амьдардаг	2.3	1.1	4.8	1.0	0.4	2.1	15.5	11.9	20.0	4.7	2.8	7.8	0.84	426
<b>Эхийн боловсрол</b>														
Боловсролгүй	2.0	0.3	12.4	2.0	0.3	12.4	17.7	9.2	31.5	2.0	0.3	13.3	0.67	53
Бага / суурь	0.8	0.2	3.5	-	-	-	10.5	5.9	18.2	3.9	1.4	10.8	0.71	146
Дунд	1.7	0.9	3.1	1.1	0.5	2.3	11.6	9.4	14.3	2.3	1.4	3.7	0.69	981
Дээд	1.3	0.8	2.1	0.4	0.2	0.9	11.2	9.2	13.6	2.3	1.6	3.4	0.69	1423

## Бичил тэжээлийн байдал

Тураал, өсөлт хоцролт, туранхай болон бичил тэжээлийн дутал зэрэг нь хоол тэжээлийн дуталд багтдаг. Судалгаагаар 2-59 сартай хүүхдийг цус багадалт, 6-59 сартай хүүхдийг төмөр, А аминдэм, Д аминдэмийн дутал, үрэвслийн байдлыг илрүүлэх шинжилгээнд хамруулсан.

Төмөр нь дархлаа болон мэдрэлийн тогтолцоо, цусны улаан эсийн өсөлт, үйл ажиллагаанд нэн шаардлагатай бичил тэжээл юм [45]. А аминдэм нь хүүхдийн бие махбодын өсөлт, хөгжлийг дэмжихийн зэрэгцээ, халдвараас хамгаалахад чухал үүрэгтэй. А аминдэмийн дуталд өртсөн хүүхдэд хараа муудах (шөнийн харалган), дархлаа суларч, ойр ойр өвчлөх, улмаар эндэх эрсдэл нь ихэсдэг [46]. Цусны кальцийн хэмжээг хэвийн түвшинд барих, ясны бат бөх чанарыг хангахад Д аминдэм шийдвэрлэх үүрэгтэй оролцдог. Д аминдэм дутлын улмаас яс сийрэгжих, яс зөөлрөх (рахит, хугарал), таталт, дархлаа сулрах, ХБӨ-өөр өвчлөх эрсдэл ихсэх зэрэг олон төрлийн сөрөг үр дагавар илэрдэг байна [47-52]. Тав хүртэлх насны хүүхдийн бичил тэжээлийн байдлыг илтгэх үзүүлэлтийг Хүснэгт UF.7-д нэгтгэн харуулав.

Хүснэгт UF.7: Тав хүртэлх насны хүүхдийн бичил тэжээлийн байдал

Бичил тэжээлийн дутлын төрөл		95% ИХ		Жинлээгүй Тоо
		Доод	Дээд	
<b>Цус багадалт</b>				<b>2679</b>
Нийт цус багадалт <sup>a</sup>			23.6	
<b>Төмрийн байдал</b>				
Төмрийн дутал <sup>b</sup>	14.1	11.4	17.4	191
Төмөр хангалттай	85.9	82.6	88.6	1080
Уусдаг трансферрин рецепторын төмрийн дутал <sup>c</sup>	10.8	8.7	13.5	156
Төмрийн нөөц багадах <sup>d</sup>	13.1	10.4	16.3	175
Төмөр дутлын цус багадалт <sup>e</sup>	5.7	4.3	7.5	82
<b>А аминдэмийн байдал <sup>f</sup></b>				
А аминдэм дутал	7.1	5.4	9.2	89
А аминдэмийн нөөц дутмаг	57.9	54.3	61.3	772
А аминдэм хангалттай	35.1	31.4	38.9	460
<b>Д аминдэмийн байдал <sup>g</sup></b>				
Д аминдэм дутал	48.4	43.5	53.4	712
Д аминдэмийн нөөц дутмаг	31.0	26.7	35.8	405
Д аминдэм хангалттай	20.2	16.5	24.5	195
Д аминдэмийн хордлого	0.3	0.1	1.3	3
<b>Үрэвсэл</b>				
Дагзны яс зөөлөрсөн (0 – 23 сартай хүүхэд)	29	2.4	1.3	4.6
Эрэг дух (хүүхдийн дух урагшаа хэт овгор)	128	3.6	2.6	4.8
Толгойн хэлбэр өөрчлөгдсөн (дөрвөлжин, далиу, шовгор, хавтгай гэх мэт )	252	7.3	5.7	9.3
Зулай битүүрээгүй (хүүхдийн нас $\geq 1$ )	1998	19.4	15.4	24.2
Рахитын эрх	42	1.3	0.8	1.9
Гаррисоны ховил	81	1.7	1.2	2.4
Цээжний хэлбэр өөрчлөгдсөн (“Шувуун цээж”, “Гуталчны” цээж)	168	5.3	3.6	7.8
Бугуйвчийн шинж	10	0.3	0.1	0.6
Мэлхий гэдэс	250	7.0	4.8	10.0
Нурууны ясны өөрчлөлт	4	0.1	0.0	0.5
Майга хөл (12 – 59 сартай хүүхэд)	91	2.8	2.1	3.8
Саруй хөл (12 – 59 сартай хүүхэд)	110	4.4	2.6	7.4
Өвдөгний үе бүдүүрсэн (12 – 59 сартай хүүхэд)	203	7.4	4.3	12.5
Шагайн үе бүдүүрсэн (12 – 59 сартай хүүхэд)	10	0.5	0.2	1.1

### Нялх, бага насны хүүхдийн хооллолт

Нялх, бага насны хүүхдийн хооллолт (НБНХХ)-ын дадал нь тэдний эрүүл мэнд, өсөлт хөгжил, хоол тэжээлийн байдал, улмаар хүүхэд эсэн мэнд амьдрахад шууд нөлөөлдөг. ДЭМБ-ын зөвлөх мэргэжилтнүүдийн боловсруулсан “Хүүхдийн нэмэгдэл хооллолтын суурь зарчим” [56], “Эхийн сүүгээр хооллодоггүй 6–24 сартай хүүхдийн хооллолтын зарчим” [57] техникийн баримт бичиг нь нялх, бага насны хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийг дэмжих зохистой хооллолтын үндсэн удирдамж болдог.

Олон улсын болон үндэсний түвшинд нялх, бага насны хүүхдийн хооллолтын дадлыг үнэлэх, хянах шалгуур үзүүлэлтийг ДЭМБ-аас боловсруулсан байдаг [58, 59]. ДЭМБ болон НҮБ-ын Хүүхдийн Сангийн мэргэжилтнүүд хамтран 2021 онд нялх, бага насны хүүхдийн хооллолтын дадлыг үнэлэх дээрх шалгуур үзүүлэлтийн удирдамжийг шинэчлэн боловсруулсан. Энэхүү шинэчилсэн удирдамж нь нийт 17 шалгуурыг багтаасан бөгөөд хүн ам, өрхөд суурилсан судалгаанд ашиглах боломжтой, зөвхөн 2 хүртэлх насны хүүхдийн хооллолтын дадлыг үнэлэхэд зориулагдсан болно [60].

НҮБ-ын Хүүхдийн Сан, ДЭМБ-аас нярай хүүхдийг төрмөгц 1 цагийн дотор ангир уургаар амлуулж, амьдралынх нь эхний 6 сарын хугацаанд зөвхөн эхийн сүүгээр дагнан, 2 нас хүртэл нь эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллохыг зөвлөдөг. Мөн хүүхдийг 6 сартайгаас нь эхлэн эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ аюулгүй, тэжээллэг, өтгөн, өтгөвтөр нэмэгдэл хоолоор насанд нь тохируулан хооллохыг зөвлөдөг [61]. Иймд нялх, бага насны хүүхдийн эрүүл хооллолтын үндэс нь хүүхдийг 6 сар хүртэл нь зөвхөн эхийн сүүгээр дагнан, 6 сартайгаас эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллохын зэрэгцээ олон нэр төрлийн тэжээллэг, аюулгүй хоол хүнсээр, тэдний насанд нь тохирсон давтамж, хэмжээгээр хооллоход оршино [62].

Хоол тэжээлийн үндэсний VI судалгааны 5 хүртэлх насны хүүхдийн асуулгад нялх, бага насны хүүхдийн хооллолтын дадлыг үнэлэх шинэчилсэн шалгуурт багтсан үзүүлэлтүүдийг тодорхойлох зорилгоор ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн Сангийн мэргэжилтнүүдийн боловсруулсан стандарт асуулгыг ашигласан болно. МУ-ын нялх, бага насны хүүхдийн хооллолтын дадлыг ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн Сангийн шинэчлэн боловсруулсан шалгуур үзүүлэлтээр үнэлж, үр дүнг UF.22 хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт UF.22: Нялх, бага насны хүүхдийн хооллолтын байдал

№	Үзүүлэлтүүд	Хүүхдийн нас	Жинлээгүй тоо	%	95% ИХ	
					доод	дээд
1.	Эхийн сүүгээр хооллолт	0–23 сар	1069	95.9	93.9	97.2
2.	Эрт амлуулалт	0–23 сар	1069	87.4	84.2	90.0
3.	Эхийн сүүгээр дагнан хооллолт (Төрсний дараах эхний 2 хоногт)	0–23 сар	1041	75.8	72.5	78.8
4.	Эхийн сүүгээр дагнан хооллолт (6 сар хүртэл)	0–5 сар	172	59.6	49.9	68.6
5.	Эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ сүүн тэжээл, малын сүү уусан хүүхэд	0–5 сар	172	95.4	89.5	98.0
6.	Эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллолт	12–23 сар	590	64.1	58.8	69.0
7.	Угжаар хооллолт	0–23 сар	1069	33.4	30.5	36.5
8.	Эхийн сүүгээр хооллодоггүй, малын сүү, сүүн тэжээлийг зохих давтамжаар уусан хүүхэд	6–23 сар	250	60.2	53.4	66.6
9.	Нэмэгдэл хоолонд орсон хүүхэд	6–8 сар	146	90.9	79.9	96.2
10.	Зохих нэр төрлийн хүнс хэрэглэж байгаа хүүхэд	6–23 сар	897	49.4	44.9	54.0
11.	Насандаа тохирсон давтамжаар хооллож байгаа хүүхэд	6–23 сар	897	51.9	45.7	58.1
12.	Зохистой байдлаар хооллож байгаа хүүхэд	6–23 сар	897	30.4	25.7	35.5
13.	Эхийн сүүгээр хооллодог	6–23 сар	647	39.3	33.2	45.6
14.	Эхийн сүүгээр хооллодоггүй	6–23 сар	250	9.1	5.5	14.6
15.	Мал, амьтны мах, өндөг хэрэглэсэн хүүхэд	6–23 сар	897	89.3	85.4	92.2
16.	Эрүүл бус хүнс хэрэглэсэн хүүхэд	6–23 сар	897	42.2	37.1	47.4
17.	Чихэртэй, чихэрлэг амт оруулагч нэмсэн ундаа хэрэглэсэн хүүхэд	6–23 сар	897	36.7	32.6	41.0
18.	Жимс, хүнсний ногоо огт хэрэглээгүй хүүхэд	6–23 сар	897	31.8	28.0	35.9

Сүүлийн 2 жилийн хугацаанд төрсөн хүүхдийн дунд эхийн сүүгээр хооллож байсан болон төрсний дараа 1 цагийн дотор ангир уургаар амласан хүүхдийн үзүүлэлтийг нэгтгэн UF.23 хүснэгтэд харуулав. Хоёр хүртэлх насны бараг бүх хүүхэд (95.9%) эхийн сүүгээр хооллож байсан хэдий ч, эхийн хөхөнд сүү орох, эх хүүхэд хоорондын бие махбодын болон сэтгэл зүйн холбоо үүсэх зэрэг эхийн сүүгээр хооллолтыг амжилттай үргэлжлүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой “эрт амлуулалт” буюу хүүхдийг төрсний дараа 1 цагийн дотор ангир уургаар амлуулах дадал 87.4% байна. Эхийн сүүгээр хооллолтын байдал бүс нутаг, хүүхдийн насны бүлэг, өрхийн тэргүүний үндэс угсаагаар ялгаатай байв. Тухайлбал, Улаанбаатар хот (93.9%), Казак өрх (90.6%), 6–11 сартай хүүхдийн (92.0%) дунд эхийн сүүгээр хооллож байсан хүүхдийн үзүүлэлт харьцангуй бага байна ( $p=0.001$ ,  $p=0.01$ ,  $p=0.02$ ). Мөн төрсний дараа 1 цагийн дотор ангир уургаа амласан хүүхдийн хувь бага жинтэй төрсөн (41.8%) хүүхдийн дунд хэвийн жинтэй төрсөн хүүхэд (90.0%)-ээс 1.9 дахин бага байгаа нь анхаарал татаж байв. Мөн эрт амлуулалтын хувь хөдөөд (91.8%) хотоос (85.6%) илүү, Улаанбаатар хот (84.0%)-ын хүүхдийн дунд бусад бүсийн үзүүлэлтээс харьцангуй доогуур, Халх өрхийн тэргүүнтэй хүүхдийн (86.2%) дунд бусад үндэсний цөөнхийн үзүүлэлтээс 5.0–6.9 пунктээр бага байна (Хүснэгт UF.23).

Хүснэгт UF.23: Эхийн сүүгээр хооллолт ба эрт амлуулалтын байдал

Үзүүлэлт	Эхийн сүүгээр хооллолт, %	Төрсний дараа 1 цагийн дотор ангир уургаа амласан хүүхэд			2 хүртэлх насны хүүхдийн тоо
		%	95% ИХ		
			дээд	доод	
<b>Бүгд</b>	<b>95.9</b>	<b>87.4</b>	<b>84.2</b>	<b>90.0</b>	<b>1069</b>
<b>Хүүхдийн хүйс</b>					
Эрэгтэй	96.3	85.5	80.2	89.6	564
Эмэгтэй	95.4	89.4	85.1	92.5	505
<b>Хүүхдийн нас</b>					
0 – 5 сар	98.4	86.5	78.4	91.9	172
6 – 11 сар	92.0	84.3	78.1	89.0	307
12 – 23 сар	97.1	89.2	85.7	91.9	590
<b>Хүүхдийн төрөх үеийн жин</b>					
Бага жинтэй	94.2	41.8	24.7	61.1	51
Хэвийн жинтэй	95.9	90.0	86.9	92.4	870
Том жинтэй	96.2	88.5	79.7	93.8	133
<b>Бүсээр</b>					
Баруун	94.6	89.7	85.0	93.1	222
Хангай	99.0	90.2	84.4	4.0	205
Төв	98.6	91.2	87.9	93.6	219
Зүүн	99.0	90.6	84.9	94.3	210
Улаанбаатар	93.9	84.0	77.6	88.8	213
<b>Хот, хөдөөгөөр</b>					
Хот	95.3	85.6	81.2	89.1	597
Хөдөө	97.3	91.8	88.8	94.0	472
<b>Байршлаар</b>					
Нийслэл	93.9	84.0	77.6	88.8	213
Аймгийн төв	98.3	88.7	84.9	91.7	384
Сумын төв / баг	97.3	91.8	88.8	94.0	472

<b>Эхийн нас</b>					
16-29 нас	96.2	90.8	85.9	94.1	429
30-39 нас	95.6	84.6	79.4	88.7	527
40-49 нас	97.3	91.1	78.1	96.7	77
<b>Эхийн гэрлэлтийн байдал</b>					
Гэрлэсэн	96.0	88.9	84.5	92.1	761
Гэрлээгүй	92.7	80.2	55.3	93.0	59
Хамтран амьдардаг	96.7	85.7	79.8	90.1	213
<b>Эхийн боловсролын түвшин</b>					
Боловсролгүй / бага / суурь	97.5	90.8	82.6	95.3	74
Дунд	97.6	88.9	81.9	93.5	384
Дээд	95.0	86.6	81.5	90.5	575
<b>Эхийн ажил эрхлэлт</b>					
Ажилтай	95.4	87.5	82.9	90.9	610
Ажилгүй	96.7	87.8	83.4	91.2	423
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>					
Халх	95.7	86.2	82.3	89.3	814
Казак	90.6	91.2	81.2	96.2	69
Бусад	98.7	93.1	88.6	95.9	186
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>					
Ядуу	97.3	88.6	83.0	92.5	277
Дунджаас доогуур	97.0	89.3	83.7	93.1	235
Дундаж	93.7	90.5	84.5	94.3	218
Дунджаас дээгүүр	95.9	85.2	78.4	90.1	210
Чинээлэг	95.5	83.7	71.3	91.3	125

Хоёр хүртэлх насны хүүхдийн эхийн сүүгээр хооллолтын дадлыг илтгэх үндсэн үзүүлэлтийг нэгтгэн Хүснэгт UF.24–д харуулав. Ингэхдээ төрсний дараах 2 хоногт зөвхөн эхийн сүүгээр дагнан хооллосон 2 хүртэлх насны хүүхэд, 6 сар хүртлээ зөвхөн эхийн сүүгээр дагнан хооллосон, эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ сүүн тэжээл, малын сүү хэрэглэсэн 0–5 сартай хүүхдийн тархалтыг тус тус тооцсон. Эхийн сүүгээр дагнан хооллолтыг тооцохдоо эмч, эрүүл мэндийн ажилтны заавраар хэрэглэсэн аминдэм, эрдсийн бэлдмэл, шингэн сэлбэх давсны уусмалыг бусад шингэн эсвэл хүнсний хэрэглээнд оролцуулаагүй болно [63].

Манай улсын 0-5 сартай хүүхдийн 59.8% эхийн сүүгээр дагнан, 95.4% эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ сүүн тэжээл эсвэл малын сүү хэрэглэсэн байв. Эхийн сүүгээр дагнан хооллолтын тархалтад эхийн хоол тэжээлийн байдлаас бусад үзүүлэлтээр статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдаагүй бөгөөд илүүдэл жинтэй, тарган эхчүүдийн дунд тус үзүүлэлт харьцангуй бага ( $p=0.004$ ) байгаа нь анхаарал татаж байна. Хоёр хүртэлх насны нийт хүүхдийн 75.8% төрсний дараах эхний 2 хоногт зөвхөн эхийн сүүгээр хооллосон байв. Төрсний дараах эхний 2 хоногт зөвхөн эхийн сүүгээр дагнан хооллосон хүүхдийн хувь бага жинтэй төрсөн (51.6%), хот суурин газар (73.2%), Улаанбаатар хот (69.0%)-ын хүүхдийн дунд хамгийн бага байна. Мөн өрхийн аж байдлын түвшин дээшлэхэд төрсний дараах эхний 2 хоногт эхийн сүүгээр дагнан хооллосон хүүхдийн хувь буурч байгаа нь анхаарал татаж байна ( $p=0.004$ ). Өөрөөр хэлбэл чинээлэг өрхийн хүүхдийн 32.5% төрсний дараах эхний 2 хоногт эхийн сүүнээс гадна бусад сүү,

шингэн хэрэглэсэн бол аж байдлын түвшин доогуур өрхөд тус үзүүлэлт 14.1% байв (Хүснэгт

Хүснэгт UF.24: Эхийн сүүгээр дагнан хооллолтын байдал

Үзүүлэлт	0 – 5 сартай хүүхэд			0 – 23 сартай хүүхэд			
	Эхийн сүүгээр дагнан хооллосон, %	Эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ сүүн тэжээл, малын сүү уусан, %	Жинлээгүй тоо	Төрсний дараах эхний 2 хоногт эхийн сүүгээр дагнан хооллосон			Жинлээгүй тоо
				%	95% ИХ		
					Доод	Дээд	
<b>Бүгд</b>	<b>59.6</b>	<b>95.4</b>	<b>172</b>	<b>75.8</b>	<b>72.5</b>	<b>78.8</b>	<b>1041</b>
<b>Хүүхдийн хүйс</b>							
Эрэгтэй	56.9	95.4	91	77.4	72.5	81.6	550
Эмэгтэй	62.5	95.4	81	74.0	68.1	79.2	491
<b>Хүүхдийн нас</b>							
0 – 5 сар	59.6	95.4	172	71.6	61.4	80.0	170
6 – 11 сар	-	-	-	73.8	66.8	79.8	296
12 – 23 сар	-	-	-	78.2	73.7	79.8	575
<b>Хүүхдийн төрөх үеийн жин</b>							
Бага жинтэй	-	-	4	51.6	34.2	68.7	49
Хэвийн жинтэй	58.9	95.3	149	76.6	72.7	80.1	847
Том жинтэй	63.2	94.9	19	79.3	68.8	86.9	131
<b>Бүсээр</b>							
Баруун	48.1	100.0	33	82.6	75.9	87.7	212
Хангай	60.5	94.5	36	82.6	76.2	87.5	203
Төв	68.1	94.5	37	80.4	73.2	86.0	216
Зүүн	72.9	92.4	26	81.8	74.0	87.7	210
Улаанбаатар	58.3	95.2	40	69.0	63.5	74.0	200
<b>Хот, хөдөөгөөр</b>							
Хот	58.6	94.6	101	73.2	69.1	77.0	579
Хөдөө	62.7	97.7	71	82.1	77.3	86.1	462
<b>Байршлаар</b>							
Нийслэл	58.3	95.2	40	69.0	63.5	74.0	200
Аймгийн төв	59.2	93.2	61	81.5	76.7	85.5	379
Сумын төв / баг	62.7	97.7	71	82.1	77.3	86.1	462
<b>Эхийн нас</b>							
16-29 нас	64.1	95.7	76	80.1	74.9	84.4	419
30-39 нас	58.0	95.2	88	72.3	66.6	77.4	52
40-49 нас	-	-	4	69.5	53.8	81.7	76
<b>Эхийн гэрлэлтийн байдал</b>							
Гэрлэсэн	62.4	94.4	117	75.5	71.2	79.3	742
Гэрлээгүй	-	-	7	74.3	62.1	83.6	56
Хамтран амьдардаг	60.4	98.4	44	74.6	68.3	80.0	209
<b>Эхийн боловсролын түвшин</b>							
Боловсролгүй	-	-	3	-	-	-	19
Бага / суурь	-	-	9	76.6	59.1	88.1	53
Дунд	64.0	92.9	66	80.0	73.7	85.0	376
Дээд	56.4	96.7	90	72.4	68.0	76.4	559
<b>Эхийн ажил эрхлэлт</b>							
Ажилтай	53.8	95.8	103	75.8	71.2	79.9	594

Ажилгүй	69.7	95.0	65	74.5	68.7	79.5	413
<b>Эхийн хоол тэжээлийн байдал</b>							
Тураалтай	-	-	3	70.4	47.2	86.3	37
Хэвийн жинтэй	76.2	95.6	61	80.3	75.0	84.7	418
Илүүдэл жинтэй	50.4	95.5	62	72.1	65.8	77.6	329
Тарган	41.4	100.0	42	67.2	57.0	75.9	179
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>							
Халх	58.9	94.7	133	76.0	72.0	79.6	794
Казак	-	-	10	78.4	63.5	88.4	63
Бусад	66.7	95.4	29	73.7	64.9	81.0	184
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>							
Ядуу	82.0	100.0	43	85.9	80.5	90.0	270
Дунджаас доогуур	49.9	93.6	41	82.2	73.0	88.7	231
Дундаж	36.3	100.0	22	75.5	68.4	81.5	210
Дунджаас дээгүүр	59.5	88.1	38	73.3	65.9	79.7	205
Чинээлэг	64.4	100.0	26	65.1	56.7	72.6	121

Бага насны хүүхдийн эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллолтын байдлыг өмнө ашиглаж байсан болон шинэчилсэн шалгуур үзүүлэлтээр харьцуулан үнэлж, Хүснэгт UF.25-д харуулав. Манай улсын 12–23 сартай хүүхдийн 64.1% эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож байна. Эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож буй хүүхдийн хувь эхийн ажил эрхлэлтийн байдал, өрхийн тэргүүний үндэс угсаа, өрхийн аж байдлын түвшнээс бусад үзүүлэлтээр статистик ач холбогдол бүхий ялгаа илрээгүй бөгөөд ажилгүй эхийн хүүхдийн дунд эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллох байдал эх нь хөдөлмөр эрхэлдэг хүүхдээс 11.5 пунктээр ( $p=0.03$ ), мөн бусад ястны хүүхдийн (77.4%) дунд Казак үндэстэн (58.5%)-ээс тус тус илүү ( $p=0.03$ ) байв. Эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллосон хүүхдийн хувь аж байдлын түвшин доогуур өрхөд хамгийн их (76.3% ба 58.2%), харин чинээлэг өрхийн хүүхдийн дунд хамгийн бага (45.8%) байгааг UF.25 хүснэгтээс харж болно ( $p=0.002$ ).

Хүснэгт UF.25: Эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллолтын байдал

Үзүүлэлт	12–15 сартай хүүхэд <sup>a</sup>		20–23 сартай хүүхэд <sup>a</sup>		12 – 23 сартай хүүхэд <sup>b</sup>			
	Нэг нас хүртлээ эхийн сүүгээр хооллосон, %		Хоёр нас хүртлээ эхийн сүүгээр хооллосон, %		Эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллосон %			
	%	Жинлээгүй тоо	%	Жинлээгүй тоо	%	95% ИХ доод	95% ИХ дээд	Жинлээгүй тоо
<b>Бүгд</b>	<b>77.8</b>	<b>234</b>	<b>40.4</b>	<b>161</b>	<b>64.1</b>	<b>58.8</b>	<b>69.0</b>	<b>590</b>
<b>Хүүхдийн хүйс</b>								
Эрэгтэй	80.7	125	45.1	94	64.6	56.5	71.9	313
Эмэгтэй	74.2	109	35.3	67	63.5	56.9	69.7	277
<b>Хүүхдийн төрөх үеийн жин</b>								
Бага жинтэй	66.3	15	56.2	10	65.6	45.0	81.6	34
Хэвийн жинтэй	78.3	195	37.5	126	62.2	56.3	67.8	478
Том жинтэй	83.1	22	52.9	19	80.3	65.2	89.9	65
<b>Хүүхдийн хоол тэжээлийн байдал</b>								
Өсөлт хоцролттой	69.6	22	30.5	24	53.2	39.8	71.0	68
Өсөлт хэвийн	80.4	206	41.5	136	65.7	59.9	71.0	513

<b>Хүүхдийн хоол тэжээлийн байдал</b>								
Илүүдэл жинтэй	70.6	27	42.4	28	58.8	46.0	70.4	85
Хэвийн жинтэй	79.5	198	39.8	132	64.9	59.5	69.9	490
<b>Бүсээр</b>								
Баруун	98.0	48	52.6	36	77.7	69.2	84.4	121
Хангай	70.1	50	45.4	33	64.1	54.9	72.4	114
Төв	75.3	52	36.0	31	60.0	50.1	69.1	124
Зүүн	76.6	47	43.6	37	60.4	50.7	69.4	121
Улаанбаатар	75.5	37	33.8	24	61.9	51.7	69.0	110
<b>Хот, хөдөөгөөр</b>								
Хот	76.5	121	35.6	75	62.8	55.6	69.5	311
Хөдөө	80.4	113	48.2	86	66.9	60.8	72.5	279
<b>Байршлаар</b>								
Нийслэл	75.5	37	33.8	24	61.9	51.7	69.0	110
Аймгийн төв	77.9	84	38.7	51	64.7	56.9	71.7	201
Сумын төв / баг	80.4	113	48.2	86	66.9	60.8	72.5	279
<b>Эхийн нас</b>								
16-29 нас	84.4	102	40.3	63	63.4	55.1	71.1	231
30-39 нас	77.1	108	44.0	74	66.7	58.6	74.0	286
40-49 нас	71.9	16	25.2	17	62.5	43.6	78.1	49
<b>Эхийн гэрлэлтийн байдал</b>								
Гэрлэсэн	78.0	164	46.5	124	65.5	58.7	71.6	426
Гэрлээгүй	55.9	13	17.9	10	45.9	29.6	63.2	33
Хамтран амьдардаг	88.6	49	22.9	20	68.3	55.6	78.7	107
<b>Эхийн боловсролын түвшин</b>								
Боловсролгүй	-	7	-	4	-	-	-	15
Бага / суурь	-	12	-	5	72.8	52.7	86.5	31
Дунд	85.7	76	39.6	63	66.3	58.7	73.2	204
Дээд	77.6	131	41.0	82	63.8	56.2	70.8	316
<b>Эхийн ажил эрхлэлт</b>								
Ажилтай	73.8	132	41.8	105	60.0	52.3	67.2	346
Ажилгүй	86.4	94	38.6	49	71.5	64.1	77.9	220
<b>Эхийн хоол тэжээлийн байдал</b>								
Тураалтай	-	7	-	3	-	-	-	17
Хэвийн жинтэй	80.9	106	41.4	62	66.4	58.7	73.6	257
Илүүдэл жинтэй	84.6	67	33.5	52	65.0	55.2	73.7	172
Тарган	80.5	33	57.1	28	72.8	62.8	81.0	85
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>								
Халх	74.1	176	40.1	122	62.0	56.2	67.5	451
Казак	92.8	13	33.2	14	58.5	39.9	75.0	38
Бусад	92.9	45	46.5	25	77.4	65.8	85.9	101
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>								
Ядуу	69.2	60	40.5	47	58.2	49.0	66.8	159
Дунджаас доогуур	86.8	56	44.5	26	76.3	65.7	84.4	122
Дундаж	78.2	51	48.9	3	69.9	60.2	78.1	137
Дунджаас дээгүүр	91.2	42	30.1	36	66.8	54.4	77.2	108
Чинээлэг	56.9	25	33.2	12	45.8	32.1	60.2	62
<sup>a</sup> Нэг нас, хоёр нас хүртлээ эхийн сүүгээр хооллосон хүүхэд: ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн Сангийн 2008 оны шалгуур байсан үзүүлэлт <sup>b</sup> Эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллосон хүүхэд: ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн Сангийн 2021 оны шинэчилсэн шалгуурт орсон үзүүлэлт								

Бага насны хүүхдийн 77.8% нэг нас хүртлээ, 40.4% хоёр нас хүртлээ эхийн сүүгээр хооллосон байна. Эдгээр үзүүлэлт нь 2021 онд шинэчилсэн “Нялх бага насны хүүхдийн хооллолтын

дадлыг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ээс хасагдсан хэдий ч, хоол тэжээлийн үндэсний V судалгааны дүнтэй харьцуулан жишиж, үнэлэх зорилгоор тооцсон болно.

Эхийн сүүгээр хооллолт нь бага насны хүүхдийн эрүүл хооллолтыг илтгэх үндсэн үзүүлэлт юм.[62] Зургаан сар хүрээгүй нялх хүүхдийг зөвхөн эхийн сүүгээр дагнан, харин 6-23 сартай хүүхдийг эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ тэдний насанд тохирсон хэмжээ, давтамжаар, зохих нэр төрлийн хүнс орсон өтгөн, өтгөвтөр, шингэн хоол өгөхийг зөвлөдөг. Иймд 6 сар хүртлээ эхийн сүүгээр дагнан хооллосон, 6 сартайгаас хөхөө хөхөхийн зэрэгцээ нэмэгдэл хоол идэж байгаа хүүхдийн үзүүлэлтийг нэгтгэн “эхийн сүүгээр зохистой хооллолт”-той хүүхдийн хувийг тооцсон болно.

Хоёр хүртэлх насны нийт хүүхдийн 66.5%, 6-23 сартай хүүхдийн 69.7% насандаа тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллож байна. Нийт 6–23 сартай эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ нэмэгдэл хоол идэж байгаа хүүхдийн үзүүлэлт чинээлэг өрхөд хамгийн бага (51.3%), харин аж байдлын түвшин дунджаас доогуур өрхийн хүүхдийн дунд (78.4%) харьцангуй түгээмэл байв ( $p < 0.0001$ ). Эхийн сүүгээр зохистой хооллож байгаа хүүхдийн үзүүлэлт тэдний төрөх үеийн биеийн жин, эхийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, өрхийн аж байдлын түвшнээр ялгаатай байв. Тухайлбал, ажил хийдэг (65.8%), бага жинтэй төрсөн (59.0%) хүүхдийн эхийн сүүгээр зохистой хооллох магадлал нь хэвийн жинтэй (65.3%) төрсөн ( $p = 0.02$ ), хөдөлмөр эрхэлдэггүй (72.8%) эхийн хүүхдээс ( $p = 0.003$ ) бага байна. Мөн эхийн сүүгээр зохистой хооллосон хүүхдийн үзүүлэлт чинээлэг өрхөд хамгийн бага (53.9%), харин аж байдлын түвшин нь дунджаас дээгүүр өрхийн хүүхдийн дунд (73.2%) хамгийн өндөр байгааг ( $p = 0.01$ ) дараах хүснэгтээс харж болно (Хүснэгт

Хүснэгт UF.26: Насандаа тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллолт

Үзүүлэлт	0 – 5 сартай хүүхэд		6 – 23 сартай хүүхэд		0 – 23 сартай хүүхэд	
	Эхийн сүүгээр дагнан хооллосон, %	Жинлээгүй тоо	Эхийн сүүгээр хооллож байгаа, өтгөн, өтгөвтөр хоол хэрэглэсэн %	Жинлээгүй тоо	Эхийн сүүгээр зохистой хооллосон %	Жинлээгүй тоо
<b>Бүгд</b>	<b>59.6</b>	<b>172</b>	<b>69.7</b>	<b>897</b>	<b>66.5</b>	<b>1069</b>
<b>Хүүхдийн хүйс</b>						
Эрэгтэй	56.9	91	67.4	473	65.6	564
Эмэгтэй	62.5	81	68.5	424	67.5	505
<b>Хүүхдийн төрөх үеийн жин</b>						
Бага жинтэй	-	4	57.8	47	59.0	51
Хэвийн жинтэй	58.9	149	66.8	721	65.3	870
Том жинтэй	63.2	19	82.0	114	79.5	133
<b>Бүсээр</b>						



Баруун	48.1	33	76.8	189	72.5	222
Хангай	60.5	36	70.6	169	68.8	205
Төв	68.1	37	68.7	182	68.6	219
Зүүн	72.9	26	67.9	184	68.6	210
Улаанбаатар	58.3	40	64.1	173	63.0	213
<b>Хот, хөдөөгөөр</b>						
Хот	58.6	101	66.2	496	64.8	597
Хөдөө	62.7	71	72.2	401	70.7	472
<b>Байршлаар</b>						
Нийслэл	58.3	40	64.1	173	63.0	213
Аймгийн төв	59.2	61	70.3	323	68.4	384
Сумын төв / баг	62.7	71	72.2	401	70.7	472
<b>Эхийн нас</b>						
16-29 нас	64.1	76	69.2	353	68.3	429
30-39 нас	58.0	88	70.6	439	68.0	527
40-49 нас	-	4	62.7	73	67.7	77
<b>Эхийн гэрлэлтийн байдал</b>						
Гэрлэсэн	62.4	117	69.9	644	68.7	761
Гэрлээгүй	-	7	59.8	52	56.0	59
Хамтран амьдардаг	60.4	44	69.7	169	67.6	213
<b>Эхийн боловсролын түвшин</b>						
Боловсролгүй	-	3	-	18	-	21
Бага / суурь	-	9	75.5	44	76.3	53
Дунд	64.0	66	68.8	318	67.8	384
Дээд	56.4	90	69.1	485	67.0	575
<b>Эхийн ажил эрхлэлт</b>						
Ажилтай	53.8	103	65.8	507	63.5	610
Ажилгүй	69.7	65	73.4	358	72.8	423
<b>Эхийн хоол тэжээлийн байдал</b>						
Тураалтай	-	3	84.9	34	86.6	37
Хэвийн жинтэй	76.2	61	68.8	373	70.0	434
Илүүдэл жинтэй	50.4	62	72.7	25	69.0	335
Тарган	41.4	42	71.7	140	63.8	182
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>						
Халх	58.9	133	66.6	681	65.2	814
Казак	-	10	66.1	59	63.9	69
Бусад	66.7	29	76.4	157	74.7	186
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>						
Ядуу	82.0	43	65.3	234	68.1	277
Дунджаас доогуур	49.9	41	78.4	194	73.2	235
Дундаж	36.3	22	72.7	196	69.4	218
Дунджаас дээгүүр	59.5	38	71.0	172	68.5	210
Чинээлэг	64.4	26	51.3	99	53.9	125

Судалгааны өмнөх 1 хоногт угжаар ямар нэгэн шингэн уусан 0–23 сартай хүүхдийн үзүүлэлтийг сонгосон үзүүлэлтээр харьцуулан үнэлж, үр дүнг дараах хүснэгтэд харуулав (Хүснэгт UF.27). Хоёр хүртэлх насны 3 хүүхэд тутмын нэг (33.4%) нь угжаар хооллосон бөгөөд угжны хэрэглээ Улаанбаатар хот (41.3%), хот суурин газрын (37.5%) хүүхдийн дунд бусад бүс, хөдөөгийн хүүхдээс харьцангуй түгээмэл байна ( $p < 0.0001$ ,  $p = 0.005$ ). Мөн том жинтэй төрсөн хүүхдийн (42.3%) угжаар хооллосон байдал нь хэвийн жинтэй хүүхдийн (32.1%) үзүүлэлтээс 10.2 пунктээр илүү байв ( $p < 0.0001$ ). Өрхийн аж байдлын түвшин дээшлэхэд судалгааны өмнөх 1

хоногт угжаар ямар нэгэн шингэн уусан 2 хүртэлх насны хүүхдийн хувь нэмэгдэх хандлага илэрсэн ( $p=0.002$ ) бөгөөд чинээлэг өрхийн нийт хүүхдийн 42.6% угжаар шингэн уусан бол тус үзүүлэлт ядуу өрхөд бараг 2 дахин бага буюу 21.4% байна (Хүснэгт UF.27).

Хүснэгт UF.27: Бага насны хүүхдийн угжаар хооллолтын байдал

Үзүүлэлт	%	95% ИХ		Жинлээгүй тоо
		Доод	Дээд	
<b>Бүгд</b>	<b>33.4</b>	<b>30.5</b>	<b>36.5</b>	<b>1069</b>
<b>Хүүхдийн хүйс</b>				
Эрэгтэй	33.2	28.6	38.2	564
Эмэгтэй	33.6	29.3	38.2	505
<b>Хүүхдийн нас</b>				
0 – 5 сар	32.2	24.9	40.4	172
6 – 11 сар	38.0	32.4	44.0	307
12 – 23 сар	31.3	26.6	36.5	590
<b>Хүүхдийн төрөх үеийн жин</b>				
Бага жинтэй	32.3	18.9	49.4	51
Хэвийн жинтэй	32.1	29.1	35.3	870
Том жинтэй	42.3	32.5	52.7	133
<b>Бүсээр</b>				
Баруун	29.3	32.8	35.5	222
Хангай	21.2	15.8	27.8	205
Төв	25.6	19.1	33.4	219
Зүүн	32.2	25.2	40.2	210
Улаанбаатар	41.3	36.8	46.0	213
<b>Хот, хөдөөгөөр</b>				
Хот	37.5	33.8	41.3	597
Хөдөө	23.2	19.4	27.4	472
<b>Байршлаар</b>				
Нийслэл	41.3	36.8	46.0	213
Аймгийн төв	29.5	24.4	35.2	384
Сумын төв / баг	23.2	19.4	27.4	472
<b>Эхийн нас</b>				
16-29 нас	25.8	21.4	30.8	429
30-39 нас	37.0	32.1	42.3	527
40-49 нас	39.3	26.7	53.5	77
<b>Эхийн гэрлэлтийн байдал</b>				
Гэрлэсэн	31.8	28.2	35.7	761
Гэрлээгүй	28.3	16.6	43.9	59
Хамтран амьдардаг	36.4	29.8	43.5	213
<b>Эхийн боловсролын түвшин</b>				
Боловсролгүй / бага / суурь	29.4	19.4	41.8	74
Дунд	27.3	22.6	32.7	384
Дээд	35.9	31.4	40.5	575
<b>Эхийн ажил эрхлэлт</b>				
Ажилтай	32.4	28.2	36.9	610
Ажилгүй	33.1	27.8	38.9	423
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>				
Халх	34.0	30.6	37.6	814
Казак	28.1	19.2	39.1	69
Бусад	31.4	22.8	41.6	186
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>				

Ядуу	21.4	16.0	28.0	277
Дунджаас доогуур	29.7	21.9	38.9	235
Дундаж	31.6	24.7	39.3	218
Дунджаас дээгүүр	39.2	32.2	46.5	210
Чинээлэг	42.6	35.4	50.1	125

Судалгааны өмнөх 1 хоногт 6-8 сартай нийт хүүхдийн 90.9% өтгөн, өтгөвтөр хоолыг ядаж 1 удаа идсэн буюу нэмэгдэл хоолонд хугацаандаа орсон байв. Тус үзүүлэлт эхийн сүүгээр хооллож байгаа хүүхдийн дунд 91.6% байгаа бөгөөд судалгааны өмнөх 1 хоногт эхийн сүүгээр хооллоогүй буюу хөхөө хөхөөгүй 6-8 сартай хүүхдийн тоо хэт цөөн (n=17) байгаа тул эдгээр хүүхдийн дунд уг үзүүлэлтийг тооцоогүй болно. Нэмэгдэл хоолонд хугацаандаа орсон 6-8 сартай хүүхдийн тархалтыг судалгаанд сонгосон үзүүлэлтээр харьцуулан үнэлэхэд эхийн насны бүлгээс бусад шинж байдлаар ялгаа ажиглагдаагүй бөгөөд 16-29 насны залуу эхчүүд хүүхдээ зохих насанд нь нэмэгдэл хоолонд оруулах байдал 30-49 насны эхчүүдээс (p=0.02) бага байна (Хүснэгт UF.28).

Хүснэгт UF.28: Нэмэгдэл хоолонд хугацаандаа орсон 6-8 сартай хүүхэд

Үзүүлэлт	Эхийн сүүгээр хооллож байгаа хүүхэд		Эхийн сүүгээр хооллодоггүй хүүхэд		Бүгд хүүхэд	
	Өтгөн, өтгөвтөр хоол, хүнс хэрэглэсэн %	Жинлээгүй тоо	Өтгөн, өтгөвтөр хоол, хүнс хэрэглэсэн %	Жинлээгүй тоо	Өтгөн, өтгөвтөр хоол, хүнс хэрэглэсэн %	Жинлээгүй тоо
<b>Бүгд</b>	<b>91.6</b>	<b>129</b>	<b>-</b>	<b>17</b>	<b>90.9</b>	<b>146</b>
<b>Хүүхдийн хүйс</b>						
Эрэгтэй	90.0	64	-	10	91.2	74
Эмэгтэй	93.5	65	-	7	90.6	72
<b>Хүүхдийн төрөх үеийн жин</b>						
Бага жинтэй	-	3	-	3	-	6
Хэвийн жинтэй	90.0	101	-	13	89.0	114
Том жинтэй	98.1	25	-	1	98.1	26
<b>Бүсээр</b>						
Баруун	85.5	28	-	1	86.0	29
Хангай	96.3	28	-	3	96.6	31
Төв	94.4	21	-	3	65.2	24
Зүүн	93.2	30	-	3	90.7	33
Улаанбаатар	90.5	22	-	7	89.1	29
<b>Хот, хөдөөгөөр</b>						
Хот	90.1	78	-	13	89.3	91
Хөдөө	95.5	51	-	4	95.8	55
<b>Байршлаар</b>						
Нийслэл	90.5	22	-	7	89.1	29
Аймгийн төв	89.6	56	-	6	89.7	62
Сумын төв / баг	95.5	51	-	4	95.8	55
<b>Эхийн нас</b>						
16-29 нас	89.2	47	-	4	85.7	51
30-39 нас	96.8	72	-	8	97.4	80
40-49 нас	-	8	-	3	91.5	11

<b>Эхийн гэрлэлтийн байдал</b>						
Гэрлэсэн	92.9	98	-	10	93.5	108
Гэрлээгүй	-	5	-	1	-	6
Хамтран амьдардаг	100.0	24	-	4	91.5	28
<b>Эхийн боловсролын түвшин</b>						
Боловсролгүй	-	1	-	-	-	1
Бага / суурь	-	7	-	1	-	8
Дунд	86.6	48	-	2	94.7	50
Дээд	97.4	71	-	12	92.2	83
<b>Эхийн ажил эрхлэлт</b>						
Ажилтай	95.4	71	-	10	92.2	81
Ажилгүй	91.3	56	-	5	92.3	61
<b>Эхийн хоол тэжээлийн байдал</b>						
Тураалтай	-	-	-	-	-	5
Хэвийн жинтэй	90.0	53	-	6	87.7	59
Илүүдэл жинтэй	96.9	42	-	4	96.2	46
Тарган	93.7	26	-	3	94.5	29
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>						
Халх	90.4	94	-	14	89.5	108
Казак	-	13	-	-	-	13
Бусад	94.7	22	-	3	96.0	25
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>						
Ядуу	88.2	26	-	3	89.5	29
Дунджаас доогуур	89.3	34	-	1	89.6	35
Дундаж	100.0	28	-	2	100.0	30
Дунджаас дээгүүр	92.0	29	-	5	93.2	34
Чинээлэг	87.0	12	-	6	82.4	18

Нялх хүүхдийг 6 сартайгаас эхлэн эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ аюулгүй, зохистой давтамжаар, аль болох олон нэр төрлийн хүнс орсон өтгөн, өтгөвтөр нэмэгдэл хоолоор насанд нь тохируулан хооллохыг зөвлөдөг.[61] Дараах үндсэн шалгуурыг баримтлан 6–23 сартай хүүхдийн хооллолтын дадлыг үнэлдэг. Үүнд:

- (i) Эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож байгаа эсэх,
- (ii) Хооллох давтамж нь хүүхдийн нас болон эхийн сүүгээр хооллолтын байдалтай тохирсон байх;
- (iii) Хоногт зохих нэр төрлийн хүнс хэрэглэсэн эсэх

Хооллох давтамжаар хүүхдийн илчлэгийн хэрэглээг шууд бусаар хянах боломжтой байдаг. ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн Сангийн “Нялх, бага насны хүүхдийн хооллолтын дадлыг үнэлэх шалгуур үзүүлэлт”-д эхийн сүүгээр хооллодог 6–8 сартай хүүхдийг өдөрт хамгийн багадаа 2 удаа, 9–23 сартай хүүхдийг 3 удаа өтгөн, өтгөвтөр хоол, хүнс өгсөн бол “Хооллох давтамжийн хамгийн бага шаардлага” хангасан гэж үнэлэхийг, харин эхийн сүүгээр хооллодоггүй бага насны хүүхдийг өдөрт хамгийн багадаа 4 удаа хооллосон бол дээрх шаардлагыг хангасан гэж үнэлэхийг заасан. Бага насны хүүхдийг аль болох олон нэр төрлийн хүнсээр хооллох нь тэдний хоол хүнсээр авах шимт бодисын хэрэгцээг хангахад чухал үүрэгтэй. Хэрэв нялх, бага насны

хүүхэд эхийн сүүг оролцуулаад хоногт хэрэглэвэл зохих 8 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээс хамгийн багадаа 5 төрлийн хүнс хэрэглэсэн бол “Хүнсний нэр төрлийн хамгийн бага шаардлага” хангасан хооллолттой гэж үнэлэхийг зөвлөсөн байдаг. Эдгээр 8 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнд эхийн сүүний зэрэгцээ дийлэнх улс орны хувьд өргөн хэрэглээний хүнсний бүрэлдэхүүнд багтдаг үр тариа, булцуут үндэст ногоо, амьтны гаралтай хүнс (мах, загас, сүү, өндөг), жимс, хүнсний ногоог тус бүр хамгийн багадаа нэг удаа хэрэглэх магадлал буюу “5 нэр төрлийн хүнс” хэрэглэх зөвлөмжийг үндэслэсэн болно.[64]

Хоол тэжээлийн үндэсний VI судалгаанд 2021 онд шинэчлэн гаргасан “Нялх, бага насны хүүхдийн хооллолтын дадлыг үнэлэх шалгуур үзүүлэлт”[60] -ийг тооцох зорилгоор хүүхдийн хооллолтын дадлыг үнэлэх “Жишиг асуулга”-ыг ашигласан бөгөөд судалгааны өмнөх 1 хоногт хүүхдийг эхийн сүүгээр хооллосон эсэх, идсэн, уусан хоол хүнс, шингэн зүйлсийн талаар эх, асрамжлагчийн өгсөн мэдээлэлд тулгуурлан үнэлсэн. Мөн “хоногт хэрэглэвэл зохих хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл” болон “хоногт хоолловол зохих давтамж”-ийн хамгийн бага шаардлагыг бүрэн хангасан хүүхдийн хувийг нэгтгэн тооцож, “Зохистой байдлаар хооллосон хүүхэд”-ийн үзүүлэлтийг гаргасан болно.

Судалгааны өмнөх 1 хоногт зохистой хооллолтын хамгийн бага шаардлага хангасан хооллолттой 6–23 сартай хүүхдийн үзүүлэлтийг эхийн сүүгээр хооллож байгаа болон хооллодоггүй хүүхдийн дунд тооцон, сонгосон үзүүлэлтээр харьцуулан үнэлж UF.29–р хүснэгтэд нэгтгэн харуулав.

Нийт 6-23 сартай хүүхдийн 51.9% нэмэгдэл хоолыг насандаа тохирсон давтамжаар идсэн байв. Нэмэгдэл хоолоор зохих давтамжаар хооллох байдал эхийн хоол тэжээлийн байдлаар ялгаатай, хэвийн жинтэй эхийн хүүхдийн дунд (54.7%), тарган эхийн хүүхэд (43.9%)-ээс илүү байна ( $p=0.001$ ). Мөн нэмэгдэл хоолыг зохих давтамжаар идсэн хүүхдийн хувь эхийн сүүгээр хооллодог хүүхэдтэй (60.1%) харьцуулахад эхийн сүүгээр хооллодоггүй хүүхдийн (32.3%) дунд 1.9 дахин бага байв ( $p<0.005$ ).

Судалгааны өмнөх өдөр хамгийн багадаа 5 нэр төрлийн хүнс хэрэглэсэн хүүхдийн хувь (49.4%), нэмэгдэл хоолыг зохих давтамжаар идэж байгаа хүүхдийн үзүүлэлт (51.9%)-ээс ялимгүй доогуур байна. Хоногт хэрэглэвэл зохих хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан хооллолттой хүүхдийн үзүүлэлт бүс нутаг, байршил, хүүхдийн нас, өсөлтийн байдал, эхийн боловсролын түвшин, гэрлэлт, хоол тэжээлийн байдлаар ялгаатай байв. Тухайлбал, хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан хооллолттой хүүхдийн үзүүлэлт 6-11 сартай хүүхэдтэй (42.3%) харьцуулахад 12-23 сартай хүүхэдэд (53.2%), хөдөөтэй (41.2%) харьцуулахад хотод (52.8%) илүү түгээмэл байна ( $p=0.002$ ,

$p=0.008$ ). Баруун (38.4%) болон Хангайн (39.1%) бүсийн хүүхдийн дунд зохих нэр төрлийн хүнс хэрэглэх дадал хамгийн доогуур байв. Мөн энэхүү үзүүлэлт эхийн сүүгээр хооллодоггүй (30.4%) хүүхдийн дунд эхийн сүүгээр хооллож байгаа хүүхэд (57.3%)-ийн үзүүлэлтээс 1.9 дахин бага байгаа нь анхаарал татаж байна ( $p<0.0001$ ).

Нялх, бага насны хүүхдийн өсөлт хөгжилд тэдний хооллолтын дадал чухал үүрэгтэй болохыг өсөлт хоцролттой болон хэвийн өсөлттэй хүүхдийн хооллолтын чанарын үзүүлэлтээр харьцуулан харж болно. Тухайлбал, хоногт хэрэглэвэл зохих нэр төрлийн хүнс хэрэглэсэн хүүхдийн хувь өсөлт хоцролттой (36.2%) хүүхдийн дунд хэвийн өсөлттэй (51.8%) хүүхдээс харьцангуй доогуур 1.4 дахин бага байна. Бага насны хүүхдийн хооллолтын чанарыг илтгэх энэхүү үзүүлэлт өрхийн аж байдал, тэдний эхийн боловсролын түвшин, гэрлэлт, хооллолт, хоол тэжээлийн байдлаар статистик ач холбогдол бүхий ялгаатай байв. Чинээлэг өрхийн 6–23 сартай хүүхдийн 64.9% хоногт хэрэглэвэл зохих нэр төрлийн хүнс хэрэглэж байгаа бол ядуу өрхийн хүүхдийн дунд тус үзүүлэлт 1.9 дахин бага (33.1%) байна ( $p<0.0001$ ). Хоногт хэрэглэвэл зохих хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан хооллолттой хүүхдийн үзүүлэлт эхийн боловсролын түвшнээс шууд хамааралтай нэмэгдэж, дээд боловсролтой эхийн хүүхдэд харьцангуй өндөр (57.4%), харин боловсролгүй, бага, суурь боловсролтой эхийн хүүхдэд (28.2%) хамгийн бага байгааг UF.29 хүснэгтээс харж болно. Түүнчлэн гэрлээгүй (31.5%), тарган эхийн (35.7%) хүүхдийн хооллолтын чанарын үзүүлэлт доогуур байх магадлалтай байв.

Манай улсын 6–23 сартай нийт хүүхдийн дөнгөж 30.4% зохистой байдлаар хооллож байгаа бөгөөд тус үзүүлэлт эхийн сүүгээр хооллодог хүүхэдтэй (39.3%) харьцуулахад хөхөө хөхдөггүй хүүхдийн дунд (9.1%) нэлээд доогуур, 4.2 дахин бага байгааг судалгаагаар илрүүлэв. Мөн эхийн сүүгээр хооллодоггүй хүүхдийн 60.2% судалгааны өмнөх хоногт малын сүү эсвэл сүүн тэжээлийг зөвлөмжийн дагуу буюу өдөр 2 ба түүнээс олон удаа хэрэглэж байна. Зохистой байдлаар хооллодог хүүхдийн хувь 6-11 сартай хүүхэдтэй (25.5%) харьцуулахад 12-23 сартай хүүхэд (33.0%)-ийн дунд харьцангуй илүү байв ( $p=0.02$ ). Түүнчлэн зохистой байдлаар хооллодог хүүхдийн үзүүлэлтийг бүс нутаг, байршлаар харьцуулан үнэлэхэд төдийлөн ялгаатай бус, харин Халх болон бусад ястантай (32.8%; 24.9%) харьцуулахад Казак үндэстний (6.1%) дунд бага байгааг илрүүлэв ( $p<0.0001$ ). Зохистой байдлаар хооллодог, нэмэгдэл хоолыг насандаа тохирсон давтамжаар идэж буй хүүхдийн үзүүлэлтийг өрхийн аж байдлын түвшин, хүнсний баталгаат байдлын алдагдлын зэргээр харьцуулан үнэлэхэд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдаагүй болно (Хүснэгт UF.29).

Хүснэгт UF.29: Нялх, бага насны хүүхдийн нэмэгдэл хооллолтын дадал

Үзүүлэлт	Эхийн сүүгээр хооллож байгаа				Эхийн сүүгээр хооллодоггүй					Бүгд хүүхэд			
	Зохих шаардлага хангасан хооллолтой хүүхдийн хувь			Жинлэ эгүй тоо	Зохих шаардлага хангасан хооллолтой хүүхдийн хувь				Жинлэ эгүй тоо	Зохих шаардлага хангасан хооллолтой хүүхдийн хувь			Жинлэ эгүй тоо
	Хүнсний нэр төрлийн хамгийн бага шаардлага	Хооллох давтамжийн хамгийн бага шаардлага	Зохистой байдлаар хооллодог		Хүнсний нэр төрлийн хамгийн бага шаардлага	Хооллох давтамжийн хамгийн бага шаардлага	Зохистой байдлаар хооллодог	Сүүн тэжээл хэрэглэх давтамжийн хамгийн бага шаардлага		Хүнсний нэр төрлийн хамгийн бага шаардлага	Хооллох давтамжийн хамгийн бага шаардлага	Зохистой байдлаар хооллодог	
<b>Бүгд</b>	<b>57.3</b>	<b>60.1</b>	<b>39.3</b>	<b>647</b>	<b>30.4</b>	<b>32.3</b>	<b>9.1</b>	<b>60.2</b>	<b>250</b>	<b>49.4</b>	<b>51.9</b>	<b>30.4</b>	<b>897</b>
<b>Хүүхдийн хүйс</b>													
Эрэгтэй	55.6	61.3	40.9	342	33.0	38.3	9.7	58.3	131	49.0	54.6	31.7	473
Эмэгтэй	59.2	58.8	37.5	305	27.5	25.8	8.4	62.2	119	49.9	49.1	28.9	424
<b>Хүүхдийн нас</b>													
6 – 11 сар	62.4	62.4	23.7	129	37.0	37.0	3.6	77.5	17	42.3	53.1	25.5	307
12 – 23 сар	59.5	59.5	43.0	518	31.9	31.9	9.6	58.5	233	53.2	51.3	33.0	590
<b>Хүүхдийн төрөх үеийн жин</b>													
Бага жинтэй	62.9	61.7	50.5	29	22.3	15.0	11.4	77.7	18	45.8	42.0	34.0	47
Хэвийн жинтэй	55.8	60.3	38.1	518	33.1	36.9	9.7	60.3	203	49.0	53.3	29.6	721
Том жинтэй	61.1	56.9	38.9	94	20.9	8.0	4.2	54.8	20	54.2	48.5	32.9	114
<b>Хүүхдийн хоол тэжээлийн байдал</b>													
Өсөлт хоцролттой	36.9	49.4	26.8	56	35.1	44.0	28.2	74.9	36	36.2	47.3	27.4	92
Өсөлт хэвийн	60.2	61.8	41.1	585	30.2	30.1	6.4	57.2	209	51.8	52.9	31.3	794
<b>Бүсээр</b>													
Баруун	41.0	50.4	19.8	155	26.4	26.6	5.8	58.6	34	38.4	46.1	17.3	189
Хангай	47.2	73.0	44.0	121	18.6	28.8	10.3	48.0	48	39.1	60.5	34.5	169
Төв	58.7	68.2	45.7	127	38.3	37.1	7.8	55.4	55	52.5	58.8	34.2	182
Зүүн	58.5	61.9	40.5	128	23.2	30.6	3.5	52.1	56	47.8	52.4	29.3	184
Улаанбаатар	66.4	55.9	42.3	116	33.2	33.1	10.4	66.6	57	55.5	48.4	31.8	173
<b>Хот, хөдөөгөөр</b>													
Хот	61.2	58.2	40.9	353	33.8	34.2	11.1	63.0	143	52.8	50.8	31.7	496
Хөдөө	48.5	64.4	35.6	294	20.5	27.1	3.3	52.2	107	41.2	54.6	27.1	401
<b>Байршлаар</b>													
Нийслэл	66.4	55.9	42.3	116	33.2	33.1	10.4	66.6	57	55.5	48.4	31.8	173
Аймгийн төв	51.6	62.5	38.3	237	35.3	36.7	12.9	53.9	86	47.2	55.6	31.5	323
Сумын төв/баг	48.5	64.4	35.6	294	20.5	27.1	3.3	52.2	107	41.2	54.6	27.1	401
<b>Эхийн нас</b>													
16-29 нас	57.6	56.9	36.9	252	26.7	36.4	10.9	55.2	101	48.9	51.1	29.5	353
30-39 нас	59.5	63.2	42.2	335	36.4	25.6	6.6	58.2	104	53.2	52.9	32.5	439

40-49 нас	43.1	47.7	25.3	49	33.1	45.4	18.6	82.2	24	36.9	47.0	23.1	73
<b>Эхийн гэрлэлтийн байдал</b>													
Гэрлэсэн	55.4	60.8	38.9	483	31.3	31.5	8.2	57.0	161	48.8	52.8	30.5	644
Гэрлээгүй	34.5	50.8	26.6	35	26.3	50.8	20.6	39.5	17	31.5	50.8	24.4	52
Хамтран амьдардаг	68.4	56.3	40.1	118	36.6	28.2	10.6	73.7	51	59.1	48.2	31.6	169
<b>Эхийн боловсролын түвшин</b>													
Боловсролгүй/Бага / суурь	31.2	56.8	25.0	47	18.7	35.5	7.6	65.7	15	28.2	51.8	20.9	62
Дунд	45.1	58.8	36.1	231	25.8	31.1	11.1	61.2	87	39.9	51.3	29.4	318
Дээд	66.2	59.8	41.2	358	36.1	32.3	9.1	58.5	127	57.4	51.8	31.8	485
<b>Эхийн ажил эрхлэлт</b>													
Ажилтай	57.6	61.0	39.0	362	30.2	29.1	6.7	57.6	145	48.8	50.7	28.6	507
Ажилгүй	56.9	57.5	38.1	274	35.4	37.0	14.5	63.0	84	51.8	52.7	32.6	358
<b>Эхийн хоол тэжээлийн байдал</b>													
Тураалтай	71.2	80.4	58.0	28	35.6	51.9		35.6	6	65.8	76.1	49.3	34
Хэвийн жинтэй	58.5	61.2	40.5	278	41.9	38.3	15.7	67.6	95	53.8	54.7	33.5	373
Илүүдэл жинтэй	60.5	55.2	36.3	212	23.9	28.9	2.3	41.0	63	51.2	48.5	27.7	275
Тарган	41.5	54.7	29.5	106	18.1	11.2	2.8	84.9	34	35.7	43.9	22.9	140
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>													
Халх	59.6	61.9	43.1	479	28.0	31.5	9.7	64.3	202	49.8	52.5	32.8	681
Казак	34.7	47.5	6.4	43	26.7	26.4	5.3	53.0	16	32.4	41.3	6.1	59
Бусад	52.9	54.9	29.8	125	53.2	42.9	5.4	26.7	32	52.9	52.5	24.9	157
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>													
Ядуу	42.1	58.9	30.4	156	14.6	26.8	1.9	45.8	78	33.1	48.4	21.1	234
Дунджаас доогуур	58.7	64.4	44.6	161	13.3	19.2	9.2	49.5	33	50.0	55.8	37.8	194
Дундаж	52.4	64.0	39.4	1500	13.9	34.2	1.3	59.7	46	42.4	56.3	29.6	196
Дунджаас дээгүүр	60.0	57.3	35.3	124	36.4	26.0	14.0	56.2	48	53.6	48.8	29.5	172
Чинээлэг	72.7	52.2	43.9	54	544	44.7	15.6	77.5	45	64.9	49.0	31.7	99
<b>Өрхийн хүнсний баталгаат байдал</b>													
ХББ хангагдсан/хөнгөн алдагдсан	56.9	60.4	38.6	509	31.5	34.9	10.8	64.8	202	49.1	52.5	30.1	711
ХББ дунд зэрэг алдагдсан	52.7	60.3	38.1	109	27.1	21.1	2.2	42.5	42	45.2	48.8	27.6	151
ХББ ноцтой алдагдсан	-	-	31.1	16	-	-	-	-	4	-	-	-	20



Нялх, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөмжид мал, амьтны гаралтай хүнсийг өдөр бүр тогтмол хэрэглэхийг заасан. Түүнчлэн бага насны хүүхдийн өдөр бүр тогтмол хэрэглэвэл зохих хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл (8 нэр төрөл)-д мал, амьтны мах, өндгийг тусгайлсан оруулсан байдаг. Мах, махан бүтээгдэхүүн, өндөгний хэрэглээг тусгайлан тооцохыг “Нялх, бага насны хүүхдийн хооллолтын дадлыг үнэлэх шинэчилсэн шалгуур”-т заасан тул уг үзүүлэлтийг сонгосон үзүүлэлтээр харьцуулан үнэлж, үр дүнг UF.30 хүснэгтэд нэгтгэн үзүүлэв. МУ-ын 6–23 сартай хүүхдийн 90 орчим хувь (89.3%) судалгааны өмнөх 1 хоногт мал, амьтны мах болон өндөг идсэн байв. Мал, амьтны мах, өндөгний хэрэглээ 6–8 сартай (57.3%), Улаанбаатар хот (84.%), Баруун бүсийн (87.8%) хүүхдийн дунд хамгийн бага байна ( $p < 0.0001$ ). Мөн бага насны хүүхдийн мах, өндөгний хэрэглээ 40–49 насны эхийн хүүхдийн (80.9%) дунд 30–39 насны эхийн хүүхэд (93.4%)-тэй харьцуулахад 12.5 пунктээр, хөдөөгийн хүүхэд (95.2%)-тэй харьцуулахад хот (86.8%)-д 8.4 пунктээр тус тус бага байгааг UF.30 хүснэгтээс харж болно ( $p = 0.001$ ,  $p = 0.007$ ).

Хүснэгт UF.30: Бага насны хүүхдийн мал, амьтны мах, өндөгний хэрэглээ

Үзүүлэлт	%	95% ИХ		Жинлээгүй тоо
		Доод	Дээд	
<b>Бүгд</b>	<b>89.3</b>	<b>85.4</b>	<b>92.2</b>	<b>897</b>
<b>Хүүхдийн хүйс</b>				
Эрэгтэй	89.3	83.8	93.1	473
Эмэгтэй	89.2	84.8	92.4	424
<b>Хүүхдийн нас</b>				
6 – 8 сар	57.3	45.5	68.3	146
9 – 11 сар	93.5	85.8	97.2	161
12 – 23 сар	96.1	92.7	97.9	590
<b>Хүүхдийн төрөх үеийн жин</b>				
Бага жинтэй	87.6	67.2	96.1	47
Хэвийн жинтэй	89.0	85.0	92.1	721
Том жинтэй	89.9	85.0	92.1	114
<b>Бүсээр</b>				
Баруун	87.8	80.6	92.5	189
Хангай	96.5	92.9	98.3	169
Төв	95.7	90.9	98.0	182
Зүүн	92.9	87.9	95.9	184
Улаанбаатар	84.6	76.7	90.2	173
<b>Хот, хөдөөгөөр</b>				
Хот	86.8	81.4	90.8	496
Хөдөө	95.2	92.2	97.0	401
<b>Байршлаар</b>				
Нийслэл	84.6	76.7	90.2	173
Аймгийн төв	91.3	86.9	94.3	323
Сумын төв / баг	95.2	92.2	97.0	401
<b>Эхийн нас</b>				
16-29 нас	86.9	79.9	91.6	353
30-39 нас	93.4	89.7	95.9	493
40-49 нас	80.9	68.5	89.2	73
<b>Эхийн гэрлэлтийн байдал</b>				
Гэрлэсэн	89.8	86.1	92.6	644

Гэрлээгүй	83.3	62.8	93.6	52
Хамтран амьдардаг	90.5	82.8	95.0	169
<b>Эхийн боловсролын түвшин</b>				
Боловсролгүй / бага / суурь	85.0	70.3	93.1	62
Дунд	89.3	82.6	93.6	318
Дээд	90.2	86.1	93.2	485
<b>Эхийн ажил эрхлэлт</b>				
Ажилтай	90.7	86.8	93.5	507
Ажилгүй	88.3	81.7	92.7	358
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>				
Халх	88.4	83.6	91.9	681
Казак	84.5	69.9	92.7	59
Бусад	96.0	88.3	98.7	157
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>				
Ядуу	94.0	89.1	96.8	234
Дунджаас доогуур	91.6	86.4	96.8	194
Дундаж	90.6	83.0	95.0	196
Дунджаас дээгүүр	87.9	80.4	92.8	172
Чинээлэг	82.5	71.7	89.7	99
<b>Өрхийн хүнсний баталгаат байдал</b>				
ХББ хангагдсан / хөнгөн алдагдсан	89.2	84.9	92.4	711
ХББ дунд зэрэг алдагдсан	88.4	79.2	93.8	151
ХББ ноцтой алдагдсан	96.4	77.5	99.5	20

Энэ удаагийн хоол тэжээлийн үндэсний VI судалгаагаар 6–23 сартай хүүхдийн эрүүл, зохистой хооллолтын үзүүлэлтүүдийг тооцохын зэрэгцээ “Нялх, бага насны хүүхдийн хооллолтын дадлыг үнэлэх шинэчилсэн шалгуур”-т багтсан эрүүл бус хүнсний хэрэглээ, жимс, ногоо огт хэрэглээгүй хүүхдийн тархалтыг үнэлсэн.

Бага насны хүүхдийн чихэрлэг ундааны хэрэглээг тооцохдоо судалгааны өмнөх 24 цагт чихэртэй, эсвэл чихэрлэг амт оруулагч нэмсэн малын сүү, тарган ундаа, жимсний шүүс, жимсний ундаа, шоколадтай, хийжүүлсэн, исгэсэн ундаа, цай, кофе, ургамлын ундаа уусан эсэхийг тусгайлан тодруулж, эдгээр үзүүлэлтийг нэгтгэн тодорхойлсон болно. Нийт 6–23 сартай хүүхдийн 36.7% чихэртэй эсвэл амт оруулагч нэмсэн ундаа хэрэглэсэн байна. Чихэрлэг ундааны хэрэглээ бүс нутаг, хүүхдийн насны бүлэг, өрхийн тэргүүний үндэс угсаагаар ялгаатай, 12–23 сартай хүүхэд, Улаанбаатар хот, Төв болон Зүүн бүсийн хүүхдийн дунд хамгийн түгээмэл, харин Казак өрхийн хүүхдэд харьцангуй бага байв (Хүснэгт UF.31).

Хэрэв судалгааны өмнөх 1 хоногт шоколад, чихэр, бялуу, нарийн боов, жигнэмэг, зайрмаг гэх мэт амтлаг хүнс, их тосонд шарсан гурилан бүтээгдэхүүн, чипс, шарсан төмс зэрэг хүнс хэрэглэсэн бол тухайн хүүхдийг эрүүл бус хүнс хэрэглэсэн гэж үнэлсэн болно. Нийт 6–23 сартай хүүхдийн 42.2% эрүүл бус хүнс хэрэглэсэн байв. Бага насны хүүхдийн эрүүл бус хүнсний хэрэглээ нь тэдний эхийн нас, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлтийн байдал, өрхийн аж байдлын түвшнээс үл хамааран харьцангуй түгээмэл байна. Гэхдээ Төвийн бүс (57.2%), 12–23 сартай хүүхдийн (53.4%) эрүүл бус хүнсний хэрэглээ бусад бүс, 6–11 сартай хүүхдийн

үзүүлэлтээс нэлээд өндөр ( $p=0.03$ ,  $p<0.0001$ ) байгааг дараах хүснэгт дэх үр дүнгээс харж болно (Хүснэгт UF.31).

Хүснэгт UF.31: Бага насны хүүхдийн чихэрлэг ундаа, эрүүл бус хүнсний хэрэглээ

Үзүүлэлт	Жинлээ гүй тоо	Чихэрлэг ундаа			Эрүүл бус хүнс			Жимс, ногоо огт хэрэглээгүй		
		%	95% ИХ		%	95% ИХ		%	95% ИХ	
			доод	дээд		доод	дээд		доод	дээд
<b>Бүгд</b>	<b>897</b>	<b>36.7</b>	<b>32.6</b>	<b>41.0</b>	<b>42.2</b>	<b>37.1</b>	<b>47.4</b>	<b>31.8</b>	<b>28.0</b>	<b>35.9</b>
<b>Хүүхдийн хүйс</b>										
Эрэгтэй	473	34.5	29.5	39.8	37.8	32.3	43.7	32.8	27.0	39.1
Эмэгтэй	424	39.1	33.4	45.1	46.9	39.9	54.0	30.7	26.1	35.8
<b>Хүүхдийн нас</b>										
6 – 8 сар	146	12.2	6.6	21.4	14.3	9.2	21.6	50.3	41.0	59.6
9 – 11 сар	161	24.6	18.0	32.8	23.9	16.4	33.5	34.3	25.7	44.0
12 – 23 сар	590	46.2	40.8	51.7	54.3	48.6	59.9	26.5	22.4	31.0
<b>Хүүхдийн төрөх үеийн жин</b>										
Бага жинтэй	47	35.6	19.2	56.2	37.7	20.4	58.9	49.0	31.6	66.7
Хэвийн жинтэй	721	37.8	33.6	42.2	43.3	38.1	48.7	31.1	26.8	35.6
Том жинтэй	114	29.3	19.4	41.7	36.6	25.3	49.6	26.9	18.8	36.8
<b>Бүсээр</b>										
Баруун	189	20.6	15.4	27.1	43.7	35.3	52.4	43.0	36.1	50.1
Хангай	169	25.7	19.4	33.2	35.5	26.7	45.4	44.1	35.1	53.4
Төв	182	46.4	38.1	55.0	57.2	49.1	64.9	29.8	22.4	38.5
Зүүн	184	46.7	37.8	55.8	38.7	30.6	47.4	34.9	28.6	41.8
Улаанбаатар	173	40.7	33.2	48.6	39.8	30.8	49.6	24.4	18.1	32.0
<b>Хот, хөдөөгөөр</b>										
Хот	496	37.5	32.1	43.2	40.2	33.6	47.0	27.5	22.9	32.7
Хөдөө	401	34.7	29.5	40.2	47.1	40.7	53.5	42.2	36.0	48.6
<b>Байршлаар</b>										
Нийслэл	173	40.7	33.2	48.6	39.8	30.8	49.6	24.4	18.1	32.0
Аймгийн төв	323	31.1	25.2	37.8	40.8	34.4	47.5	33.9	29.1	39.0
Сумын төв / баг	401	34.7	29.5	40.2	47.1	40.7	53.5	42.2	36.0	48.6
<b>Эхийн нас</b>										
16-29 нас	353	38.1	32.4	44.2	42.9	36.2	49.8	28.7	24.0	33.9
30-39 нас	493	37.7	31.5	44.2	43.6	36.9	50.4	33.7	27.8	40.2
40-49 нас	73	23.6	14.1	36.8	37.7	26.5	50.3	36.6	24.8	50.2
<b>Эхийн гэрлэлтийн байдал</b>										
Гэрлэсэн	644	34.7	30.8	38.8	43.2	37.8	48.7	33.3	28.8	38.2
Гэрлээгүй	52	34.0	18.7	53.6	44.4	31.4	58.2	33.8	20.3	50.6
Хамтран амьдардаг	169	42.9	33.0	53.4	40.9	30.6	52.1	27.3	20.1	35.8
<b>Эхийн боловсролын түвшин</b>										
Боловсролгүй/баг а/суурь	62	30.7	18.7	46.1	35.7	22.8	51.1	60.1	43.1	75.0
Дунд	318	40.8	34.9	46.9	41.4	35.1	48.1	45.9	38.9	53.1
Дээд	485	34.9	30.1	40.0	44.0	37.6	50.6	22.4	18.4	27.0
<b>Эхийн ажил эрхлэлт</b>										
Ажилтай	507	34.8	30.2	39.7	42.0	36.6	47.5	30.1	25.2	35.6
Ажилгүй	358	38.5	31.8	45.7	43.6	35.5	52.1	34.2	28.6	40.2
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>										
Халх	681	39.3	34.6	44.2	43.2	37.6	49.1	30.7	26.1	35.6
Казак	59	17.5	9.7	29.5	39.2	26.3	53.9	56.7	44.1	68.4
Бусад	157	28.1	20.4	37.3	37.0	27.5	47.7	29.8	20.6	40.9


<b>Өрхийн аж байдлын түвшин</b>										
Ядуу	234	36.6	29.2	44.7	47.2	39.4	55.1	48.7	40.9	56.
Дунджаас доогуур	194	33.4	24.9	43.1	42.2	32.0	53.2	40.1	31.9	48.9
Дундаж	196	44.6	34.9	54.7	52.4	41.9	62.7	35.2	28.4	42.7
Дунджаас дээгүүр	172	35.0	27.7	43.2	33.9	25.0	44.1	17.8	11.3	26.9
Чинээлэг	99	33.0	24.0	43.4	37.1	25.9	49.9	21.2	13.8	31.3

Жимс, хүнсний ногооны тогтмол хэрэглээ нь насанд хүрэгчид төдийгүй, бага насны хүүхдийн эрүүл хооллолтыг илтгэх чухал үзүүлэлт юм. Судалгаагаар А аминдэмээр баялаг болон бусад төрлийн жимс, ногоо огт хэрэглээгүй хүүхдийн хувийг тооцон, сонгосон үзүүлэлтээр харьцуулан үнэлсэн болно. Бага насны 3 хүүхэд тутмын 1 орчим (31.8%) нь жимс, хүнсний ногоо огт хэрэглээгүй байв. Жимс, хүнсний ногоо огт хэрэглээгүй хүүхдийн үзүүлэлт тэдний нас, оршин суугаа бүс нутаг, байршлаар ялгаатай ( $p < 0.0001$ ) байна. Тухайлбал, Баруун болон Хангайн бүс, хөдөөгийн хүүхдийн дунд бусад бүс, хотын хүүхэдтэй харьцуулахад илүү түгээмэл байв. Мөн нэмэгдэл хоол идэж эхэлж буй нас 6–8 сартай хүүхдийн (50.3%) дунд 12–23 сартай хүүхэдтэй (26.5%) харьцуулахад жимс, ногоо огт хэрэглээгүй байдал 1.9 дахин илүү байна. Жимс, ногоо огт хэрэглээгүй хүүхдийн үзүүлэлт өрхийн аж байдлын түвшин доогуур өрх ( $p < 0.0001$ ), Казак үндэстэн ( $p = 0.01$ ), боловсролгүй, эсвэл бага, суурь боловсролтой эхийн хүүхдийн ( $p < 0.0001$ ) дунд харьцангуй илүү байгааг UF.30 хүснэгт дэх үр дүн илтгэж байв.

## **ХЭЛЦЭМЖ**

### ***Хоол тэжээлийн байдал***


Тав хүртэлх насны хүүхдийн дундах уураг илчлэг дутал болон илүүдлийн тархалтын нийгмийн эрүүл мэндийн нөлөөг үнэлэх олон улсын шалгуур үзүүлэлтээр туранхай хүүхдийн хувь  $< 2.5\%$  бол “Маш бага”, өсөлт хоцролттой хүүхэд  $2.5\%–10.0\%$  байвал “Бага”, илүүдэл жинтэй хүүхэд  $10\%–15\%$  байвал “Их” тархалттай гэж үнэлэхийг заасан [65]. Энэхүү шалгуураар МУ-ын 5 хүртэлх насны хүүхдийн дундах тураал, өсөлт хоцролт, туранхайн тархалт үндэсний түвшинд дээрх босго үзүүлэлтээс бага байгаа тул манай улс хоол тэжээлийн цочмог дутлын тархалт “Маш бага”, өсөлт хоцролтын тархалт “Бага” орны бүрэлдэхүүнд багтаж байгаа бол илүүдэл жингийн тархалтаар “Их” орны бүлэгт хамаарч байна. Тав хүртэлх насны хүүхдийн дундах уураг илчлэг дутлын тархалтыг 1992–2023 онд хийгдсэн хоол тэжээлийн үндэсний судалгааны дүнтэй харьцуулбал тасралтгүй буурсан, харин илүүдэл жингийн тархалт 2004 оноос хойш 3.3 дахин нэмэгдсэн хэдий ч, 2017 оны судалгааны дүнгээс өөрчлөгдөөгүй байна (Зураг UF.2).



Зураг UF.2. Монгол улсын 5 хүртэлх насны хүүхдийн дундах хоол тэжээлээс хамааралт эмгэгийн тархалт, 1992–2023 онд

Монгол улсын Засгийн газраас 5 хүртэлх насны хүүхдийг хоол тэжээлийн дутлаас сэргийлэх, тархалтыг бууруулах чиглэлээр “Нялх, бага насны хүүхдийн хооллолт”-ыг дэмжих, “Бичил тэжээлийн дутлаас сэргийлэх” бодлого баримталж, “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл”, “Хүнсний баталгаат байдал”, “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөр, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг шат дараалан хэрэгжүүлсний үр дүнд өсөлт хоцролт, тураалын тархалт тогтвортой буурч, бага тархалттай орны тоонд багтаж байна.

Дэлхийн хоол тэжээлийн зорилт (2012–2025 он)-д 5 хүртэлх насны хүүхдийн дундах өсөлт хоцролтыг 40% бууруулах, хоол тэжээлийн цочмог дутал (туранхай)-ыг <5% түвшинд барих, илүүдэл жинг 2017 оны түвшнээс нэмэгдүүлэх байхыг заасан. Монгол Улс нь 5 хүртэлх насны хүүхдийн дундах өсөлт хоцролтын тархалтыг 40% бууруулж чадсан хэдий ч, илүүдэл жингийн тархалтыг нэмэгдүүлэхгүй байх Дэлхийн зорилтыг хангахгүй байна.




Зураг UF.3. Тав хүртэлх насны хүүхдийн дундах хоол тэжээлээс хамааралт эмгэгийн тархалтыг дэлхийн болон Ази тивийн улс орны 2022 оны түвшинтэй <sup>[66]</sup> харьцуулсан дүн

Харин 5 хүртэлх насны хүүхдийн дундах илүүдэл жингийн тархалт их байгаа нь цаашид “Дэлхийн хоол тэжээлийн зорилго”-д заасан “Илүүдэл жин ба таргалалтын тархалтыг суурь түвшнээс нэмэгдүүлэхгүй байх” зорилтыг хангахад илүү анхаарал хандуулах шаардлагатайг илтгэж байна.

### Бичил тэжээлийн дутал

Монгол улсын хүн амын хоол тэжээлийн байдалд үнэлгээ өгсөн удаа дараагийн үндэсний судалгаагаар 5 хүртэлх насны хүүхдийн дундах бичил тэжээлийн дутал, түүнээс үүдэлтэй эмгэгийн тархалтыг судлан 6-59 сартай хүүхдийн дунд төмөр, А, Д аминдэм дутлын тархалт түгээмэл, нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болохыг онцлон тодорхойлсон байдаг. Цус багадалтын тархалтын Нийгмийн эрүүл мэнд (НЭМ)-ийн нөлөөг тодорхойлох ДЭМБ-ын шалгуурт цус багадалттай хүн амын хувь 20.0%–39.9% байвал “Дунд” зэрэг гэж үнэлэхийг заасан [67]. Монголын 2-59 сартай хүүхдийн дундах цус багадалтын тархалт нь ДЭМБ-ын үнэлгээгээр “Дунд” зэргийн тархалттай, сүүлийн 20 орчим жилд энэхүү түвшнээс төдийлөн буурахгүй, харин төмөр дутлын цус багадалтын тархалт бага зэрэг буурсан байгааг дараах зургаас харж болно (Зураг UF.4).



Зураг UF.4. Тав хүртэлх насны хүүхдийн дундах нийт цус багадалт<sup>10</sup>, төмөр дутлын цус багадалтын<sup>11</sup> тархалт, 1999-2023 онд

Энэхүү судалгаагаар 2017 оны хоол тэжээлийн үндэсний V судалгааны нэгэн адил төмөр дутлыг 2 төрлийн биомаркераар тодорхойлсон болно. Судалгаагаар манай улсын 6–59 сартай хүүхдийн дунд ферритиний түвшнээр тодорхойлсон төмөр дутал 14.1%, уусдаг трансферрин

<sup>10</sup> Цус багадалтын тархалтыг 2-56 сартай хүүхдийн дунд үнэлсэн.


<sup>11</sup> Төмөр дутлын цус багадалтын тархалтыг 6-59 сартай хүүхдийн дунд тогтоосон.

рецепторийн түвшнээр тодорхойлсон төмөр дутал 10.8% байгааг ДЭМБ-ын цус багадалтаас сэргийлэх, хянах арга зүйн [68] удирдамжид тодорхойлсон тархалтын шалгуураар үнэлэхэд МУ-ын 5 хүртэлх насны хүүхдийн дунд “төмөр дутлын тархалт түгээмэл, аливаа хэлбэрийн үрэвслийн тархалт ихтэй” гэсэн ангилалд багтаж байна (Хүснэгт UF.31).

Хүснэгт UF.31: Ийлдсийн ферритины агууламж буурах, трансферрин рецепторийн хэмжээ ихсэлтийг үнэлгээ, НЭМ-ийн нөлөөг тодорхойлох тайлбар

Ферритиний түвшнээр тодорхойлсон төмөр дутал	Уусдаг трансферрин рецепторийн түвшнээр тодорхойлсон төмөр дутал	НЭМ-ийн нөлөөг тодорхойлсон тархалтын ангилал
< 20.0%	< 10.0%	Төмөр дутлын тархалт түгээмэл бус
< 20.0%	≥ 10.0%	Төмөр дутлын тархалт түгээмэл, үрэвслийн тархалт ихтэй
≥ 20.0%	≥ 10.0%	Төмөр дутлын тархалт түгээмэл
≥ 20.0%	< 10.0%	Төмөр дутлын тархалт түгээмэл


Уусдаг трансферрин рецепторийн түвшнээр тодорхойлсон төмөр дутал болон бие махбод дахь төмрийн нөөц дутмаг байдал үндэсний түвшинд 2017 оны судалгааны үзүүлэлтээс буурсан эерэг үр дүн ажиглагдаж байна (Зураг UF.5). Гэхдээ 2023 оны байдлаар Баруун бүсийн хүүхдийн 26.2%, 6–23 сартай хүүхдийн 36.6%, боловсролгүй, бага эсвэл суурь боловсролтой эхийн хүүхдийн 29.1% төмөр дуталтай байгаа нь төмөр дутлын тархалт НЭМ-ийн тулгамдсан асуудал хэвээр байгааг илтгэх үзүүлэлт юм.



Зураг UF.5. Төмөр дутал, төмрийн нөөц дутмаг байдал, судалгааны оноор

Хүний бие махбодын эрчимтэй өсөлтийн үе буюу жирэмслэлт, нялх, балчир үе, өсвөр насанд А, Д аминдэмийн хэрэгцээ хамгийн өндөр байдаг. А аминдэм нь биеийн эд, эсийн нөхөн


төлжилтөд оролцохын зэрэгцээ дархлааны тогтолцооны хариу урвалд оролцож, халдвартай тэмцэхэд тусалдаг. Удаа дараагийн хоол тэжээлийн судалгаагаар А, Д аминдэмийн байдлыг судлан, дутлын тархалтыг тодорхойлсон байдаг. Энэ удаагийн үндэсний VI судалгааны дүнгээр Монголын 6-59 сартай хүүхдийн 7.1% А аминдэм дуталтай, 2010 болон 2017 оны судалгааны дүн (ХТҮС-IV ба V, 2010 ба 2017 он)-гээс буурсан хэдий ч, нөөц дутмаг буюу дуталд өртөх эрсдэлтэй хүүхдийн хувь өндөр (57.9%) хэвээр байна (Зураг UF.5).



Зураг UF.5. МУ-ын 6–59 сартай хүүхдийн А аминдэмийн байдал, 2004 – 2023 онд

Хүний бие махбодын эрчимтэй өсөлтийн үед кальцийг биед шингээх, ясны хэвийн өсөлтийг хангахад Д аминдэм шийдвэрлэх үүрэгтэй. Д аминдэм нь А аминдэм, кальци болон фосфорын шингэцийг түргэсгэж, шүдийг бэхжүүлэх ба хүүхдийн биед кальци дутахаас хамгаалж ясыг бэхжүүлнэ. Мөн Д аминдэм нь бие махбодын дархлаа тогтолцооны хэвийн үйл ажиллагааг хангахад оролцож, чихрийн шинжин, түрүү булчирхай, бүдүүн гэдэс зэрэг эрхтний хавдраас сэргийлэх нөлөөтэйг судалгаагаар тогтоосон байдаг. Иймд Д аминдэмийн түвшин хангалтгүй байх нь ясны эрдэжилтэд сөргөөр нөлөөлж, хүүхдийн өсөлт хоцрох, насанд хүрэгчдийн яс зөөлөрч сийрэгжин хугарах, чихрийн шинжин, зарим хавдраар өвчлөх эрсдэл нэмэгддэг байна. Энэхүү судалгаагаар 6-59 сартай 10 хүүхэд тутмын 5 нь (48.4%) Д аминдэм дуталтай, 31.0% Д аминдэмийн нөөц дутмаг байгааг илрүүлсэн болно. Түүнчлэн Д аминдэмийн хангамж багатай (25 (ОН)  $D \leq 29.9$  нг/мл) байдал аль ч насны хүүхэд, нийт бүс нутаг, өрхийн аж байдлын түвшнээс үл хамааран нийт хүүхдийн дунд түгээмэл байгааг тогтоов. Д аминдэмийн дутлын тархалтыг өмнөх судалгааны дүнтэй харьцуулан үзвэл 2017 оны түвшнээс 11.6 пунктээр буурсан, харин Д аминдэмийн нөөц дутмаг байдалд өөрчлөлт харагдахгүй байна (Зураг UF.6).





Зураг UF.6. МУ-ын 6–59 сартай хүүхдийн Д аминдэмийн байдал, 2004 – 2023 онд


Эцэст нь 5 хүртэлх насны хүүхдийн дундах бичил тэжээлийн дутлын тархалтыг 2004–2023 онд зохион байгуулсан хоол тэжээлийн үндэсний судалгааны дүнтэй харьцуулан үнэлэхэд цус багадалт, төмөр дутал, Д аминдэм дутлын тархалт НЭМ-ийн тулгамдсан асуудал хэвээр, энэ төрлийн “далд өлсгөлөн”-д өртсөн хүүхдийн хувь олон улсын шалгуурт тодорхойлсноор “дунд” болон “их” түвшний ангилалд багтаж байна.

### **Бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглээ**

МУ-ын Засгийн газраас 5 хүртэлх насны хүүхдийн дунд түгээмэл тохиолдож байгаа цус багадалт, төмөр, А, Д аминдэмийн дутал болон өвчлөл, эндэгдлийг бууруулах зорилгоор эрүүл, зохистой хооллолтыг дэмжиж өндөр тунт А аминдэм, ОНБТБ-оор хангах арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн билээ. Энэхүү судалгаагаар 5 хүртэлх насны хүүхдийн А, Д аминдэм, ОНБТБ, төмрийн бэлдмэл болон бусад бичил тэжээлийн хэрэглээг өмнө хийгдсэн судалгааны үр дүнтэй харьцуулан жиших зорилгоор үнэлсэн болно. Эрүүл мэндийн Сайдын 2020 оны 490 дүгээр тушаалд 5 хүртэлх насны хүүхдийг жилд 2 удаа өндөр тунт А аминдэмээр, 6-23 сартай хүүхдийг ОНБТБ-оор үнэ төлбөргүй хангахыг заасан хэдий ч, хэрэгжилт туйлын хангалтгүй байгааг UF.7 зургаас харж болно.

Тав хүртэлх насны хүүхдийг Д аминдэмээр үнэ төлбөргүй хангах арга хэмжээг 2020 оны шинэчилсэн тушаалаар зогсоож, Д аминдэм дутлаас сэргийлэх хоногийн зөвлөмж хэмжээ болон хоногт хэрэглэх дээд тунг дээр дурдсан тушаалд заасан. Тав хүртэлх насны хүүхдийн Д аминдэмийн хэрэглээ 2017 оны түвшнээс 21.5 пунктээр өссөн байгаа нь Д аминдэм дутлын тархалт буурсан шалтгааныг тайлбарлаж болох юм (Зураг UF.6).

Харин улсын төсөв болон сум, өрхийн ЭМТ-ийн нэг иргэнээр тооцсон суурь төсөвт тусган хүүхэд, эмэгтэйчүүдийг үнэ төлбөргүй хангахаар заасан өндөр тунт А аминдэмийн хэрэглээ 2017 оны түвшнээс нэмэгдээгүй (61.2%), ОНБТБ-ийн хэрэглээ 2.9 дахин буурсан байна (Зураг




Зураг UF.7. Тав хүртэлх насны хүүхдийн бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглээ, 2004-2023 он

Түүнчлэн манай улс 2000 оноос эхлэн 5 хүртэлх насны хүүхдийг жилд 2 удаа өндөр тунт А аминдэмээр хангах арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн хэдий ч, хамралтын түвшин төдийлөн нэмэгдэхгүй байгааг удаа дараагийн судалгааны дүн илтгэж байна (Зураг UF.7). Аливаа арга хэмжээний үр дүн, үр нөлөөг сайжруулахад байнгын хяналт-шинжилгээ, үнэлгээ шаардлагатай байдаг. Тус төв нь жилд 2 удаа аймаг, нийслэлийн ЭМГ-аас А аминдэмийн түгээлтийн тайлан, мэдээг цуглуулж, нэгтгэн ЭМЯ-д илгээдэг бөгөөд 2023 оны тайланд А аминдэмжүүлэлтийн хамралт 90 орчим хувь байсан. Гэтэл судалгаагаар тогтоосон хамрагдалтын түвшин 60 орчим хувь байгаа нь анхаарвал зохих асуудал юм. Иймд сум, өрхийн ЭМТ-ийн А аминдэмийн бэлдмэл түгээх үйл ажиллагаа болон хэрэглээнд тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

### **Нялх, бага насны хүүхдийн хооллолт**

Хоол тэжээлийн үндэсний VI судалгаагаар тогтоосон нялх, бага насны хүүхдийн эхийн сүүгээр хооллолт, нэмэгдэл хооллолтын үр дүнг өмнө хийгдсэн хоол тэжээлийн үндэсний IV, V судалгааны үр дүнтэй харьцуулан үнэлэв.


Бага насны хүүхдийн эхийн сүүгээр хооллолтын дадлыг олон улсын түвшинд түгээмэл ашигладаг үзүүлэлтээр, өмнөх судалгааны дүнтэй харьцуулан үнэлж, UF.8 зурагт харуулав. Нярай хүүхдийг төрсний дараа 1 цагийн дотор ангир уургаар амлуулах, 6 сар хүртэл нь зөвхөн эхийн сүүгээр дагнан хооллох үзүүлэлтүүд 2017 оны түвшнээс төдийлөн нэмэгдээгүй, 87.4% ба 59.6% байна. Харин бага насны хүүхдийг эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллох байдал, ялангуяа 2 нас хүртлээ эхийн сүүгээр хооллосон хүүхдийн хувь жилээс жилд тасралтгүй буурч байгааг удаа дараагийн судалгааны дүн илтгэж байна. Тодруулбал, 2023 оны байдлаар 2 нас хүртлээ эхийн сүүгээр хооллосон хүүхдийн хувь 2017 оны түвшнээс 6.9 пунктээр буурчээ (Зураг



Зураг UF.8: Бага насны хүүхдийн эхийн сүүгээр хооллолтын байдал, 1999 – 2023 онд

ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн Сангаас “Нялх, бага насны хүүхдийн хооллолтын дадлыг үнэлэх шалгуур үзүүлэлт”-д өөрчлөлт оруулж, зарим үзүүлэлтийг хасахын зэрэгцээ шинэ шалгуур үзүүлэлтийг нэмэлтээр оруулсан. Энэ удаагийн хоол тэжээлийн судалгаагаар өмнө ашиглаж байсан үзүүлэлтийг тооцохын зэрэгцээ, шинээр нэмэгдсэн шинэчилсэн үзүүлэлтээр эхийн сүүгээр хооллолтын дадлыг үнэлсэн болно. Тухайлбал, шинэчилсэн шалгуурт 1 нас, 2 нас хүртлээ эхийн сүүгээр хооллосон хүүхдийн үзүүлэлтийг хасаж, харин 12–23 сартай хүүхдийн дунд эхийн сүүгээр хооллож буй хүүхдийн хувийг тооцохыг заасан. Мөн шинэчилсэн шалгуурт багтсан “төрсний дараах эхний 2 хоногт эхийн сүүгээр дагнан хооллосон хүүхэд”, “чихрийн агууламжтай ундааны хэрэглээ” зэрэг үзүүлэлтийг нэмэлтээр тооцсон. Манай улсын 12–23 сартай нийт хүүхдийн 64.1% эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож байгаа бөгөөд 0–23 сартай хүүхдийн 75.8% төрсний дараах эхний 2 хоногт эхийн сүүгээр дагнан хооллосон байв.

Нялх, бага насны хүүхдийн нэмэгдэл хооллолтын дадлыг тэдний хооллолтын чанар, тоо хэмжээг илтгэх жишиг үзүүлэлтээр тогтоож, хоол тэжээлийн үндэсний IV ба V судалгааны дүнтэй харьцуулан үнэлэхэд, хооллолтын чанар төдийлөн сайжраагүй, харин зохих давтамжаар хооллож байгаа хүүхдийн хувь 2017 оны түвшнээс нэлээд буурсан байна. Нялх, бага насны хүүхдийн хооллолтын чанарыг илтгэх хамгийн чухал үзүүлэлт бол өдөрт хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл юм. Бага насны хүүхдийн эрүүл, зохистой хооллолтын зөвлөмжид хүүхэд өдөрт хамгийн багадаа эхийн сүүг оролцуулаад 5 нэр төрлийн хүнс хэрэглэхийг заасан. Энэхүү зөвлөмжийн дагуу хооллож буй хүүхдийг “хүнсний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан хооллолт”-той байна гэж үнэлдэг бөгөөд 2023 оны байдлаар уг үзүүлэлт өмнөх судалгааны дүн (49.6%)-гээс нэмэгдээгүй байна. Түүнчлэн судалгааны өмнөх 1 хоногт зохистой байдлаар хооллосон хүүхдийн хувь 2017 оны судалгааны дүн (43.8%)-гээс 13.4 пунктээр буурсан байгааг анхаарах шаардлагатай байна (Зураг UF.9).



Зураг UF.9: Бага насны хүүхдийн нэмэгдэл хооллолтын дадал, 2010-2023 он

Хоол тэжээлийн үндэсний VI судалгаагаар 6–23 сартай хүүхдийн зохистой хооллолтын үндсэн үзүүлэлтүүдийг тооцохын зэрэгцээ “Нялх бага насны хүүхдийн хооллолтын дадлыг үнэлэх шинэчилсэн шалгуур”-т багтсан эрүүл бус хүнсний хэрэглээ, жимс, ногоо огт хэрэглээгүй хүүхдийн тархалтыг үнэлэхэд 10 хүүхэд тутмын 4 орчимд нь чихэрлэг ундаа уулгасан, эрүүл бус хүнсээр хооллосон байгааг анхаарах шаардлагатай байна. Түүнчлэн бага насны хүүхдийн эрүүл өсөлт, хөгжлийг дэмжих, өвчинтэй тэмцэхэд нэн шаардлага аминдэм, эрдсээр баялаг жимс, хүнсний ногоог 3 хүүхэд тутмын 1 орчим нь огт идээгүй байв.

Эцэст нь дүгнэхэд 2 нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллосон, зохистой байдлаар хооллож байгаа 6–23 сартай хүүхдийн хувь буурахын зэрэгцээ, эрт амлуулалт, эхийн сүүгээр

дагнан хооллолтын үзүүлэлтүүд сайжраагүй байна. Түүнчлэн нялх, бага насны хүүхдийг эрүүл бус хүнсээр хооллох дадал харьцангуй түгээмэл байгааг анхаарвал зохино. Иймд хүн ам, ялангуяа эх, асрамжлагчдын бага насны хүүхдийн хооллолтын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, дадлыг сайжруулах чиглэлээр анхаарч ажиллах, эрүүл мэндийн мэргэжилтний хүүхдийн хооллолтын талаар зөвлөгөө өгөх ур чадвар, чадавхыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний төрөл, хэлбэр, арга зүйг өөрчилөх, чанар хяналт тавих орон нутгийн оролцоо, идэвхийг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг судалгааны дүн илтгэж байна. Түүнчлэн нялх, бага насны хүүхдийн хооллолтын дадал нь тэдний нас, эхийн боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлтийн байдал, өрхийн тэргүүний үндэс угсаагаар ялгаатай байгаа тул эхийн сүүгээр хооллолт, бага насны хүүхдийн нэмэгдэл хооллолтыг дэмжих үйл ажиллагааг зорилтот бүлэгт чиглэсэн, тэдний хэрэгцээнд нийцсэн өвөрмөц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## ДҮГНЭЛТ

1. Монгол улсын 5 хүртэлх насны хүүхдийн 8.4% өсөлт хоцролттой, 1.5% тураалтай, 1.3% туранхай буюу хоол тэжээлийн цочмог дуталтай байна. Өсөлт хоцролтын тархалт Баруун болон Хангайн бүс, аж байдлын түвшин дунджаас доогуур, ядуу өрх, боловсролгүй, бага эсвэл суурь боловсролтой эхийн хүүхэд, Казак үндэстний хүүхдийн дунд харьцангуй өндөр байв.
2. Тав хүртэлх насны хүүхдийн дунд бага жинтэй төрөлтийн тархалт харьцангуй бага (3.9%), харин том жинтэй төрөлт 11.8% байв. Бага жинтэй төрсөн хүүхдийн дунд өсөлт хоцролтын тархалт хэвийн жинтэй төрсөн хүүхэдтэй харьцуулахад 3.6 дахин, хоол тэжээлийн цочмог хүнд дутлын тархалт 5.8 дахин, харин том жинтэй төрсөн хүүхдийн дунд илүүдэл жингийн тархалт хэвийн жинтэй төрсөн хүүхдээс 1.7 дахин илүү байгаа нь хүүхдийн төрөх үеийн биеийн жин тэдний хоол тэжээлээс хамааралт эмгэгт өртөх эрсдэлийг ихэсгэж байгааг илтгэж байна.
3. Монгол улсын 5 хүртэлх насны хүүхдийн дунд цус багадалт “Дунд” зэргийн (21.3%) тархалттай, цус багадалттай хүүхдүүдийн дийлэнх хувь хөнгөн, хүндэвтэр хэлбэрийн цус багадалттай байна. Цус багадалтын тархалт 2 хүртэлх насны хүүхэд, ядуу өрх, боловсролгүй, бага эсвэл суурь боловсролтой эхийн, Казак хүүхдийн дунд харьцангуй түгээмэл байв.
4. Төмөр дутлын цус багадалтын тархалт харьцангуй бага, нийт 6–59 сартай хүүхдийн 5.7% төмөр дутлын цус багадалттай байв. Төмөр дутлын цус багадалтын тархалт хөвгүүдийн дунд охидоос 2 дахин илүү, 6–23 сартай 5 хүүхэд тутмын 1 орчим, аж

байдлын түвшин доогуур өрхийн хүүхэд, боловсролгүй, бага эсвэл суурь боловсролтой эхийн хүүхдийн дунд илүү түгээмэл байна.

5. Монгол улсын 6–59 сартай хүүхдийн 14.1% ийлдэс дэх ферритиний түвшин багатай, 10.8% уусдаг трансферрин агууламж багатай буюу төмөр дуталтай байна. Төмөр дутлын тархалтын түвшин өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг буурсан хэдий ч, 6–23 сартай хүүхэд, Баруун бүс, ядуу өрх, Казак хүүхдийн дунд харьцангуй өндөр хэвээр байна.
6. Монгол улсын 6-59 сартай 2 хүүхэд тутмын 1 орчим (48.4%) Д аминдэмийн дуталтай, 3 хүүхэд тутмын 1 нь Д аминдэмийн нөөц дутмаг байдалд байв. Д аминдэм дутлын тархалт 2017 оны түвшнээс буурсан, харин Д аминдэмийн нөөц дутмаг байдалд өөрчлөлт ажиглагдахгүй байна. А аминдэм дутлын тархалт харьцангуй бага (7.1%) байгаа боловч, 10 хүүхэд тутмын 6 орчим нь А аминдэмийн нөөц багатай буюу дуталд өртөх эрсдэлтэй хэвээр байв.
7. Тав хүртэлх насны хүүхдийн 61.2% өндөр тунт А аминдэмжүүлэлтэд хамрагдсан, 79.5% ямар нэг хэлбэрийн Д аминдэмийн бэлдмэлийг хэрэглэсэн байна. Нийт хүүхдийн Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийнхэрэглээ туйлын хангалтгүй, тэдний 7.9% нь дунджаар 41 уут бичил тэжээлийн холимог хэрэглэсэн байв.
8. Бага насны хүүхдийн эхийн сүүгээр хооллолтын үзүүлэлтүүд өмнөх судалгааны үзүүлэлтээс төдийлөн сайжраагүй, эхийн сүүгээр хооллох хугацаа буурсаар байна. Хоёр хүртэлх насны хүүхдийн 87.4% төрөөд 1 цагийн дотор ангир уургаа амласан, 75.8% төрсний дараах эхний 2 хоногт эхийн дүүгээр дагнан хооллож байв. Зургаан сар хүртэлх насны хүүхдийн 59.6% эхийн сүүгээр дагнан, 95.4% эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ сүүн тэжээл, малын сүү уусан байв.
9. Монгол улсын 6-23 сартай 10 хүүхэд тутмын 7 нь зохистой байдлаар хооллож чадахгүй байна. Хоёр хүүхэд тутмын 1 нь насандаа тохирсон давтамжаар, зохих нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэж чадахгүй, 31.8% жимс, хүнсний ногоо огт хэрэглээгүй байв. Бага насны хүүхдийн нэмэгдэл хооллолтын дадлын үзүүлэлтүүд 2017 оны түвшнээс сайжраагүй төдийгүй, их тосонд шарсан эрүүл бус хүнсний хэрэглээ (42.2%) харьцангуй түгээмэл, 3 хүүхэд тутмын 1 чихэрлэг ундаа хэрэглэж байна.



## Түүврийн шинж байдал

Судалгаанд 5 хүртэлх насны хүүхэдтэй, 15-49 насны 2513 жирэмсэн бус эмэгтэйг бүрэн хамруулж, тэдний хоол тэжээлийн байдал, хүнсний болон аминдэм, эрдсийн бэлдмэлийн хэрэглээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ашиглалтын талаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийв.

Төрөх насны эхчүүдийн 67.6% нь 20-39 насны, 54.5% их, дээд сургууль төгссөн эсвэл төгсөлтийн дараах боловсролтой, 72.8% гэрлэсэн, 71.4% хот суурин газарт амьдарч байна. Тав хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн дийлэнх нь халх ястан, 61.2% төрийн болон хувийн хэвшлийн байгууллага эсвэл хувийн аж ахуй эрхэлж байв. Мөн өсвөр насны буюу 16–19 насны эхчүүд 6.3% (n=18) бүрдүүлж байна (Хүснэгт W.1).

Хүснэгт W.1. Тав хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн шинж байдал, үндэсний түвшинд

Үзүүлэлт	Жинлэсэн хувь	95% ИХ		Жинлээгүй тоо
		Доод	Дээд	
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	-		<b>2513</b>
<b>Нас</b>				
< 20 нас	6.3	3.2	11.8	18
20-29 нас	29.9	26.9	33.1	822
30-39 нас	37.7	34.4	41.1	1380
40-49 нас	26.1	22.8	29.7	293
<b>Эдийн засгийн бүс</b>				
Баруун	12.2	10.6	14.0	516
Хангай	16.9	15.1	18.8	483
Төв	14.2	12.7	15.8	524
Зүүн	7.0	6.0	8.0	489
Улаанбаатар	49.7	46.9	5.5	501
<b>Хот, хөдөө</b>				
Хот	71.4	66.6	75.7	1335
Хөдөө	28.6	24.3	33.4	1178
<b>Байршил</b>				
Нийслэл хот	49.7	46.5	52.5	501
Аймгийн төв	21.6	17.4	26.6	834
Сумын төв / Баг	28.6	24.3	33.4	1178
<b>Яс үндэс</b>				
Халх	85.4	82.5	87.8	1942
Казак	3.5	2.2	5.5	165
Дөрвөд	2.9	1.8	4.7	77
Буриад	1.4	0.8	2.2	65
Баяд	1.5	0.9	2.4	59
Дарьганга	0.5	0.2	0.9	34
Бусад	5.4	3.9	7.3	205
<b>Боловсролын түвшин</b>				
Боловсролгүй / бүрэн бус баг	1.2	0.9	1.7	51
Бага / суурь	5.5	4.0	7.5	141



Бүрэн дунд	38.8	33.9	44.0	935
Дээд / магистр	54.5	49.3	59.6	1386
<b>Ажил эрхлэлт</b>				
Ажилтай	61.2	56.8	65.4	1666
Ажилгүй	38.8	34.6	43.2	847
<b>Гэрлэлтийн байдал</b>				
Гэрлэсэн	72.8	69.0	76.4	1973
Гэрлээгүй	7.3	5.5	9.7	135
Хамтран амьдардаг	19.8	16.8	23.3	405
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>				
Ядуу	20.0	17.1	23.2	661
Дунджаас доогуур	19.7	16.3	23.8	582
Дундаж	19.9	16.4	23.9	532
Дунджаас дээгүүр	20.4	16.5	25.0	448
Чинээлэг	19.9	14.9	26.2	287

Бүрэн дунд боловсролтой эхчүүдийн хувь хөдөөд харьцангуй илүү (43.1%), харин дээд боловсролтой эхчүүдийн хувь хот суурин газар (58.8%), Улаанбаатар хотод (63.9%) илүү, ажил эрхэлдэг эхчүүдийн хувь хот (75.3%)-д хөдөө (55.5%)-өөс илүү байна (Хүснэгт W.2).

Хүснэгт W.2. Тав хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн шинж байдал, бүсийн түвшинд

Үзүүлэлтүүд	Жинлэсэн Хувь	Хот, хөдөө		Эдийн засгийн бүс					Жинлээгүй Тоо
		Хот	Хөдөө	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	
<b>Бүгд</b>									
<b>Хот, хөдөө</b>									
Хот									
Хөдөө									
<b>Байршил</b>									
Нийслэл хот									
Аймгийн төв									
Сумын төв / Баг									
<b>Нас</b>									
15-19 нас									
20-29 нас									
30-39 нас									
40-49 нас									
<b>Гэрлэлтийн байдал</b>									
Гэрлэсэн									
Гэрлээгүй									
Хамтран амьдардаг									
<b>Яс үндэс</b>									
Халх									
Казак									
Дөрвөд									
Буриад									
Баяд									
Бусад									
<b>Боловсролын түвшин</b>									
Боловсролгүй									

Бага / суурь									
Бүрэн дунд									
Дээд / магистр									
<b>Ажил эрхлэлтийн байдал</b>									
Ажилтай									
Ажилгүй									
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>									
Ядуу	20.0	11.8	40.3	32.4	37.1	30.9	31.4	6.4	
Дунджаас доогуур	19.7	19.2	21.1	29.9	24.9	17.0	24.8	15.5	
Дундаж	19.9	17.3	26.4	24.7	21.8	22.1	19.2	17.6	
Дунджаас дээгүүр	20.4	23.8	12.1	10.1	10.1	24.7	20.4	25.3	
Чинээлэг	19.9	27.9	0.1	2.9	6.1	5.3	4.1	35.2	

## Хоол тэжээлийн байдал

Судалгаанд хамрагдсан төрөх насны, жирэмсэн бус эхчүүдийн биеийн жин, өндрийг хэмжин БЖИ-ийг тодорхойлж хоол тэжээлийн байдлыг үнэлсэн бөгөөд тэдний захын цусны гемоглобины агууламжаар цус багадалтын тархалтыг үнэлж, үр дүнг W.3-р хүснэгтэд хураангуйлан харуулав. Тав хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн 18.0% таргалалттай, 3.4% тураалтай, 5.1% дунджаас доош өндөртэй, 16.3% (95%ИХ 14.3–18.6) ямар нэг хэлбэрийн цус багадалтай байна.

Хүснэгт W.2: Эхчүүдийн хоол тэжээлийн байдал

Үзүүлэлтүүд	Жинлэсэн хувь	95% ИХ		Жинлээгүй тоо
		доод	дээд	
<b>Хоол тэжээлийн байдал</b>				<b>2507</b>
Тураалтай (БЖИ < 18.5 кг/м <sup>2</sup> )	3.4	2.4	4.7	81
Хэвийн жинтэй (БЖИ = 18.5 – 24.9 кг/м <sup>2</sup> )	43.6	40.6	46.8	1085
Илүүдэл жинтэй (БЖИ = 25.0 – 29.9 кг/м <sup>2</sup> )	35.0	32.1	38.1	847
Таргалалттай (БЖИ ≥ 30.0 кг/м <sup>2</sup> )	18.0	15.3	21.0	494
<b>Эхчүүдийн биеийн өндөр, см</b>				<b>2507</b>
Намхан (< 145 см)	0.9	0.5	1.4	35
Намхавтар (< 145-149 см)	4.2	3.2	5.5	149
Дундаж (150-159 см)	52.2	48.3	56.1	1275
Дунджаас дээш (>160 см)	42.7	38.9	46.7	1048
<b>Цус багадалт</b>				<b>2477</b>
Цус багадалтгүй (Hb ≥ 120 г/л)	83.7	81.4	85.7	2036
Хөнгөн цус багадалттай (Hb = 110–119 г/л)	11.3	9.8	12.9	307
Хүндэвтэр цус багадалттай (Hb = 80–109 г/л)	4.9	3.9	6.3	130
Хүнд цус багадалттай (Hb < 80 г/л)	0.1	0.0	0.3	4

Эхчүүдийн талаас илүү (53.0%) хувь илүүдэл жин ба таргалалт (БЖИ ≥ 25.0 кг/м<sup>2</sup>)-тэй байв (Хүснэгт W.4). Тураалын тархалтыг сонгосон үзүүлэлтээр харьцуулан үнэлэхэд залуу (нас ≤ 29) эхчүүд (7.6%), гэрлээгүй эмэгтэйчүүд (7.3%)-ийн дунд харьцангуй өндөр байв (p≤0.001). Илүүдэл жин ба таргалалтын тархалт 40–49 насны эхчүүд (74.9%) болон гэрлэсэн эмэгтэйчүүд (56.3%)-ийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр (p=0.009), харин өрхийн аж байдлын түвшин, бүс нутаг, орон нутгийн байршил, үндэс угсаа зэрэг бусад үзүүлэлтээр ялгаатай бус байна.

Хүснэгт W.4. Төрөх насны эхчүүдийн хоол тэжээлийн байдал

Үзүүлэлтүүд	Тураал (БЖИ < 18.5 кг/м <sup>2</sup> )		Илүүдэл жин (БЖИ ≥ 25.0 кг/м <sup>2</sup> )		Таргалалт (БЖИ ≥ 30.0 кг/м <sup>2</sup> )		Жинлээгүй тоо
	95% ИХ		95% ИХ		95% ИХ		
	Доод	Дээд	Доод	Дээд	Доод	Дээд	
<b>Бүгд</b>							
<b>Нас</b>							
16-29 нас							
30-39 нас							
40-49 нас							
<b>Эдийн засгийн бүс</b>							
Баруун							
Хангай							
Төв							
Зүүн							
Улаанбаатар							
<b>Хот, хөдөө</b>							
Хот							
Хөдөө							
<b>Байршил</b>							
Нийслэл хот							
Аймгийн төв							
Сумын төв / Баг							
<b>Яс үндэс</b>							
Халх							
Казак							
Бусад							
<b>Боловсрол</b>							
Боловсролгүй							
Бага / суурь							

Бүрэн дунд											
Дээд / магистр											
<b>Ажил эрхлэлт</b>											
Ажил эрхэлдэг											
Ажилгүй											
<b>Гэрлэлтийн байдал</b>											
Гэрлэсэн											
Гэрлээгүй											
Хамтран амьдардаг											
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>											
Ядуу	4.4	2.3	8.2	54.9	47.5	62.2	19.4	13.9	26.5	658	
Дунджаас доогуур	3.6	1.8	7.0	53.6	47.0	60.1	15.3	11.9	19.4	582	
Дундаж	1.9	0.9	3.9	60.1	51.0	68.5	22.2	17.0	28.5	532	
Дунджаас дээгүүр	2.8	1.7	4.6	42.9	34.8	51.4	15.8	11.5	21.3	446	
Чинээлэг	4.1	1.9	9.0	53.7	45.5	61.7	17.3	9.8	28.6	286	

Төрөх насны эхчүүдийн хоол тэжээлийн байдлыг үнэлэх зорилтын хүрээнд тэдний дунд намхан болон намхавтар эмэгтэйчүүдийн тархалтыг тогтоосон. Хэрэв эмэгтэйн биеийн өндөр нь 145 см-ээс доош бол намхан, 150 см-ээс доош бол намхавтар гэж үнэлэв.

Нийт эхчүүдийн 0.9% намхан, харин намхавтар эхчүүд 5.1% байв (Хүснэгт W.5). Намхан эмэгтэйн тархалт боловсролын түвшнээр ялгаатай сургуульд сураагүй эсвэл бүрэн бус бага боловсролтой (6.7%) эхчүүдийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр ( $p=0.005$ ), сонгосон бусад үзүүлэлтээр ялгаа илрээгүй болно. Биеийн өндөр нь 150 см ба түүнээс бага буюу намхавтар эхчүүдийн хувь Улаанбаатар хотод 4.1%, Хангайн бүсэд 4.5% байгаа бол Зүүн бүсэд 11.1%, Баруун бүсэд 6.0% буюу харьцангуй илүү байна ( $p=0.047$ ). Түүнчлэн энэ үзүүлэлт боловсролгүй (16.7%) болон бага боловсролтой (9.6%) эхчүүд ( $p=0.016$ ), бусад ястны цөөнхийн бүлгийн (6.9%) эхчүүдийн дунд харьцангуй түгээмэл байв. Аж байдлын түвшин доогуур бүлэгт хамаарах эхчүүдийн дунд намхан эмэгтэйн хувь (7.3%) хамгийн өндөр, харин аж байдлын түвшин дээшлэхэд уг үзүүлэлт (1.2%) буурч байна ( $p=0.01$ ).

Хүснэгт W.5. Намхан, намхавтар эхчүүдийн тархалт

Үзүүлэлтүүд	Намхан (< 145 см)		Намхавтар (< 150 см)		Жинлээгүй Тоо
	95% ИХ		95% ИХ		
	Доод	Дээд	Доод	Дээд	
<b>Бүгд</b>					
<b>Нас</b>					
16-29 нас					
30-39 нас					
40-49 нас					
<b>Эдийн засгийн бүс</b>					
Баруун					
Хангай					
Төв					
Зүүн					
Улаанбаатар					
<b>Хот, хөдөө</b>					
Хот					
Хөдөө					
<b>Байршил</b>					
Нийслэл хот					
Аймгийн төв					
Сумын төв / Баг					
<b>Яс үндэс</b>					
Халх					
Казак					
Бусад					

<b>Орон байны төрөл</b>							
Гэр							
Орон сууц							
Бие даасан тохилог сууц							
Сууцны тусдаа байшин							
Нийтийн байр							
<b>Боловсрол</b>							
Боловсролгүй							
Бага / суурь							
Бүрэн дунд							
Дээд / магистр							
<b>Ажил эрхлэлт</b>							
Ажил эрхэлдэг							
Ажилгүй							
<b>Гэрлэлтийн байдал</b>							
Гэрлэсэн							
Гэрлээгүй							
Хамтран амьдардаг							
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>							
Ядуу	1.7	0.8	3.5	.	5.2	10.4	658
Дунджаас доогуур	1.2	0.4	3.3	4.1	2.6	6.2	582
Дундаж	1.5	0.6	3.5	5.9	3.5	9.9	532
Дунджаас дээгүүр	0.0	0.0	0.0	6.7	3.7	11.9	446
Чинээлэг	0.0	0.0	0.0	1.2	0.5	3.0	286

### Бичил тэжээлийн байдал

Хоол тэжээлийн үндэсний VI судалгаанд хамрагдсан төрөх насны эмэгтэйчүүдийн түүврийн дэд бүлэгт бичил тэжээлийн байдлыг үнэлэх зорилгоор төмөр дутлын цус багадалт, төмөр, А, Д аминдэмийн дутал болон үрэвслийн тархалтыг холбогдох биомаркерийн шинжилгээгээр тогтоосон болно. Эхчүүдийн бичил тэжээлийн байдлыг илтгэх үзүүлэлтүүдийг нэгтгэн W.6 хүснэгтэд харуулав.

Хүснэгт W.6. Төрөх насны эхчүүдийн бичил тэжээлийн байдал

Үзүүлэлт	%	95% ИХ		Жинлээгүй тоо
		доод	дээд	
<b>Цус багадалт<sup>a</sup></b>				<b>2477</b>
Цус багадалтын бүх хэлбэр	16.3	14.3	18.6	441
<b>Төмрийн байдал</b>				<b>1320</b>
Төмрийн дутал <sup>b</sup>	15.2	12.6	18.2	174
Төмөр хангалттай	80.6	77.3	83.6	997
Төмрийн илүүдэл	4.2	2.7	6.4	45
Уусдаг трансферрин рецепторын төмрийн дутал <sup>c</sup>	7.5	5.8	9.5	96



Төмрийн нөөц дутмаг <sup>d</sup>	9.2	7.2	11.7	112
Төмөр дутлын цус багадалт <sup>e</sup>	5.6	4.1	7.8	68
<b>А аминдэмийн байдал<sup>f</sup></b>				<b>1288</b>
А аминдэм дутал	1.3	0.7	2.5	14
А аминдэмийн нөөц дутмаг	17.2	14.8	19.9	218
А аминдэм хангалттай	81.4	78.4	84.1	1056
<b>Д аминдэмийн байдал<sup>g</sup></b>				<b>1319</b>
Д аминдэм дутал	70.6	65.0	75.6	982
Д аминдэмийн нөөц дутмаг	19.6	15.6	24.3	244
Д аминдэм хангалттай	9.8	6.5	14.6	93
Д аминдэмийн хордлого	-	-	-	0
<b>Үрэвсэл<sup>h</sup></b>				<b>1311</b>
Бүх төрлийн үрэвсэл	19.8	17.1	22.8	261
a Гемоглобин < 120 г/л. b Ийлдсийн ферритин < 15 мкг/л. c sTfR > 8.3 мг/л. d Бие дэх төмрийн нөөц < 0 мг/кг. e Гемоглобин < 120 г/л ба ферритин < 15 мкг/л. f Ийлдсийн РХУ < 0.70 мкгмоль/л (дутал); ≥ 0.7–1.05 мкгмоль/л (нөөц дутмаг); > 1.05 мкгмоль/л (хангалттай). g Ийлдсийн 25(OH)D < 20 наног/мл (дутал); 20 – 29.9 наног/мл I (нөөц дутмаг); 30 – 100 наног/мл (хангалттай); >100 наног/мл (илүүдэл буюу хордлого) h С-идэвхт уураг > 5 мг/л ба / эсвэл α1-ацид гликопротеин >1 г/л. (-) Жинлээгүй тоон үзүүлэлт 25-аас бага тохиолдлыг хассан.				

Төрөх насны эхчүүдийн захын цусны гемоглобины дундаж хэмжээ 129.7 г/л (95%ИХ 128.8-130.5) байна. Эхчүүдийн боловсрол, өрхийн аж байдлын түвшин дээшлэх тутам гемоглобины дундаж хэмжээ ихсэх хандлага ажиглагдсан болно. Тухайлбал, боловсролгүй эсвэл бага / суурь боловсролтой эхчүүдэд (125.6 г/л, 95%ИХ 122.6–128.6) хамгийн бага, харин дээд боловсролтой эмэгтэйчүүдийн гемоглобины дундаж хэмжээ (130.7 г/л, 95%ИХ 129.6–131.8) харьцангуй өндөр байна (p=0.001). Мөн ядуу өрхийн эхчүүдийн гемоглобины дундаж хэмжээ 127.5 г/л (95%ИХ 126.2–128.7) байгаа бол чинээлэг бүлэгт хамаарах эхчүүдэд 130.4 г/л (95%ИХ 128.7–132.2) байв (p<0.0001).

Цус багадалтын тархалт 15-49 насны эхчүүдийн дунд 16.3% байна. Цус багадалтын тархалтыг сонгосон үзүүлэлтээр харьцуулан судлахад Казак эмэгтэйчүүд (25.5%), боловсролгүй эхчүүдийн (26.2%) дунд тархалтын хамгийн өндөр үзүүлэлт (p=0.04, p=0.006) ажиглагдсан болно. Мөн цус багадалтын тархалт аж байдлын түвшин доогуур өрхийн эхчүүдийн (20.5%) дунд дээгүүр бүлэгт хамаарах эхчүүдээс 6.5 пунктээр илүү (p=0.03) байна (Хүснэгт W.7).

Хүснэгт W.7. Цус багадалтын тархалт

Үзүүлэлтүүд	Гемоглобины дундаж (г/л)	%	95% ИХ		Жинлээгүй Тоо
			Доод	Дээд	
<b>Бүгд</b>	<b>129.7</b>	<b>16.3</b>	<b>14.3</b>	<b>18.6</b>	<b>2477</b>
<b>Насны бүлэг</b>					
16 – 29 нас	130.1	15.7	12.9	19.0	831
30-39 нас	129.7	16.8	14.5	19.3	1358
40-49 нас	128.6	16.1	11.4	22.2	288

<b>Эдийн засгийн бүс</b>					
Баруун	130.9	15.5	11.9	19.9	510
Хангай	128.1	17.8	14.2	22.0	477
Төв	127.2	18.7	15.2	22.9	515
Зүүн	127.2	21.9	17.5	27.0	483
Улаанбаатар	131.0	14.6	11.2	18.8	492
<b>Хот, хөдөө</b>					
Хот	130.2	15.7	13.1	18.7	1314
Хөдөө	128.6	17.8	15.1	20.9	1163
<b>Байршил</b>					
Нийслэл хот	131.0	14.6	11.2	18.8	492
Аймгийн төв	128.3	18.3	15.6	21.4	822
Сумын төв / Баг	128.6	17.8	15.1	20.9	1163
<b>Яс үндэс</b>					
Халх	129.9	15.8	13.7	18.3	1917
Казак	127.3	25.5	17.9	35.0	163
Бусад	128.9	16.9	13.0	21.6	397
<b>Сууцны төрөл</b>					
Гэр	129.8	18.0	15.4	20.9	956
Орон сууц	130.0	16.6	12.9	21.1	599
Бие даасан тохилог сууц	129.5	18.8	11.2	29.9	80
Сууцны тусдаа байшин	129.2	14.4	11.6	17.7	824
Нийтийн байр	-	-	-	-	18
<b>Боловсрол</b>					
Боловсролгүй	125.6	26.2	16.0	39.9	50
Бага / суурь	127.5	22.9	15.8	32.0	138
Бүрэн дунд	128.2	18.8	15.6	22.5	922
Дээд / магистр	130.7	14.3	12.0	17.0	1367
<b>Ажил эрхлэлт</b>					
Ажил эрхэлдэг	129.3	16.7	14.2	19.5	1644
Ажилгүй	130.3	15.8	13.1	18.9	833
<b>Гэрлэлтийн байдал</b>					
Гэрлэсэн	129.5	16.6	14.3	19.2	1950
Гэрлээгүй	129.9	16.7	10.2	26.2	130
Хамтран амьдардаг	130.6	15.2	11.4	20.1	397
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>					
Ядуу	127.5	20.5	17.3	24.2	653
Дунджаас доогуур	130.4	15.4	12.1	19.5	570
Дундаж	130.4	12.5	9.6	16.1	52
Дунджаас дээгүүр	129.6	19.7	14.5	26.2	442
Чинээлэг	130.4	14.0	10.3	18.8	282

(-) Жинлээгүй тоон үзүүлэлт нь < 25 тохиолдлыг хассан.

Төрөх насны эхчүүдэд тохиолдож буй цус багадалтын 39.3% (n=68) төмөр дутлын шалтгаантай байна. Тодруулбал, нийт эхчүүдийн 6 орчим хувь (5.6%) төмөр дутлын цус багадалттай байв. Төмөр дутлын цус багадалтын тархалтыг сонгосон үзүүлэлтээр харьцуулан үнэлж, хүснэгт W.8-д нэгтгэн харуулав. Төмөр дутлын цус багадалтын тархалтыг сонгосон үзүүлэлтээр харьцуулан үзвэл, эхчүүдийн оршин суугаа бүс нутаг, байршил, гэрлэлт, ажил эрхлэлтийн байдал, боловсролын түвшнээр ялгаатай бус, харин Казак эмэгтэйчүүд (18.4%)-ийн дунд халх болон бусад ястны үзүүлэлтээс статистик ач холбогдол бүхий өндөр ( $p=0.003$ ) байна (Хүснэгт W.8).

Хүснэгт W.8. Төмөр дутлын цус багадалтын тархалт

Үзүүлэлт	%	95% ИХ		Жинлээгүй тоо
		доод	дээд	
<b>Төмөр дутлын цус багадалт<sup>a</sup></b>				<b>1214</b>
Бүгд	5.6	4.1	7.8	68
<b>Насны бүлэг</b>				
16 – 29 нас	4.5	2.8	7.3	411
30 – 39 нас	5.5	3.5	8.63	673
40 – 49 нас	9.4	4.9	17.5	133
<b>Эдийн засгийн бүс</b>				
Баруун	7.1	4.4	11.4	250
Хангай	5.2	3.1	8.9	230
Төв	6.6	4.0	10.6	235
Зүүн	2.8	1.3	6.0	245
Улаанбаатар	5.6	3.0	10.1	257
<b>Хот, хөдөө</b>				
Хот	5.8	3.7	8.9	651
Хөдөө	5.4	3.7	7.7	566
<b>Байршил</b>				
Улаанбаатар	5.6	3.0	10.1	257
Аймгийн төв	6.3	4.2	9.4	394
Сумын төв / хөдөө	5.4	3.7	7.7	566
<b>Яс үндэс</b>				
Халх	5.3	3.5	7.9	938
Казак	18.4	9.5	32.8	83
Бусад	4.2	1.8	9.8	196
<b>Сууцны төрөл</b>				
Гэр	4.9	2.9	7.9	457
Орон сууц	6.5	3.4	12.0	301
Бие даасан тохилог сууц	9.3	3.8	21.2	44
Сууцны тусдаа байшин	5.3	3.0	9.3	409
Нийтийн байр	-	-	-	6
<b>Боловсрол</b>				
Боловсролгүй	-	-	-	22
Бага / суурь	9.3	4.3	18.8	68
Бүрэн дунд	7.0	4.5	10.9	449
Дээд / магистр	4.8	3.0	7.4	678
<b>Ажил эрхлэлт</b>				
Ажилтай	6.6	4.5	9.6	808
Ажилгүй	4.1	2.4	7.0	409
<b>Гэрлэлтийн байдал</b>				
Гэрлэсэн	5.6	3.7	8.3	962

Гэрлээгүй	11.9	5.0	25.7	64
Хамтран амьдардаг	4.2	2.0	8.8	191
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>				
Ядуу	7.7	4.7	12.3	303
Дунджаас доогуур	4.7	2.7	8.2	285
Дундаж	2.8	1.5	5.3	265
Дунджаас дээгүүр	7.6	4.0	14.0	216
Чинээлэг	5.8	2.5	12.7	145
а Гемоглобин < 120 г/л ба ферритин < 15 мкг/л. (-) Жинлээгүй тоон үзүүлэлт 25-аас бага тохиолдолыг хассан.				

Тохируулга хийсэн ферритин, уусдаг трансферрин рецептор (sTFR)-ийн түвшнээр үнэлсэн төмөр дутлын тархалт тус тус 15.2% ба 7.5% байна. Мөн эхчүүдийн дунд бие дэх төмрийн нөөц дутмаг байдал 9.2% байв (Хүснэгт W.9). Ийлдэс дэх ферритиний түвшнээр үнэлсэн төмөр дутлын тархалт Халх (15.4%) болон бусад үндэстний цөөнхийн бүлгийн эмэгтэйчүүдтэй (7.1%) харьцуулахад, Казак эхчүүдийн дунд (36.5%) 2.1–5.2 дахин их байгааг судалгаагаар тогтоосон ( $p < 0.0001$ ). Мөн ийлдэс дэх ферритиний агууламжаар тодорхойлсон төмөр дутлын тархалт эхчүүдийн гэрлэлтийн байдал, сууцны төрлөөр ялгаатай, тохилог сууцад амьдардаг (39.2%), гэрлээгүй эхчүүдийн дунд (31.6%) харьцангуй түгээмэл байв ( $p = 0.03$ ,  $p = 0.009$ ).

Ийлдэс дэх уусдаг трансферрин рецепторын түвшнээр үнэлсэн төмөр дутлын тархалт эхчүүдийн яс үндэс, гэрлэлтийн байдлаар ялгаатай, Казак (17.6%) эхчүүд ( $p = 0.001$ ), гэрлээгүй эмэгтэйчүүдийн дунд (16.9%) харьцангуй их ( $p = 0.047$ ) байна. Бие дэх төмрийн нөөц дутмаг байдал нь цус багадалт, төмөр дутлын тархалтын дүнтэй нэлээд төстэй, бие даасан тохилог сууцад амьдардаг эхчүүд (27.4%), Казак үндэстний дунд (22.6%) хамгийн түгээмэл байв

Төрөх насны эхчүүдийн А аминдэмийн байдлыг үнэлэхэд, дийлэнх хувь (81.4%) А аминдэмийн хангалттай нөөцтэй, харин нөөц дутмаг болон А аминдэмийн дуталтай эхчүүд тус тус 17.3% ба 1.3% байв (Хүснэгт W.10). Бие дэх А аминдэмийн түвшин хангалтгүй буюу нөөц дутмаг байдлыг судалгаанд сонгосон үзүүлэлтээр харьцуулан үнэлэхэд статистик ач холбогдол бүхий ялгаа илрээгүй болно.

Хүснэгт W.9. Төрөх насны эхчүүдийн дундах төмөр дутлын тархалт

Үзүүлэлт	Ферритиний түвшнээр (Fer < 15 мкг/л)				Уусдаг ТФР-ийн түвшнээр (sTFR > 8.3 мг/л)				Төмрийн нөөц дутмаг (Бие дэх төмрийн нөөц < 0.0 мг/кг)			
	Жинлээгүй тоо	%	95%ИХ		Жинлээгүй тоо	%	95%ИХ		Жинлээгүй тоо	%	95%ИХ	
			Дээд	Доод			Дээд	Доод			Дээд	Доод
<b>Бүгд</b>	<b>1216</b>	<b>15.2</b>	<b>12.6</b>	<b>18.2</b>	<b>1315</b>	<b>7.5</b>	<b>5.8</b>	<b>9.5</b>	<b>1219</b>	<b>9.2</b>	<b>7.2</b>	<b>11.7</b>
<b>Насны бүлэг</b>												
16 – 29 нас	410	14.5	10.7	19.4	447	7.5	5.1	10.9	411	8.9	6.1	12.9
30 – 39 нас	62	15.1	12.0	18.8	724	7.7	5.5	10.5	673	8.7	6.4	11.8
40 – 49 нас	134	17.6	11.2	26.6	144	6.6	3.1	13.8	135	12.3	7.2	20.3
<b>Эдийн засгийн бүс</b>												
Баруун	249	15.3	11.0	20.8	274	8.5	5.6	12.7	251	10.7	7.7	14.7
Хангай	230	14.3	10.4	19.5	250	8.0	5.3	11.9	229	8.7	5.7	13.2
Төв	236	15.7	11.7	20.9	258	6.6	4.1	10.5	238	10.0	7.0	14.3
Зүүн	244	9.0	6.3	12.7	265	4.9	3.0	7.9	245	6.5	4.2	9.9
Улаанбаатар	257	16.1	11.7	21.8	268	7.6	4.9	11.6	256	9.2	5.8	14.2
<b>Хот, хөдөө</b>												
Хот	652	15.5	12.1	19.6	695	7.3	5.2	10.1	652	9.2	6.6	12.7
Хөдөө	564	14.4	11.5	18.0	620	7.9	5.8	10.5	567	9.4	7.2	12.1
<b>Байршил</b>												
Улаанбаатар	257	16.1	11.7	21.8	268	7.6	4.9	11.6	256	9.2	5.8	14.2
Аймгийн төв	395	14.0	10.9	18.0	427	6.6	4.5	9.5	396	9.1	6.6	12.5
Сумын төв / хөдөө	564	14.4	11.5	18.0	620	7.9	5.8	10.5	567	9.4	7.2	12.1
<b>Яс үндэс</b>												
Халх	936	15.4	12.4	18.8	1012	7.5	5.6	9.9	938	9.1	6.8	12.1
Казак	84	36.5	24.2	50.8	90	17.6	11.6	25.8	84	22.6	14.1	34.2
Бусад	196	7.1	3.9	12.8	213	4.3	2.4	7.7	197	5.7	2.7	11.3
<b>Сууцны төрөл</b>												
Гэр	455	11.6	8.2	16.1	505	6.7	4.5	9.9	460	5.9	3.9	9.0
Орон сууц	303	16.8	11.9	23.3	323	7.2	4.2	12.1	302	11.3	7.2	17.3
Бие даасан тохилог сууц	45	39.2	25.5	54.8	48	17.4	7.8	34.4	45	27.4	15.7	43.3
Сууцны тусдаа байшин	407	15.2	11.0	20.7	433	7.8	5.5	11.1	406	8.9	6.0	13.1
Нийтийн байр	6	-	-	-	6	-	-	-	6	-	-	-
<b>Боловсрол</b>												
Боловсролгүй	21	-	-	-	24	-	-	-	21	-	-	-
Бага / суурь	69	19.0	9.8	33.8	75	6.7	2.8	15.2	68	8.4	3.7	17.9

Бүрэн дунд	447	15.4	11.8	20.0	493	7.4	4.9	11.2	450	9.1	6.3	13.0
Дээд / магистр	679	15.0	11.8	18.9	723	7.6	5.6	10.3	680	9.4	6.9	12.7
<b>Ажил эрхлэлт</b>												
Ажилтай	807	16.8	13.8	20.4	866	8.2	6.1	10.9	809	10.5	8.1	13.4
Ажилгүй	409	12.5	8.9	17.2	449	6.3	4.2	9.4	410	7.2	4.6	11.0
<b>Гэрлэлтийн байдал</b>												
Гэрлэсэн	960	15.3	12.3	18.9	1043	6.5	4.9	8.6	965	9.5	7.1	12.6
Гэрлээгүй	64	31.6	17.3	50.6	69	16.9	8.0	32.2	62	16.3	7.3	32.7
Хамтран амьдардаг	192	10.1	6.4	15.4	203	8.8	5.0	15.1	192	6.3	3.6	10.8
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>												
Ядуу	303	12.2	8.6	17.2	338	8.2	5.4	12.2	306	8.2	5.6	11.8
Дунджаас доогуур	284	12.7	8.4	18.8	310	7.1	4.5	10.9	285	7.0	4.5	10.8
Дундаж	263	12.7	8.3	18.9	280	4.8	2.8	8.3	264	6.4	3.8	10.5
Дунджаас дээгүүр	217	17.8	12.2	25.2	227	8.8	5.2	14.4	215	10.8	6.5	17.4
Чинээлэг	146	19.6	13.0	28.3	157	8.7	4.6	15.8	146	13.8	8.0	22.6

(-) Жинлээгүй тоон үзүүлэлт 25-аас бага тохиолдлыг хассан.

Хүснэгт W.10. Төрөх насны эхчүүдийн А аминдэмийн байдал

Үзүүлэлт	Жинлээгүй тоо	А аминдэм дутал (РХУ < 0.07 мкмол/л)			А аминдэмийн нөөц дутмаг (РХУ = 0.07–1.05 мкмол/л)			А аминдэм хангалттай (РХУ > 1.05 мкмол/л)		
		%	95% ИХ		%	95% ИХ		%	95% ИХ	
			дээд	доод		дээд	доод		дээд	доод
<b>Бүгд</b>	<b>1288</b>	<b>1.3</b>	<b>0.7</b>	<b>2.5</b>	<b>17.2</b>	<b>14.8</b>	<b>19.9</b>	<b>81.4</b>	<b>78.4</b>	<b>84.1</b>
<b>Насны бүлэг</b>										
16 – 29 нас	433	0.4	0.1	1.4	16.9	12.7	22.3	82.7	77.3	87.0
30 – 39 нас	712	2.1	1.0	4.2	17.9	14.5	21.9	80.0	75.8	83.6
40 – 49 нас	143	0.4	0.1	2.9	14.7	9.1	22.9	84.9	76.7	90.6
<b>Эдийн засгийн бүс</b>										
Баруун	269	1.5	0.4	4.8	15.8	11.7	20.8	82.8	77.3	87.2
Хангай	241	1.7	0.7	4.3	14.9	10.7	20.4	83.4	77.8	87.8
Төв	247	0.3	0.0	2.0	17.4	12.8	23.2	82.3	76.6	86.9
Зүүн	263	0.4	0.1	2.8	18.2	13.9	23.6	81.	75.8	85.9
Улаанбаатар	268	1.6	0.6	4.1	18.2	14.1	23.1	80.2	74.6	84.8
<b>Хот, хөдөө</b>										
Хот	683	1.7	0.8	3.3	17.4	14.2	21.1	80.9	76.8	84.5
Хөдөө	605	0.5	0.2	2.0	16.8	14.0	20.1	82.7	79.3	85.6
<b>Байршил</b>										

Улаанбаатар	268	1.6	0.6	4.1	18.2	14.1	23.1	80.2	74.6	84.8
Аймгийн төв	415	1.8	0.8	3.9	15.5	11.5	20.4	82.7	7.7	86.8
Сумын төв / хөдөө	605	0.5	0.2	2.0	16.8	14.0	20.1	82.7	79.3	85.6
<b>Яс үндэс</b>										
Халх	988	1.4	0.7	2.8	17.8	15.1	21.0	80.8	77.3	83.8
Казак	88	0	-	-	18.9	11.6	29.2	81.1	70.8	88.4
Бусад	212	1.5	0.4	4.7	12.4	8.1	18.5	86.2	79.6	90.8
<b>Сууцны төрөл</b>										
Гэр	492	0.4	0.1	1.2	18.4	14.6	23.0	81.2	76.5	85.1
Орон сууц	320	1.1	0.3	3.4	17.1	12.8	22.5	81.8	76.2	86.3
Бие даасан тохилог сууц	47	1.8	0.3	10.9	15.8	6.6	33.2	82.5	64.	92.3
Сууцны тусдаа байшин	423	2.6	1.1	5.9	16.5	12.1	22.0	80.9	75.2	85.6
Нийтийн байр	6	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Боловсрол</b>										
Боловсролгүй	24	-	-	-	-	-	-	-	-	-
Бага / суурь	71	0.0	-	-	22.3	12.4	36.9	77.7	63.1	87.6
Бүрэн дунд	487	1.1	0.3	3.7	15.6	11.9	20.1	83.3	78.7	87.1
Дээд / магистр	706	1.6	0.8	3.3	17.9	14.6	21.7	80.5	76.3	84.2
<b>Ажил эрхлэлт</b>										
Ажилтай	847	1.1	0.5	2.7	18.1	15.2	21.3	80.8	77.2	84.1
Ажилгүй	441	1.8	0.7	4.4	15.	12.1	20.5	82.4	77.5	86.4
<b>Гэрлэлтийн байдал</b>										
Гэрлэсэн	1023	1.7	0.9	3.3	16.1	13.4	19.2	82.2	78.8	85.2
Гэрлээгүй	68	0.5	0.1	3.4	24.3	13.1	40.6	75.3	59.0	86.5
Хамтран амьдардаг	197	0.2	0.0	1.5	19.7	13.	27.1	80.1	72.8	85.9
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>										
Ядуу	329	0.0	-	-	18.1	13.8	23.4	81.9	76.6	86.2
Дунджаас доогуур	300	1.6	0.4	5.7	17.0	12.2	23.3	81.4	75.1	86.4
Дундаж	276	2.5	0.8	7.2	17.1	13.7	21.2	80.4	74.9	84.9
Дунджаас дээгүүр	226	2.0	0.6	5.9	19.2	13.5	26.6	78.8	70.3	85.4
Чинээлэг	154	0.7	0.2	2.7	15.2	9.9	22.4	84.2	76.9	89.5

(-) Жинлээгүй тоон үзүүлэлт 25-аас бага тохиолдлыг хассан.

Халдварын болон халдварын бус хүчин зүйлсийн нөлөөгөөр бие махбодын дархлаа тогтолцооны хамгаалах хариу үйлдэл идэвхжиж, улмаар үрэвсэл үүсдэг. Аливаа үрэвсэл нь төмрийн шимэгдэлтэд сөргөөр нөлөөлдөг тул А аминдэмийн байдал, төмрийн солилцоог үнэлэх зорилгоор ийлдэст СИУ болон α1-АГП тодорхойлж, үрэвслийг илрүүлэн төмөр, А аминдэмийн биомаркерийн түвшинд холбогдох тохируулга хийсэн. Хоол тэжээлийн үндэсний VI судалгаагаар нийт эхчүүдийн 19.8% ямар нэг төрлийн үрэвсэлтэй байгааг тогтоов (Хүснэгт W.11). Үрэвслийн тархалтад Төрөх насны эхчүүдийн оршин суугаа газар, бүс нутаг, болон хүн ам зүйн үзүүлэлтээс хамаарсан ялгаа ажиглагдаагүй болно.

Хүснэгт W.11. Төрөх насны эхчүүдийн дундах үрэвслийн тархалт<sup>a</sup>

Үзүүлэлт	%	95% ИХ		Жинлээгүй тоо
		доод	дээд	
<b>Бүгд</b>	<b>19.8</b>	<b>17.1</b>	<b>22.8</b>	<b>1311</b>
<b>Насны бүлэг</b>				
16 – 29 нас	20.0	15.4	25.6	444
30 – 39 нас	20.4	17.0	24.4	722
40 – 49 нас	16.3	9.9	25.8	145
<b>Эдийн засгийн бүс</b>				
Баруун	16.2	12.6	20.5	272
Хангай	21.4	17.2	26.3	247
Төв	20.0	15.0	26.2	257
Зүүн	22.3	17.2	28.3	265
Улаанбаатар	19.8	15.1	25.5	269
<b>Хот, хөдөө</b>				
Хот	19.3	15.7	23.4	694
Хөдөө	21.0	17.8	24.6	617
<b>Байршил</b>				
Улаанбаатар	19.8	15.1	25.5	269
Аймгийн төв	18.2	14.8	22.1	425
Сумын төв / хөдөө	21.0	17.8	24.6	617
<b>Яс үндэс</b>				
Халх	19.9	16.9	23.4	1011
Казак	12.7	6.8	22.4	90
Бусад	21.2	15.3	28.6	210
<b>Сууцны төрөл</b>				
Гэр	22.4	18.9	26.2	501
Орон сууц	18.2	12.7	25.2	323
Бие даасан тохилог сууц	10.3	4.8	21.0	48
Сууцны тусдаа байшин	20.1	16.3	24.6	433
Нийтийн байр	-	-	-	6
<b>Боловсрол</b>				
Боловсролгүй	-	-	-	23
Бага / суурь	14.5	7.6	26.0	76
Бүрэн дунд	20.5	16.5	25.2	492
Дээд / магистр	19.8	16.3	23.8	720
<b>Ажил эрхлэлт</b>				
Ажил эрхэлдэг	20.1	16.7	24.0	861
Ажилгүй	1.3	14.7	25.0	450
<b>Гэрлэлтийн байдал</b>				
Гэрлэсэн	18.8	16.0	21.9	1036
Гэрлээгүй	18.2	10.5	29.9	71



Хамтран амьдардаг	24.3	17.3	32.9	204
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>				
Ядуу	23.4	18.4	29.3	337
Дунджаас доогуур	18.2	13.2	24.7	310
Дундаж	19.9	14.5	26.8	278
Дунджаас дээгүүр	21.8	14.4	31.7	227
Чинээлэг	15.6	10.1	23.4	156

<sup>a</sup>С-идэвхт уураг > 5 мг/л ба / эсвэл α1-ацид гликопротеин >1 г/л.

(-) Жинлээгүй тоон үзүүлэлт 25-аас бага тохиолдлыг хассан.

Д аминдэмийн дуталтай эсвэл нөөц багатай ( $25(\text{ОН})\text{D} \leq 29.9$  нг/мл) эхчүүдийн тархалт маш түгээмэл буюу 90.2% (95%ИХ 83.8–94.1) байна. Тодруулбал, төрөх насны эхчүүдийн дунд Д аминдэм дутлын тархалт 70.6%, нөөц дутмаг байдал 19.6% байв. Д аминдэмийн хангамж багатай байдал бүх насны эхчүүд, нийт бүс нутаг, ястан, үндэстний бүлэг, өрхийн аж байдал нь аль ч түвшинд байгаа эмэгтэйчүүдийн дунд түгээмэл тохиолдож байна. Гэхдээ аж байдлын түвшин дээгүүр өрхийн эхчүүдийн дунд Д аминдэм дутлын тархалт хамгийн бага (58.1%), харин бусад бүлэгт хамаарах эхчүүдийн 70 гаруй хувь дуталтай байгааг  $W.12$  хүснэгтээс харж болно ( $p=0.008$ ). Судалгаагаар ийлдэс дэх Д аминдэмийн агууламж нь хангалттай түвшинд байгаа эхчүүдийн хувь Улаанбаатар (14.7%), хот суурин газар (12.9%), аймгийн төвд (8.4%) амьдардаг, чинээлэг өрхийн (20.1%) эмэгтэйчүүдийн дунд харьцангуй илүү байгааг илрүүлэв. Д аминдэмийн дуталтай эсвэл нөөц дутмаг тохиолдлын тархалтыг сонгосон үзүүлэлтээр харьцуулан үнэлэхэд, өрхийн аж байдлын түвшин, бүс нутаг, байршлаас бусад шинж байдлаар статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдаагүй болно (Хүснэгт  $W.12$ ).

Хүснэгт W.12. Төрөх насны эхчүүдийн Д аминдэмийн байдал


Үзүүлэлтүүд	Д аминдэм дутал (25(OH) D < 20.0 нг/мл)		Д аминдэмийн нөөц дутмаг (25(OH) D = 20.0–29.9 нг/мл)		Д аминдэм хангалттай (25(OH) D ≥ 30.0 нг/мл)		Жинлээгүй Тоо
	95% ИХ		95% ИХ		95% ИХ		
	Доод	Дээд	Доод	Дээд	Доод	Дээд	
<b>Бүгд</b>							
<b>Нас</b>							
16-29 нас							
30-49 нас							
<b>Эдийн засгийн бүс</b>							
Баруун							
Хангай							
Төв							
Зүүн							
Улаанбаатар							
<b>Хот, хөдөө</b>							
Хот							
Хөдөө							
<b>Байршил</b>							
Нийслэл хот							
Аймгийн төв							
Сумын төв / Баг							
<b>Яс үндэс</b>							
Халх							
Бусад							
<b>Боловсрол</b>							
Боловсролгүй/ бага, суурь							
Бүрэн дунд							
Дээд / магистр							
<b>Ажил эрхлэлт</b>							

Ажилтай										
Ажилгүй										
<b>Гэрлэлтийн байдал</b>										
Гэрлэсэн										
Гэрлээгүй										
Хамтран амьдардаг										
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>										
Ядуу	73.3	64.6	80.6	22.9	16.5	30.8	3.8	1.7	8.2	338
Дунджаас доогуур	76.4	63.9	85.6	13.7	9.1	20.1	9.9	3.2	27.1	313
Дундаж	72.1	62.7	80.0	24.2	17.3	32.7	3.7	1.9	7.0	282
Дунджаас дээгүүр	73.9	65.0	81.3	15.9	10.2	24.0	10.1	6.3	15.7	228
Чинээлэг	58.1	45.5	69.7	21.8	13.8	32.8	20.1	11.8	32.0	155

## Хооллолтын чанар, хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ

Судалгаагаар “Дэлхийн хооллолтын чанар” төслийн багийн боловсруулсан Хооллолтын чанарын асуулга (ХЧА)-ыг ашиглан судалгааны өмнөх өдөрт (24 цаг) хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүнийг нэр төрлөөр үнэлэх шинэ удирдамж, стандарт асуултыг ашиглан 15–49 насны эхчүүдийн хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг судалж, тэдний хооллолтын чанарт үнэлээ өгөв [13].

Мөн хүнсний 10 бүлэг бүтээгдэхүүнээс сүүлийн 24 цагт хамгийн багадаа 5 нэр төрлийн хүнс хэрэглэсэн бол хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан хооллолттой гэж үнэлсэн болно [8]. Энэхүү үзүүлэлтийг эмэгтэйчүүдийн хоол, хүнсээр авах шимт бодисын агууламж буюу хооллолтын чанарыг үнэлэхэд ашигладаг бөгөөд бичил тэжээлийн дуталд өртөмтгий байдлыг илтгэх шууд бус шалгуур үзүүлэлт юм. Төрөх насны эхчүүдийн 68.1% уг шаардлагыг хангасан хооллолттой байв (Хүснэгт W.1). Хүнсний 10 бүлэг<sup>12</sup> бүтээгдэхүүнээс хамгийн багадаа 5 нэр төрлийн хүнс хэрэглэсэн эхчүүдийн хувь бүс нутаг, байршлаар ялгаатай, харин тэдний насны бүлгээр ялгаа ажиглагдаагүй болно (Зураг W.1).



Зураг W.1. Хоногт хэрэглэвэл зохих хүнсний бүтээгдэхүүний хамгийн бага шаардлага хангасан хооллолттой эхчүүд, бүс нутаг ба байршлаар

Тав хүртэлх насны хүүхэдтэй эхчүүд (N=2506)-ийн хооллолтын чанарын үзүүлэлтийг W.7 хүснэгтэд нэгтгэн харуулав. Нийт эхчүүдийн дөнгөж 14.3% хоногт хэрэглэвэл зохих 5 бүлэг хүнс (жимс; ногоо; цардуулаг хүнс; мал, амьтны гаралтай хүнс; буурцаг, самар үр)-ний бүтээгдэхүүнийг хэрэглэж байна. Харин малын мах, тахиа, загас, сүү, цагаан идээ зэрэг амьтны гаралтай хүнс (99.3%), төрөл бүрийн үр тариан бүтээгдэхүүн, төмс, манжин зэрэг булцуут үндэст ургамал буюу цардууллаг хүнс (98.3%)-ийг бараг бүх эхчүүд хэрэглэсэн байв.

<sup>12</sup> Хүнсний 10 бүлэг бүтээгдэхүүн: үр тариа, үндэст болон булцуут ногоо (төмс, манжин); буурцагт ургамлууд (шош, вандуй); самар болон үр; сүү; мал, амьтан, шувууны мах, загас; өндөг; гүн ногоон өнгөт навчит ногоо; А аминдэмээр баялаг жимс, ногоо; бусад ногоо; бусад жимс

ХБӨ-өөс сэргийлэх хооллолтын зөвлөмжид хоногт  $\geq 25$  г эслэг хэрэглэхийг заасан бөгөөд үүний тулд өдөрт хамгийн багадаа 400 г жимс, ногоо; бүхэл үрийн үр тариан бүтээгдэхүүн, төрөл бүрийн вандуй, шош гэх мэт буурцагт ургамал, самар, үр идэхийг зөвлөдөг. Тав хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн дунд ДЭМБ-ын эрүүл хооллолтын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, тэдний 53.2% жимс, 48.8% бүхэл үрийн үр тариан бүтээгдэхүүн, 22.0% буурцагт ногоо, самар үр хэрэглэсэн, харин А аминдэмээр баялаг жимс, ногооны хэрэглээ харьцангуй өндөр (68.0%) байна (Хүснэгт W.13).

Хүснэгт W.13. Төрөх насны эхчүүдийн хооллолтын чанарын үнэлгээний дүн

Үзүүлэлт	Жинлээгүй тоо	Жинлэсэн хувь	95%ИХ		
			Доод	Дээд	
<b>Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл</b>					
DQ1	5 нэр төрлийн хүнсний хэрэглээ (AII-5)	247	14.3	11.2	18.0
DQ2	Хоногт хэрэглэвэл зохих хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан	1556	68.1	64.2	71.7
DQ3	Ногооны хэрэглээ	1826	77.8	74.6	80.8
DQ4	Жимсний хэрэглээ	1253	53.2	49.2	57.1
DQ5	Буурцагт ногоо (вандуй, шош), самар, үрний хэрэглээ	393	22.0	17.9	26.7
DQ6	Амьтны гаралтай хүнсний хэрэглээ	2496	99.3	98.0	99.8
DQ7	Цардууллаг хүнсний хэрэглээ	2476	98.3	96.6	99.1
DQ8	Жимс, ногооны хэрэглээ	2036	84.9	82.1	87.3
<b>Эрүүл хүнсний хэрэглээ</b>					
DQ9	Бүхэл үрийн үр тариан бүтээгдэхүүний хэрэглээ	1137	48.8	44.8	52.8
DQ10	Буурцагт ургамал (вандуй, шош)-ын хэрэглээ	113	6.7	4.4	10.0
DQ11	Бүх төрлийн самар, үрний хэрэглээ	318	17.9	14.1	22.3
DQ12	А аминдэмээр баялаг жимс, ногооны хэрэглээ	1586	68.0	64.1	71.6
<b>Эрүүл бус хүнсний хэрэглээ</b>					
DQ13	Ногоо, эсвэл жимс огт хэрэглээгүй	470	15.1	12.7	17.9
DQ14	Хийжүүлсэн ундааны хэрэглээ (soft drinks)	697	29.9	26.3	33.8
DQ15	Чихэрлэг, хийжүүлсэн ундааны хэрэглээ	1609	67.7	62.6	72.4
DQ16	Боловсруулсан махан бүтээгдэхүүний хэрэглээ	400	19.5	16.6	22.8
DQ17	Давстай, хэт боловсруулсан зуушны хэрэглээ (савласан)	231	11.5	9.0	14.6
DQ18	Их тосонд шарж болгосон хоол, хүнсний хэрэглээ	857	29.1	25.7	32.9

DQ19	Чихэр, амтлаг хүнсний хэрэглээ	1548	64.8	60.9	68.4
DQ20	Түргэн хоол, бэлэн гоймонгийн хэрэглээ	209	13.0	9.5	17.4

Хоногт хэрэглэвэл зохих 5 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг бүгдийг хэрэглэсэн болон хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлагыг хангасан хооллолттой эмэгтэйчүүдийн тархалтыг сонгосон үзүүлэлтээр харьцуулан судалж, үр дүнг W.14 хүснэгтэд харуулав. Хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлагыг хангасан хооллолттой эхчүүдийн хувь Улаанбаатар хот, хот суурин газар, дээд боловсролтой, орон сууцад амьдардаг эмэгтэйчүүдийн дунд харьцангуй өндөр, харин боловсролгүй, бага эсвэл суурь боловсролтой эхчүүд, Хангайн болон Баруун бүс, хөдөө орон нутаг, гэрт амьдардаг эмэгтэйчүүдийн дунд бага байв ( $p < 0.0001$ ). Мөн хоногт хэрэглэвэл зохих хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан эхчүүдийн хувь өрхийн аж байдлын түвшнээс шууд хамааралтай ихсэх, харин ХББ-ын алдагдал гүнзгийрэх тутамд буурах хандлага ажиглагдсан болно ( $p < 0.0001$ ). Тодруулбал, хүнсний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан хооллолттой эмэгтэйчүүдийн үзүүлэлт чинээлэг өрхийн эхчүүдэд аж байдлын түвшин доогуур бүлгээс 2.2 дахин, ХББ хангагдсан эсвэл хөнгөн алдагдсан өрхийн эхчүүдэд ХББ ноцтой алдагдсан эмэгтэйчүүдээс 1.7 дахин их байгааг W.14 хүснэгтээс харж болно.

Хүснэгт W.14. Эхчүүдийн хооллолтын чанарыг хүнсний нэр төрлөөр үнэлсэн дүн

Үзүүлэлтүүд	Хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан хооллолттой эхчүүд			Хоногт 5 бүлэг хүнсний бүтээгдэхүүн хэрэглэсэн эхчүүд			Жинлээгүй тоо
	%	95% ИХ		%	95% ИХ		
		Доод	Дээд		Доод	Дээд	
<b>Бүгд</b>	<b>68.1</b>	<b>64.2</b>	<b>71.7</b>	<b>14.3</b>	<b>11.2</b>	<b>18.0</b>	<b>2506</b>
<b>Нас</b>							
16-29 нас	63.4	56.5	69.8	14.2	10.0	19.7	837
30-39 нас	67.9	64.0	71.6	12.9	10.2	16.2	1379
40-49 нас	74.8	68.1	80.4	16.5	9.7	26.5	290
<b>Эдийн засгийн бүс</b>							
Баруун	54.2	43.0	64.9	6.2	4.2	9.0	515
Хангай	51.6	43.9	59.2	7.5	5.1	10.9	483
Төв	58.3	50.1	66.1	7.1	4.8	10.5	522
Зүүн	68.9	61.2	75.7	10.0	4.4	21.0	487
Улаанбаатар	79.8	73.8	84.7	21.2	15.4	28.5	499
<b>Хот, хөдөө</b>							
Хот	73.1	68.1	77.5	17.5	13.2	22.6	1330
Хөдөө	55.7	49.5	61.8	6.4	4.8	8.6	1176
<b>Байршил</b>							
Нийслэл хот	79.8	73.8	84.7	21.2	15.4	28.5	499
Аймгийн төв	57.5	50.5	64.2	8.8	6.0	12.6	831
Сумын төв / Баг	55.7	49.5	61.8	6.4	4.8	8.6	1176
<b>Яс үндэс</b>							

Халх	68.6	64.4	72.6	15.0	11.5	19.4	1937
Казак	63.1	42.7	79.7	5.7	3.7	8.5	165
Бусад	65.5	56.6	73.4	11.2	7.5	16.5	404
<b>Сууцны төрөл</b>							
Гэр	51.5	45.1	57.9	9.1	5.6	14.3	965
Орон сууц	81.5	76.3	85.8	18.0	12.0	26.2	604
Бие даасан тохилог сууц	66.4	44.5	82.9	9.7	5.8	15.8	83
Сууцны тусдаа байшин	68.9	62.8	74.3	15.0	11.1	20.1	835
Нийтийн байр	-	-	-	-	-	-	19
<b>Боловсрол</b>							
Боловсролгүй	16.9	8.9	29.8	3.6	0.5	21.7	50
Бага / суурь	48.8	33.1	64.6	7.1	2.9	16.2	141
Бүрэн дунд	56.8	49.4	64.0	10.4	6.6	15.9	477
Дээд / магистр	79.2	75.8	82.2	18.0	13.7	23.3	1382
<b>Ажил эрхлэлт</b>							
Ажилтай	68.5	64.4	72.4	14.8	11.6	18.7	1662
Ажилгүй	67.4	60.7	73.4	13.4	8.5	20.6	844
<b>Гэрлэлтийн байдал</b>							
Гэрлэсэн	71.9	67.6	75.8	13.4	10.0	17.8	1967
Гэрлээгүй	56.7	41.7	70.5	19.5	8.8	37.9	135
Хамтран амьдардаг	58.5	50.0	66.5	15.6	10.5	22.5	404
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>							
Ядуу	38.9	31.8	46.4	4.7	2.8	7.7	659
Дунджаас доогуур	64.9	57.6	71.5	11.6	6.2	20.8	581
Дундаж	71.2	64.3	77.3	14.9	9.9	21.8	531
Дунджаас дээгүүр	78.4	70.4	84.7	17.1	12.1	23.6	446
Чинээлэг	86.7	80.6	91.2	22.9	14.1	35.0	286
<b>Өрхийн хүнсний баталгаат байдал</b>							
ХББ хангагдсан / хөнгөн алдагдсан	71.8	67.7	75.5	15.4	11.8	19.8	1968
ХББ дунд зэрэг алдагдсан	55.1	47.4	62.7	9.6	5.9	15.2	439
ХББ ноцтой алдагдсан	42.6	25.5	61.7	16.1	5.8	37.4	56

Хоногт 5 бүлэг хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэсэн эхчүүдийн хувь Улаанбаатар хот (21.2%), хот суурин газар (17.5%)-т бусад бүс нутаг, хөдөөгийн эмэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс харьцангуй өндөр байв ( $p < 0.0001$ ). Мөн халх эмэгтэйчүүд (15.0%), дээд боловсролтой эхчүүдийн (18.0%) дунд 5 нэр төрлийн хүнсний хэрэглээ харьцангуй илүү байв (Хүснэгт W.14).

ХЧА-д багтсан 8 асуулт нь ХБӨ-өөр өвчлөх эрсдэлийг нэмэгдүүлдэг эрүүл бус хүнсний хэрэглээг үнэлэхэд чиглэсэн болно. Тухайлбал, судалгаанд хамрагдсан эхчүүдийн хийжүүлсэн ундаа, чихэрлэг ундаа, боловсруулсан махан бүтээгдэхүүн, их тосон шарж болгосон хоол, хүнс, давс ихтэй зууш, чихэр, амттан, түргэн хоол, бэлэн гоймон зэрэг эрүүл бус хүнсний хэрэглээг судалж, ХБӨ-өөр өвчлөх эрсдэлийг үнэлсэн. Судалгааны өмнөх 24 цагт эхчүүдийн 67.7% чихэрлэг, хийжүүлсэн ундаа, 43.6% чипс, шаржигнуур зэрэг давс ихтэй, их тосонд шарж болгосон зууш, 29.1% их тосонд шарж болгосон хоол, хүнс, 64.8% чихэр, амттан хэрэглэсэн нь эрүүл бус хүнсний хэрэглээ түгээмэл байгааг илтгэж байна.

Эхчүүдийн хүнсний хэрэглээнд тулгуурлан тэдний ХБӨ-өөс сэргийлэх буюу хамгаалах хүнсний хэрэглээ, эрүүл хооллолт, хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг оноогоор үнэлж, тэдгээрийн дундаж утгыг тооцон, эмэгтэйчүүдийн насны бүлэг, бүс нутаг, орон нутгийн байршлаар харьцуулан үнэлэв (Хүснэгт W.15). Хүнсний бүтээгдэхүүнийг 10 бүлэгт хувааж, тэдгээр бүлэгт хамаарах аль нэг бүтээгдэхүүнийг хэрэглэсэн бол 1 оноо, хэрэглээгүй бол 0 оноо өгч, судалгааны өмнөх 24 цагт тухайн хүний хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг 0–10 оноогоор үнэлсэн.

Эхчүүдийн судалгааны өмнөх 24 цагт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн дундаж оноо 5.4 байгаа бөгөөд Улаанбаатар хот, хот суурин газар, дээд боловсролтой эмэгтэйчүүдэд харьцангуй их ( $p < 0.0001$ ), харин Баруун бүс, хөдөө орон нутаг, боловсролгүй болон бага боловсролтой эхчүүдэд бага байна (Хүснэгт W.15).

ХБӨ-өөс сэргийлэх үйлдэлтэй эрүүл хүнсний бүтээгдэхүүнийг бүлэглэн хэрэглэсэн бол 1, хэрэглээгүй бол 0 оноо өгч, 0–9 оноогоор үнэлэхэд төрөх насны эмэгтэйчүүдийн дундаж үзүүлэлт харьцангуй бага буюу 3.2 байв. Өөрөөр хэлбэл, Монголын 15–49 насны эмэгтэйчүүдийн ХБӨ-ний эрсдэлээс хамгаалах эрүүл хүнсний хэрэглээ туйлын хангалгүй байна. ХБӨ-өөс хамгаалах эрүүл хүнсний хэрэглээний дундаж оноо Улаанбаатар хот, хот суурин газар, дээд боловсролтой эхчүүдэд харьцангуй их ( $p < 0.0001$ ), харин Баруун болон Хангайн бүс, хөдөө орон нутаг, боловсролгүй, бага боловсролтой эхчүүдэд статистик ач холбогдол бүхий бага байв (Хүснэгт W.15).

Эрүүл бус хүнсний бүтээгдэхүүн хэрэглэсэн бол 1–2, хэрэглээгүй бол 0 оноо өгч, ХБӨ-ий эрсдэлийг 0–9 оноогоор үнэлсэн. Төрөх насны эхчүүдийн эрүүл бус хүнсний хэрэглээг илтгэх ХБӨ-ний эрсдэлийн дундаж оноо 4.0 байгаа бөгөөд Улаанбаатар хот, хот суурин газрын эхчүүдэд ялимгүй их байна. Мөн дээд боловсролтой эхчүүдийн ХБӨ-ний эрсдэлийн дундаж (3.9) оноо боловсролгүй эхчүүдийн үзүүлэлт (3.0)-ээс илүү байв ( $p < 0.0001$ ).

Дараах хүснэгтэд харуулсан “Эрүүл хооллолтын оноо” нь эхчүүдийн судалгаанаас өмнөх 24 цагт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн нь ДЭМБ-ын эрүүл хооллолтын зөвлөмжид хэрхэн нийцэж байгааг илтгэх үзүүлэлт юм. Эрүүл хооллолтын оноог ХБӨ-өөс хамгаалах болон ХБӨ-өөр өвчлөх эрсдэлийн онооны ялгавраар тооцон, 0–18 оноогоор үнэлэх хооллолтын чанарын үнэлгээний удирдамжийг ашиглан гаргасан болно. Тав хүртэлх насны хүүхдийн эхчүүдийн эрүүл хооллолтыг илтгэх дундаж оноо 8.1 байгаа бөгөөд уг үзүүлэлт тэдний насны бүлэг, боловсролын түвшин, эдийн засгийн бүс, байршлаар ялгаатай байв. Тодруулбал, эхчүүдийн боловсролын түвшин ахих тутам эрүүл хооллолтын дундаж оноо нэмэгдэж байгаа зүй тогтол ажиглагдсан бөгөөд дээд боловсролтой эхчүүдийн эрүүл хооллолтын дундаж оноо нь



боловсролгүй, бага боловсролтой, бүрэн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс их байна ( $p < 0.0001$ ). Мөн Улаанбаатар хот, Хот суурин газрын эхчүүдийн дунд тус үзүүлэлт статистик ач холбогдол бүхий их байгааг  $W.15$  хүснэгтээс харж болно.

Хүснэгт W.15: Төрөх насны эхчүүдийн хооллолтын чанарыг оноогоор үнэлсэн дүн

Үзүүлэлтүүд	Жинлээгүй тоо	Хүнсний нэр төрөл, оноо (Minimum dietary diversity score)			Зөвлөмжийн дагуу хооллолт, оноо (Global dietary recommendation score)			ХБӨ-өөс урьдчилан сэргийлэлт, оноо (NCD-Protect)			ХБӨ-ий эрсдэл, оноо (NCD-Risk)		
		Дундаж	95% ИХ		Дундаж	95% ИХ		Дундаж	95% ИХ		Дундаж	95% ИХ	
			Доод	Дээд		Доод	Дээд		Доод	Дээд		Доод	Дээд
<b>Бүгд</b>	<b>2506</b>	<b>5.4</b>	<b>5.2</b>	<b>5.6</b>	<b>8.1</b>	<b>7.9</b>	<b>8.2</b>	<b>3.2</b>	<b>3.0</b>	<b>3.4</b>	<b>4.0</b>	<b>3.8</b>	<b>4.1</b>
<b>Нас</b>													
16 – 29 нас	837	5.3	5.0	5.6	7.6	7.3	7.9	2.8	2.5	3.1	4.1	4.0	4.4
30 – 39 нас	1379	5.4	5.2	5.6	8.2	8.1	8.4	2.9	2.8	3.1	3.7	3.6	3.8
40 – 49 нас	290	5.6	5.3	6.0	8.4	8.0	8.8	3.1	2.8	3.5	3.8	3.5	4.0
<b>Эдийн засгийн бүс</b>													
Баруун	515	4.6	4.3	5.0	7.4	7.1	7.7	2.1	1.8	2.5	3.7	3.5	3.9
Хангай	483	4.7	4.5	4.9	7.5	7.2	7.9	2.1	1.9	2.3	3.5	3.3	3.8
Төв	522	5.0	4.7	5.3	7.7	7.2	8.1	2.5	2.2	2.9	3.9	3.6	4.1
Зүүн	487	5.2	4.9	5.6	7.9	7.6	8.2	2.7	2.4	3.0	3.8	3.4	4.3
Улаанбаатар	499	6.0	5.7	6.3	8.5	8.2	8.8	3.6	3.3	3.8	4.1	3.9	4.2
<b>Хот, хөдөө</b>													
Хот	1330	5.7	5.4	5.9	8.2	8.0	8.5	3.2	3.0	3.4	4.0	3.8	4.1
Хөдөө	1176	4.8	4.6	5.0	7.6	7.4	7.8	2.3	2.0	2.5	3.7	3.5	3.8
<b>Байршил</b>													
Нийслэл	499	6.0	5.7	6.3	8.5	8.2	8.8	3.6	3.3	3.8	4.1	3.9	4.2
Аймгийн төв	831	4.9	4.7	5.1	7.6	7.3	8.0	2.4	2.2	2.6	3.8	3.5	4.0
Сумын төв / баг	1176	4.8	4.6	5.0	7.6	7.4	7.8	2.3	2.0	2.5	3.7	3.5	3.8
<b>Яс үндэс</b>													
Халх	1937	5.5	5.3	5.7	8.1	7.9	8.3	3.0	2.8	3.2	3.9	3.8	4.0
Казак	165	4.9	4.4	5.4	7.7	7.1	8.3	2.3	1.7	2.9	3.6	3.3	3.9
Бусад	404	5.2	4.9	5.5	7.8	7.4	8.2	2.8	2.5	3.1	4.0	3.7	4.3
<b>Боловсролын түвшин</b>													
Боловсролгүй	50	3.3	3.0	3.7	6.9	6.6	7.2	0.9	0.5	1.3	3.0	2.7	3.3
Бага	141	4.4	3.9	4.9	7.1	6.5	7.7	1.9	1.4	2.5	3.8	3.5	4.1
Бүрэн дунд	933	5.0	4.6	5.3	7.6	7.3	7.9	2.5	2.2	2.7	3.9	3.7	4.1
Дээд/магистр	1382	5.9	5.7	6.1	8.5	8.3	8.7	3.4	3.2	3.6	3.9	3.8	4.0
<b>Ажил эрхлэлтийн байдал</b>													
Ажилтай	1662	5.4	5.2	5.6	8.0	7.8	8.2	3.0	2.7	3.2	4.0	3.8	4.1
Ажилгүй	844	5.5	5.1	5.8	8.1	7.9	8.4	2.9	2.7	3.2	3.8	3.6	4.0
<b>Гэрлэлтийн байдал</b>													
Гэрлээгүй	135	5.5	5.3	5.7	8.2	8.0	8.4	3.0	2.9	3.2	3.9	3.7	4.0
Гэрлэсэн	1967	4.9	4.2	5.7	8.0	7.2	8.8	2.7	2.0	3.4	3.7	3.4	4.0
Хамтран амьдардаг	404	5.2	4.9	5.6	7.6	7.2	8.0	2.7	2.3	3.0	4.1	3.8	4.4

## Бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглээ

Сүүлийн 1 жилийн хугацаанд нийт эхчүүдийн 55.3% ямар нэг төрлийн аминдэм, эрдсийн бэлдмэл хэрэглэсэн байна (Хүснэгт W.16). Хотын эмэгтэйчүүдийн (58.6%) аминдэм, эрдсийн хэрэглээ хөдөө (47.0%)-ийн эхчүүдийн хэрэглээнээс 1.3 дахин их байв. Аминдэм, эрдсийн хэрэглээг бүсээр авч үзвэл, Улаанбаатар хотод (61.9%) хамгийн их, баруун бүсэд хамгийн бага (47.2%) байна. Сүүлийн нэг жилийн хугацаанд аминдэм, эрдсийн бэлдмэл хэрэглэсэн байдал нь 5 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн оршин суугаа орон нутаг, боловсролын түвшин, гэрлэлтийн байдлаар ялгаатай, хөдөөгийн эмэгтэйчүүд (47.0%), гэрлээгүй эхчүүд (35.7%), боловсролгүй (22.1%), бага боловсролтой (35.7%) эмэгтэйчүүдийн хэрэглээ статистик ач холбогдол бүхий бага байгааг W.16 хүснэгтээс харж болно. Мөн өрхийн аж байдлын түвшин, хүнсний баталгаат байдлын алдагдал нь эмэгтэйчүүдийн бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглээнд ихээхэн нөлөөлж байгааг судалгааны үр дүн илтгэж байна. Аж байдлын түвшин доогуур (40.9%), ХББ ноцтой алдагдсан (31.4%) өрхийн эхчүүдийн аминдэм, эрдсийн бэлдмэлийн хэрэглээ чинээлэг (76.7%), ХББ хангагдсан (56.9%) өрхийн эмэгтэйчүүдээс 1.8–1.9 дахин бага байв ( $p=0.4=04$ ,  $p=0.003$ ).

Хүснэгт W.16. Эхчүүдийн сүүлийн 1 жилд аминдэм, эрдсийн бэлдмэл хэрэглэсэн байдал

Үзүүлэлтүүд	95% ИХ		Жинлээгүй Тоо
	Доод	Дээд	
<b>Бүгд</b>		.	
<b>Нас</b>			
16-29 нас			
30-39 нас			
40-49 нас			
<b>Эдийн засгийн бүс</b>			
Баруун			
Хангай			
Төв			
Зүүн			
Улаанбаатар			
<b>Хот, хөдөө</b>			
Хот			
Хөдөө			
<b>Байршил</b>			
Нийслэл хот			
Аймгийн төв			
Сумын төв / Баг			
<b>Яс үндэс</b>			
Халх			

Казак				
Бусад				
<b>Боловсрол</b>				
Боловсролгүй				
Бага				
Дунд				
Дээд				
<b>Ажил эрхлэлт</b>				
Ажилтай				
Ажилгүй				
<b>Гэрлэлтийн байдал</b>				
Гэрлэсэн				
Гэрлээгүй				
Хамтран амьдардаг				
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>				
Ядуу				
Дунджаас доогуур	47.1	39.7		
Дундаж	54.0	45.8		
Дунджаас дээгүүр	57.5	45.9		
Чинээлэг	76.7	68.9		
<b>Өрхийн хүнсний баталгаат байдал</b>				
ХББ хангагдсан / хөнгөн алдагдсан		51.7		
ХББ дунд зэрэг алдагдсан	50.5	42.7		
ХББ ноцтой алдагдсан	31.4	16.3		

Сүүлийн 1 жилд аминдэм, эрдсийн бэлдмэл хэрэглэсэн эхчүүдийн дөнгөж 12.1% олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл (ОНБТБ) хэрэглэсэн байгаа нь туйлын хангалтгүй байна. Эхчүүдийн ОНБТБ-ийн хэрэглээ бүс нутаг, хөдөлмөр эрхлэлтийн байдал, үндэс угсаагаар ялгаатай, Баруун бүсэд хамгийн их, Зүүн болон Төвийн бүсэд хамгийн бага байв. Ажилгүй эмэгтэйчүүд, Казак эхчүүдийн дунд харьцангуй их байна (Хүснэгт W.17).

Хүснэгт W.17. Төрөх насны эхчүүдийн ОНБТБ хэрэглээ

Үзүүлэлтүүд	95% ИХ		Жинлээгүй тоо
	Доод	Дээд	
<b>Бүгд</b>			
<b>Нас</b>			
16-29 нас			
30-39 нас			
40-49 нас			
<b>Эдийн засгийн бүс</b>			
Баруун			
Хангай			
Төв			

Зүүн				
Улаанбаатар				
<b>Хот, хөдөө</b>				
Хот				
Хөдөө				
<b>Байршил</b>				
Нийслэл хот				
Аймгийн төв				
Сумын төв / Баг				
<b>Яс үндэс</b>				
Халх				
Казак				
Бусад				
<b>Боловсрол</b>				
Боловсролгүй				
Бага				
Дунд				
Дээд				
<b>Ажил эрхлэлт</b>				
Ажилтай				
Ажилгүй				
<b>Гэрлэлтийн байдал</b>				
Гэрлэсэн				
Гэрлээгүй				
Хамтран амьдардаг				
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>				
Ядуу	16.9	7.9	32.7	238
Дунджаас доогуур	17.6	11.4	26.2	281
Дундаж	13.5	5.3	30.1	295
Дунджаас дээгүүр	6.1	3.5	10.3	282
Чинээлэг	10.1	2.6	31.7	218


Эхчүүдийн ОНБТБ-ийг хэрэглэсэн дундаж хугацаа 54.4 хоног байв. ОНБТБ хэрэглэсэн эхчүүдийн тоо хэт цөөн байгаа тул дундаж хугацааг сонгосон үзүүлэлтээр харьцуулан үнэлэх боломжгүй болно (Хүснэгт W.18).

Хүснэгт W.18. Төрөх насны эхчүүдийн ОНБТБ хэрэглэсэн дундаж хугацаа, хоногоор

Үзүүлэлт	Хэрэглэсэн дундаж хугацаа, хоногоор	95% ИХ		Жинлээгүй тоо
		Доод	Дээд	
<b>Бүгд</b>	<b>54.4</b>	<b>38.4</b>	<b>70.4</b>	<b>129</b>
<b>Насны бүлэг</b>				
16-29 нас	37.7	21.3	54.0	48
30-49 нас	67.3	40.8	93.9	81

<b>Хот, хөдөө</b>				
Хот	57.2	36.1	78.2	69
Хөдөө	49.0	25.2	72.8	60
<b>Яс үндэс</b>				
Халх	54.6	36.0	73.2	94
Бусад	53.2	26.9	79.5	35
<b>Ажил эрхлэлтийн байдал</b>				
Ажилтай	74.0	43.3	104.7	82
Ажилгүй	38.2	26.2	50.3	47

ОНБТБ хэрэглэсэн эхчүүдээс тэдгээр бэлдмэлийг хаанаас авсан талаар тодруулахад, тал орчим хувь (45.2%) эрүүл мэндийн төвөөс, 16.4% хувь хүнээс, 36.5% эмийн сангаас, 1.9% хаанаас авснаа санахгүй байна гэж хариулсан болно (Зураг W.2).



Зураг W.2. Төрөх насны эхчүүдийн хэрэглэсэн ОНБТБ-ийн эх сурвалж

Сүүлийн 1 жилд аминдэм, эрдсийн бэлдмэл хэрэглэсэн эхчүүдийн 70 орчим хувь нь аль нэг хэлбэрийн Д аминдэмийн бэлдмэл хэрэглэсэн байна. Эхчүүдийн Д аминдэмийн хэрэглээ тэдний оршин суугаа орон нутгийн байршил, насны бүлэг, боловсролын түвшин, гэрлэлтийн байдлаар статистик ач холбогдол бүхий ялгаатай байв. Тухайлбал, Улаанбаатар хот, 40–49 насны эхчүүд, дээд боловсролтой эмэгтэйчүүдийн дунд хамгийн түгээмэл, харин аймгийн төвд оршин суудаг, хамтран амьдардаг, бага болон суурь боловсролтой эхчүүдийн Д аминдэмийн хэрэглээ харьцангуй бага байв (Хүснэгт W.19).

Хүснэгт W.19. Төрөх насны эхчүүдийн Д аминдэмийн хэрэглээ

Үзүүлэлтүүд	Хувь	95% ИХ		Жинлээгүй тоо
		Доод	Дээд	
<b>Бүгд</b>				
<b>Нас</b>				
16-29 нас				

30-39 нас				
40-49 нас				
<b>Эдийн засгийн бүс</b>				
Баруун				
Хангай				
Төв				
Зүүн				
Улаанбаатар				
<b>Хот, хөдөө</b>				
Хот				
Хөдөө				
<b>Байршил</b>				
Нийслэл хот				
Аймгийн төв				
Сумын төв / Баг				
<b>Яс үндэс</b>				
Халх				
Казак				
Бусад				
<b>Боловсрол</b>				
Боловсролгүй				
Бага				
Дунд				
Дээд				
<b>Ажил эрхлэлт</b>				
Ажилтай				
Ажилгүй				
<b>Гэрлэлтийн байдал</b>				
Гэрлэсэн				
Гэрлээгүй				
Хамтран амьдардаг				
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>				
Ядуу	62.4	50.6	72.9	238
Дунджаас доогуур	57.2	44.9	68.7	281
Дундаж	66.1	55.2	75.5	295
Дунджаас дээгүүр	65.8	56.2	74.3	282
Чинээлэг	75.9	65.0	84.2	218

Эхчүүд сүүлийн 1 жилийн хугацаанд Д аминдэмийн бэлдмэлийг хоногт 500–50,000 ОУН тунгаар (Mean=3116 ОУН) дунджаар 92.4 хоног хэрэглэсэн байв. Төрөх насны эхчүүдийн Д аминдэм хэрэглэсэн хугацаа нь тэдний оршин суугаа бүс нутаг, үндэс угсаа, боловсролын түвшнээр ялгаатай, халх эмэгтэйчүүдийн Д аминдэм хэрэглэсэн хугацаа нь Казак болон бусад ястан

эхчүүдээс 1.5–2.0 дахин илүү, дээд, бүрэн дунд боловсролтой эмэгтэйчүүдэд боловсролгүй эсвэл бага боловсролтой эхчүүдээс 2.0–3.0 дахин илүү байгааг W.20 хүснэгтээс харж болно.

Хүснэгт W.20. Эхчүүдийн хэрэглэсэн Д аминдэмийн тун ба хэрэглэсэн хугацаа

Үзүүлэлтүүд	Хэрэглэсэн тун, олон улсын нэгжээр	Хэрэглэсэн хугацаа, хоногоор	Жинлээгүй тоо
<b>Бүгд</b>			
<b>Нас</b>			
16-29 нас			
30-39 нас			
40-49 нас			
<b>Эдийн засгийн бүс</b>			
Баруун			
Хангай			
Төв			
Зүүн			
Улаанбаатар			
<b>Хот, хөдөө</b>			
Хот			
Хөдөө			
<b>Байршил</b>			
Нийслэл хот			
Аймгийн төв			
Сумын төв / Баг			
<b>Яс үндэс</b>			
Халх			
Казак			
Бусад			
<b>Боловсрол</b>			
Боловсролгүй			
Бага			
Дунд			
Дээд			
<b>Ажил эрхлэлт</b>			
Ажилтай			
Ажилгүй			
<b>Гэрлэлтийн байдал</b>			
Гэрлэсэн			
Гэрлээгүй			
Хамтран амьдардаг			
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>			
Ядуу	1565	99	128
Дунджаас доогуур	3351	75	172



Дундаж	3570	72	17
Дунджаас дээгүүр	4375	86	187
Чинээлэг	2692	115	159

Судалгаагаар төрөх насны эхчүүдийн сүүлийн 1 жилийн хугацаанд ОНБТБ, Д аминдэмээс бусад төрлийн бэлдмэлийн хэрэглээг үнэлсэн болно. Нийт эхчүүдийн 78.7% холимог болон дан найрлагатай аминдэм, эрдсийн бэлдмэл хэрэглэсэн бөгөөд бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглээ нь өрхийн аж байддын түвшнээс үл харгалзан түгээмэл байв. Гэхдээ бусад төрлийн аминдэм, эрдсийн бэлдмэлийн хэрэглээ бүс нутгаар ялгаатай ( $p=0.008$ ), Төвийн бүсэд хамгийн бага (69.4%), Хангайн бүсэд (89.7%) харьцангуй түгээмэл байна (Хүснэгт W.21).

Хүснэгт W.21. Төрөх насны эхчүүдийн бусад төрлийн аминдэм, эрдсийн бэлдмэл хэрэглээ

Үзүүлэлтүүд	95% ИХ		Жинлээгүй тоо
	Доод	Дээд	
<b>Бүгд</b>			
<b>Нас</b>			
16-29 нас			
30-39 нас			
40-49 нас			
<b>Эдийн засгийн бүс</b>			
Баруун			
Хангай			
Төв			
Зүүн			
Улаанбаатар			
<b>Хот, хөдөө</b>			
Хот			
Хөдөө			
<b>Байршил</b>			
Нийслэл хот			
Аймгийн төв			
Сумын төв / Баг			
<b>Яс үндэс</b>			
Халх			
Казак			
Бусад			
<b>Боловсрол</b>			
Боловсролгүй			
Бага			
Дунд			
Дээд			
<b>Ажил эрхлэлт</b>			

Ажилтай				
Ажилгүй				
<b>Гэрлэлтийн байдал</b>				
Гэрлэсэн				
Гэрлээгүй				
Хамтран амьдардаг				
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>				
Ядуу		75.7		
Дунджаас доогуур	80.0	73.3		
Дундаж	75.0	61.0		
Дунджаас дээгүүр	77.4	68.8		
Чинээлэг	79.4	68.6		

Бусад төрлийн аминдэм, эрдсийн бэлдмэл хэрэглэсэн эхчүүдийн 37.9% төмрийн бэлдмэл, 22.3% фолийн хүчил, 22.6 % магни  $M_6$  бэлдмэл уусан байна. ОНБТБ, Д аминдэмээс бусад төрлийн бэлдмэл хэрэглэсэн эхчүүдийн 23.9% прегнавит, пренатал, элевит, лактональ, дуовит, эхчүүдэд зориулсан альфавит зэрэг нийлмэл найрлагатай бичил тэжээлийн бэлдмэлийг сүүлийн 1 жилийн хугацаанд хэрэглэсэн байв. Мөн 4 эмэгтэй тутмын 1 орчим нь кальци, цайр, селен зэрэг эрдсийн бэлдмэлийг дангаар нь болон бусад эрдэстэй холимог хэлбэрээр хэрэглэж байна. Тав хүртэлх насны хүүхэдтэй эхчүүд эдгээр бэлдмэлийг 56.3–80.7 хоногоор хэрэглэсэн байгааг W.22 хүснэгтээс харж болно.

Хүснэгт W.22. Төрөх насны эхчүүдийн бусад төрлийн аминдэм, эрдсийн бэлдмэлийн хэрэглээ

Бэлдмэлийн төрөл	Бэлдмэл хэрэглэсэн эхчүүд				Хэрэглэсэн дундаж хугацаа, хоногоор	Жинлээгүй тоо
	n	%	95% ИХ			
			Доод	Дээд		
Төмрийн бэлдмэл	409	37.9	32.6	43.6	74.2	1020
Фолийн хүчил	236	22.3	18.3	26.9	63.6	1020
Нийлмэл найрлагатай бичил тэжээлийн бэлдмэл	273	23.9	18.1	30.9	62.6	1020
А, С, Е аминдэм	375	40.5	34.7	46.6	56.7	1020
Эрдсийн бэлдмэл (Ca, Zn, Se)	213	25.4	20.0	31.8	74.3	1020
Магни $B_6$	233	22.6	19.5	26.1	54.1	1020
Омега 3, 6, 9 тосны хүчил	175	18.4	14.0	23.8	80.7	1020
Бусад бэлдмэл	41	4.1	2.6	6.2	56.3	1020

## Жирэмсэн үеийн эрүүл мэндийн тусламжийн хамрагдалт

Төрөх насны эхчүүд дунджаар 5 хүртэлх насны 1.4 (95%ИХ 1.3–1.4) хүүхэдтэй байгаа бөгөөд хүүхдийн тоо нь эдийн засгийн бүс, байршлаар ялгаатай бус, харин насны бүлгээр харьцуулан үнэлэхэд, 29 хүртэлх насны (1.5, 95%ИХ 1.4–1.5) залуучуудад 40–49 насны эхчүүдийн дундаж үзүүлэлт (1.2, 95%ИХ 1.1–1.3)-ээс бага зэрэг илүү байв.

Төрөх насны эхчүүдээс судалгаанд сонгогдсон хүүхдээ тээж байхдаа жирэмсэн үеийн эрүүл мэндийн тусламж (ЖҮЭМТ) үйлчилгээнд хамрагдсан байдлыг жирэмсний хяналтын анхны үзлэгийн хугацаа, үзлэгийн тоо, хэнээс, ямар байгууллагаас ЖҮЭМТ авсан, жирэмслэлтийн явцад бичил тэжээлийн бэлдмэл хэрэглэсэн зэрэг асуултаар үнэлсэн.

Судалгаанд хамрагдсан нийт эхчүүдийн 99.4% хүүхдээ тээж байхдаа эрүүл мэндийн ажилтны хяналтад хамрагдаж тусламж, үйлчилгээ авсан байв. Эхчүүдийн ЖҮЭМТ үйлчилгээнд хамрагдах байдал нь сонгосон үзүүлэлтээр ялгаатай бус, жигд байна. Мөн эхчүүдийн 44.6% эх барих, эмэгтэйчүүдийн эмч, 54.6% сум, өрхийн Эрүүл мэндийн төв (ЭМТ)-ийн эмч, 0.9% багийн эмч эсвэл эх баригчийн хяналтад хамрагдаж, тусламж үйлчилгээ авсан байв. Эхчүүдийн 98.6% эх барих, эмэгтэйчүүдийн чиглэлээр мэргэшсэн их эмч эсвэл ерөнхий мэргэжлийн эмчийн хяналтад байж, тусламж үйлчилгээ авсан байна. Мөн дээд боловсролтой эхчүүдийн их эмчийн хяналтад хамрагдаж, тусламж авсан байдал нь бага боловсролтой эмэгтэйчүүдээс харьцангуй илүү ( $p=0.02$ ), Баруун бүсийн эмэгтэйчүүдийн их эмчийн хяналтад хамрагдсан хувь бусад бүсийн үзүүлэлтээс ялимгүй бага ( $p=0.04$ ) байв (Хүснэгт W.23).

Хүснэгт W.23. Жирэмсэн үеийн эрүүл мэндийн тусламжид хамрагдсан байдал, хувиар

Үзүүлэлт	ЖҮЭМТ үзүүлэгчид		ЖҮЭМТ-д хамрагдаагүй	Жинлээгүй Тоо
	Их эмч*	Багийн эмч, эх баригч		
<b>Бүгд</b>				
<b>Эдийн засгийн бүс</b>				
Баруун				
Хангай				
Төв				
Зүүн				
Улаанбаатар				
<b>Хот, хөдөө</b>				
Хот				
Хөдөө				
<b>Байршил</b>				
Нийслэл хот				
Аймгийн төв				

Сумын төв / Баг				
<b>Нас</b>				
16-29 нас				
30-39 нас				
40-49 нас				
<b>Гэрлэлтийн байдал</b>				
Гэрлэсэн				
Гэрлээгүй				
Хамтран амьдардаг				
<b>Яс үндэс</b>				
Халх				
Казак				
Бусад				
<b>Боловсрол</b>				
Боловсролгүй				
Бага				
Дунд				
Дээд				
<b>Ажил эрхлэлт</b>				
Ажилтай				
Ажилгүй				
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>				
Ядуу	99.5	0.5	1.2	661
Дунджаас доогуур	97.9	2.1	0.6	582
Дундаж	99.6	0.4	0.6	532
Дунджаас дээгүүр	99.8	0.2	0.0	448
Чинээлэг	98.9	1.1	0.4	287
<i>*Эх барих, эмэгтэйчүүдийн эмч, ерөнхийн мэргэжлийн эмчийг хамруулсан</i>				

Эхчүүдийн 96.0% “Жирэмсний хяналтын хөтөч”-тэй байсан бөгөөд ажил эрхэлдэг эхчүүд ( $p=0.007$ ), Баруун, Зүүн бүс, хөдөөгийн эмэгтэйчүүдийн дунд тус үзүүлэлт харьцангуй өндөр, харин хот суурин газар, Улаанбаатар хот, ажилгүй эмэгтэйчүүдэд бага ( $p<0.0001$ ) байна (Хүснэгт W.24).

Хүснэгт W.24: Жирэмсний хяналтын хөтөчтэй эхчүүд

Үзүүлэлтүүд	%	95% ИХ		Жинлээгүй тоо
		Доод	Дээд	
<b>Бүгд</b>	<b>96.0</b>	<b>91.0</b>	<b>98.3</b>	<b>2502</b>
<b>Эдийн засгийн бүс</b>				
Баруун	99.6	98.9	99.3	514
Хангай	99.1	95.1	99.8	482
Төв	98.7	96.2	99.6	523
Зүүн	99.5	97.8	99.9	486
Улаанбаатар	92.7	83.0	97.1	497

<b>Хот, хөдөө</b>				
Хот	94.8	87.8	97.9	1328
Хөдөө	98.8	96.9	99.5	1174
<b>Байршил</b>				
Нийслэл хот	92.7	83.0	97.1	497
Аймгийн төв	99.7	99.3	99.9	831
Сумын төв / Баг	98.8	96.9	99.5	1174
<b>Ажил эрхлэлт</b>				
Ажилтай	98.0	96.7	98.8	1661
Ажилгүй	92.7	79.6	97.7	841

Эхчүүдээс судалгаанд сонгогдсон хүүхдийг тээж байхдаа ЖҮЭМТ үйлчилгээг ямар байгууллагаас авсан талаар тодруулахад, 9.5% (95%ИХ 6.3–13.9) улсын төрөх эмнэлэг, 12.6% (95%ИХ 10.1–15.5) аймгийн нэгдсэн эмнэлэг, 26.2% (95%ИХ 22.1–30.7) дүүргийн ЭМТ, 50.8% чиглэлээр төрөлжсөн хувийн хэвшлийн эмнэлгээс авсан байв.

ДЭМБ-ын зөвлөмжид эмэгтэйчүүдийг жирэмсний эхний 3 сарын хугацаанд ЖҮЭМТ үйлчилгээнд хамрагдаж,  $\geq 4$  удаа, МУ-ын Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/318 тушаалд 8 удаа (хэвийн явцтай жирэмслэлтийн үед 6 удаа) эрүүл мэндийн үзлэг хийлгэж, зөвлөгөө авахыг заасан байдаг. Судалгааны дүнгээс харахад, нийт эхчүүдийн 86.1% жирэмсний эхний 3 сард, 12.7% жирэмсний дунд 3 сард, маш бага хувь сүүлийн 3 сард ЖҮЭМТ үйлчилгээнд хамрагдсан байна (Хүснэгт W.25).


Хүснэгт W.25: Жирэмсэн үеийн эрүүл мэндийн тусламжид хамрагдсан хугацаа

Үзүүлэлт	Эхний 3 сар			Дунд 3 сар			Сүүлийн 3 сар			Жинлээгүй Тоо
	%	95%ИХ		%	95%ИХ		%	95%ИХ		
		доод	дээд		доод	дээд		доод	дээд	
<b>Бүгд</b>	<b>86.1</b>	<b>82.9</b>	<b>88.8</b>	<b>12.7</b>	<b>10.2</b>	<b>15.8</b>	<b>1.2</b>	<b>0.5</b>	<b>2.8</b>	<b>2483</b>
<b>Эдийн засгийн бүс</b>										
Баруун	75.6	63.2	84.9	19.8	11.9	31.0	4.6	0.9	21.1	503
Хангай	87.9	83.5	91.3	10.9	8.0	14.8	1.1	0.3	4.4	479
Төв	79.3	70.9	85.9	20.0	13.5	28.5	0.7	2.3	0.2	522
Зүүн	82.2	71.1	89.6	17.3	9.9	28.5	0.5	0.2	1.2	484
Улаанбаатар	90.6	85.3	94.1	8.9	5.4	14.2	0.5	0.2	1.4	495
<b>Хот, хөдөө</b>										
Хот	88.7	84.8	91.7	10.6	7.6	14.5	0.7	0.4	1.5	1320
Хөдөө	79.7	73.6	84.7	18.1	13.6	23.6	2.2	0.5	9.2	1163
<b>Байршил</b>										
Нийслэл хот	90.6	85.3	94.1	8.9	5.4	14.2	0.5	0.2	1.4	495
Аймгийн төв	84.3	77.9	89.1	14.5	9.9	20.8	1.2	0.4	3.5	825
Сумын төв / Баг	79.7	73.6	84.7	18.1	13.6	23.6	2.2	0.5	9.2	1163
<b>Нас</b>										
16-29 нас	83.7	77.8	88.3	14.1	10.0	19.5	2.2	0.6	7.3	832
30-39 нас	91.7	89.5	93.4	7.5	5.8	9.5	0.9	0.4	1.9	1362
40-49 нас	81.5	71.3	88.6	18.4	11.2	28.6	0.2	0.0	1.1	289

<b>Гэрлэлтийн байдал</b>										
Гэрлэсэн	89.6	86.0	92.3	10.1	7.4	13.7	0.3	0.1	0.8	1952
Гэрлээгүй	65.0	50.3	77.4	33.2	20.9	48.3	1.8	0.6	5.2	132
Хамтран амьдардаг	81.3	71.7	88.2	14.8	9.0	23.5	3.9	1.1	13.0	399
<b>Яс үндэс</b>										
Халх	85.6	82.0	88.6	13.1	10.2	16.6	1.3	0.5	3.2	1924
Казак	94.4	88.8	97.3	5.3	2.6	10.8	0.3	0.0	1.9	162
Бусад	87.5	81.4	91.8	12.3	8.0	18.4	0.3	0.1	1.0	397
<b>Боловсрол</b>										
Боловсролгүй	62.8	45.1	77.5	36.5	21.8	54.3	0.7	0.1	5.0	49
Бага	66.5	47.3	81.5	23.0	11.9	39.8	10.5	2.0	40.1	137
Дунд	81.1	75.0	85.9	18.0	13.1	24.1	1.0	0.4	2.3	923
Дээд	92.1	88.6	94.6	7.5	5.0	11.1	0.4	0.1	1.1	1374
<b>Ажил эрхлэлт</b>										
Ажилтай	85.7	81.3	89.2	12.6	9.3	16.8	1.7	0.6	4.4	1645
Ажилгүй	86.8	82.0	90.4	12.9	9.3	17.7	0.3	0.1	0.9	838
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>										
Ядуу	78.1	70.5	84.1	18.2	13.1	24.7	3.7	1.0	12.8	650
Дунджаас доогуур	85.0	78.3	89.9	14.3	9.5	20.9	0.7	0.2	1.9	575
Дундаж	82.0	70.9	89.5	17.3	9.9	28.4	0.7	0.1	4.2	525
Дунджаас дээгүүр	92.6	86.8	96.0	7.4	4.0	13.2	0.1	0.0	0.4	445
Чинээлэг	92.5	83.4	96.8	6.8	2.6	16.4	0.7	0.2	2.7	285
<b>Өрхийн хүнсний баталгаат байдал</b>										
ХББ хангагдсан/хөнгөн алдагдсан	87.3	83.5	90.3	12.2	9.2	15.9	0.5	0.2	1.2	1953
ХББ дунд зэрэг алдагдсан	81.8	74.0	87.6	13.8	9.7	19.3	4.4	1.2	14.6	431
ХББ ноцтой алдагдсан	65.8	45.4	81.7	33.8	17.9	54.4	0.4	0.1	2.8	56

Жирэмсний эхний 3 сард ЖҮЭМТ-д хамрагдсан эхчүүдийн хувь яс үндэс, ажил эрхлэлтийн байдлаас бусад бүх үзүүлэлтээр ялгаатай, гэрлээгүй (65.0%), боловсролгүй болон бага, суурь боловсрол (62.8%, 66.5%)-той эмэгтэйчүүд, 40–49 насны эхчүүд (81.5%), хөдөө орон нутаг (79.7%), Баруун бүс (75.6%) хамгийн бага байв. Мөн эхчүүдийн жирэмсний эхний 3 сард ЖҮЭМТ-д хамрагдсан байдал өрхийн аж байдлын түвшин, ХББ-ын алдагдлын зэргээр ялгаатай, ХББ ноцтой алдагдсан, ядуу өрхийн эхчүүдийн жирэмсний эхний 3 сард хяналтад хамрагдсан хувь харьцангуй бага байгааг  $W.25$  хүснэгтээс харж болно ( $p=0.006$ ,  $p<0.0001$ ).

Төрөх насны эхчүүд судалгаанд сонгогдсон хүүхдээ тээх хугацаанд дунджаар 7.5 удаа жирэмсний хяналтын үзлэгт хамрагдсан байв. Жирэмсний хяналтын үзлэгт хамрагдсан дундаж тоо Баруун болон Зүүн бүс, хөдөөгийн эмэгтэйчүүдэд харьцангуй цөөн байна (Зураг W.3).



Зураг W.3: Эхчүүдийн жирэмсний хяналтын үзлэгт хамрагдсан дундаж тоо

Нийт эхчүүдийн 93.9% (95%ИХ 91.4–95.7) хүүхдээ тээж байх хугацаандаа 4 ба түүнээс олон, 79.1% (95%ИХ 75.0–82.8) 6 ба түүнээс олон удаа жирэмсний хяналтын үзлэгт хамрагдсан байна. Харин жирэмсний үзлэг, хяналтад 3 ба түүнээс цөөн удаа хамрагдсан эмэгтэйчүүд 6.1% байгаа бөгөөд энэ үзүүлэлт аж байдлын түвшин доогуур ядуу өрх (12.5%), боловсролгүй (14.3%), эсвэл бага / суурь боловсролтой (17.8%), Баруун бүс (12.5%), хөдөө (9.3%)-гийн эхчүүдэд их байв ( $p=0.002$ ,  $p=0.02$ ,  $p<0.0001$ ,  $p=0.03$ ). Жирэмсэн үедээ 8 ба түүнээс олон удаа хяналтын үзлэгт хамрагдсан эхчүүдийн хувь аж байдлын түвшин дээгүүр өрх, Хангайн бүс, Улаанбаатар хот, хот суурин газар, гэрлэсэн, 30–49 насны эмэгтэйчүүдэд их байна (Хүснэгт

Хүснэгт W.26: Эхчүүдийн жирэмсний хяналтын үзлэгт хамрагдсан байдал

Үзүүлэлт	Жирэмсний хяналтын үзлэгийн тоо ба хувь									Жинлээгүй Тоо
	1 – 3 удаа			4 – 7 удаа			≥ 8 удаа			
	%	95%ИХ		%	95%ИХ		%	95%ИХ		
		Доод	Дээд		Доод	Дээд		Доод	Дээд	
<b>Бүгд</b>	<b>6.1</b>	<b>4.3</b>	<b>8.6</b>	<b>44.3</b>	<b>39.9</b>	<b>48.9</b>	<b>49.5</b>	<b>44.7</b>	<b>54.4</b>	<b>2493</b>
<b>Эдийн засгийн бүс</b>										
Баруун	12.5	6.6	22.5	48.9	40.5	57.4	38.5	29.4	48.6	514
Хангай	7.0	4.4	11.2	34.9	28.7	41.7	58.0	51.0	64.8	479
Төв	3.7	2.4	5.9	53.6	43.9	63.0	42.7	33.5	52.4	521
Зүүн	4.8	2.9	7.7	66.1	57.1	74.0	29.2	22.2	37.3	485
Улаанбаатар	5.1	2.6	9.9	40.7	33.0	48.8	54.2	45.5	62.7	494
<b>Хот, хөдөө</b>										
Хот	4.8	2.9	8.0	42.7	37.0	48.7	52.4	46.0	58.7	1320
Хөдөө	9.3	6.2	13.8	48.3	42.4	54.3	42.4	36.3	48.7	1163
<b>Байршил</b>										
Нийслэл хот	5.1	2.6	9.9	40.7	33.0	48.8	54.2	45.5	62.7	494
Аймгийн төв	4.3	2.7	6.6	47.4	40.4	54.5	48.3	41.4	55.4	828
Сумын төв / Баг	9.3	6.2	13.8	48.3	42.4	54.3	42.4	36.3	48.7	1163
<b>Нас</b>										

16-29 нас	7.3	4.4	11.7	52.4	45.4	59.4	40.3	33.8	47.2	836
30-39 нас	5.3	3.7	7.5	39.9	35.1	44.9	54.8	49.2	60.3	1370
40-49 нас	5.8	3.3	9.7	39.4	31.5	47.9	54.9	45.5	63.9	287
<b>Гэрлэлтийн байдал</b>										
Гэрлэсэн	5.6	3.9	7.8	42.3	37.3	47.6	52.1	46.7	57.4	1959
Гэрлээгүй	6.1	3.3	11.0	50.1	36.4	63.8	43.8	30.5	58.0	133
Хамтран амьдардаг	8.2	3.9	16.2	49.5	42.0	56.9	42.5	34.5	50.7	401
<b>Яс үндэс</b>										
Халх	5.9	4.1	8.5	43.6	38.6	48.8	50.4	45.0	55.8	1925
Казак	6.0	3.3	10.7	48.0	33.0	63.4	45.9	30.9	61.8	164
Бусад	7.6	3.6	15.3	48.4	40.9	55.9	44.1	36.2	52.2	404
<b>Боловсрол</b>										
Боловсролгүй	14.3	6.3	29.3	59.6	42.1	75.0	26.0	14.5	42.3	51
Бага	17.8	6.7	39.8	40.1	25.6	56.5	42.1	26.7	59.1	
Дунд	6.5	3.8	11.1	48.4	42.4	54.5	45.0	39.2	51.0	925
Дээд	4.5	3.0	6.7	41.5	35.3	47.9	54.0	47.2	60.7	1378
<b>Ажил эрхлэлт</b>										
Ажилтай	7.6	5.1	11.1	43.4	38.5	48.5	49.0	43.5	54.6	1655
Ажилгүй	3.8	2.4	6.0	45.8	38.8	53.0	50.4	43.3	57.4	837
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>										
Ядуу	12.5	8.0	19.0	45.5	38.4	52.9	42.0	34.4	50.0	657
Дунджаас доогуур	6.3	3.3	11.7	52.1	44.8	59.4	41.6	33.7	50.0	578
Дундаж	4.1	1.4	11.4	46.4	38.1	54.8	49.5	40.9	58.2	525
Дунджаас дээгүүр	4.4	2.2	8.5	46.7	35.7	58.2	48.8	37.7	60.1	446
Чинээлэг	3.5	1.8	6.7	30.5	20.5	42.7	66.0	53.3	76.8	284

Тав хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн 80.3% энэ судалгаанд сонгогдсон хүүхдийг тээж байхдаа ямар нэг төрлийн бичил тэжээлийн бэлдмэлийг ЭМБ-аас үнэ төлбөргүйгээр эсвэл эмийн сангаас худалдан авч хэрэглэсэн байна. Сонгогдсон хүүхдийг тээж байхдаа эхчүүдийн холимог эсвэл дан найрлагатай аминдэм, эрдсийн бэлдмэл хэрэглэх байдал нь тэдний оршин суугаа бүс нутаг, байршлаар ялгаатай, Хангайн бүс (94.4%)-д хамгийн өндөр, Улаанбаатар хот (74.3%)-д бага ( $p < 0.0001$ ) байв (Хүснэгт W.27).

Хүснэгт W.27. Жирэмслэлтийн явцад бичил тэжээлийн бэлдмэл хэрэглэсэн эхчүүд

Үзүүлэлтүүд	%	95% ИХ		Жинлээгүй тоо
		Доод	Дээд	
<b>Бүгд</b>				
<b>Нас</b>				
16-29 нас				
30-39 нас				
40-49 нас				
<b>Эдийн засгийн бүс</b>				
Баруун				
Хангай				
Төв				



Зүүн				
Улаанбаатар				
<b>Хот, хөдөө</b>				
Хот				
Хөдөө				
<b>Байршил</b>				
Нийслэл хот				
Аймгийн төв				
Сумын төв / Баг				
<b>Яс үндэс</b>				
Халх				
Казак				
Бусад				
<b>Боловсрол</b>				
Боловсролгүй				
Бага				
Дунд				
Дээд				
<b>Ажил эрхлэлт</b>				
Ажилтай				
Ажилгүй				
<b>Гэрлэлтийн байдал</b>				
Гэрлэсэн				
Гэрлээгүй				
Хамтран амьдардаг				
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>				
Ядуу	79.9	72.6	85.6	661
Дунджаас доогуур	83.4	75.5	89.1	582
Дундаж	83.2	74.6	89.3	532
Дунджаас дээгүүр		60.8	89.6	448
Чинээлэг	76.7	61.7	87.0	287

Судалгаанд хамрагдсан 5 хүртэлх насны хүүхдийг тээж байхдаа хэрэглэсэн бичил тэжээлийн бэлдмэлийг харьцуулан үнэлж, W.21 хүснэгтэд нэгтгэн харууллаа. Судалгаанд сонгогдсон хүүхдийг тээж байхдаа эхчүүдийн хэрэглэсэн бичил тэжээлийн бэлдмэлийг нэр төрлөөр харьцуулан судлахад, төмрийн бэлдмэлийг дангаар эсвэл фолийн хүчилтэй хавсарсан хэлбэрээр (75.1%), фолийн хүчлийн бэлдмэл (60.4%)-ийг хамгийн түгээмэл хэрэглэсэн байв. Мөн эхчүүдийн 51.7% (95%ИХ 57.3–56.3) Элевит, Пренатал, Прегнавит, Витрум зэрэг жирэмсэн эмэгтэйд зориулсан холимог найрлагатай бэлдмэлийг хэрэглэсэн байна (Хүснэгт W.27).

Эхчүүдийн ОНБТБ-ийн хэрэглээ туйлын хангалтгүй, дөнгөж 7.8% уусан байв. ОНБТБ хэрэглэсэн эхчүүдийн хувь Баруун болон Хангайн бүсэд харьцангуй илүү, Төв болон Зүүн бүсэд

маш бага, Улаанбаатар хотод үндэсний түвшний үзүүлэлттэй ойролцоо байна ( $p=0.004$ ). Судалгааны бусад үзүүлэлтээр эхчүүдийн ОНБТБ-ийн хэрэглээнд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдаагүй болно.

Төмрийн бэлдмэлийг дангаар эсвэл фолийн хүчилтэй хавсарсан байдлаар Улаанбаатар хот, Хот суурин газар, дээд боловсролтой, Халх ястан, гэрлээгүй эхчүүдийн дунд бага, харин Хангайн болон Төвийн бүс, Хөдөө орон нутаг, бага боловсролтой эхчүүд, Казак эмэгтэйчүүдэд харьцангуй илүү байв.

Элевит, Пренатал, Прегнавит, Витрум зэрэг жирэмсэн эмэгтэйд зориулсан холимог найрлагатай бэлдмэлийн хэрэглээ Улаанаатар хот, Төвийн бүс, Хот суурин газар, дээд боловсролтой, 30–49 насны эхчүүдэд харьцангуй их, Баруун болон Зүүн бүс, хөдөө орон нутаг, 16–29 насны эхчүүдэд бага байна (Хүснэгт W.28).

Д аминдэм, В аминдэмийн холимог, Омега 3, кальци зэрэг бусад төрлийн бичил тэжээлийн бэлдмэлийг эхчүүдийн 14.5% хэрэглэсэн байв. Хүснэгт W.21-д харуулсан үр дүнгээр бусад төрлийн бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглээ эдийн засгийн бүс, эмэгтэйчүүдийн боловсролын түвшнээр ялгаатай, Төв болон Зүүн бүсэд харьцангуй бага, дээд боловсролтой эхчүүдийн дунд илүү байна.

Хүснэгт W.28. Эхчүүдийн судалгаанд сонгогдсон хүүхдээ тээж байхдаа хэрэглэсэн аминдэм, эрдсийн бэлдмэлүүд

Үзүүлэлт	Төмөр, фолийн хүчлийн хавсарсан бэлдмэл		Фолийн хүчил		ОНБТБ		Бусад бэлдмэл		Нийлмэл найрлагатай бэлдмэл		Жинлээгүй тоо
	Эхчүүдийн хувь	Хэрэглэсэн хоног, дундаж	Эхчүүдийн хувь	Хэрэглэсэн хоног, дундаж	Эхчүүдийн хувь	Хэрэглэсэн хоног, дундаж	Эхчүүдийн хувь	Хэрэглэсэн хоног, дундаж	Эхчүүдийн хувь	Хэрэглэсэн хоног, дундаж	
<b>Бүгд</b>	<b>75.1</b>	<b>70.9</b>	<b>60.4</b>	<b>67.0</b>	<b>7.8</b>	<b>70.0</b>	<b>14.5</b>	<b>76.4</b>	<b>51.7</b>	<b>66.6</b>	<b>2114</b>
<b>Эдийн засгийн бүс</b>											
Баруун	80.3	62.8	57.4	55.1	18.0	50.4	20.0	46.0	27.3	44.2	416
Хангай	86.4	82.6	59.5	75.1	10.3	79.6	19.9	73.8	41.3	64.9	465
Төв	87.4	82.0	69.4	70.0	1.9	-	5.2	54.5	50.9	62.5	439
Зүүн	77.3	62.7	60.3	55.3	3.1	-	8.6	61.0	38.7	66.9	426
Улаанбаатар	64.6	63.5	58.8	67.3	6.8	-	14.8	102.2	64.9	70.5	377
<b>Хот, хөдөө</b>											
Хот	71.4	69.4	59.5	67.1	6.8	67.3	15.3	85.0	58.2	70.1	1103
Хөдөө	83.7	73.9	62.6	66.8	10.1	74.1	12.6	58.8	36.8	54.3	1011
<b>Байршил</b>											
Нийслэл хот	64.6	63.5	58.8	67.3	6.8	-	14.8	102.2	64.9	70.5	377
Аймгийн төв	84.5	78.0	60.9	66.7	6.9	50.0	16.5	64.0	45.2	68.8	726
Сумын төв / Баг	83.7	73.9	62.6	66.8	10.1	74.1	12.6	58.8	36.8	54.3	1011
<b>Нас</b>											
16-29 нас	76.7	76.1	61.9	66.3	6.5	66.6	15.1	62.2	45.1	72.5	706
30-39 нас	74.6	73.3	61.7	69.5	7.8	68.3	14.4	75.9	54.5	65.1	1164
40-49 нас	73.8	60.4	56.6	64.2	9.7	-	13.9	-	56.4	62.6	244
<b>Гэрлэлтийн байдал</b>											
Гэрлэсэн	76.4	70.5	62.2	65.4	8.7	75.9	13.8	67.5	53.6	62.4	1675
Гэрлээгүй	59.1	53.3	33.5	73.3	7.6	-	14.5	-	40.8	72.0	103
Хамтран амьдардаг	75.9	77.4	63.1	71.7	4.7	-	17.0	-	48.2	84.2	336
<b>Яс үндэс</b>											
Халх	73.5	71.6	60.2	68.4	7.9	68.6	13.2	84.1	53.1	69.9	1651
Казак	90.5	60.7	72.8	46.0	2.3	-	27.1	34.1	39.8	38.0	121
Бусад	82.7	69.2	58.5	64.2	9.2	82.4	20.7	65.8	44.8	45.2	342
<b>Боловсрол</b>											
Боловсролгүй	76.4	87.6	40.7	-	22.1	-	29.0	-	11.4	56.7	35
Бага	82.5	52.6	54.5	57.4	6.7	-	20.2	-	28.2	46.5	111
Дунд	81.2	72.7	52.8	65.4	7.5	77.7	9.6	70.0	45.0	64.1	790

Дээд	70.4	70.8	66.4	68.1	7.9	65.8	17.1	81.6	58.8	68.7	1178
<b>Ажил эрхлэлт</b>											
Ажилтай	73.9	71.9	60.0	69.1	8.7	67.5	14.0	71.6	52.0	69.0	1418
Ажилгүй	77.1	69.3	61.2	63.6	6.4	75.5	15.4	85.8	51.3	62.7	696
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>											
Ядуу	81.7	74.0	52.1	67.0	8.6	63.5	12.1	55.3	27.6	63.5	547
Дунджаас доогуур	78.1	72.0	58.5	60.4	7.8	57.2	12.7	63.5	45.1	65.7	493
Дундаж	78.2	71.3	60.3	73.0	10.0	89.3	12.7	87.0	54.7	74.8	455
Дунджаас дээгүүр	70.7	75.2	64.5	66.0	4.6	69.7	13.4	82.6	60.5	61.8	386
Чинээлэг	66.4	60.3	67.0	68.5	8.2	66.6	21.2	91.3	71.1	66.2	230

Тав хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн 97.6% төрийн өмчийн нэгдсэн эмнэлэг эсвэл Амаржих газарт, 2.1% хувийн хэвшлийн эмнэлэг эсвэл төрөх тасагт, 0.3% гэртээ эсвэл бусад газарт хүүхдээ төрүүлсэн байв. Хувийн хэвшлийн эмнэлэг эсвэл төрөх тасаг гэдэгт гадаад улсын эмнэлэгт хүүхдээ төрүүлсэн, бусад газар гэдэгт гадуур явж байгаад гудамжинд эсвэл эмнэлэг явах замдаа хүүхдээ төрүүлсэн 4 тохиолдлыг бүртгэсэн болно (Хүснэгт W.29).

Хүснэгт W.29. Эхчүүдийн хүүхдээ төрүүлсэн газар

Үзүүлэлтүүд	Эхчүүдийн хувь				Жинлээгүй Тоо
	Нэгдсэн эмнэлэг / Амаржих газар	Хувийн эмнэлэг/ төрөх тасаг	Гэртээ	Бусад	
<b>Бүгд</b>					
<b>Эдийн засгийн бүс</b>					
Баруун					
Хангай					
Төв					
Зүүн					
Улаанбаатар					
<b>Хот, хөдөө</b>					
Хот					
Хөдөө					
<b>Байршил</b>					
Нийслэл хот					
Аймгийн төв					
Сумын төв / Баг					
<b>Нас</b>					
16-29 нас					
30-39 нас					
40-49 нас					
<b>Гэрлэлтийн байдал</b>					
Гэрлэсэн					
Гэрлээгүй					
Хамтран амьдардаг					
<b>Яс үндэс</b>					
Халх					
Казак					
Бусад					
<b>Боловсрол</b>					
Боловсролгүй					
Бага					
Дунд					
Дээд					
<b>Ажил эрхлэлт</b>					

Ажилтай					
Ажилгүй					
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>					
Ядуу	98.1	0.7	0.0	1.2	661
Дунджаас доогуур	99.6	0.2	0.1	0.0	582
Дундаж	99.2	0.5	0.1	0.2	532
Дунджаас дээгүүр	99.5	0.5	0.0	0.0	448
Чинээлэг	91.4	8.6	0.0	0.0	287

### Зөвлөгөө, мэдээлэл авсан байдал

Эхчүүдийн ЖҮЭМТ үйлчилгээний хүрээнд эсвэл хүүхдээ төрүүлсний дараа хооллолт, хоол тэжээл, ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлээр зөвлөгөө авсан байдлыг нэгтгэн W.23-р хүснэгтэд харуулав. Хүүхдийн хооллолт, асаргаа, сувилгааны талаар 71.3%, хүүхдээ төрүүлсний дараа ангир уургаар амлуулах талаар 71.8%, зургаан сар хүртэл зөвхөн эхийн сүүгээр дагнан хооллох талаар 75.3% тус тус зөвлөгөө авсан байна. Эхчүүдийн талаас илүү хувь (58.4%) жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхийн хооллолт, 45.7% хүүхдэд төмрөөр баялаг хоол хүнс, 37.7% цус багадалт, түүний шалтгаан, сэргийлэлт талаар зөвлөгөө авсан байв. Мөн төрөх насны 3 эмэгтэй тутмын 1 орчим нь бага насны хүүхдэд олон найрлагат бичил тэжээлийн холимог (ОНБТБ) өгөх талаар зөвлөгөө, мэдээлэл авсан хангалтгүй дүн гарчээ (Хүснэгт W.30).

Хүснэгт W.30. Эхчүүдийн зөвлөгөө авсан байдал, мэдээллийн төрлөөр

Мэдээллийн төрөл	95%ИХ		Жинлээгүй Тоо
	Доод	Дээд	
Хүүхдийн хооллолт, асаргаа, сувилгаа			
Төрөнгүүт ангир уургаар амлуулах			
Зургаан сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллох			
Нэмэгдэл хооллолт			
Гараа угаалт			
Өндөр тунт А аминдэм өгөх			
Жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхийн хооллолт			
Зургаан сар хүрсэн хүүхдийг хөхүүлэхийн зэрэгцээ олон нэр төрлийн хүнс өгөх			
Суулгалтын үеийн хүүхдийн асаргаа			
Суулгалтын үед амаар шингэн сэлбэх уусмал өгөх			
Хүүхдэд төмрөөр баялаг хоол хүнс өгөх			
Цус багадалт, түүний шалтгаан, сэргийлэлт			
Олон найрлагат бичил тэжээлийн холимог (ОНБТБ) өгөх			

Эхчүүдийн хооллолт, хоол тэжээл, хүүхдийн асаргаа, эрүүл ахуйн дадлын талаар зөвлөгөө авсан байдлыг эдийн засгийн бүсээр харьцуулан үнэлэхэд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсан болно. Тухайлбал, Хангайн бүсийн эхчүүдийн эх, хүүхдийн хооллолт, хоол тэжээлийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл авсан байдал нь бусад бүсийн үзүүлэлтээс харьцангуй их байна. Харин Төвийн бүсийн эхчүүдийн “өндөр тунт А аминдэм өгөх” асуудлаас бусад чиглэлээр зөвлөгөө авсан байдал нь хамгийн бага байв. Ялангуяа хүүхдэд ОНБТБ, төмрөөр баялаг хоол, хүнс өгөх талаар зөвлөгөө авсан эхчүүдийн хувь бусад бүсийн үзүүлэлтээс 1.1–2.0 дахин бага байна (Хүснэгт W.31).

Хүснэгт W.31. Эхчүүдийн зөвлөгөө авсан байдал, бүсээр

Мэдээллийн төрөл	Зөвлөгөө, мэдээлэл авсан эхчүүд, %				
	Баруун	Хангай	Төв	Зүүн	УБ
Хүүхдийн хооллолт, асаргаа, сувилгаа					
Төрөнгүүт ангир уургаар амлуулах					
Зургаан сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллох					
Хүүхдийг бор хоолонд оруулах, нэмэгдэл хооллолт					
Гараа угаалт					
Өндөр тунт А аминдэм өгөх					
Жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхийн хооллолт					
Зургаан сар хүрсэн хүүхдийг хөхүүлэхийн зэрэгцээ олон нэр төрлийн хүнс өгөх					
Суулгалтын үеийн хүүхдийн асаргаа					
Суулгалтын үед амаар шингэн сэлбэх уусмал өгөх					
Хүүхдэд төмрөөр баялаг хоол хүнс өгөх					
Цус багадалт, түүний шалтгаан, сэргийлэлт					
Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл өгөх					

Эхчүүдийн жирэмсэн эмэгтэй, хөхүүл хүүхэдтэй эх, нялх, бага насны хүүхдийн хооллолт, хоол тэжээлийн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл авсан эх сурвалжийг судлахад 61.1% сум, өрхийн ЭМТ, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн ЭМТ-ийн эмч, сувилагч, эрүүл мэндийн нийгмийн ажилтнаас, 44.0% эх барих, эмэгтэйчүүдийн эмчээс, 12.6% нярайн эсвэл хүүхдийн эмчээс, 10.4% бусад эх сурвалжийг нэрлэсэн байна. Бусад эх сурвалжийг тодруулахад талаас илүү хувь нь нийгмийн сүлжээ (29.6%), эсвэл мэдээллийн хэрэгсэл (28.8%)-ээс авсан байв. Зөвлөгөө, мэдээлэл авсан эх сурвалжийг дараах хүснэгтэд нэгтэн харуулав (Хүснэгт W.32).

Хүснэгт W.32. Эхчүүдийн зөвлөгөө, мэдээллэл авсан эх сурвалж

Мэдээллийн эх сурвалж	95%ИХ		Жинлээгүй Тоо
	Доод	Дээд	
Эх барих, эмэгтэйчүүдийн эмч			
Нярайн / хүүхдийн эмч			
Хоол зүйч			
Сум, Өрх, дүүргийн ЭМТ, аймгийн НЭ-ийн эмч, ЭМА			
Сургагдсан зөвлөгч			
Гэр бүл / хамаатан садан			
Бусад жирэмсэн эмэгтэй			
Бусад эх сурвалж			
Интернет			
Нийгмийн сүлжээ: фэйсбүүк			
Мэдээллийн хэрэгсэл: ТВ			
Эх, хүүхдийн ЭМ-ийн дэвтэр / Жирэмсний хөтөч			
Сургалт: Албан / албан бус төлбөртэй сургалт			
Сургалтын материал: МСС-ний материал / ном			

Нялх, бага насны хүүхэддээ эхчүүдийн өгсөн анхны нэмэгдэл хоолыг W.25-р хүснэгтэд нэгтгэн харуулав. Нийт эхчүүдийн дийлэнх нь хүүхэддээ бантан (26.1%), хүүхдийн будааны агшаамал (20.4%), тараг (14.4%), цагаан будааны шүүс (9.5%), төрөл бүрийн зутан (9.5%) өгч нэмэгдэл хоолонд оруулсан байна. Бага насны хүүхдэд бантан, хүүхдийн будааны агшаамал өгч нэмэгдэл хоолонд оруулах дадал бүс нутаг, байршил, насны бүлгээс үл харгалзан түгээмэл байв. Тараг өгч хүүхдээ нэмэгдэл хоолонд оруулсан тохиолдол эхчүүдийн боловсролын түвшнээр ялгаатай, дээд боловсролтой эхчүүдэд боловсролгүй, бага болон дунд боловсролтой эхчүүдийн үзүүлэлтээс 2.7–4.5 дахин их байна ( $p < 0.0001$ ). Хүүхдэд бантан өгч нэмэгдэл хоолонд оруулах дадал Зүүн бүс, хөдөө орон нутаг (36.2%), боловсролгүй (49.0%), бага / суурь боловсролтой (36.7%), гэрлээгүй эхчүүдийн дунд харьцангуй их, харин хот суурин газар эмэгтэйчүүдийн хүүхэддээ өгсөн анхны нэмэгдэл хоол нь хар шөл (21.0%), хүүхдийн будааны агшаамал байсан бол халх (27.3%; 20.6%) болон бусад ястан (23.7%; 19.7%) эхчүүд бантан, хүүхдийн будааны агшаамал өгсөн байв. Мөн дээд боловсролтой эхчүүдийн хүүхэддээ өгсөн анхны нэмэгдэл хоол нь үйлдвэрийн эсвэл гэрийн нөхцөлд бэлдсэн жимс, ногооны нухаш, Нан, Миласан гэх мэт брэндийн хүүхдийн хоол (7.4%) байсан нь боловсролгүй, бага/суурь боловсролтой (1.3%) эхчүүдээс илүү байв. Өрхийн аж байдлын түвшин дээшлэхэд хүүхдэд өгсөн анхны нэмэгдэл хоол нь бантан бус, төрөл бүрийн зутан (13.1%), тараг (23.2%) өгсөн эхчүүдийн хувь нэмэгдэж байна ( $p < 0.0001$ ). Харин аж байдлын түвшин доогуур өрхийн эхчүүд (45.6%) хүүхэддээ ихэвчлэн бантан өгч нэмэгдэл хоолонд оруулжээ (Хүснэгт W.33).



Хүснэгт W.33. Эхчүүдийн хүүхэддээ өгсөн анхны нэмэгдэл хоол

Үзүүлэлтүүд	Бантан	Махны шөл	Зутан	Тараг	Сүү	Хүүхдийн будааны агшаамал /каша/	Цагаан будааны шүүс	Нэмэгдэл хоол өгөөгүй	Бусад хоол, хүнс	Жинлээгүй Тоо
<b>Бүгд</b>										
<b>Эдийн засгийн бүс</b>										
Баруун										
Хангай										
Төв										
Зүүн										
Улаанбаатар										
<b>Хот, хөдөө</b>										
Хот										
Хөдөө										
<b>Байршил</b>										
Нийслэл хот										
Аймгийн төв										
Сумын төв / баг										
<b>Нас</b>										
16-29 нас										
30-49 нас										
<b>Гэрлэлтийн байдал</b>										
Гэрлэсэн										
Гэрлээгүй										
Хамтран амьдардаг										
<b>Яс үндэс</b>										
Халх										
Казак										
Бусад										

<b>Боловсрол</b>										
Боловсролгүй / бага										
Дунд										
Дээд										
<b>Ажил эрхлэлт</b>										
Ажилтай										
Ажилгүй										
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>										
Ядуу	45.6	4.4	5.1	7.2	11.0	16.7	2.7	3.9	3.3	655
Дунджаас доогуур	32.3	5.7	12.0	8.6	3.4	22.2	9.3	2.7	3.7	576
Дундаж	24.8	8.3	7.3	16.6	4.1	19.5	9.7	1.0	8.8	527
Дунджаас дээгүүр	25.5	3.8	10.5	17.0	1.4	21.8	10.2	6.2	3.6	440
Чинээлэг	3.8	6.5	13.1	23.2	0.6	23.0	16.1	2.8	10.7	284

Судалгаагаар эхчүүдээс хүүхдийг эхийн сүүгээр дагнан хооллох хугацаа, нэмэгдэл хоолонд оруулах нас, бага насны хүүхдийг хооллох давтамжийн талаар асууж, хүүхдийн хооллолтын талаарх ойлголтыг тодруулсан болно. Нялх, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөмжид 6 сар хүртэл зөвхөн эхийн сүүгээр дагнан хооллох, 6 сартайгаас нэмэгдэл хоол өгч эхлэх талаар зөвлөсөн байдаг. Мөн 6 сараас дээш насны хүүхдэд хамгийн багадаа 2 удаа хоол, 1 удаа хөнгөн зууш өгөхийг зөвлөдөг. Нялх, бага насны хүүхдийн хооллолтын талаар зөв ойлголттой эхчүүдийн үзүүлэлтийг W.27–р хүснэгтэд нэгтгэн харуулав.

Нийт эхчүүдийн 83.6% нялх хүүхдийг 6 сар хүртэл зөвхөн эхийн сүүгээр дагнан хооллоно гэсэн зөв ойлголттой байна. Нялх хүүхдийг эхийн сүүгээр дагнан хооллох хугацааны талаар зохих ойлголттой эхчүүдийн хувь өрхийн аж байдлын түвшин, бүс нутаг, боловсролын түвшнээр ялгаатай байна ( $p=0.02$ ,  $p=0.01$ ). Тодруулбал, өрхийн аж байдлын түвшин дээгүүр (87.7%)-ийн дунд зохих мэдлэгтэй эмэгтэйчүүдийн хувь харьцангуй их, харин аж байдлын түвшин доогуур өрх (75.5%), Баруун бүс (71.8%), бага эсвэл суурь боловсрол (73.5%)-той эхчүүдэд уг үзүүлэлт бага байв (Хүснэгт W.34).

Хүснэгт W.34. Бага насны хүүхдийн хооллолтын талаар зохих ойлголттой эхчүүд

Үзүүлэлт	Эхийн сүүгээр дагнан хооллох хугацаа			Нэмэгдэл хоол өгч эхлэх нас			≥6 сартай хүүхдийг хооллох давтамж			Жинлээгүй Тоо
	%	95%ИХ		%	95%ИХ		%	95%ИХ		
		Доод	Дээд		Доод	дээд		Доод	дээд	
<b>Бүгд</b>	<b>83.6</b>	<b>80.5</b>	<b>86.2</b>	<b>79.6</b>	<b>76.5</b>	<b>82.3</b>	<b>77.4</b>	<b>74.3</b>	<b>80.3</b>	<b>2513</b>
<b>Эдийн засгийн бүс</b>										
Баруун	71.8	60.2	81.1	70.6	59.2	79.9	56.5	46.6	65.9	516
Хангай	85.1	80.7	88.6	84.6	79.9	88.4	73.5	67.3	78.9	483
Төв	86.4	79.0	91.4	76.3	69.2	82.1	82.0	75.3	87.2	524
Зүүн	82.6	72.2	89.7	77.8	67.9	82.1	77.6	67.0	85.6	489
Улаанбаатар	85.3	80.3	89.2	81.3	76.4	85.3	82.6	77.5	86.7	501
<b>Хот, хөдөө</b>										
Хот	84.3	80.4	87.5	80.4	76.6	83.7	79.4	75.4	82.9	1335
Хөдөө	81.8	76.5	86.1	77.5	72.0	82.2	72.5	67.0	77.3	1178
<b>Байршил</b>										
Нийслэл хот	85.3	80.3	89.2	81.3	76.4	85.3	82.6	77.5	86.7	501
Аймгийн төв	82.0	75.3	87.1	78.4	72.1	83.6	72.2	65.8	77.7	834
Сумын төв / Баг	81.8	76.5	86.1	77.5	72.0	82.2	72.5	67.0	77.3	1178
<b>Нас</b>										
1629 нас	80.1	74.1	85.0	78.5	72.0	83.7	75.7	70.2	80.4	840
3039 нас	86.0	82.8	88.7	80.7	77.4	83.5	78.0	74.9	80.8	1381
4049 нас	84.8	76.5	90.5	79.6	70.8	86.2	79.0	71.6	84.9	292
<b>Гэрлэлтийн байдал</b>										
Гэрлэсэн	84.9	82.1	87.4	79.8	76.6	82.6	78.4	74.7	81.6	1973
Гэрлээгүй	83.2	70.9	91.0	85.6	75.7	91.9	64.2	48.3	77.5	135
Хамтран амьдардаг	78.6	69.4	85.6	76.7	67.6	83.9	78.9	73.1	83.6	405
<b>Яс үндэс</b>										


Халх	84.3	80.8	87.2	80.1	76.8	83.1	79.0	75.4	82.1	1942
Казак	69.4	50.2	83.6	68.4	50.7	82.0	56.3	40.1	71.3	165
Бусад	82.6	73.9	88.8	78.9	70.3	85.5	72.3	63.7	79.6	406
<b>Боловсрол</b>										
Боловсролгүй	82.0	67.7	90.8	72.9	56.9	84.6	52.6	34.9	69.6	51
Бага	73.5	55.0	86.3	69.7	51.1	83.5	66.0	48.5	80.0	141
Дунд	79.2	72.7	84.6	75.4	69.8	80.3	76.5	70.2	81.7	935
Дээд	87.7	84.6	90.2	83.7	80.4	86.5	79.8	76.5	82.8	1386
<b>Ажил эрхлэлт</b>										
Ажилтай	82.2	78.1	85.7	79.3	75.5	82.6	78.0	74.8	80.9	1666
Ажилгүй	85.7	81.2	89.2	80.0	75.5	83.9	76.5	70.6	81.4	847
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>										
Ядуу	75.5	67.9	81.9	73.3	65.6	79.7	75.1	68.3	80.8	661
Дунджаас доогуур	83.0	76.5	87.9	81.3	74.8	86.4	71.1	63.1	77.9	582
Дундаж	83.5	74.8	89.6	74.1	65.2	81.4	76.0	69.0	81.8	532
Дунджаас дээгүүр	89.4	84.4	92.9	85.4	80.1	89.4	78.9	71.5	84.8	448
Чинээлэг	86.4	80.6	90.7	83.9	78.0	88.4	86.4	82.0	89.8	287

Тав хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн 79.6% “хүүхдийг 6 сар хүрмэгц нэмэгдэл хоол өгч эхэлнэ”, 77.4% нь “6 сар ба түүнээс дээш настай хүүхдийг өдөр 3–5 удаа” хооллох шаардлагатай гэсэн зөв ойлголттой байна. Нялх хүүхдийг нэмэгдэл хоолонд оруулах насны талаар зөв ойлголттой эхчүүдийн хувь дээд боловсролтой эмэгтэйчүүд, Хангайн бүс, Улаанбаатар хотод статистик ач холбогдол бүхий өндөр, боловсролгүй, бага эсвэл суурь боловсролтой эмэгтэйчүүд, Баруун болон Төвийн бүсэд бага байв. Зургаан сар ба түүнээс дээш настай нялх хүүхдийг өдөрт хооллох давтамжийн талаар зохих ойлголттой эхчүүдийн үзүүлэлтэд бүс нутаг ( $p < 0.0001$ ), байршил ( $p = 0.003$ ), яс үндэс ( $p = 0.003$ ), боловсролын түвшин ( $p = 0.04$ )-ээр статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсан болно. Тухайлбал, Казак эмэгтэйчүүд (56.3%), хөдөө орон нутаг (72.5%), Баруун бүс (56.5%), боловсролгүй, бага эсвэл суурь боловсролтой (52.6%–66.0%) эхчүүдийн дунд зохих ойлголттой эмэгтэйчүүдийн хувь харьцангуй бага, харин Улаанбаатар хот (82.6%), Төвийн бүс (82.0%), хот суурин газрын (79.4%) эмэгтэйчүүд, дээд боловсролтой (79.8%) эхчүүдэд уг үзүүлэлт өндөр байна (Хүснэгт W.34).

## ХЭЛЦЭМЖ


### Хоол тэжээлийн байдал

Судалгаагаар төрөх насны эхчүүдийн 53.0% илүүдэл жин ба таргалалттай байгаа нь “Монголын хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний V судалгааны дүн (46.2%)-гээс 6.8 пунктээр өссөн байна. Мөн илүүдэл жин ба таргалалтын тархалт эхчүүдийн наснаас шууд хамаарч нэмэгдэх хандлагатай байгаа нь хоол тэжээлийн өмнөх судалгааны үр дүнтэй дүйж байна (Зураг W.4).




Зураг W.4: Илүүдэл жин ба таргалалттай эхчүүд (БЖИ $\geq$ 25.0 кг/м<sup>2</sup>)

Төрөх насны эхчүүдийн дунд хоол тэжээлийн дутал буюу тураалын тархалт буурсан хэдий ч, илүүдэл жин, таргалалтын тархалт тасралтгүй нэмэгдэж байгаа нь тулгамдсан асуудал болж байна.



Зураг W.5: Эхчүүдийн дундах илүүдэл жин ба таргалалтын тархалт, оноор

Хоол тэжээлийн үндэсний V судалгааны дүн (2017 он)-гээр хот (44.3%), хөдөөгийн (50.1) эхчүүдийн дунд илүүдэл жин ба таргалалтын тархалт ялгаатай байсан бол энэ удаагийн судалгааны дүнгээр тус үзүүлэлтийн тархалтад хот, хөдөөгийн болон бүс нутгийн ялгаа ажиглагдаагүй бөгөөд аль ч бүс нутгийн эмэгтэйчүүдийн дунд илүүдэл жин, таргалалтын тархалт жигд нэмэгдсэн байв. “Монголын хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний VI судалгааны дүнг 2017 оны үндэсний V судалгааны үр дүнтэй харьцуулан W.6 зурагт дүрслэн харуулав.



Зураг W.6: Илүүдэл жин ба таргалалттай эхчүүд, бүс нутаг ба оноор


Хоол тэжээлийн үндэсний V судалгаанаас хойшхи жилүүдэд 15-49 насны эхчүүдийн дунд илүүдэл жин ба таргалалтын тархалт Улаанбаатар хотод 9.5, Төвийн бүсэд 8.3 пунктээр тус тус нэмэгдсэн бол Баруун бүсэд төдийлөн өөрчлөгдөөгүй, Хангайн болон Зүүн бүсэд бага зэрэг өссөн байна (Зураг W.5).

Хоол тэжээлийн үндэсний V судалгаагаар 15-49 насны эхчүүдийн дунд намхан, намхавтар эмэгтэйчүүдийн тархалтыг сонгосон үзүүлэлтээр харьцуулан судалж, нийт эхчүүдийн 1.3% Энэхүү судалгаагаар намхан (0.9%, 95% ИХ 0.5–1.4), намхавтар (5.1%, 95% ИХ 4.0–6.4) эмэгтэйчүүдийн хувь 0.4; 3.5 пунктээр тус тус буурсан байна.


### **Бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглээ**

Судалгаагаар Төрөх насны эхчүүдийн бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглээг сүүлийн нэг жилийн байдлаар болон судалгаанд сонгогдсон хүүхдийг тээх үеийн хэрэглээгээр ялган үнэлсэн болно. Нийт эхчүүдийн 55.3% сүүлийн 1 жилийн хугацаанд, 80.3% сонгогдсон хүүхдийг тээж байхдаа ямар нэг төрлийн аминдэм, эрдсийн бэлдмэл хэрэглэсэн байв. Энэхүү үр дүнг Хоол тэжээлийн үндэсний V судалгааны дүнтэй харьцуулан үзвэл, сүүлийн

1 жилд бичил тэжээлийн бэлдмэл хэрэглэсэн эхчүүдийн хувь 1.4 дахин нэмэгдсэн, харин сүүлийн жирэмслэлтийн явц дахь аминдэм, эрдсийн бэлдмэлийн хэрэглээ төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Сүүлийн 1 жилийн хугацаанд бичил тэжээлийн бэлдмэл хэрэглэсэн эхчүүдийн хувь нийт бүс нутагт нэмэгдсэн хэдий ч, Хангай болон Зүүн бүсэд хамгийн их, төвийн бүсэд хамгийн бага өссөн байгааг Зураг W.8-аас харж болно (Зураг W.7,8).



Зураг W.7. Эхчүүдийн бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглээ, оноор




Зураг W.8. Сүүлийн 1 жилд бичил тэжээлийн бэлдмэл хэрэглэсэн эхчүүд, бүс ба оноор

ДЭМБ болон ЭМС-ын 2020 оны 490 дүгээр тушаалд жирэмслэлтийн явцад эмэгтэйчүүд хамгийн багадаа 180 хоног аминдэм, эрдсийн бэлдмэл хэрэглэхийг зөвлөсөн. Энэхүү судалгааны дүнгээр эхчүүд жирэмсний хугацаанд аминдэм, эрдсийн бэлдмэлийг дунджаар 67–70 хоног хэрэглэсэн байгаа нь ДЭМБ болон МУ-ын үндэсний зөвлөмжийн шаардлагад хүрэхгүй, хангалтгүй хэрэглэсэн төдийгүй, 2017 оны түвшин (60.0 хоног, ХТҮС V)-ээс төдийлөн нэмэгдээгүй байна.

### Жирэмсэн үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хамрагдалт

Судалгаанд сонгогдсон хүүхдийг тээж байх үедээ эхчүүд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хэрхэн хамрагдсан байдалд үнэлгээ өгөв. Бараг бүх эхчүүд (98.6%) эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр мэргэшсэн, эсвэл ерөнхий мэргэжлийн эмчийн хяналтад хамрагдаж ЖҮЭМТ үйлчилгээ авсан байв. Мөн эхчүүдийн 90 орчим хувь жирэмсний эхний 3 сард эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдаж, ЖҮЭМТ авсан нь өмнөх судалгааны үзүүлэлтээс сайжирсан болохыг илтгэж байна (Зураг W.9).



Зураг W.9: Эхчүүдийн ЖҮЭМТ-д хамрагдсан хугацаа, судалгааны оноор

Хоол тэжээлийн үндэсний V судалгааны тайланд эхчүүдийн 94.3% сүүлийн жирэмслэлтийн хугацаанд 4 ба түүнээс олон удаа жирэмсний үзлэг, хяналтад хамрагдсан гэж мэдээлсэн байдаг. Тус үзүүлэлт 2023 оны байдлаар 93.9% байгаа ойролцоо үр дүн гарсан байна.

### Эхчүүдийн бичил тэжээлийн байдал

Нийт эхчүүдийн 16.3% цус багадалттай байгаа бөгөөд хоол тэжээлийн үндэсний V судалгааны дүн (16.2%)-гээс төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Төрөх насны эхчүүдийн 0.1% хүнд (n=4), 4.9% хүндэвтэр (n=130), 11.3% хөнгөн (n=307) хэлбэрийн цус багадалттай байгаа нь 2017 оны судалгааны дүнтэй харьцуулахад, нийт цус багадалтын тархалт нэмэгдээгүй хэдий ч, хүнд цус багадалтын тохиолдол бүртгэгдсэн төдийгүй, хүндэвтэр хэлбэрийн цус багадалт ялимгүй өссөн байна.

Цус багадалтын тархалтыг сонгосон үзүүлэлтээр харьцуулан судлахад Казак эмэгтэйчүүдэд 25.5%, боловсролгүй, бүрэн бус бага эсвэл суурь боловсролтой эхчүүдийн дунд 26.2% байгаа нь тархалтын хамгийн өндөр үзүүлэлт байв. Энэхүү үр дүнг 2017 оны судалгааны дүнтэй харьцуулан үзвэл ижил төстэй байдал ажиглагдсан болно. Тодруулбал, хоол тэжээлийн үндэсний V судалгаагаар Казак эмэгтэйчүүдийн дунд цус багадалтын тархалт

ДЭМБ-аас гаргасан цус багадалт, бичил тэжээлийн дутлын тархалтын нийгмийн эрүүл мэндийн нөлөөг үнэлэх шалгуурыг ашиглан эхчүүдийн дундах бичил тэжээлийн дутлын тархалтыг үнэлж, хүснэгт W.35 нэгтгэн харуулав.

Хүснэгт W.35: Эхчүүдийн дундах бичил тэжээлийн дутлын тархалтыг ДЭМБ-ын шалгуураар үнэлсэн дүн [19] [69] [70] [71]



Бичил тэжээлийн дутал	Тархалт, %	ДЭМБ-ын шалгуур, %	НЭМ-ийн ач холбогдол Үнэлгээ
Цус багадалт, нийт	16.3	5.0 – 19.9	Хөнгөн зэрэг
Төмөр дутлын цус багадалт	5.6	5.0 – 19.9	Хөнгөн зэрэг
Төмөр дутал (ферритийн түвшнээр)	15.2	< 20.0	Хөнгөн зэрэг
Төмөр дутал (γТФР-ийн түвшнээр)	7.5	< 10.0	Түгээмэл бус тархалт
А аминдэм дутал / нөөц дутмаг	1.3	< 2.0	Хэвийн түвшин
Д аминдэм дутал	70.6	-	Маш түгээмэл “НЭМ-ийн асуудал”


ДЭМБ-аас Д аминдэм дутлын тархалтыг үнэлэх шалгуурыг гаргаагүй хэдий ч, бичил тэжээлийн дутлын түвшин 20% ба түүнээс их байвал НЭМ-ийн тулгамдсан асуудал гэж үнэлдэг олон улсын жишиг байдаг. Үүнээс үзвэл Д аминдэм дутал Төрөх насны эхчүүдийн дунд маш түгээмэл, НЭМ-ийн тулгамдсан асуудал хэвээр байгааг илтгэж байна.

Хоол тэжээлийн үндэсний V судалгаагаар цус багадалтын тархалт Баруун бүсэд (23.8%) харьцангуй их байсан бол, энэ удаагийн судалгаагаар Зүүн бүсэд хамгийн өндөр тархалт (21.9%) илэрсэн болно (Зураг W.6).



Зураг W.6: Эхчүүдийн дундах цус багадалтын тархалт, бүс нутаг ба оноор

Хоол тэжээлийн үндэсний V судалгаа (2017 он)-гаар дэлхийн Хүнс хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ)-ын аргачлалыг ашиглан эхчүүдийн дунд хоногт хэрэглэвэл зохих хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан тохиолдлын тархалтыг тогтоосон байдаг.[72] Тус судалгааны дүнгээр 15–49 насны эхчүүдийн 70.2% хоногт хэрэглэвэл зохих хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлагыг хангасан хооллолттой байжээ. Мөн хоногт хэрэглэвэл зохих хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлагыг хангасан хооллолттой эхчүүдийн хувь тэдний оршин суугаа орон нутгийн байршлаар ялгаатай, хотод 74.8%, хөдөөд 61.1% байгааг тогтоосон байдаг (Зураг W.7).



Зураг W.7: Хоногт хэрэглэвэл зохих хүнсний бүтээгдэхүүний хамгийн бага шаардлагыг хангасан хооллолттой эхчүүд, судалгааны он ба байршлаар

Энэхүү судалгаагаар хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан хооллолттой эхчүүдийн хувь өмнөх судалгааны дүнгээс төдийлөн өөрчлөгдөөгүй (68.1%), байршлаар харьцуулан судлахад статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдаагүй болно.

“Дэлхийн хооллолтын чанар” төслийн хүрээнд боловсруулсан стандарт аргачлалын дагуу хооллолтын чанарын үнэлгээг 2020–2021 онд зохион байгуулсан Ази, Номхон далайн бүсийн 11 улсын дундаж үзүүлэлттэй харьцуулахад манай улсын төрөх насны эмэгтэйчүүдийн хооллолтын чанарын үзүүлэлтүүд хангалтгүй, ХБӨ-өөс сэргийлэх эрүүл хүнсний хэрэглээг илтгэх дундаж оноо Ази, Номхон далайн орнуудын дундаж (2.9–4.7) үзүүлэлтийн доод хязгаар (3.2)-т байна (Хүснэгт W.36).

Хүснэгт W.36: Эхчүүдийн хооллолтын чанарын зарим үзүүлэлтийг Ази, Номхон далайн орнуудын дундаж үзүүлэлттэй харьцуулсан дүн

Хооллолтын чанарын үзүүлэлтүүд	Ази, номхон далайн бүс	Монгол Улс
5 нэр төрлийн хүнсний хэрэглээ (All-5)	21% – 60%	14.3%
ХБӨ-ий эсрэг хамгаалалт, оноо (NCD-Protect )	2.9 – 4.7	3.2
ХБӨ-ий эрсдэл, оноо (NCD-Risk)	1.5 – 3.2	4.0

Ази, Номхон далайн орнуудын эхчүүдийн хийжүүлсэн ундааны хэрэглээ 7%–45% байгаа бол манай улсын 5 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн хэрэглээ 29.9% байв. Мөн манай улсын 15–49 насны эхчүүдийн дөнгөж 22.0% вандуй, шош, төрөл бүрийн самар, үр хэрэглэж байгаа нь “Дэлхийн хооллолтын чанар” төслийн 2022 оны тайланд дурьдсан бусад орны үзүүлэлт (Казакстан–31%, ОХУ–33%, Мексик–75%, Никарагуа–88%)–ээс 1.4–3.4 дахин бага байна [26].

## Дүгнэлт

1. Нийт эхчүүдийн талаас илүү хувь илүүдэл жин ба таргалалттай, 18.0% тарган байна. Илүүдэл жин ба таргалалтын тархалт 40–49 насны эхчүүд, гэрлэсэн эмэгтэйчүүдийн дунд харьцангуй их, харин эдийн засгийн бус, орон нутгийн байршил, үндэс угсаа зэрэг бусад сонгосон үзүүлэлтээр ялгаатай бус жигд өндөр байв.
2. Төрөх насны эхчүүдийн 16.3% цус багадалттай, тэдний дийлэнх хувь хөнгөн хэлбэрийн цус багадалттай байв. Цус багадалтын тархалт Казак эмэгтэйчүүд, боловсролгүй эсвэл бүрэн бус бага боловсролтой эхчүүдийн дунд харьцангуй өндөр байна. Эхчүүдэд тохиолдож буй цус багадалтын 39.3% төмөр дутлын шалтгаантай, нийт эхчүүдийн 5.6% төмөр дутлын цус багадалттай байв.
3. Судалгаагаар эхчүүдийн 15.2% тохируулга хийсэн ферритиний, 7.5% уусдаг трансферрин рецепторийн түвшнээр төмөр дуталтай, 9.2% бие дэх төмрийн нөөц дутмаг байгааг илрүүлэв. Хоёр төрлийн биомаркераар үнэлсэн төмөр дутлын тархалт Казак эмэгтэйчүүд, гэрлээгүй эхчүүдийн дунд харьцангуй түгээмэл байна.
4. Төрөх насны эхчүүдийн 70.6% Д аминдэм дуталтай, 19.6% Д аминдэмийн нөөц дутмаг байдалд байна. Харин 5 эх тутмын 4 нь А аминдэмийн хангалттай нөөцтэй, 18.6% А аминдэм нөөц дутмаг эсвэл дуталтай байв.
5. Тав хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн 14.3% хоногт хэрэглэвэл зохих 5 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг бүгдийг хэрэглэсэн, 68.1% хоногт хэрэглэвэл зохих хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан хооллолттой байна.
6. Эхчүүдийн дунд ХБӨ-өөр өвчлөх эрсдэлээс хамгаалдаг эрүүл хүнсний хэрэглээ туйлын хангалтгүй, харин ХБӨ-ий эрсдэлд хүргэдэг эрүүл бус хүнсний хэрэглээ түгээмэл, хоногт хэрэглэвэл зохих 5 нэр төрлийн хүнс хэрэглэсэн эхчүүдийн хувь Ази, Номхон далайн бүсийн 11 орны дундаж үзүүлэлтээс харьцангуй доогуур байв.
7. Төрөх насны эхчүүдийн 55.3% сүүлийн нэг жилийн хугацаанд ямар нэг төрлийн аминдэм, эрдсийн бэлдмэл хэрэглэсэн бөгөөд тэдний дөнгөж 12.1% олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг дунджаар 54.4 хоног, 66.7% Д аминдэмийг дунджаар 92.4 хоног хэрэглэсэн байна.
8. Нийт эхчүүдийн 86.1% жирэмсний эхний 3 сарын хугацаанд жирэмсэн үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан бөгөөд дунджаар 7.5 удаа жирэмсний хяналтын үзлэгт хамрагдсан байв. Төрөх насны эхчүүдийн 93.9% ДЭМБ-ын зөвлөмжид зааснаар жирэмсний хугацаанд  $\geq 4$  удаа, 79.1% нь  $\geq 6$  удаа эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, тусламж авсан байна. Судалгаанд сонгогдсон хүүхдийг тээж байхдаа эхчүүдийн 75.1% төмөр, фолийн хүчлийн холимог, 60.4% фолийн хүчил, 51.7%

жирэмсэн эмэгтэйд зориулсан нийлмэл найрлагатай бичил тэжээлийг бэлдмэлийг тус тус хэрэглэсэн байв.

9. Эхчүүдийн 80 орчим хувь хүүхдийг эхийн сүүгээр дагнан хооллох хугацаа, нэмэгдэл хоолонд оруулах нас, хооллох давтамжийн талаар зохих ойлголттой, тэдний 26.4% бантан, 20.6% хүүхдийн будаа, 14.6% таргаар нэмэгдэл хоолонд оруулсан байна.
10. Төрөх насны эмэгтэйчүүдийн 61.1% сум, өрх, дүүргийн ЭМТ, аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч, эрүүл мэндийн мэргэжилтэн, 44.0% эх барих, эмэгтэйчүүдийн эмч, 12.6% нярай, хүүхдийн эмчээс, 10.4% бусад эх сурвалжаас эх, хүүхдийн хооллолт, хоол тэжээлийн талаар зөвлөгөө, мэдээлэл авсан байв. Бусад эх сурвалжаас мэдээлэл авсан эхчүүдийн 29.6% нийгмийн сүлжээ, фэйсбүүк, 28.8% телевиз, радио, цахим сэтгүүл зэрэг мэдээллийн хэрэгсэл, 15.6% эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, эсвэл жирэмсний хөтчөөс эрүүл мэндийн мэдээлэл авсан байна.

## ТҮҮВРИЙН БАЙДАЛ

Хоол тэжээлийн үндэсний VI судалгаанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн түүврийн шинж байдлыг нэгтгэн PW.1-р хүснэгтэд харуулав. Судалгаанд 15-49 насны 2796 жирэмсэн эмэгтэй хамрагдсан бөгөөд тэдний 14.2% жирэмсний эхний 3 сартай, 42.3% жирэмсний 2 дахь 3 сартай, 43.5% жирэмсний сүүлийн 3 сартай эмэгтэйчүүд байв. Байршлаар нь авч үзвэл жирэмсэн эмэгтэйчүүдийн дийлэнх буюу 68.1% хот суурин газар, 31.9% хөдөө, орон нутагт амьдарч байна. Жирэмсэн эмэгтэйчүүдийн судалгааны түүвэрт эдийн засгийн 4 бүс, Улаанбаатар хотын төлөөлөл багтсан болно.

### Хүснэгт PW.1 Жирэмсэн эмэгтэйчүүдийн түүврийн байдал

Үзүүлэлт	Жинлэсэн хувь	Жинлээгүй тоо
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>2796</b>
<b>Насны бүлэг</b>		
< 20 нас	2.9	83
20-29 нас	45.6	1254
30-39 нас	47.1	1340
40-49 нас	4.5	119
<b>Бүсээр</b>		
Баруун	14.0	560
Хангай	17.5	547
Төв	14.7	560
Зүүн	7.8	567
Улаанбаатар	45.9	562
<b>Хот, хөдөөгөөр</b>		
Хот	68.1	1488
Хөдөө	31.9	1308
<b>Байршил</b>		
Нийслэл хот	45.9	562
Аймгийн төв	22.1	926
Сум/Баг	31.9	1308
<b>Яс үндэс</b>		
Халх	76.9	2150
Казак	7.1	198
Бусад	16.0	448
<b>Боловсрол</b>		
Боловсролгүй	1.0	40
Бага	3.8	126
Дунд	38.4	1125
Дээд	56.7	1504
<b>Ажил эрхлэлтийн байдал</b>		
Ажилтай	71.3	2050
Ажилгүй	28.7	746
<b>Гэрлэлтийн байдал</b>		
Гэрлэсэн	64.1	1892
Гэрлээгүй	6.2	152
Хамтран амьдардаг	29.7	752
<b>Жирэмсний хугацаа</b>		
Эхний 3 сар	14.2	367

Дунд 3 сар	42.3	1177
Сүүлийн 3 сар	43.5	1221

Хүснэгт PW.2-т судалгаанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн дийлэнх хувь (93.7%) хүүхдийнхээ эцэгтэй хамт амьдарч байв. Харин хүүхдийн эцгээс тусдаа амьдардаг эмэгтэйчүүд Хангайн бүс болон Улаанбаатарт (6.7%,7.5%) харьцангуй илүү байна.

Хүснэгт PW.2. Хүүхдийн эцгийн оршин суугаа газар

Үзүүлэлт	Жинлэсэн хувь	Жинлээгүй тоо
<b>Бүгд</b>	<b>100</b>	<b>2797</b>
<b>Хүүхдийнхээ эцэгтэй хамт амьдардаг эсэх</b>		
Хамт амьдардаг	93.7	2615
Тусдаа амьдардаг	6.3	148
<b>Тусдаа амьдардаг</b>		
Баруун	2.9	560
Хангай	6.7	547
Төв	5.3	560
Зүүн	5.2	567
Улаанбаатар	7.5	562
<b>Тусдаа амьдардаг</b>		
Хот	6.9	1488
Хөдөө	4.9	1308

### Хоол тэжээлийн байдал

Жирэмсэн эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн байдлыг зүүн гарын бугалганы дунд хэсгийн тойрог (БДХТ)-ийн хэмжээ болон биеийн өндрийн үзүүлэлтээр тодорхойлсон. Жирэмслэлтээс шалтгаалан эмэгтэйн зүүн гарын БДХТ-ийн үзүүлэлт 0.05 см-ээс бага хэмжээгээр өөрчлөгддөг тул уг хэмжигдхүүнийг ашиглан тухайн эмэгтэйн жирэмслэхээс өмнөх үеийн хоол тэжээлийн байдлыг тодорхойлох жишиг үзүүлэлт болгон ашигладаг. Жирэмсэн эмэгтэйн зүүн гарын БДХТ-ийн хэмжээ бага эсвэл хэт намхан байвал бага жинтэй хүүхэд төрүүлэх, ургийн өсөлт саатах эрсдэл нэмэгддэг байна. Судалгаагаар зүүн гарын БДХТ-ийн хэмжээ 22.5 см-ээс бага байгаа тохиолдол (1.5%) жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд харьцангуй бага байгааг тогтоов. Зүүн гарын БДХТ-ийн хэмжээ багатай жирэмсэн эмэгтэйн тархалт 20-29 насныхан (2.3%), төвийн бүс (2.6%), гэрлээгүй эмэгтэйчүүдийн (3.0%) дунд харьцангуй илүү байгааг дараах хүснэгтээс харж болно (Хүснэгт PW.3).

Хүснэгт PW.3: Хоол тэжээлийн цочмог дуталтай жирэмсэн эмэгтэйчүүд

Үзүүлэлт	Зүүн гарын бугалганы дунд хэсгийн тойргийн хэмжээ < 22.5 см			Жинлээгүй тоо
	%	95%ИХ		
		Доод	Дээд	
<b>Бүгд</b>	<b>1.5</b>	<b>1.1</b>	<b>2.1</b>	<b>2791</b>
<b>Жирэмсний хугацаа</b>				
Эхний 3 сар	1.5	0.8	2.9	355
Дунд 3 сар	1.4	0.8	2.5	1157
Сүүлийн 3 сар	1.5	0.9	2.6	1202
<b>Насны бүлэг</b>				

< 20 нас	0.9	0.1	6.3	82
20-29 нас	2.3	1.6	3.5	1217
30-39 нас	0.8	0.4	1.6	1327
40-49 нас	1.5	1.1	2.1	46
<b>Бүсээр</b>				
Баруун	1.4	0.7	2.6	552
Хангай	1.1	0.5	2.3	540
Төв	2.6	0.8	1.4	541
Зүүн	1.9	0.9	3.6	557
Улаанбаатар	1.2	0.6	2.5	555
<b>Хот, хөдөөгөөр</b>				
Хот	1.3	0.8	2.2	1465
Хөдөө	1.9	1.3	2.7	1280
<b>Байршил</b>				
Нийслэл хот	1.2	0.6	2.5	562
Аймгийн төв	1.4	0.7	2.8	924
Сум /Баг	1.9	1.3	2.7	1305
<b>Яс үндэс</b>				
Халх	1.5	1.0	2.2	2144
Казак	1.4	0.5	3.8	198
Бусад	1.4	0.5	3.7	448
<b>Боловсрол</b>				
Боловсролгүй	-	-	-	40
Бага	0.9	0.1	6.4	126
Дунд	2.0	1.3	3.1	1123
Дээд	1.2	0.7	2.1	1501
<b>Ажил эрхлэлтийн байдал</b>				
Ажилтай	1.7	1.1	2.5	2045
Ажилгүй	1	0.5	1.8	746
<b>Гэрлэлтийн байдал</b>				
Гэрлэсэн	1.5	1.0	2.3	1889
Гэрлээгүй	3.0	1.5	5.9	152
Хамтран амьдардаг	1.1	0.5	2.6	750

(-) Жинлээгүй тоон үзүүлэлт нь < 25 тохиолдлын хассан.

Жирэмсэн эмэгтэйчүүдийн 0.8% намхан (БӨ<145 см), 3.5% намхавтар (БӨ<150 см) байна. Боловсролгүй жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд намхавтар эмэгтэйн тархалт харьцангуй илүү буюу 12.2% байв (Хүснэгт PW.4).

Хүснэгт PW 4. Жирэмсэн намхан эмэгтэй

Үзүүлэлт	< 145 см			< 150 см			Жинлээгүй тоо
	%	95%ИХ		%	95%ИХ		
		Доод	Дээд		Доод	Дээд	
<b>Бүгд</b>	<b>0.8</b>	<b>0.6</b>	<b>1.2</b>	<b>3.5</b>	<b>2.6</b>	<b>4.5</b>	<b>2790</b>
<b>Жирэмсний хугацаа</b>							
Эхний 3 сар	1.0	0.3	3.1	4.7	2.7	8.2	365
Дунд 3 сар	0.7	0.4	1.3	3.4	2.2	5.2	1174
Сүүлийн 3 сар	0.9	0.5	1.7	3.1	2.2	4.5	1219
<b>Насны бүлэг</b>							
< 20 нас	-	-	-	3.1	1.0	9.2	83
20-29 нас	1.1	0.6	1.9	4.0	2.8	5.7	1250
30-39 нас	0.6	0.4	1.1	3.0	2.1	4.4	1338
40-49 нас	0.7	0.1	5.1	2.5	1.0	6.2	119
<b>Яс үндэс</b>							
Халх	0.9	0.6	1.3	3.1	2.3	4.1	2143
Казак	1.1	0.4	3.4	3.3	1.5	6.9	198
Бусад	0.5	0.2	1.6	5.7	3.4	9.3	448

<b>Бүсээр</b>							
Баруун	1.4	0.7	2.6	5.1	3.4	7.6	560
Хангай	1.9	1.0	3.5	3.9	2.6	5.8	546
Төв	0.7	0.3	1.9	2.3	1.3	4.0	556
Зүүн	1.5	0.8	2.8	4.1	3.0	5.8	566
Улаанбаатар	0.2	0.0	1.3	3.0	1.7	5.4	562
<b>Хот, хөдөөгөөр</b>							
Хот	0.6	0.3	1.1	3.3	2.2	4.8	1486
Хөдөө	1.3	0.8	2.2	3.8	2.8	5.2	1304
<b>Боловсрол</b>							
Боловсролгүй	-	-	-	12.2	3.2	36.8	40
Бага / суурь	3.0	1.1	8.1	6.7	3.6	12.1	126
Дунд	1.3	0.8	2.2	4.8	3.2	7.1	1125
Дээд	0.4	0.2	0.7	2.2	1.5	3.1	1498
<b>Ажил эрхлэлтийн байдал</b>							
Ажилтай	0.9	0.6	1.3	3.3	2.6	4.3	2047
Ажилгүй	0.7	0.3	1.8	3.7	2.3	6.0	743
<b>Байршлаар</b>							
Нийслэл хот	0.2	0.0	1.3	3.0	1.7	5.4	562
Аймгийн төв	1.5	0.9	2.5	3.8	2.8	5.1	924
Сум/Баг	1.3	0.8	2.2	3.8	2.8	5.2	1304
<b>Гэрлэлтийн байдал</b>							
Гэрлэсэн	0.8	0.5	1.2	3.4	2.6	4.5	1891
Гэрлээгүй	0.4	0.1	2.7	3.6	1.5	8.3	151
Хамтран амьдардаг	1.1	0.5	2.1	3.5	2.1	5.6	748

(-) Жинлээгүй тоон үзүүлэлт нь < 25 тохиолдлын хассан.

### Бичил тэжээлийн байдал

Жирэмсэн эмэгтэйчүүдийн бичил тэжээлийн байдлыг үнэлэх зорилгоор цус багадалтын тархалт, төмөр дутал, А, Д аминдэмийн байдал, үрэвслийн тархалтыг тодорхойлж, үндсэн үр дүнг PW.5 хүснэгтэд харуулав.

Хүснэгт PW.5: Бичил тэжээлийн байдал

Үзүүлэлт	%	95% ИХ		Жинлээгүй тоо
		доод	дээд	
<b>Цус багадалт<sup>a</sup></b>				<b>2785</b>
Цус багадалтын бүх хэлбэр	22.3	20.0	24.8	622
Хүндэвтэр цус багадалт	5.2	4.3	6.4	153
Хөнгөн цус багадалт	17.1	15.2	19.1	469
Төмөр дутлын цус багадалт <sup>e</sup>	13.6	11.4	16.1	179
<b>Төмрийн байдал</b>				<b>1308</b>
Төмрийн дутал <sup>b</sup>	39.8	36.0	43.7	531
Төмөр хангалттай	56.9	53.2	60.5	737
Төмрийн илүүдэл	3.3	2.3	4.9	40
Уусдаг трансферрин рецепторын төмрийн дутал <sup>c</sup>	9.0	7.1	11.3	110
Төмрийн нөөц дутмаг <sup>d</sup>	19.5	16.7	22.6	282
<b>А аминдэмийн байдал<sup>f</sup></b>				<b>1345</b>
А аминдэм дутал	0.4	0.2	1.2	6
А аминдэмийн нөөц дутмаг	15.8	13.7	18.3	214
А аминдэм хангалттай	83.7	81.2	86.0	1125
<b>Д аминдэмийн байдал<sup>g</sup></b>				<b>1385</b>
Д аминдэм дутал	76.6	71.9	80.7	1127
Д аминдэмийн нөөц дутмаг	15.9	12.7	19.6	187
Д аминдэм хангалттай	7.5	4.7	11.8	70



Д аминдэмийн хордлого	0.1	0.0	0.4	1
<b>Үрэвсэл<sup>h</sup></b>				<b>1372</b>
Бүх төрлийн үрэвсэл	36.0	32.7	39.3	485
a Гемоглобин < 110 г/л. b Ийлдсийн ферритин < 15 мкг/л. c sTfR > 8.3 мг/л. d Бие дэх төмрийн нөөц < 0 мг/кг. e Гемоглобин < 110 г/л ба ферритин < 15 мкг/л. f Ийлдсийн РХУ < 0.70 мкгмоль/л (дутал); ≥ 0.7–1.05 мкгмоль/л (нөөц дутмаг); > 1.05 мкгмоль/л (хангалттай). g Ийлдсийн 25(OH)D < 20 наног/мл (дутал); 20 to < 30 наног/мл I (нөөц думар); 30 to ≤100 наног/мл (хангалттай); >100 наног/мл (илүүдэл буюу хордлого) h С-идэвхт уураг > 5 мг/л эсвэл α1-ацид гликопротеин >1 г/л. (-) Жинлээгүй тоон үзүүлэлт 25-аас бага тохиолдлыг хассан.				

Нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 22.3% цус багадалттай, 13.6% төмөр дутлын цус багадалттай (ТДЦБ) байна (Хүснэгт РW.6). Цус багадалт болон ТДЦБ-ын тархалтын түвшин жирэмсний хугацаа нэмэгдэх тутам ихсэж байв. Тухайлбал, жирэмсний сүүлийн 3 сартай эмэгтэйчүүдийн дунд цус багадалт болон ТДЦБ-ын тархалт 28.4% ба 22.0% байна. Казак жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд цус багадалт 25.7%, ТДЦБ-ын тархалт 16.4% байгаа нь бусад ястны бүлгээс харьцангуй өндөр байв.

#### Хүснэгт РW.6: Цус багадалтын тархалт

Үзүүлэлт	Цус багадалт				Төмөр дутлын цус багадалт			
	Жинлээгүй тоо	%	95% ИХ		Жинлээгүй тоо	%	95% ИХ	
			Дээд	Доод			Дээд	Доод
<b>Бүгд</b>	<b>2785</b>	<b>22.3</b>	<b>20.0</b>	<b>24.8</b>	<b>1309</b>	<b>13.6</b>	<b>11.4</b>	<b>16.1</b>
<b>Жирэмсний хугацаа</b>								
Эхний 3 сар	365	7.5	5.0	11.3	156	0.7	0.2	3.2
Дунд 3 сар	1171	21.5	18.4	24.9	555	9.2	6.8	12.5
Сүүлийн 3сар	1218	28.4	25.0	32.1	586	22.0	18.1	26.6
<b>Насны бүлэг</b>								
< 20 нас	82	26.0	15.5	40.3	32	19.1	7.3	41.5
20-29 нас	1250	21.9	19.0	25.0	588	13.6	10.8	17.1
30-39 нас	1334	22.4	19.3	25.9	634	13.3	10.2	17.2
40-49 нас	119	22.5	14.9	32.7	55	12.2	5.3	25.5
<b>Яс үндэс</b>								
Халх	2141	21.9	19.2	24.8	1011	13.7	11.2	16.8
Казак	197	25.7	18.2	34.9	100	16.4	11.0	23.9
Бусад	447	23.4	18.7	28.9	198	10.9	7.2	16.1
<b>Бүсээр</b>								
Баруун	559	19.3	15.1	24.4	266	13.6	9.8	18.4
Хангай	546	20.8	16.6	25.9	263	13.8	10.3	18.3
Төв	558	25.5	20.6	31.0	258	17.0	13.3	21.3
Зүүн	566	24.1	20.5	28.1	269	13.2	9.4	18.3
Улаанбаатар	556	22.5	18.4	27.1	253	12.4	8.5	17.6
<b>Хот, хөдөөгөөр</b>								
Хот	1480	22.6	19.6	25.9	688	13.4	10.5	16.9
Хөдөө	1305	21.6	18.3	25.2	621	13.9	11.2	17.1
<b>Боловсрол</b>								
Боловсролгүй	40	28.9	14.9	48.6	19	11.3	2.7	36.8
Бага	127	19.9	13.0	29.2	64	15.8	7.7	29.9
Дунд	1122	22.4	19.3	25.7	541	15.0	11.6	19.1
Дээд	1496	22.3	19.4	25.6	685	12.3	9.5	15.8
<b>Ажил эрхлэлтийн байдал</b>								

Ажилтай	2042	21.5	19.1	24.0	977	12.8	10.4	15.6
Ажилгүй	743	24.4	19.9	29.5	332	15.5	10.9	21.6
<b>Байршлаар</b>								
Нийслэл хот	556	22.5	18.4	27.1	253	12.4	8.5	17.6
Аймгийн төв	924	23.0	19.7	26.7	435	15.5	12.6	18.8
Сумын/Баг	1305	21.6	18.3	25.2	621	13.9	11.2	17.1
<b>Гэрлэлтийн байдал</b>								
Гэрлэсэн	1884	24.2	21.6	27.0	906	15.2	12.6	18.3
Гэрлээгүй	152	22.7	17.2	29.3	62	10.9	4.9	22.5
Хамтран амьдардаг	749	18.1	14.7	22.1	341	10.2	7.0	14.6
<b>Биеийн өндөр</b>								
< 145 см	31	40.2	22.1	61.4	16	29.6	11.4	57.9
145 – 149 см	104	28.5	19.3	39.9	53	15.7	6.0	35.3
150 – 159 см	1419	23.0	20.4	25.9	683	14.0	11.0	17.6
>160 см	1224	20.8	17.5	24.6	554	12.6	9.2	17.0
<b>Зүүн гарын бугалганы дунд хэсгийн тойргийн хэмжээ</b>								
Хэвийн	2733	22.1	19.8	24.7	1290	13.2	11.0	15.8
Бага	46	35.4	20.8	53.3	17	40.8	17.5	69.1
а Гемоглобин < 110 г/л. б Гемоглобин < 110 г/л ба ферритин < 15 мкг/л. (-) Жинлээгүй тоон үзүүлэлт нь < 25 тохиолдлын хассан.								

Тохируулга хийсэн ийлдсийн ферритин ба уусдаг трансферрины рецепторийн түвшнээр үнэлсэн төмөр дутлын тархалт тус тус 39.8% ба 9.0% байна. Бие дэх төмрийн нөөц дутмаг байдал нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд 19.5% байв. Ийлдэс дэх ферритиний түвшнээр үнэлсэн төмөр дутлын тархалт жирэмсний эхний 3 сартай эмэгтэйчүүдийн дунд (9.0%) хамгийн бага, харин сүүлийн 3 сартай эмэгтэйчүүдэд (63.6%) хамгийн түгээмэл байна. Ийлдсийн ферритиний түвшнээр үнэлсэн төмөр дутлын тархалт Казак эмэгтэйчүүдийн дунд 47.6% байгаа нь бусад ястны үзүүлэлтээс харьцангуй их байна. Жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд ферритиний агууламжаар тодорхойлсон төмөр дутлын тархалт Баруун бүсэд (41.8%) харьцангуй түгээмэл, Улаанбаатарт (38.3%) хамгийн бага байв. Бие дэх төмрийн нөөц дутмаг байдал, төмөр дутлын тархалт жирэмсний сүүлийн 3 сард байгаа эмэгтэйчүүд

Хүснэгт PW.7: Жирэмсэн эмэгтэйчүүдийн төмөр дутлын байдал

Үзүүлэлт	Төмөр дутал								Төмрийн нөөц дутмаг (Бие дэх төмрийн нөөц < 0.0 мг/кг)					
	Ферритиний түвшнээр (Fer < 15 мкг/л)				Уусдаг ТФР-ийн түвшнээр (sTFR > 8.3 мг/л)				Жинлээгүй тоо		%		95%ИХ	
	Жинлээгүй тоо	%	95%ИХ		Жинлээгүй тоо	%	95%ИХ							
			Дээд	Доод			Дээд	Доод						
<b>Бүгд</b>	<b>531</b>	<b>39.8</b>	<b>36.0</b>	<b>43.7</b>	<b>110</b>	<b>9.0</b>	<b>7.1</b>	<b>11.3</b>	<b>282</b>	<b>19.5</b>	<b>16.7</b>	<b>22.6</b>		
<b>Жирэмсний хугацаа</b>														
Эхний 3 сар	17	9.0	5.1	15.6	5	3.7	1.3	10.1	17	2.5	1.1	5.3		
Дунд 3 сар	134	25.5	21.2	30.3	25	4.1	2.5	6.5	134	11.8	8.9	15.4		
Сүүлийн 3 сар	374	63.6	58.6	68.3	79	15.8	12.7	19.4	374	32.8	28.2	37.7		
<b>Насны бүлэг</b>														
< 20 нас	18	51.1	31.0	71.0	4	12.3	3.7	33.8	14	30.6	15.7	51.1		
20-29 нас	264	45.0	39.8	50.2	55	10.7	8.0	14.3	321	22.9	18.8	27.5		
30-39 нас	229	34.5	29.9	39.4	49	7.4	5.2	10.4	407	16.6	13.3	20.5		
40-49 нас	20	35.5	20.4	54.2	2	5.1	1.0	21.1	35	7.9	3.9	15.4		
<b>Бүсээр</b>														
Баруун	111	41.9	34.0	50.4	26	9.4	6.2	14.1	111	24.5	18.0	32.4		
Хангай	105	40.2	35.4	45.1	23	8.4	5.5	12.5	105	19.8	15.3	25.3		
Төв	107	41.0	35.6	46.6	14	5.0	3.1	8.1	107	19.0	14.5	24.4		
Зүүн	111	41.5	34.6	48.7	18	6.4	4.3	9.3	111	20.8	16.0	26.5		
Улаанбаатар	97	38.3	31.1	45.9	29	10.7	7.2	15.5	97	17.7	13.0	23.8		
<b>Хот, хөдөөгөөр</b>														
Хот	300	41.0	35.9	46.4	61	9.6	7.0	12.9	300	20.0	16.3	24.2		
Хөдөө	231	37.1	32.9	41.4	49	7.7	5.8	10.1	231	18.4	14.9	22.5		
<b>Байршлаар</b>														
Улаанбаатар	97	38.3	31.1	45.9	29	10.7	7.2	15.5	97	17.7	13.0	23.8		
Аймгийн төв	203	46.8	42.3	51.4	32	7.2	4.9	10.5	203	24.7	20.5	29.4		
Сумын төв / хөдөө	231	37.1	32.9	41.4	49	7.7	5.8	10.1	231	18.4	14.9	22.5		
<b>Яс үндэс</b>														
Халх	399	39.3	35.1	43.7	78	8.6	6.6	11.2	399	18.6	15.5	22.1		
Казак	54	47.6	37.0	58.3	19	17.7	11.8	25.7	54	33.5	24.2	44.4		
Бусад	78	38.6	30.1	47.9	13	6.7	3.6	12.2	78	18.0	12.4	25.2		
<b>Боловсрол</b>														
Боловсролгүй	5	25.3	9.9	51.1	1	4.7	0.6	27.8	5	11.4	3.3	32.8		
Бага / суурь	19	28.4	17.2	43.2	5	4.8	1.8	12.0	19	11.2	5.6	21.0		
Бүрэн дунд	232	40.7	35.5	46.0	43	8.3	6.1	11.1	232	19.4	15.6	23.9		
Дээд / магистр	275	40.2	35.0	45.7	61	9.8	7.0	13.7	275	20.3	16.5	24.6		

<b>Ажил эрхлэлтийн байдал</b>													
Ажилтай	380	38.9	35.2	42.7	65	7.4	5.5	9.7	380	18.3	15.7	21.3	
Ажилгүй	151	42.1	34.3	50.3	45	13.0	9.3	18.0	151	22.4	16.9	29.1	
<b>Гэрлэлтийн байдал</b>													
Гэрлэсэн	358	38.3	34.2	42.7	77	8.5	6.3	11.4	358	19.2	16.3	22.5	
Гэрлээгүй	27	40.1	24.5	58.1	5	8.6	3.2	21.3	27	13.9	6.6	26.8	
Хамтран амьдардаг	146	43.0	36.0	50.2	28	10.0	6.5	15.2	146	21.2	15.7	27.9	
<b>Биеийн өндөр</b>													
< 145 см	6	39.8	16.9	68.3	1	2.9	0.4	18.6	6	29.7	12.1	56.5	
145 – 149 см	22	42.7	26.2	61.0	2	2.3	0.5	9.9	22	16.2	6.7	34.1	
150 – 159 см	276	39.4	35.2	43.9	51	7.7	5.5	10.6	276	18.5	15.3	22.3	
>160 см	227	40.0	34.2	46.1	56	11.0	7.9	15.0	227	20.6	16.3	25.6	
<b>Зүүн гарын бугалганы дунд хэсгийн тойргийн хэмжээ</b>													
Хэвийн	519	39.4	35.6	43.4	108	9.0	7.1	11.3	519	19.4	16.6	22.6	
Бага	10	62.3	33.5	84.5	2	9.4	2.3	31.0	10	21.0	8.2	44.5	
(-) Жинлээгүй тоон үзүүлэлт 25-аас бага тохиолдолыг хассан.													

Жирэмсэн эмэгтэйчүүдийн А аминдэмийн байдлыг үнэлэхэд, дийлэнх буюу 83.7% нь А аминдэмийн хангалттай нөөцтэй, Д аминдэмийн нөөц дутмаг болон дуталтай эмэгтэйчүүдийн тархалт 15.8% ба 0.4% байв. А аминдэмийн нөөц дутмаг байдал нь жирэмсний дунд (13.1%) болон сүүлийн 3 сард (17.5%) байгаа эмэгтэйтэй харьцуулахад эхний 3 сард байгаа эмэгтэйчүүдийн дунд (20.0%) өндөр байна.

Зүүн гарын БДХТ-ийн хэмжээ нь хэвийн жирэмсэн эмэгтэйд 15.7%, БДХТ бага буюу хоол тэжээлийн цочмог дуталтай эмэгтэйчүүдэд 26.0% байна. А аминдэмийн нөөц дутмаг байдал нь казак жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд 23.7% байгаа нь бусад эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүү байна (Хүснэгт PW.8).

Хүснэгт PW.8. Жирэмсэн эмэгтэйчүүдийн А аминдэмийн байдал

Үзүүлэлт	Жинлээ гүй тоо	А аминдэм дутал (РХУ < 0.07 мкмол/л)			А аминдэмийн нөөц дутмаг (РХУ = 0.07–1.05 мкмол/л)			А аминдэм хангалттай (РХУ > 1.05 мкмол/л)		
		%	95%ИХ		%	95%ИХ		%	95%ИХ	
			Дээд	Доод		Дээд	Доод		Дээд	Доод
<b>Бүгд</b>	1125	0.4	0.2	1.2	15.8	13.7	18.3	83.7	81.2	86.0
<b>Жирэмсний хугацаа</b>										
Эхний 3 сар	162	1.8	0.4	8.5	20.0	13.8	28.1	78.2	69.6	84.9
Дунд 3 сар	579	0.3	0.1	1.2	13.1	10.2	16.7	86.6	83.0	89.5
Сүүлийн 3 сар	593	0.2	0.0	0.8	17.5	14.2	21.4	82.3	78.4	85.6
<b>Насны бүлэг</b>										
< 20 нас	35	-	-	-	13.3	5.8	27.7	86.7	72.3	94.2
20-29 нас	599	-	-	-	17.4	14.3	21.1	82.6	78.9	85.7
30-39 нас	653	0.9	0.4	2.5	14.9	11.8	18.7	84.1	80.0	87.5
40-49 нас	58	-	-	-	10.2	3.8	24.9	89.8	75.1	96.2
<b>Яс үндэс</b>										
Халх	1038	0.4	0.1	1.4	14.8	12.5	17.5	84.8	82.0	87.2
Казак	103	0.8	0.1	5.6	23.7	15.5	34.4	75.5	65.0	83.6
Бусад	204	0.4	0.1	3.1	18.3	12.6	25.7	81.3	73.8	87.0
<b>Бүсээр</b>										
Баруун	270	0.4	0.1	2.7	19.1	14.5	24.8	80.5	74.9	85.1
Хангай	264	0.4	0.1	2.9	11.4	8.6	15.0	88.2	84.7	91.0
Төв	273	0.7	0.2	2.9	11.6	8.6	15.5	87.7	83.3	91.0
Зүүн	272	0.3	0.0	2.4	20.1	15.5	25.6	79.6	74.1	84.1
Улаанбаатар	266	0.4	0.1	2.8	17.2	13.3	22.0	82.4	77.4	86.5
<b>Хот, хөдөөгөөр</b>										
Хот	715	0.5	0.2	1.6	16.6	13.6	20.0	82.9	79.3	86.0
Хөдөө	630	0.2	0.0	1.6	14.3	11.9	17.1	85.5	82.7	87.9
<b>Боловсрол</b>										
Боловсролгүй	19	-	-	-	21.8	7.9	47.3	78.2	52.7	92.1
Бага	64	-	-	-	15.9	7.9	29.3	84.1	70.7	92.1
Дунд	551	0.7	0.3	1.6	16.6	13.0	21.0	82.7	78.3	86.4
Дээд	711	0.3	0.0	2.3	15.2	12.0	19.0	84.5	80.5	87.8
<b>Ажил эрхлэлтийн байдал</b>										
Ажилтай	1002	0.3	0.1	0.8	14.4	12.1	17.1	85.3	82.6	87.6
Ажилгүй	343	0.8	0.2	3.9	19.5	14.7	25.2	79.7	73.5	84.8
<b>Байршлаар</b>										
Нийслэл хот	266	0.4	0.1	2.8	17.2	13.3	22.0	82.4	77.4	86.5
Аймгийн төв	449	0.9	0.3	2.3	15.1	11.9	19.0	84.0	79.9	87.4

Сумын төв/ Баг	630	0.2	0.0	1.6	14.3	11.9	17.1	85.5	82.7	87.9
<b>Гэрлэлтийн байдал</b>										
Гэрлэсэн	928	0.6	0.2	1.8	16.0	13.2	19.4	83.3	79.8	86.3
Гэрлээгүй	69	-	-	-	16.0	8.4	28.4	84.0	71.6	91.6
Хамтран амьдардаг	348	0.1	0.0	0.6	15.4	11.1	20.9	84.6	79.0	88.9
<b>Биеийн өндөр</b>										
< 145 см	15	-	-	-	3.7	0.5	23.0	96.3	77.0	99.5
145 – 149 см	53	-	-	-	19.3	9.0	36.8	80.7	63.2	91.0
150 – 159 см	700	0.2	0.0	0.7	16.3	13.3	19.8	83.6	80.0	86.6
> 159 см	574	0.8	0.3	2.4	15.4	12.5	18.8	83.9	80.2	87.0
<b>Зүүн гарын бугалганы дунд хэсгийн тойргийн хэмжээ</b>										
Хэвийн	1326	0.4	0.2	1.2	15.7	13.5	18.2	83.8	81.2	86.1
Бага	17	-	-	-	26.0	10.9	50.2	74.0	49.8	89.1
(-) Жинлээгүй тоон үзүүлэлт нь <25 тохиолдлын хассан.										

Жирэмсэн эмэгтэйчүүдийн 76.6% Д аминдэмийн дуталтай, 15.9% нөөц дутмаг байдалд байна. Жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд Д аминдэмийн илүүдлийн 1 тохиолдол (0.1%) илэрсэн болно. Д аминдэмийн дутлын тархалт Улаанбаатар хотын жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд (67.6%) хамгийн бага байв. Жирэмсэн эмэгтэйчүүдийн оршин суугаа бүс нутаг, байршил, ястан үндэстний бүлэг, боловсролын түвшин, ажил эрхлэлт болон гэрлэлт, хоол тэжээлийн байдал, жирэмсний хугацааг үл харгалзан Д аминдэмийн дутал түгээмэл тохиолдож байна (Хүснэгт РW.9).

Хүснэгт PW.9: Жирэмсэн эмэгтэйчүүдийн Д аминдэмийн байдал

Үзүүлэлт	Жинлээ гүй тоо	Д аминдэмийн дутал (25 (ОН) D < 20 нг/мл)			Д аминдэмийн нөөц дутмаг (25 (ОН) D = 20 - 29.9 нг/мл)			Д аминдэмийн илүүдэл (25 (ОН) D > 100.0 нг/мл)			Д аминдэм хангалттай (25 (ОН) D = 30 – 100.0 нг/мл)		
		%	95%ИХ		%	95%ИХ		%	95%ИХ		%	95%ИХ	
			Дээд	Доод		Дээд	Доод		Дээд	Доод		Дээд	Доод
<b>Бүгд</b>	1386	76.6	71.9	80.7	15.9	12.7	19.6	0.1	0.0	0.4	7.5	4.7	11.8
<b>Жирэмсний хугацаа</b>													
Эхний 3 сар	166	70.3	59.2	79.5	20.5	14.2	28.7	-	-	-	9.1	4.1	19.2
Дунд 3 сар	596	77.9	72.5	82.6	15.2	11.5	20	-	-	-	6.8	4.1	11.2
Сүүлийн 3сар	611	76.5	71.8	80.6	15.9	12.7	19.7	0.1	0.0	0.9	7.6	4.8	11.9
<b>Насны бүлэг</b>													
< 20 нас	37	79.5	56.7	92.0	18.0	6.4	41.6	-	-	-	2.4	0.3	15.7
20-29 нас	616	79.5	74.3	83.9	13.8	10.1	18.6	0.1	0.0	0.8	6.6	4.0	10.9
30-39 нас	673	74.4	68.9	79.2	17.1	13.6	21.2	-	-	-	8.5	5.1	13.7
40-49 нас	59	67.4	51.5	80.2	23.0	12.5	38.5	-	-	-	9.5	3.0	26.6
<b>Яс үндэс</b>													
Халх	1072	74.2	69.3	79.4	16.4	13.1	20.3	-	-	-	8.9	5.5	14.1
Казак	103	83.5	71.2	91.2	12.9	6.6	23.8	0.8	0.1	5.6	2.7	0.4	17.1
Бусад	210	85.0	76.5	90.8	14.0	8.3	22.5	-	-	-	1.0	0.3	2.1
<b>Бүсээр</b>													
Баруун	276	87.4	80.3	92.1	11.2	6.9	17.7	0.4	0.1	2.6	1.1	0.4	3.3
Хангай	277	84.8	77.5	90.0	12.9	8.2	19.6	-	-	-	2.4	1.1	5.2
Төв	278	79.2	74.0	84.3	15.4	11.0	21.0	-	-	-	5.5	3.2	9.2
Зүүн	283	87.0	82.5	90.5	8.6	6.0	12.2	-	-	-	4.3	2.2	8.5
Улаанбаатар	271	67.6	53.8	75.7	19.8	13.9	27.4	-	-	-	12.6	6.9	21.9
<b>Хот, хөдөөгөөр</b>													
Хот	730	72.5	66.0	78.2	17.6	13.3	22.8	0.1	0.0	0.6	9.8	5.8	16.1
Хөдөө	655	85.2	80.3	89.0	12.3	8.9	16.7	-	-	-	2.6	1.5	4.4
<b>Боловсрол</b>													
Боловсролгүй	21	90.1	69.7	97.3	7.6	1.6	29.3	-	-	-	2.3	0.3	15.5
Бага	67	77.5	60.7	88.4	14.4	6.2	30.0	-	-	-	8.1	2.1	26.8
Дунд	570	80.1	73.1	85.6	13.1	9.6	17.4	-	-	-	6.9	3.2	14.1
Дээд	727	73.7	67.8	78.8	18.2	13.6	23.8	0.1	0.0	0.7	8.0	5.3	12.0
<b>Ажил эрхлэлтийн байдал</b>													
Ажилтай	1030	76.1	70.8	80.7	16.4	13.0	20.5	0.1	0.0	0.5	7.5	4.3	12.5
Ажилгүй	355	77.8	71.4	83.1	14.5	10.2	20.4	-	-	-	7.7	4.4	13.0
<b>Байршлаар</b>													
Нийслэл хот	271	67.6	58.3	75.7	19.8	13.9	27.4	-	-	-	12.6	6.9	21.9
Аймгийн төв	459	82.8	78.5	86.4	13.0	9.7	17.1	-	-	-	4.0	2.4	6.4
Сум/Баг	655	85.2	80.3	89.0	12.3	8.9	16.7	-	-	-	2.6	1.5	4.4

<b>Гэрлэлтийн байдал</b>													
Гэрлэсэн	955	75.6	70.3	80.1	16.2	12.4	20.8	0.1	0.0	0.6	8.2	5.3	12.5
Гэрлээгүй	69	74.6	58.9	85.7	19.2	9.6	34.9	-	-	-	6.2	1.9	18.3
Хамтран амьдардаг	1385	79.2	72.9	84.4	14.5	10.2	20.2	-	-	-	6.2	3.1	12.0
<b>Биеийн өндөр</b>													
< 145 см	18	94.1	67.2	99.2	-	-	-	-	-	-	5.9	0.8	32.8
145 – 149 см	56	88.3	73.4	95.4	6.1	2.4	15.0	-	-	-	5.6	1.1	24.5
150 – 159 см	724	77.7	72.3	82.2	15.2	11.8	19.3	0.1	0.0	0.8	7.0	3.8	12.7
> 160 см	585	74.0	67.8	79.5	17.7	13.3	23.3	-	-	-	8.2	4.8	13.9
<b>Зүүн гарын бугалганы дунд хэсгийн тойргийн хэмжээ</b>													
Хэвийн	1366	76.6	71.9	80.7	15.8	12.7	19.6	0.1	0.0	0.4	7.5	4.7	11.8
Бага	17	71.3	39.7	90.4	19.3	4.1	57.1	-	-	-	9.4	2.4	30.8

(-) Жинлээгүй тоон үзүүлэлт нь <25 тохиолдлын хассан.



## Үрэвслийн тархалт

Өвчин эмгэг төрүүлэгч хүний бие махбодод нэвтрэхэд дархлаа тогтолцоо хамгаалах хариу үйлдэл үзүүлж, үүний улмаас үрэвслийн процесс явагддаг. Хоол тэжээлийн үндэсний VI судалгаагаар жирэмсэн эмэгтэйчүүдийн 36.0%-д нь ямар нэг төрлийн үрэвсэл байгааг илрүүлсэн. Үрэвслийн тархалтад жирэмсэн эмэгтэйчүүдийн оршин суугаа газар, бүс нутаг, жирэмсний хугацаанаас хамаарсан ялгаа ажиглагдаагүй болно (Хүснэгт PW.10).

Хүснэгт PW.10: Жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах үрэвслийн тархалт

Үзүүлэлт	Ямар нэг үрэвсэл <sup>a</sup>			Жинлээгүй тоо
	%	95%ИХ		
		Дээд	Доод	
<b>Бүгд</b>	<b>36.0</b>	<b>32.7</b>	<b>39.3</b>	<b>485</b>
<b>Жирэмсний хугацаа</b>				
Эхний 3 сар	34.5	25.6	44.5	51
Дунд 3 сар	40.7	36.3	45.4	235
Сүүлийн 3 сар	32.0	27.2	37.2	196
<b>Насны бүлэг</b>				
< 20 нас	50.1	31.8	68.4	16
20-29 нас	34.1	29.4	39.1	209
30-39 нас	37.2	32.6	42.0	242
40-49 нас	34.5	20.9	51.3	18
<b>Яс үндэс</b>				
Халх	36.8	33.3	40.3	378
Казак	36.2	25.5	48.4	35
Бусад	30.9	24.3	38.3	72
<b>Бүсээр</b>				
Баруун	30.6	24.8	37.2	84
Хангай	32.3	26.8	38.4	88
Төв	37.7	32.1	43.6	102
Зүүн	39.2	33.6	45.0	108
Улаанбаатар	38.0	32.0	44.3	103
<b>Хот, хөдөөгөөр</b>				
Хот	36.0	31.6	40.6	250
Хөдөө	35.9	32.1	39.9	235
<b>Боловсрол</b>				
Боловсролгүй	39.2	16.1	68.4	5
Бага	33.3	21.9	47.0	23
Дунд	33.8	29.0	39.0	194
Дээд	37.6	33.2	42.3	263
<b>Ажил эрхлэлтийн байдал</b>				
Ажилгүй	35.9	32.3	39.7	371
Ажилтай	36.1	29.9	42.8	114
<b>Байршлаар</b>				
Нийслэл хот	38.0	32.0	44.3	103
Аймгийн төв	38.0	32.0	44.3	103
Сумын төв/Баг	35.9	32.1	39.9	235
<b>Гэрлэлтийн байдал</b>				
Гэрлэсэн	36.7	32.7	40.8	341
Гэрлээгүй	33.6	21.3	48.6	23
Хамтран амьдардаг	34.8	29.4	40.7	121
<b>Биеийн өндөр</b>				
< 145 см	45.9	23.2	70.4	9
145 – 149 см	36.5	21.2	55.1	18
150 – 159 см	35.6	30.7	40.7	257
> 159 см	36.2	31.5	41.2	200

<b>Зүүн гарын бугалганы дунд хэсгийн тойргийн хэмжээ</b>				
Хэвийн	36.3	33.0	39.7	1353
Бага	-	-	-	17
<sup>a</sup> С идэвхт уураг > 5мг/л эсвэл α1- ацид-гликопротеин > 1 г/л. (-) Жинлээгүй тоон үзүүлэлт нь <25 тохиолдлын хассан.				

### Шээсээр ялгарах иодын голч хэмжээ

Жирэмсэн эмэгтэйн бие махбодод иодын хэмжээ хангалттай байх нь ургийн өсөлт, тархины хөгжилд чухал үүрэгтэй байдаг. Хүний биед шимэгдсэн иодын ихэнхи нь эргээд шээсээр ялгардаг тул шээсэн дэх иодын агууламжийг тодорхойлж, жирэмсэн эмэгтэйчүүдийн иодын хэрэглээг үнэлэхэд ашигладаг. Судалгаагаар тодорхойлсон жирэмсэн эмэгтэйчүүдийн шээсээр ялгарах иодын агууламжийн үр дүнг PW.11 хүснэгтэд үзүүлэв. Жирэмсэн эмэгтэйн шээсээр ялгарах иодын хэмжээ 76.4 мкг/л байгаа нь лавлагаа хязгаар буюу 150-249 мкг/л-ээс хэт доогуур хангалтгүй түвшинд байна. Жирэмсний эхний 3 сард эмэгтэйчүүдийн шээсээр ялгарах иодын хэмжээ хамгийн их буюу 78.3 мкг/л, харин сүүлийн 3 сард хамгийн бага буюу 72.9 мкг/л байв. Энэхүү үзүүлэлтийг бүсээр нь авч үзэхэд Хангайн бүсэд хамгийн бага буюу 61.8 мкг/л, Төвийн бүсэд хамгийн их буюу 90.9 мкг/л байна. Зөвхөн иоджуулсан давс хүнсэндээ хэрэглэдэг эмэгтэйчүүдийн шээсээр ялгарах иодын хэмжээ 75.8 мкг/л, иоджуулсан давс хэрэглэдэггүй эмэгтэйчүүдийн үзүүлэлт 71.1 мкг/л байна (Хүснэгт PW.11).

Хүснэгт PW.11 Жирэмсэн эмэгтэй шээсээр ялгарах иодын хэмжээ

Үзүүлэлт	Шээсээр ялгарах иодын хэмжээ, мкг/л			Жинлээгүй тоо
	Голч	95%ИХ		
		Дээд	Доод	
<b>Бүгд</b>	<b>76.4</b>	<b>79.7</b>	<b>73.5</b>	<b>2763</b>
<b>Жирэмсний хугацаа</b>				
Эхний 3 сар	78.3	76.3	80.4	361
Дунд 3 сар	75.2	75.0	77.1	1164
Сүүлийн 3сар	72.9	71.9	73.9	1208
<b>Насны бүлэг</b>				
< 20 нас	69.1	69.1	76.0	82
20-29 нас	74.7	73.6	75.6	1233
30-39 нас	75.2	75.0	76.4	1330
40-49 нас	68.9	66.0	74.4	118
<b>Яс үндэс</b>				
Халх	75.1	74.7	75.8	2121
Казак	89.4	89.3	91.2	198
Дөрвөд	61.6	60.9	65.0	90
Буриад	87.2	79.2	99.0	49
Баяд	56.4	54.3	56.5	62
Захчин	65.4	63.9	66.7	45
Бусад	73.6	72.6	74.9	180
<b>Бүсээр</b>				
Баруун	71.1	69.5	71.8	560
Хангай	61.8	61.5	62.4	536
Төв	90.9	89.3	91.7	559
Зүүн	86.2	84.5	87.9	560
Улаанбаатар	75.1	74.7	75.8	548
<b>Хот, хөдөөгөөр</b>				
Хот	75.8	75.2	77.7	1464
Хөдөө	71.8	71.1	73.2	1299

<b>Боловсрол</b>				
Боловсролгүй	88.9	88.4	110.0	40
Бага	74.0	72.9	76.6	126
Дунд	72.1	71.3	72.9	1115
Дээд	76.6	75.2	78.2	1481
<b>Ажил эрхлэлтийн байдал</b>				
Ажилгүй	74.7	74.6	75.2	2022
Ажилтай	73.7	72.2	76.0	741
<b>Байршлаар</b>				
Нийслэл хот	75.1	74.7	75.8	548
Аймгийн төв	79.2	76.9	80.4	916
Сум/Баг	71.8	71.1	73.2	1299
<b>Гэрлэлтийн байдал</b>				
Гэрлэсэн	73.5	73.1	74.3	1873
Гэрлээгүй	69.1	68.2	72.1	148
Хамтран амьдардаг	78.5	78.4	79.4	742
<b>Иоджуулсан давсны хэрэглээ</b>				
Зөвхөн иоджуулсан давс хэрэглэдэг	75.8	75.1	77.0	1058
Энгийн болон иоджуулсан давс хольж хэрэглэдэг	71.1	69.4	72.2	716
(-) Жинлээгүй тоон үзүүлэлт нь <25 тохиолдлын хассан.				

### Иод дутал ба иоджуулсан давсны талаарх ойлголт

Жирэмсэн эмэгтэйчүүдийн 32.4% иод дутлын талаар зохих ойлголттой, 74.8% иоджуулсан давсны талаар сонссон гэж хариулсан байна (Хүснэгт PW.12). Иоджуулсан давсны талаар зохих ойлголттой жирэмсэн эмэгтэйчүүд Улаанбаатар хотод 78.4%, 30-аас дээш насныханд дунд 81.1%-85.0% байна. Харин боловсролгүй% бага эсвэл суурь боловсролтой жирэмсэн эмэгтэйчүүдийн иоджуулсан давсны талаар сонссон байдал 61.4%-64.4% байна. Нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 53.0% хоол хүнсэндээ зөвхөн иоджуулсан давс хэрэглэдэг, 35.7% иоджуулсан болон иоджуулаагүй давсыг хольж хэрэглэдэг, харин 11.3% иоджуулаагүй давс хэрэглэж байв. Иоджуулсан давсны хэрэглээ Зүүн бүсэд хамгийн өндөр (60.6%), Хангайн бүсэд (48.2%) харьцангуй бага байна (Хүснэгт PW.12).

Хүснэгт PW.12: Иод дутал, иоджуулсан давсны талаарх ойлголт, давсны хэрэглээ

Үзүүлэлт	Жинлэ э гүй тоо	Иод дутлын талаар сонссо н (%)	Иоджуулса н давсны талаар сонссон (%)	Хэрэглэдэг давсны төрөл (Эмэгтэйн мэдээллээр)				
				Зөвхөн иоджуу л сан давс (%)	Иоджуулсан , иоджуулаа гүй давсыг хольж (%)	Иоджуу л аагүй давс (%)	Мэдэ х гүй (%)	Жинлэ э гүй тоо
<b>Бүгд</b>	<b>2794</b>	<b>32.4</b>	<b>74.8</b>	<b>53.0</b>	<b>35.7</b>	<b>11.3</b>	<b>0.8</b>	<b>2029</b>
<b>Насны бүлэг</b>								
< 20 нас	83	13.2	67.2	35.6	47.6	16.8		45
20-29 нас	1253	25.3	67.6	53.6	33.2	12.2	1.0	83
30-39 нас	1340	38.9	81.1	54.0	36.8	8.7	0.5	1058
40-49 нас	119	48.3	85.0	46.6	38.8	11.3	3.3	93
<b>Бүсээр</b>								
Баруун	560	28.9	69.6	50.5	40.3	9.2	-	390
Хангай	547	33.4	77.3	48.2	38.8	11.6	1.	423
Төв	560	30.3	67.9	50.7	33.6	14.7	1.0	380
Зүүн	567	25.8	69.6	60.6	29.1	8.7	1.6	395
Улаанбаатар	561	34.8	78.4	55.0	34.0	9.5	0.7	441


<b>Хот, хөдөөгөөр</b>								
Хот	1487	33.9	76.0	53.1	35.7	10.5	0.7	1530
Хөдөө	1308	29.1	72.0	52.8	35.7	10.3	1.2	499
<b>Боловсрол</b>								
Боловсролгүй	40	11.2	61.4	55.0	34.9	9.5	0.7	20
Бага	126	18.1	63.5	48.7	37.7	12.9	0.7	72
Дунд	1125	19.5	64.4	52.8	35.7	10.3	1.2	714
Дээд	1503	42.4	82.8	53.0	35.7	10.5	0.8	1223
<b>Ажил эрхлэлтийн байдал</b>								
Ажилтай	2050	35.3	75.9	53.9	34.3	10.8	1.0	1530
Ажилгүй	745	25.1	71.9	50.6	39.4	9.6	0.3	499
<b>Байршлаар</b>								
Нийслэл хот	561	34.8	78.4	55.0	34.9	9.5	0.7	441
Аймгийн төв	926	32.0	71.2	48.7	37.7	12.9	0.7	654
Сум/ Баг	1308	29.1	72.0	52.8	35.7	10.3	1.2	954
<b>Хүүхдийн эцэг хамт амьдардаг</b>								
Тийм	2643	32.9	75.3	53.5	35.4	10.3	0.7	1935
Үгүй	152	24.7	66.8	44.5	40.2	12.6	2.7	94
<b>Гэрлэлтийн байдал</b>								
Гэрлэсэн	1892	37.0	77.7	55.0	33.8	10.4	0.8	1423
Гэрлээгүй	152	24.7	66.8	44.5	40.2	12.6	2.7	94
Хамтран амьдардаг	751	24.0	69.9	49.8	39.4	10.1	0.6	512
(-) Жинлээгүй тоон үзүүлэлт нь <25 тохиолдлын хассан.								

### Жирэмсэн эмэгтэйчүүдийн хооллолтын чанар

Судалгаагаар “Дэлхийн хооллолтын чанар” төслийн багийн боловсруулсан Хооллолтын чанарын асуулга (ХЧА)-ыг ашиглан судалгаанаас өмнөх 24 цагт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүнийг нэр төрлөөр үнэлэх шинэ удирдамж, стандарт асуултыг ашиглан жирэмсэн эмэгтэйчүүдийн хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг судалж, тэдний хооллолтын чанарт үнэлээ өгөв [13].

Хүнсний 10 бүлэг бүтээгдэхүүнээс сүүлийн 24 цагт хамгийн багадаа 5 нэр төрлийн хүнс хэрэглэсэн бол хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан гэж үнэлсэн болно [8]. Энэ нь жирэмсэн эмэгтэйчүүдийн хоол, хүнсээр авах шимт бодисын агууламж буюу хооллолтын чанарыг үнэлэхэд ашигладаг бөгөөд бичил тэжээлийн дуталд өртөмтгий байдлыг илтгэх шууд бус шалгуур үзүүлэлт юм. Жирэмсэн эмэгтэйчүүдийн 71.7% уг шаардлагыг хангасан хооллолттой байв (Хүснэгт PW.13). Хүнсний 10 бүлэг<sup>13</sup> бүтээгдэхүүнээс хамгийн багадаа 5 нэр төрлийн хүнс хэрэглэсэн жирэмсэн эхчүүдийн хувь бүс нутаг, байршлаар ялгаатай, харин тэдний насны бүлгээр ялгаатай бус байна (Зураг PW.1).

<sup>13</sup> Хүнсний 10 бүлэг бүтээгдэхүүн: үр тариа, үндэст болон булцуут ногоо (төмс, манжин); буурцагт ургамлууд (шош, вандуй); самар болон үр; сүү; мал, амьтан, шувууны мах, загас; өндөг; гүн ногоон өнгөт навчит ногоо; А аминдэмээр баялаг жимс, ногоо; бусад ногоо; бусад жимс



Зураг PW.1: Хоногт хэрэглэвэл зохих хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан хооллолттой жирэмсэн эмэгтэйчүүд

Жирэмсэн эмэгтэйчүүд (N=2789)-ийн хооллолтын чанарын үнэлгээний дүнг PW.13 хүснэгтэд нэгтгэн харуулав. Нийт эмэгтэйчүүдийн дөнгөж 15.3% хоногт хэрэглэвэл зохих 5 нэр төрлийн хүнс (жимс; ногоо; цардууллаг хүнс; мал, амьтны гаралтай хүнс; буурцаг, самар үр)-ний бүтээгдэхүүнийг хэрэглэж байна. Харин малын мах, тахиа, загас, сүү, цагаан идээ зэрэг амьтны гаралтай хүнс (99.7%), төрөл бүрийн үр тариан бүтээгдэхүүн, төмс, манжин зэрэг булцуут үндэст ургамал буюу цардууллаг хүнс (98.1%)-ийг бараг бүх эмэгтэйчүүд хэрэглэсэн байв.

ХБӨ-өөс сэргийлэх хооллолтын зөвлөмжид хоногт  $\geq 25$  г эслэг хэрэглэхийг заасан бөгөөд үүний тулд өдөрт хамгийн багадаа 400 г жимс, ногоо; бүхэл үрийн үр тарианы бүтээгдэхүүн, төрөл бүрийн вандуй, шош гэх мэт буурцагт ургамал, самар, үр идэхийг зөвлөдөг. Жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд МУ-ын болон ДЭМБ-ын эрүүл хооллолтын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, тэдний 67.6% жимс, 49.8% бүхэл үрийн үр тариан бүтээгдэхүүн, 21.3% буурцагт ногоо, самар үр хэрэглэсэн, харин А аминдэмээр баялаг жимс, ногооны хэрэглээ харьцангуй өндөр (64.8%) байна (Хүснэгт PW.13).

Хүснэгт PW.13: Жирэмсэн эмэгтэйчүүдийн хооллолтын чанарын үнэлгээний дүн

Үзүүлэлт	Жинлээгүй тоо	Жинлэсэн хувь	95%ИХ		
			Доод	Дээд	
<b>Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл</b>					
DQ1	5 нэр төрлийн хүнсний хэрэглээ (All-5)	356	15.3	13.5	17.1
DQ2	Хоногт хэрэглэвэл зохих хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан	1882	71.1	69.0	73.2
DQ3	Ногооны хэрэглээ	2049	76.9	74.9	78.8
DQ4	Жимсний хэрэглээ	1800	67.6	65.3	69.9
DQ5	Буурцагт ногоо (вандуй, шош), самар, үрний хэрэглээ	511	21.3	19.4	23.4
DQ6	Амьтны гаралтай хүнсний хэрэглээ	2779	99.7	99.3	99.8
DQ7	Цардууллаг хүнсний хэрэглээ	2744	98.1	97.3	98.7
DQ8	Жимс, ногооны хэрэглээ	2414	89.1	87.7	90.4

<b>Эрүүл хүнсний хэрэглээ</b>					
DQ9	Бүхэл үрийн үр тариан бүтээгдэхүүний хэрэглээ	1340	49.8	47.4	52.3
DQ10	Буурцагт ургамал (вандуй, шош)ын хэрэглээ	173	7.5	6.3	9.0
DQ11	Бүх төрлийн самар, үрний хэрэглээ	379	15.9	14.1	17.8
DQ12	А аминдэмээр баялаг жимс, ногооны хэрэглээ	1732	64.8	62.7	66.9
<b>Эрүүл бус хүнсний хэрэглээ</b>					
DQ13	Ногоо, эсвэл жимс огт хэрэглээгүй эмэгтэйчүүд	375	10.9	9.6	12.3
DQ14	Хийжүүлсэн ундааны хэрэглээ (soft drinks)	560	22.0	19.8	24.3
DQ15	Чихэрлэг, хийжүүлсэн ундааны хэрэглээ	1731	65.4	63.1	67.6
DQ16	Боловсруулсан махан бүтээгдэхүүний хэрэглээ	436	16.7	15.0	18.5
DQ17	Давстай, хэт боловсруулсан зуушны хэрэглээ (савласан)	195	6.7	5.6	8.1
DQ18	Их тосонд шарж болгосон хоол, хүнсний хэрэглээ	875	30.3	27.7	33.1
DQ19	Чихэр, амтлаг хүнсний хэрэглээ	1824	67.0	64.2	69.7
DQ20	Түргэн хоол, бэлэн гоймонгийн хэрэглээ	281	11.9	10.3	13.7

Хоногт хэрэглэвэл зохих 5 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг бүгдийг хэрэглэсэн болон хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлагыг хангасан хооллолттой жирэмсэн эмэгтэйн тархалтыг сонгосон үзүүлэлтээр харьцуулан судалж, үр дүнг нэгтгэн PW.14 хүснэгтэд харуулав. Хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан хооллолттой жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь Улаанбаатар хот, хот суурин газар, дээд боловсролтой, орон сууцад амьдардаг эмэгтэйчүүдийн дунд харьцангуй өндөр, харин боловсролгүй эсвэл бага боловсролтой эхчүүд, Хангай болон Баруун бүс, хөдөө орон нутаг болон гэрт амьдардаг жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд бага байв ( $p < 0.0001$ ).

Хүснэгт PW.14: Жирэмсэн эмэгтэйчүүдийн хооллолтын чанарыг нэр төрлөөр үнэлсэн дүн

Үзүүлэлтүүд	Хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан хооллолттой жирэмсэн эхчүүд			Хоногт хэрэглэвэл зохих 5 нэр төрлийн хүнс хэрэглэсэн жирэмсэн эхчүүд			Жинлээгүй тоо
	%	95% ИХ		%	95% ИХ		
		Доод	Дээд		Доод	Дээд	
<b>Бүгд</b>	<b>71.7</b>	<b>69.0</b>	<b>73.2</b>	<b>15.3</b>	<b>13.5</b>	<b>17.1</b>	<b>2789</b>
<b>Насны бүлэг</b>							
< 20 нас	58.0	45.4	69.6	13.1	6.3	25.4	83
2029 нас	74.0	71.0	76.8	15.2	12.6	18.2	1251
3039 нас	69.1	66.0	72.0	15.4	13.1	18.0	1337
4049 нас	72.2	62.3	80.3	16.2	9.6	26.1	118
<b>Бүсээр</b>							
Баруун	64.9	60.4	69.1	11.9	8.7	15.9	560
Хангай	53.7	47.9	59.4	7.7	5.4	11.0	547
Төв	70.0	65.5	74.2	13.3	10.4	16.9	555
Зүүн	67.5	63.0	71.7	10.8	8.4	13.7	566
Улаанбаатар	80.7	77.1	83.8	20.5	17.3	24.2	561
<b>Хот, хөдөөгөөр</b>							

Хот	77.6	75.0	80.0	18.7	16.3	21.3	1486
Хөдөө	57.3	54.0	60.6	8.0	6.3	10.0	1303
<b>Байршлаар</b>							
Нийслэл хот	80.7	77.1	83.8	20.5	17.3	24.2	561
Аймгийн төв	71.2	67.9	74.3	14.8	12.4	17.6	925
Сум / Баг	57.3	54.0	60.6	8.0	6.3	10.0	1303
<b>Яс үндэс</b>							
Халх	71.6	69.1	74.0	15.7	13.7	17.9	2143
Казак	74.0	67.8	79.3	18.2	13.6	24.0	198
Бусад	67.0	61.4	72.3	11.5	8.2	15.8	448
<b>Боловсрол</b>							
Боловсролгүй	36.5	22.2	53.6	5.2	1.3	19.0	40
Бага / суурь	41.2	30.6	52.7	6.9	3.0	15.2	125
Бүрэн дунд	66.6	63.2	69.8	12.8	9.9	16.3	1122
Дээд / магистр	76.9	74.3	79.2	17.7	15.5	20.1	1501
<b>Ажил эрхлэлт</b>							
Ажилтай	70.6	68.1	73.1	15.0	13.0	17.2	2044
Ажилгүй	72.3	68.3	76.0	16.0	13.0	19.4	745
<b>Гэрлэлтийн байдал</b>							
Гэрлэсэн	69.8	67.1	72.4	14.7	12.8	16.8	1886
Гэрлээгүй	72.9	63.7	80.4	21.4	14.9	29.9	152
Хамтран амьдардаг	73.5	69.7	77.0	15.2	11.6	19.6	751
<b>Хүүхдийн эцэг хамт амьдардаг</b>							
Тийм	71.0	68.8	73.1	14.8	13.2	16.6	2637
Үгүй	72.9	63.7	80.4	21.4	14.9	29.9	152
<b>Жирэмсний хугацаа</b>							
Эхний 3 сар	71.1	66.1	75.7	16.7	11.9	22.8	367
Дунд 3 сар	72.2	69.3	75.0	15.7	13.4	18.4	1172
Сүүлийн 3сар	70.4	67.0	73.6	14.0	11.7	16.8	1219

Хоногт 5 бүлэг хүнсний бүтээгдэхүүн хэрэглэсэн жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь Улаанбаатар хот (20.5%), хот суурин газар (14.8%)-г бусад бүс нутаг, хөдөөгийн эмэгтэйчүүдийн үзүүлэлтээс харьцангуй өндөр байв ( $p < 0.0001$ ). Мөн халх ястан (15.7%), дээд боловсролтой жирэмсэн эмэгтэйчүүдийн (17.7%) дунд 5 нэр төрлийн хүнсний хэрэглээ харьцангуй илүү байв (Хүснэгт РW.14).

ХЧА-д багтсан 8 асуулт нь ХБӨ-өөр өвчлөх эрсдлийг нэмэгдүүлдэг эрүүл бус хүнсний хэрэглээг үнэлэхэд чиглэсэн. Тухайлбал, судалгаанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн хийжүүлсэн ундаа, чихэрлэг ундаа, боловсруулсан махан бүтээгдэхүүн, их тосонд шарж болгосон хоол, хүнс, давс ихтэй зууш, чихэр, амттан, түргэн хоол, бэлэн гоймон зэрэг эрүүл бус хүнсний хэрэглээг судалж, ХБӨ-өөр өвчлөх эрсдлийг үнэлсэн. Судалгааны өмнөх 24 цагт жирэмсэн эмэгтэйчүүдийн 65.4% чихэрлэг, хийжүүлсэн ундаа, 6.7% чипс, шаржигнуур зэрэг давс ихтэй, хэт боловсруулсан зууш, 30.3% их тосонд шарж болгосон хоол, хүнс, 67.0% чихэр, амттан хэрэглэсэн байгаа нь эрүүл бус хүнсний хэрэглээ түгээмэл байгааг илтгэж байна.

Жирэмсэн эмэгтэйчүүдийн хүнсний хэрэглээнд тулгуурлан тэдний ХБӨ-өөс сэргийлэх эрүүл хооллолтыг илтгэх хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг оноогоор үнэлж, дундаж утгыг тооцон, тэдний насны бүлэг, бүс нутаг, оршин суугаа орон нутгийн байршлаар харьцуулан

үнэлэв (Хүснэгт PW15). Хүнсний бүтээгдэхүүнийг 10 бүлэгт хувааж, тэдгээр бүлэгт хамаарах аль нэг бүтээгдэхүүнийг хэрэглэсэн бол 1 оноо, хэрэглээгүй бол 0 оноо өгч, судалгааны өмнөх 24 цагт тухайн хүний хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг 0–10 оноогоор үнэлсэн.

Жирэмсэн эмэгтэйчүүдийн хүнсний нэр төрлийн дундаж оноо 5.4 байгаа бөгөөд Улаанбаатар хот, хот суурин газар, дээд боловсролтой жирэмсэн эмэгтэйчүүдэд харьцангуй өндөр ( $p < 0.0001$ ), харин Баруун бүс, хөдөө орон нутаг, боловсролгүй болон бага боловсролтой жирэмсэн эмэгтэйчүүдэд бага байна (Хүснэгт PW15).

ХБӨ-өөс сэргийлэх үйлдэлтэй эрүүл хүнсний бүтээгдэхүүнийг бүлэглэн хэрэглэсэн бол 1, хэрэглээгүй бол 0 оноо өгч, 0–9 оноогоор үнэлэхэд жирэмсэн эмэгтэйчүүдийн дундаж үзүүлэлт харьцангуй бага буюу 3.0 байв. Өөрөөр хэлбэл, Монголын улсын жирэмсэн эмэгтэйчүүдийн ХБӨ-ний эрсдлээс сэргийлэх эрүүл хүнсний хэрэглээ туйлын хангалтгүй байна. ХБӨ-өөс хамгаалах эрүүл хүнсний хэрэглээний дундаж оноо Улаанбаатар хот, хот суурин газар, дээд боловсролтой эмэгтэйчүүдэд харьцангуй өндөр ( $p < 0.0001$ ), харин Баруун болон Хангайн бүс, хөдөө орон нутаг, боловсролгүй, бага боловсролтой эмэгтэйчүүдэд статистик ач холбогдол бүхий бага байв (Хүснэгт PW15).

Мөн эрүүл бус хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэсэн бол 1–2, хэрэглээгүй бол 0 оноо өгч, ХБӨ-ний эрсдлийг 0–9 оноогоор үнэлсэн. Жирэмсэн эхчүүдийн эрүүл бус хүнсний хэрэглээг илтгэх ХБӨ-ний эрсдлийн дундаж оноо 3.7 байгаа бөгөөд Улаанбаатар хот, хот суурин газар, 20-29 насны жирэмсэн эмэгтэйчүүдэд ялимгүй өндөр байна. Мөн дээд боловсролтой жирэмсэн эмэгтэйчүүдийн ХБӨ-ний эрсдлийн дундаж (3.7) оноо боловсролгүй эмэгтэйчүүдийн үзүүлэлт (3.2)-ээс илүү байв ( $p < 0.0001$ ).

Дараах хүснэгтэд харуулсан “Эрүүл хооллолтын оноо” нь жирэмсэн эмэгтэйчүүдийн судалгаанаас өмнөх 24 цагт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн нь ДЭМБ-ын эрүүл хооллолтын зөвлөмжид хэрхэн нийцэж байгааг илтгэх үзүүлэлт юм. Эрүүл хооллолтын оноог ХБӨ-өөс сэргийлэх болон ХБӨ-өөр өвчлөх эрсдлийн онооны ялгавраар тооцон, 0–18 оноогоор үнэлэх хооллолтын чанарын үнэлгээний удирдамжийг ашиглан тооцсон болно. Жирэмсэн эмэгтэйчүүдийн эрүүл хооллолтыг илтгэх дундаж оноо 8.3 байгаа бөгөөд уг үзүүлэлт тэдний насны бүлэг, боловсролын түвшин, эдийн засгийн бүс, байршлаар ялгаатай байв. Тодруулбал, жирэмсэн эмэгтэйчүүдийн боловсролын түвшин ахих тутам эрүүл хооллолтын дундаж оноо нэмэгдэх зүй тогтол ажиглагдсан бөгөөд дээд боловсролтой эмэгтэйчүүдийн эрүүл хооллолтын дундаж оноо нь боловсролгүй, бага боловсролтой, бүрэн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс өндөр байна ( $p < 0.0001$ ). Мөн Улаанбаатар хот, Хот суурин газрын жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд тус үзүүлэлт статистик ач холбогдол бүхий өндөр байгааг (Хүснэгт PW15) харж болно.



Хүснэгт PW15: Жирэмсэн эмэгтэйчүүдийн хооллолтын чанарыг оноогоор үнэлсэн дүн

Үзүүлэлтүүд	Жинлээгүй тоо	Хүнсний нэр төрөл, оноо (Minimum dietary diversity score)			Эрүүл хооллолт, оноо (Global dietary recommendation score)			ХБӨнөөс сэргийлэх, оноо (NCD-Protect)			ХБӨний эрсдэл, оноо (NCD-Risk)		
		Дундаж	95% ИХ		Дундаж	95% ИХ		Дундаж	95% ИХ		Дундаж	95% ИХ	
			Доод	Дээд		Доод	Дээд		Доод	Дээд		Доод	Дээд
<b>Бүгд</b>	<b>2789</b>	<b>5.4</b>	<b>5.4</b>	<b>5.5</b>	<b>8.3</b>	<b>8.2</b>	<b>8.4</b>	<b>3.0</b>	<b>2.9</b>	<b>3.2</b>	<b>3.7</b>	<b>3.6</b>	<b>3.8</b>
<b>Насны бүлэг</b>													
< 20 нас	83	4.9	4.5	5.3	7.8	7.2	8.3	2.5	2.1	3.0	3.7	3.4	4.0
20-29 нас	1251	5.5	5.3	5.6	8.2	8.0	8.4	3.1	2.9	3.2	3.8	3.7	4.0
30 – 39 нас	1337	5.5	5.3	5.6	8.5	8.3	8.6	3.0	2.8	3.1	3.7	3.6	3.8
40 – 49 нас	118	5.6	5.3	6.0	8.4	8.0	8.8	3.1	2.9	3.2	3.5	3.5	3.7
<b>Бүсээр</b>													
Баруун	560	5.1	5.0	5.3	7.9	7.7	2.2	2.8	2.5	3.0	3.8	3.6	3.9
Хангай	547	4.7	4.5	4.9	7.8	7.6	7.9	2.2	1.9	2.4	3.4	3.3	3.5
Төв	555	5.4	5.2	5.5	8.4	8.1	8.6	3.0	2.8	3.2	3.6	3.5	3.7
Зүүн	566	5.2	5.0	5.4	8.2	8.0	8.5	2.9	2.7	3.1	3.6	3.4	3.7
Улаанбаатар	561	5.9	5.7	6.1	8.7	8.5	8.9	3.5	3.4	3.7	3.8	3.7	4.0
<b>Хот, хөдөөгөөр</b>													
Хот	1486	5.7	5.6	5.9	8.6	8.4	8.7	3.4	3.2	3.5	3.7	3.7	3.9
Хөдөө	1303	4.9	4.7	5.0	7.8	7.7	8.0	2.4	2.2	2.5	3.5	3.5	3.7
<b>Байршлаар</b>													
Нийслэл	561	5.9	5.7	6.1	8.7	8.5	8.9	3.5	3.4	3.7	3.8	3.7	4.0
Аймгийн төв	925	5.4	5.3	5.5	8.3	8.2	8.5	3.0	2.9	3.1	3.6	3.5	3.7
Сум / баг	1303	4.8	4.7	5.0	7.8	7.7	8.0	2.4	2.3	2.6	3.6	3.5	3.7
<b>Яс үндэс</b>													
Халх	2143	5.5	5.3	5.6	8.3	8.2	8.4	3.0	2.9	3.2	3.7	3.6	3.8
Казак	198	5.5	5.5	5.7	8.3	8.0	8.6	3.2	3.0	3.5	3.9	3.7	4.1
Бусад	448	5.4	5.2	5.6	8.4	8.1	8.6	3.0	2.9	3.2	3.6	3.5	3.8
<b>Боловсролын түвшин</b>													
Боловсролгүй	40	4.3	3.8	4.9	7.8	7.1	8.5	2.0	1.4	2.7	3.2	2.7	3.7
Бага	125	4.4	4.1	4.8	7.8	7.2	8.4	2.1	1.7	2.5	3.2	2.9	3.5
Бүрэн дунд	1122	5.1	5.0	5.3	8.0	7.8	8.2	2.7	2.6	2.9	3.7	3.6	3.8
Дээд / магистр	1501	5.7	5.6	5.9	8.6	8.4	8.7	3.4	3.2	3.5	3.7	3.6	3.8
<b>Ажил эрхлэлтийн байдал</b>													
Ажилтай	2044	5.4	5.3	5.5	8.4	8.2	8.5	3.0	2.9	3.2	3.7	3.6	3.7
Ажилгүй	745	5.5	5.3	5.6	8.2	8.0	8.4	3.0	2.9	3.2	3.8	3.6	3.9
<b>Гэрлэлтийн байдал</b>													
Гэрлээгүй	152	5.4	5.1	5.7	8.2	7.8	8.6	3.0	2.7	3.3	3.8	3.4	4.1
Гэрлэсэн	1886	5.4	5.3	5.5	8.4	8.3	8.5	3.0	2.9	3.2	3.6	3.5	3.7
Хамтран амьдардаг	751	5.5	5.3	5.7	8.2	8.0	8.4	3.1	2.9	3.1	3.8	3.7	4.0
<b>Хүүхдийн эцэг хамт амьдардаг</b>													
Тийм	2637	5.4	5.4	5.5	8.3	8.2	8.5	3.0	2.9	3.2	3.7	3.6	3.8
Үгүй	152	5.4	5.1	5.7	8.2	7.8	8.6	3.0	2.7	3.3	3.8	3.4	4.1

## Бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглээ

Сүүлийн жирэмслэлтийн хугацаанд нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 91% ямар нэг төрлийн аминдэм, эрдсийн бэлдмэл хэрэглэсэн байна. Жирэмслэлтийн хугацаанд нийт эмэгтэйчүүдийн 78.1% ямар нэг төрлийн аминдэм, эрдсийн бэлдмэл хэрэглэсэн байна. Хот, хөдөөгийн жирэмсэн эмэгтэйчүүдийн (91.6% ба 88.8%) аминдэм, эрдсийн хэрэглээ ойролцоо түвшинд байв. Аминдэм, эрдсийн хэрэглээг бүсээр авч үзвэл, Хангайн бүс (95.3%) хамгийн их, төвийн бүсэд хамгийн бага (88.0%) байна (Хүснэгт PW.16).

Хүснэгт PW.16: Жирэмслэлтийн явцад бичил тэжээлийн бэлдмэл хэрэглэсэн байдал

Үзүүлэлт	%	95%ИХ		Жинлээгүй тоо
		Дээд	Доод	
<b>Бүгд</b>	<b>91.0</b>	<b>89.1</b>	<b>92.6</b>	<b>1789</b>
<b>Жирэмсний хугацаа</b>				
Эхний 3 сар	81.1	76.5	71.2	367
Дунд 3 сар	94.0	91.8	88.9	1177
Сүүлийн 3 сар	97.0	95.9	94.3	1221
<b>Насны бүлэг</b>				
< 20 нас	89.1	80.2	66.8	83
20-29 нас	93.4	91.5	89.1	1254
30-39 нас	93.4	91.5	89.2	1340
40-49 нас	93.2	88.1	80.0	119
<b>Яс үндэс</b>				
Халх	93.1	91.5	89.5	2150
Казак	93.4	89.8	84.6	198
Бусад	92.0	88.6	84.0	448
<b>Бүсээр</b>				
Баруун	91.3	88.4	84.6	560
Хангай	97.5	95.3	91.3	547
Төв	90.8	88.0	84.3	560
Зүүн	91.3	88.7	85.5	567
Улаанбаатар	94.3	91.6	87.8	562
<b>Хот, хөдөөгөөр</b>				
Хот	93.6	91.6	89.0	1488
Хөдөө	92.1	89.9	87.2	1308
<b>Боловсрол</b>				
Боловсролгүй	86.3	74.9	58.7	40
Бага	88.6	81.8	72.3	127
Дунд	91.8	89.7	87.2	1125
Дээд	94.7	92.8	90.3	1504
<b>Ажил эрхлэлтийн байдал</b>				
Ажилгүй	92.5	90.6	88.3	2050
Ажилтай	94.0	92.0	89.4	746
<b>Байршлаар</b>				
Нийслэл хот	94.3	91.6	87.8	562.0
Аймгийн төв	93.4	91.5	89.2	926.0
Сумын төв/Баг	92.1	89.9	87.2	1308.0
<b>Гэрлэлтийн байдал</b>				
Гэрлэсэн	93.5	91.8	89.9	1892
			доод	дээд		доод	дээд		доод	дээд		доод	дээд			
Нийт	2427	7.6	6.5	8.9	30.9	28.6	33.4	36.9	34.1	39.9	16.4	14.8	18.2	8.1	6.6	9.8
<b>Хүйсээр</b>																
Эрэгтэй	1155	7.6	6.1	9.5	34.1	30.6	37.7	36.3	32.2	40.7	15.3	12.8	18.2	6.7	4.9	9.1
Эмэгтэй	1272	7.7	6.1	9.6	27.9	24.9	31.1	37.5	34.4	40.7	17.5	15.1	20.3	9.4	7.5	11.7
<b>Бүсээр</b>																
Баруун	480	7.2	5.0	10.2	39.7	34.9	44.8	37.6	33.0	42.4	11.4	8.8	14.7	4.1	2.2	7.4
Хангай	481	10.8	8.5	13.6	33.6	27.6	40.2	33.8	28.6	39.4	14.1	11.5	17.1	7.7	5.5	10.8
Төв	461	9.2	6.1	13.6	26.6	21.7	32.1	40.3	34.0	46.9	15.8	11.8	20.8	8.2	5.3	12.6
Зүүн	507	8.8	6.6	11.7	31.6	27.7	35.8	35.6	31.1	40.3	14.4	11.1	18.6	9.6	7.4	12.4
Улаанбаатар	498	6.0	4.4	8.1	28.8	25.3	32.7	37.1	32.1	42.3	19.1	16.3	22.2	9.0	6.5	12.4
<b>Хот, хөдөөгөөр</b>																
Хот	1097	6.6	5.2	8.4	29.3	26.2	32.6	37.6	33.6	41.8	17.5	15.2	20.0	9.0	7.0	11.5
Хөдөө	1330	9.7	8.1	11.6	34.2	30.9	37.6	35.6	32.5	38.8	14.3	12.3	16.6	6.3	4.8	8.2
<b>Сургуулийн байршлаар</b>																
Дүүрэг	501	6.0	4.4	8.1	28.9	25.3	32.7	37.0	32.0	42.2	19.1	16.3	22.2	9.1	6.6	12.4
Аймгийн төв	594	7.9	5.3	11.6	29.6	23.6	36.3	39.7	33.5	46.3	14.0	11.0	17.8	8.7	6.3	12.1
Сумын төв	1332	9.9	8.3	11.7	34.6	31.4	38.0	35.3	32.3	38.5	13.9	11.8	16.2	6.3	4.8	8.2
<b>Насаар</b>																
12-15 нас	1494	8.6	7.1	10.4	35.4	32.3	38.7	35.9	32.7	39.3	13.6	11.7	15.8	6.4	4.9	8.4
16-18 нас	933	6.1	4.6	8.0	23.9	20.5	27.7	38.5	34.4	42.8	20.8	18.0	24.0	10.7	8.2	13.7

Хүснэгт SC.50: ЕБС-ийн 12–18 насны хүүхдийн гадаа тоглоход зарцуулдаг хугацаа

Үзүүлэлт	Жинлээгүй тоо	Гадаа тоглодоггүй			< 1 цаг			1-2 цаг			> 2 цаг		
		%	95% ИХ		%	95% ИХ		%	95% ИХ		%	95% ИХ	
			доод	дээд		доод	дээд		доод	дээд		доод	дээд
Нийт	2427	44.3	41.6	47.0	21.9	19.5	24.5	22.5	20.5	24.7	11.3	9.5	13.4
<b>Хүйсээр</b>													
Эрэгтэй	1155	28.0	24.8	31.5	24.5	20.9	28.6	29.2	25.7	33.0	18.2	15.1	21.8
Эмэгтэй	1272	59.9	56.2	63.4	19.4	16.9	22.1	16.1	13.6	18.9	4.7	3.4	6.4
<b>Бүсээр</b>													
Баруун	480	34.2	27.4	41.6	20.8	16.8	25.5	33.4	28.6	38.6	11.7	8.0	16.8
Хангай	481	42.6	35.5	50.1	27.7	23.0	33.1	20.8	16.6	25.8	8.8	6.0	12.7
Төв	461	42.3	37.1	47.6	19.0	15.1	23.6	25.7	21.3	30.8	13.0	9.2	18.1
Зүүн	507	39.9	32.9	47.3	22.9	18.6	27.9	25.5	21.1	30.4	11.7	7.8	17.4
Улаанбаатар	498	48.8	44.6	52.9	20.9	16.8	25.6	18.8	15.6	22.5	11.6	8.6	15.3
<b>Хот, хөдөөгөөр</b>													
Хот	1097	48.7	45.3	52.2	21.2	18.0	24.8	19.9	17.2	22.8	10.2	7.9	13.1
Хөдөө	1330	35.3	31.4	39.4	23.3	20.1	26.9	27.8	24.8	31.1	13.6	11.2	16.2
<b>Сургуулийн байршлаар</b>													
Дүүрэг	501	48.8	44.7	52.9	21.0	16.9	25.8	18.7	15.5	22.3	11.6	8.6	15.3
Аймгийн төв	594	50.4	44.1	56.7	21.4	17.5	25.7	21.5	17.7	26.0	6.7	4.0	10.9
Сумын төв	1332	34.4	30.5	38.4	23.6	20.4	27.0	28.6	25.5	31.9	13.5	11.2	16.2
<b>Насаар</b>													
12-15 нас	1494	37.8	34.7	41.1	24.7	21.6	28.1	25.3	22.4	28.5	12.2	9.9	14.9
16-18 нас	933	54.4	50.2	58.5	17.5	14.4	21.1	18.1	15.0	21.7	10.0	7.5	13.1

Хүснэгт SC.51: ЕБС-ийн 12–18 насны хүүхдийн спортын дугуйлан, секцэд хамрагдалт

Үзүүлэлт	Жинлээгүй тоо	Танай сургуульд спортын дугуйлан (секц), сонгон суралцах хичээл байдаг уу?									Сүүлийн 1 жил спортын аль нэг төрлөөр хичээллэж байна уу?								
		Тийм			Үгүй			Мэдэхгүй / хариулаагүй			Тийм			Үгүй			Мэдэхгүй / хариулаагүй		
		%	95% ИХ		%	95% ИХ		%	95% ИХ		%	95% ИХ		%	95% ИХ		%	95% ИХ	
			доод	дээд		доод	дээд		доод	дээд		доод	дээд		доод	дээд		доод	дээд
Нийт	2427	77.1	72.8	80.9	15.8	12.7	19.6	7.1	5.5	9.0	61.7	59.1	64.2	36.3	33.7	39.0	2.0	1.4	2.9
<b>Хүйсээр</b>																			
Эрэгтэй	1155	78.0	73.4	81.9	13.8	11.0	17.3	8.2	6.3	10.6	67.6	63.9	71.1	30.4	26.9	34.2	2.0	1.2	3.4
Эмэгтэй	1272	76.3	71.4	80.6	17.7	13.8	22.4	6.0	4.3	8.2	56.0	52.2	59.7	42.0	37.9	46.1	2.1	1.3	3.2
<b>Бүсээр</b>																			
Баруун	480	83.8	76.0	89.4	13.7	8.4	21.4	2.6	1.4	4.5	61.1	55.1	66.8	37.8	32.0	43.9	1.1	0.5	2.4
Хангай	481	74.4	60.3	84.8	19.0	10.8	31.3	6.6	4.2	10.1	60.9	56.8	64.7	35.9	32.3	39.6	3.3	1.9	5.6
Төв	461	88.5	83.2	92.2	6.6	3.9	11.1	4.9	3.0	8.0	64.8	59.0	70.2	33.5	28.3	39.0	1.7	0.9	3.4
Зүүн	507	84.5	76.9	89.9	10.2	6.1	16.7	5.3	3.5	8.0	63.0	57.6	68.1	34.4	29.4	39.9	2.5	1.6	4.2
Улаанбаатар	498	71.9	64.8	78.1	18.8	13.8	25.0	9.3	6.5	13.0	61.0	56.4	65.4	37.2	32.5	42.1	1.8	0.9	3.8
<b>Хот, хөдөөгөөр</b>																			
Хот	1097	74.3	68.1	79.6	16.9	12.7	22.3	8.8	6.6	11.5	60.5	56.9	63.9	37.4	33.8	41.1	2.2	1.3	3.5
Хөдөө	1329	82.8	78.1	86.6	13.6	10.1	18.1	3.6	2.7	4.9	64.1	61.0	67.0	34.1	31.1	37.3	1.8	1.2	2.7
<b>Сургуулийн байршлаар</b>																			
Дүүрэг	501	71.9	64.7	78.0	18.8	13.9	25.1	9.3	6.5	13.0	60.9	56.3	65.3	37.3	32.6	42.2	1.8	0.9	3.8
Аймгийн төв	594	81.0	66.4	90.1	11.4	4.7	24.9	7.6	5.3	10.9	59.0	54.2	63.7	38.0	33.8	42.4	3.0	1.7	5.1
Сумын төв	1332	82.7	78.1	86.4	13.9	10.4	18.2	3.5	2.5	4.7	64.2	61.2	67.2	34.0	30.9	37.2	1.8	1.2	2.6
<b>Насаар</b>																			
12-15 нас	1494	78.0	73.0	82.3	14.0	10.8	18.0	8.0	6.1	10.5	62.6	59.4	65.7	34.9	31.7	38.3	2.4	1.5	3.9
16-18 нас	933	75.8	70.5	80.4	18.7	14.2	24.2	5.6	3.6	8.5	60.1	55.6	64.5	38.5	34.1	43.0	1.4	0.8	2.4



## ЕБС-ийн бага ангийн хүүхдийн “Үдийн хоол”-ны талаарх сэтгэл ханамжийн байдал

ЕБС-ийн суралцагчдын “Үдийн хоол”-ны сэтгэл ханамжийн судалгааг 1-5 дугаар ангийн суралцагч буюу 6-10 насны 1995 хүүхдүүдийн дунд явуулав. Суралцагчдын үдийн хоолонд өгөх үнэлгээг 6 асуулт бүхий мэдээлэлд маш муу, муу, дунд, сайн, маш сайн гэсэн хариултаар дүгнэв.

Бага ангийн суралцагчдын дийлэнх хувь нь (84.9%) сургуулийн үдийн хоолонд сайн, маш сайн үнэлгээг өгсөн бол 2.9% нь муу, маш муу үнэлгээг өгчээ. Муу, маш муу үнэлгээг Улаанбаатар хотод суралцагчдын 3.3%, хангайн бүсийн суралцагчдын 3.3%, зүүн бүсэд суралцагчдын 3.2% нь тус тус өгсөн байна.

Хүснэгт SC.52: Бага ангийн суралцагчдын үдийн хоолны талаарх сэтгэл ханамжийн байдал

Үзүүлэлт	N	Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн	Мэдэхгүй
	1995	1.5	1.4	11.0	41.5	43.4	1.2
<b>Хүйсээр</b>							
Хөвгүүд	1011	1.7	1.2	9.8	43.8	42.3	1.2
Охид	984	1.2	1.6	12.2	39.2	44.6	1.3
<b>Бүсээр</b>							
Баруун	413	0.8	0.2	11.1	39.0	48.3	0.6
Хангай	350	1.0	2.1	9.8	35.7	50.8	0.7
Төв	419	0.7	1.7	8.5	47.3	41.2	0.6
Зүүн	407	1.0	2.1	9.6	34.6	50.2	2.5
Улаанбаатар	406	2.0	1.3	12.2	43.0	39.9	1.6
<b>Хот, хөдөөгөөр</b>							
Хот	860	1.9	1.4	11.3	42.6	41.4	1.3
Хөдөө	1135	0.4	1.4	10.2	39.2	47.7	1.0
<b>Сургуулийн байршлаар</b>							
Нийслэл	406	2.0	1.3	12.2	43.0	39.9	1.6
Аймгийн төв	454	1.7	1.6	8.6	41.6	45.9	0.6
Сум, баг	1135	0.4	1.4	10.2	39.2	47.7	1.0
<b>Насаар</b>							
6	339	1.8	1.4	6.6	45.3	43.9	1.1
7	285	0.8	1.3	9.3	39.8	48.5	0.3
8	324	1.9	0.6	6.7	43.9	45.7	1.1
9	362	1.2	0.6	10.5	42.1	44.4	1.1
10	452	1.2	1.9	13.9	41.9	39.8	1.3
11	233	1.9	2.9	21.3	32.6	38.3	3.0

Бага ангийн суралцагчдын 77.3% нь үдийн хоолны хэмжээ хангалттай гэжээ. Харин аймгийн төвд суралцагчдын 9.2%, хангайн бүсэд суралцагчдын 9.8% нь үдийн хоолны хэмжээг муу, маш муу гэж дүгнэжээ.

Хүснэгт SC.53: Суралцагчдын үдийн хоолны хэмжээний талаарх сэтгэл ханамжийн байдал

Үзүүлэлт	Тоо	Үдийн хоолны хэмжээ хангалттай байдаг					
		Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн	Мэдэхгүй
	1996	1.1	4.1	15.4	43.3	34.0	2.0
<b>Хүйсээр</b>							
Хөвгүүд	1013	1.1	4.2	17.5	44.1	31.3	2.0
Охид	983	1.2	4.1	13.2	42.6	36.9	2.0
<b>Бүсээр</b>							
Баруун	413	0.3	4.9	12.0	39.7	41.7	1.4
Хангай	351	2.0	7.8	13.1	31.4	44.0	1.7
Төв	419	1.1	1.5	12.7	51.4	32.1	1.2
Зүүн	408	1.5	4.4	16.0	41.6	33.3	3.2
Улаанбаатар	405	1.1	3.6	17.5	45.5	30.0	2.3
<b>Хот, хөдөөгөөр</b>							
Хот	859	1.1	4.7	16.7	43.9	31.6	2.0
Хөдөө	1137	1.2	3.0	12.6	42.2	39.0	1.9
<b>Сургуулийн байршлаар</b>							
Нийслэл	405	1.1	3.6	17.5	45.5	30.0	2.3
Аймгийн төв	454	1.3	7.9	14.1	38.8	36.6	1.1
Сум, баг	1137	1.2	3.0	12.6	42.2	39.0	1.9
<b>Насаар</b>							
6	338	1.3	3.5	16.1	49.4	27.7	1.9
7	286	1.7	8.1	11.9	46.7	30.9	0.7
8	324	2.1	2.2	12.8	49.3	32.7	0.9
9	362	0.2	1.3	14.4	37.0	43.3	3.8
10	451	1.2	3.6	16.7	39.9	37.3	1.4

ЕБС-ийн 6-11 насны суралцагчдын 52.2% нь үдийн хоолонд шинэ жимс, төрөл бүрийн ногоо, сүү, таргийг сайн болон маш сайн өгдөг гэж хариулжээ. Харин 4 хүүхэд тутмын нэг нь маш муу болон муу гэж хариулсан байна (Хүснэгт SC.54).

Хүснэгт SC.54: Суралцагчдын үдийн хоолонд жимс, ногоо, тараг өгдөг талаарх сэтгэл ханамжийн байдал

Үзүүлэлт	Тоо	Үдийн хоолонд шинэ жимс, төрөл бүрийн ногоо, сүү, тараг өгдөг					
		Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн	Мэдэхгүй
	1999	8.3	16.4	20.8	34.0	18.2	2.3
<b>Хүйсээр</b>							
Хөвгүүд	1013	7.6	17.5	18.3	35.2	18.5	2.9
Охид	986	9.1	15.3	23.3	32.7	17.9	9.1
<b>Бүсээр</b>							
Баруун	413	8.4	8.9	19.2	36.3	25.9	1.3
Хангай	353	8.8	18.7	25.1	33.0	13.6	0.7
Төв	419	4.2	17.9	14.3	37.4	24.9	1.3

Зүүн	407	8.2	9.1	24.3	34.1	21.3	3.0
Улаанбаатар	407	9.5	18.0	21.3	32.7	15.3	3.2
<b>Хот, хөдөөгөөр</b>							
Хот	862	8.7	18.2	20.8	32.9	16.6	2.8
Хөдөө	1137	7.6	12.6	20.8	36.3	21.5	1.1
<b>Сургуулийн байршлаар</b>							
Нийслэл	407	9.5	18.0	21.3	32.7	15.3	3.2
Аймгийн төв	455	6.2	18.8	19.1	33.5	20.6	1.8
Сум, баг	1137	7.6	12.6	20.8	36.3	21.5	1.1
<b>Насаар</b>							
6	339	10.8	18.2	12.8	36.0	20.2	2.0
7	286	9.5	13.2	23.9	29.7	22.3	1.4
8	324	7.6	20.8	17.4	36.4	15.8	2.0
9	363	8.7	13.6	19.7	35.5	21.2	1.3
10	451	7.3	17.8	27.9	30.8	14.4	1.9

“Үдийн хоол” хөтөлбөрт хамрагддаг нийт суралцагчдын 82.1% нь өдөр бүр өөр, өөр нэр төрлийн хоол хүнсийг сайн болон маш сайн өгдөг гэж хариулжээ (Хүснэгт SC.55).


Хүснэгт SC.55: Суралцагчдын үдийн хоолны нэр төрлийн талаарх сэтгэл ханамжийн байдал

Үзүүлэлт	Тоо	Үдийн хоолонд өдөр бүр олон нэр төрлийн хоол өгдөг					
		Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн	Мэдэхгүй
		1996	1.3	2.2	12.5	46.2	35.9
<b>Хүйсээр</b>							
Хөвгүүд	1012	1.9	2.2	13.0	45.3	35.9	1.8
Охид	984	0.7	2.2	12.1	47.1	35.9	2.0
<b>Бүсээр</b>							
Баруун	412	0.3	2.0	20.4	37.8	38.2	1.3
Хангай	351	1.5	0.8	11.0	42.7	42.7	1.3
Төв	419	0.8	1.1	8.6	52.1	35.3	2.0
Зүүн	407	2.2	1.5	12.0	41.6	39.2	3.6
Улаанбаатар	407	1.6	3.1	12.3	48.0	33.1	2.0
<b>Хот, хөдөөгөөр</b>							
Хот	860	1.6	2.7	12.3	46.9	34.7	1.7
Хөдөө	1136	0.7	1.1	12.9	44.8	38.3	2.3
<b>Сургуулийн байршлаар</b>							
Нийслэл	407	1.6	3.1	12.3	48.0	33.1	2.0
Аймгийн төв	453	1.8	1.8	12.4	43.2	39.8	1.0
Сум, баг	1136	0.7	1.1	12.9	44.8	38.3	2.3
<b>Насаар</b>							
6	339	1.3	1.0	16.8	48.0	31.0	1.9
7	286	1.8	2.3	10.5	51.5	32.6	1.2
8	322	0.2	2.1	12.1	48.7	35.5	1.4
9	363	1.1	0.5	9.0	46.9	40.5	2.0
10	452	2.3	2.7	12.7	41.9	39.5	1.0

## Хэлцэмж

### ЕБС-ийн 6-11 насны суралцагчийн судалгаа


Хүн амын хоол тэжээлийн үндэсний VI судалгаагаар 6–11 насны хүүхдийн биеийн жин, өндрийг антропометрийн хэмжилтээр тодорхойлж, уураг илчлэг дутал болон илүүдэл жин, таргалалтын тархалтыг тогтоосон. Сургуулийн 6-11 насны хүүхдийн дундах уураг илчлэг дутал болон илүүдлийн тархалтыг 2017 онд зохион байгуулагдсан “Хүн амын хоол тэжээлийн үндэсний V судалгаа”-ны дүнтэй харьцуулан үнэлэхэд, туранхай, өсөлт хоцролтын тархалт буурсан, харин илүүдэл жин ба таргалалттай хүүхдийн түвшин ойролцоо байна (зураг SC.1).



Зураг SC.1: ЕБС-ийн 6-11 насны суралцагчдын хоол тэжээлийн байдал


Манай улс ИДЭ-ийг утсгах зорилгоор “Иод дутлын эмгэгтэй тэмцэх” үндэсний хөтөлбөрийг 1996–2010 онд 3 үе шаттайгаар хэрэгжүүлсэн байдаг. Үүний үр дүнд Монгол улсын нийт хүн амын дунд ИДЭ-ийн тархалт жилээс жилд тогтвортой буурсан хэдий ч хөтөлбөр дууссанаас хойш иод дутлын тархалт нэмэгдсэн байна.

Сургуулийн хүүхдийн шээсэнд агуулагдах иодын голч хэмжээ 100 мкг/л–ээс бага байвал иоджуулсан бүтээгдэхүүний хэрэглээ багатай буюу иодын дуталтай гэж үнэлдэг. Хүн амын хоол тэжээлийн байдал үндэсний VI судалгааны дүнгээр 6-11 насны хүүхдийн шээсэнд агуулагдах иодын голч хэмжээ буурч (93.6 мкг/л) 20 жилийн өмнөх түвшиндээ хүрсэн байна. (зураг SC.2).



Зураг SC.2: ЕБС-ийн 6-11 насны хүүхдийн шээсээр ялгарах иодын голч хэмжээ, судалгааны оноор

Сургуулийн 6–11 насны суралцагчийн иод дутал, иоджуулсан давсны талаарх мэдлэгийг судлахад 7.2% иод дутлын талаар, 18.9% иоджуулсан давсны талаар тус тус сонссон байв. Энэ үзүүлэлтийг өмнөх онуудад хийгдсэн судалгааны дүнтэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна (Зураг SC.3).




Зураг SC.3: Иод дутал, иоджуулсан давсны талаар сонссон суралцагчид, судалгааны оноор

### ЕБС-ийн 12-18 насны хүүхдийн судалгаа

Сүүлийн жилүүдэд өсвөр үеийнхний таргалалт нэмэгдэж байгааг дараах судалгааны дүнгүүд нотлож байна. Тухайлбал, 2019-2021 онд хэрэгжсэн ШУТ-ийн захиалгат төсөл “Өсвөр үеийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлс, урьдчилан сэргийлэх асуудал” (ӨҮЭМЭХЗУСА)


судалгаагаар илүүдэл жин ба таргалалттай хүүхдийн хувь 24.7% байсан бол энэ удаагийн судалгаагаар 29.3% болж нэмэгдсэн байна (Зураг SC.4). Цаашид өсвөр насны хүүхдийн илүүдэл жин, таргалалтыг бууруулах арга хэмжээг өргөн цар хүрээтэйгээр зохион байгуулах шаардлагатайг харуулж байна.



Зураг SC.4. ЕБС-ийн 13-18 насны суралцагчдын илүүдэл жин, таргалалтын тархалт

Өглөөний цайгаа тогтмол уудаг болон уудаггүй суралцагчдын хувь 2019 онд хийсэн ӨҮЭМЭХЗУСА судалгааны дүн (61.5%, 7.9%)-ээс буурсан байна. Тиймээс боловсролын байгууллагын зүгээс хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч нарт зориулсан өглөөний цайг тогтмол уухын ач холбогдлын талаар сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй юм.

ЕБС-ийн 12-18 насны суралцагчдын 7 хоногт өдөр бүр нэг ба түүнээс олон удаа жимс, жимсгэнэ хэрэглэсэн үзүүлэлт 4.6% байгаа нь 2019 оны судалгааны дүн (16.3%)-тэй харьцуулахад 3.5 дахин буурсан байв. (зураг SC.5). Жимс, хүнсний ногооны хэрэглээ хангалтгүй байх нь ХБӨ-өөр өвчлөх анхдагч эрсдэлт хүчин зүйлсүүдийн нэгд хамааруулдаг. Өсвөр үеийнхий жимс ногооны хэрэглээ нь зохистой хооллолтын зөвлөмж хэмжээнд хүрэхгүй, хөдөө орон нутагт бага үзүүлэлттэй байгаа нь жимс, хүнсний ногооны хүртээмж, олдоц муу, өртөг өндөр зэргээс шалтгаалсан байх магадлалтай. Мөн өсвөр үеийнхэнд өдөр бүр 2 аяга ба түүнээс дээш сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэхийг зөвлөдөг. Энэ удаагийн судалгаагаар суралцагчдын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ 18.2 пунктээр буурсан байна. Иймээс цаашид сурагчдын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх, өдөр бүр сүү хэрэглэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.




Зураг SC.5: ЕБС-ийн 12-18 насны суралцагчдын жимс, ногоо, сүү, цагаан идээний хэрэглээ

Судалгаанд хамрагдсан өсвөр үеийнхний чихэрлэг болон хийжүүлсэн ундааны хэрэглээ 42.4% байгаа нь 2019 оны судалгааны дүн (41.8%)-тэй харьцуулахад ойролцоо үзүүлэлттэй байна. Суралцагчдын 7 хоногт 3 ба түүнээс дээш удаа их тосонд шарж болгосон хоол, хүнсний хэрэглээ 30.8% байгаа нь өмнөх судалгааны дүнгээс (41.7%) 10.9%-иар буурсан байв.

Чихэрлэг хүнсийг 7 хоногт 3 ба түүнээс дээш удаа хэрэглэдэг суралцагчдын хувь 44.9% байгаа нь ӨҮЭМЭХЗУСА судалгааны дүнгээс 19.0%-иар буурсан боловч 2 суралцагч тутмын нэг нь чихэрлэг хүнсийг 7 хоногт 3 ба түүнээс олон удаа хэрэглэж байна.

Чихэр, шоколадыг 7 хоногт 3 ба түүнээс олон удаа хэрэглэдэг суралцагчдын хувь 40.9% байгаа нь ӨҮЭМЭХЗУСА судалгааны дүн (62.4%)-гээс 21.5 хувиар буурсан байна.




Зураг SC.6: ЕБС-ийн 12-18 насны суралцагчдын эрүүл бус хүнсний хэрэглээ, оноор

Өсвөр үеийнхний хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон сургуулийн эргэн тойронд хамгийн олон удаа харж байсан хүнсний зар сурталчилгаанд түргэн хоол буюу пицца, бургер (59.1%), хийжүүлсэн ундаа (14.0%), чихэрлэг ундаа (10.9%) гэж хариулсан нь тэдний хүнс, хоолны сонголтод зар сурталчилгаа нөлөөлдөг болохыг баталж байна.

ЕБС-ийн 12-18 насны суралцагчдын давстай цайны хэрэглээ 25.6% байгаа нь 2019 оны судалгааны дүн (22.9%)-тэй харьцуулахад өссөн дүнтэй байна. Өсвөр үеийн 2 хүүхэд тутмын нэг нь (53.1%) сүүлийн 7 хоногт түргэн хоолны газар, цайны газар, сургуулийн цайны газраар үйлчлүүлж байгаа нь ӨҮЭМЭХЗУСА-ны дүн (33.7%)-гээс өссөн үзүүлэлттэй байв.

### Хөдөлгөөний идэвх

ЕБС-ийн 12-18 насны суралцагчдын 13.6% нь өдөр бүр хамгийн багадаа 60 минут идэвхтэй хөдөлгөөн хийж байгаа нь ӨҮЭМЭХЗУСА судалгааны дүн (20.8%)-тэй харьцуулахад буурсан байв. Өсвөр насны 2 хүүхэд тутмын нэг нь (49.9%) 7 хоногт 3-аас бага өдөр идэвхтэй хөдөлгөөн хийж байгаа нь 2019 оны дүнтэй харьцуулахад ижил түвшинд байна. Өдөрт 3-аас дээш цаг идэвхгүй хөдөлгөөнтэй байдаг суралцагчдын хувь 61.4% байгаа нь ӨҮЭМЭХЗУСА судалгааны дүн (38.3%)-гээс 23.1%-иар нэмэгдсэн байна. Ямар нэг спортоор хичээллэдэггүй суралцагчдын хувь 36.5% байгаа нь дээрх судалгааны дүнтэй харьцуулахад ойролцоо үзүүлэлттэй байна.



Зураг SC.7: ЕБС-ийн 12-18 насны суралцагчдын хөдөлгөөний идэвхийн байдал, хувиар

### Дүгнэлт

1. ЕБС-ийн суралцагчдын 2.6% өсөлт хоцролттой, 2.3% туранхай буюу өндөртөө тохирохгүй бага жинтэй, 19.6% илүүдэл жинтэй, харин 6.2% тарган байна. ЕБС-ийн 1-5 дугаар ангийн суралцагчдын 23.7% нь илүүдэл жин ба таргалалттай байгаа нь 2017 онд хийгдсэн “Хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний V судалгааны дүн (22.2%)-гээс өссөн байна.
2. ЕБС-ийн суралцагчдын 7.6% нь цус багадалттай, 67.3% нь Д аминдэм дуталтай, 21.8% нь Д аминдэмийн нөөц дутмаг байв.



3. ЕБС-ийн 6–11 насны хүүхдийн шээсээр ялгарах иодын голч хэмжээ зохистой түвшинд хүрэхгүй (иод  $\geq 100$  мкг/л) буюу 93.6 мкг/л байгаа нь 2017 оны судалгааны дүнгээс (144.6 мкг/л) буурсан байна.
4. ЕБС-ийн 6-11 насны суралцагчдын 73.2% өглөөний цай уудаг байна. Өглөөний цагаа тогтмол уух дадал хүүхдийн өглөө эсвэл өдрийн ээлжид хичээллэдэг байдлаас хамаарч ялгаатай байв.
5. Бага ангийн суралцагчдын 12.6% жимс, жимсгэнэ, 53.3% хүнсний ногоо, 25.1% сүү, сүүн бүтээгдэхүүнийг долоо хоногт 5-аас олон өдөр хэрэглэж байна.
6. ЕБС-ийн 6-11 насны суралцагчдын 11.7% чихэрлэг ундаа, 17.3% чихэрлэг хүнс, 20.4% их тосонд шарж болгосон хүнсийг долоо хоногт 3-с олон удаа хэрэглэж байв.
7. Бага ангийн суралцагчдын 84.9% сургуулийн үдийн хоолыг сайн, маш сайн гэж үнэлсэн байна. Мөн суралцагчдын 77.3% үдийн хоолны хэмжээ хангалттай, 52.2% үдийн хоолоор хүнсний ногоо, сүү, тараг өгдөг, 82.1% олон төрлийн хоол өгдөг гэж тус тус хариулсан байна.
8. ЕБС-ийн 12-18 насны суралцагчдын 7.9% өглөөний цай огт уудаггүй, 37.2% тогтмол ууж байв. Өглөөний цай уудаггүй хүүхдүүдийн 79.5% цаг хангалтгүй байдаг, 11.0% өглөө юм идэх сонирхолгүй гэж хариулжээ.
9. ЕБС-ын 12-18 насны суралцагчдын 4.6% өдөр бүр жимс, жимсгэнэ иддэг, 49.5% өдөр бүр хүнсний ногоо иддэг, 17.9% өдөр бүр сүү, цагаан идээ хэрэглэдэг байв.
10. Нийт 12-18 насны суралцагчдын 42.4% хийжүүлсэн, чихэрлэг ундаа, 30.8% их тосонд шарсан хүнс, 44.9% чихэрлэг хүнс, 40.9% чихэр шоколадны хэрэглэж байна.
11. ЕБС-ийн 12-18 насны суралцагчдын 53.1% 7 хоногт нэг ба түүнээс олон удаа түргэн хоолны газар, цайны газраар үйлчлүүлсэн, 33.8% өдөрт 1-3 аяга буюу маш бага хэмжээний ус уудаг, 25.6% давстай цай тогтмол ууж байв.
12. ЕБС-ийн 12-18 насны суралцагчдын 11.2% идэвхтэй хөдөлгөөн огт хийдэггүй, 92.4% нэг цаг болон түүнээс дээш хугацаагаар хөдөлгөөнгүй суудаг, 22.9% спортын дугуйланд явах боломжгүй гэж хариулсан бөгөөд 44.3% гадаа тоглодоггүй байна.

## **НЭГДСЭН ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ**

Засгийн газраас хүн амын хоол тэжээлийн дутлыг бууруулах асуудалд анхаарч ажилласны үр дүнд Монгол Улсын Мянганы хөгжлийн “Хоол тэжээлийн дуталтай хүн амын тоог 6 дахин бууруулах” зорилтыг бүрэн хангасан хэдий ч хоол тэжээлээс авч буй шимт бодис, амин дэм, эрдэс бодисын хэмжээ хангалтгүй, нийт хүн амын жимс жимсгэнэ, хүнсний ногооны хэрэглээ бага буюу хүн амын зохистой хооллолтын талаарх зөвлөмжид заасан хэмжээнд хүрэхгүй байгааг, Хоол тэжээлийн үндэсний VI судалгаагаар тогтоосон. Мөн бичил тэжээлийн дутлын тархалт түгээмэл хэвээр, илүүдэл жин ба таргалалтын тархалт нэмэгдэж байгаа нь хоол тэжээлийн дутал болон илүүдлийн эмгэгийн давхар дарамт хурдтайгаар өсөн нэмэгдэж, хувь хүн болоод гэр бүлийн амьдралын чанарт сөргөөр нөлөөлөн, эрүүл мэндийн салбарын эдийн засгийн зардлыг нэмэгдүүлж, улмаар улс орны урт хугацааны хөгжилд саатуулагч хүчин зүйл болон хувирах нөхцөл бүрдээд байна. Иймд хоол тэжээлийн байдлыг сайжруулах асуудлыг зөвхөн эрүүл мэндийн салбарын хүрээнд бус харин хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, худалдаа, нийгмийн хамгаалал, боловсрол, дэд бүтэц зэрэг бусад салбарын оролцоо, хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### **Бичил тэжээлийн дутал нь нийт хүн амын дунд түгээмэл, Монгол Улсын нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болж байна.**

“Хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний VI судалгаагаар бичил тэжээлийн дутал нь Монгол Улсын хүн амын бүх бүлэг, ялангуяа нялх, бага насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд түгээмэл тархалттай байна. Судалгааны дүнгээр 6-59 сартай хүүхдийн 7.1% А аминдэм дуталтай, 2010 болон 2017 оны судалгааны дүн (ХТҮС-IV ба V, 2010 ба 2017 он)-гээс буурсан хэдий ч, нөөц дутмаг буюу дуталд өртөх эрсдэлтэй хүүхдийн хувь өндөр (57.9%) хэвээр байна. Энэ нь Монгол Улсын нийгмийн эрүүл мэндийн салбарын өмнө тулгарч буй томоохон асуудал бөгөөд үүнийг харилцан бие биенээ дэмжсэн, уялдаа холбоотой, олон талт цогц арга хэмжээг хэрэгжүүлэх замаар шийдвэрлэх боломжтой.

Нялх, бага насны хүүхдийн нэмэгдэл хооллолтын дадлыг тэдний хооллолтын чанар, тоо хэмжээг илтгэх жишиг үзүүлэлтээр тогтоож, хоол тэжээлийн үндэсний IV ба V судалгааны дүнтэй харьцуулан үнэлэхэд, хооллолтын чанар төдийлөн сайжраагүй, харин зохих давтамжаар хооллож байгаа хүүхдийн хувь 2017 оны түвшнээс нэлээд буурсан байна. Иймд нялх, бага насны хүүхдийн хоол хүнсний чанарыг сайжруулахын тулд тэднийг олон нэр төрлийн тэжээллэг хүнсээр хооллохын ач холбогдлыг эхчүүд, асрамжлагчдад таниулан ойлгуулах шаардлагатай байна. Нялх, бага насны хүүхдийн хооллолтын чанарыг илтгэх хамгийн чухал үзүүлэлт бол өдөрт хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл юм. Бага насны хүүхдийн эрүүл,

зохистой хооллолтын зөвлөмжид хүүхэд өдөрт хамгийн багадаа эхийн сүүг оролцуулаад 5 нэр төрлийн хүнс хэрэглэхийг заасан. Энэхүү зөвлөмжийн дагуу хооллож буй хүүхдийг “хүнсний нэр төрлийн хамгийн бага шаардлага хангасан хооллолт”-той байна гэж үнэлдэг бөгөөд 2024 оны байдлаар уг үзүүлэлт өмнөх судалгааны дүн (49.6%)-гээс нэмэгдээгүй байна. Түүнчлэн судалгааны өмнөх нэг хоногт зохистой байдлаар хооллосон хүүхдийн хувь 2017 оны судалгааны дүн (43.8%)-гээс 13.4 пунктээр буурсан байгааг цаашид анхаарч эрүүл зохистой хооллолтын талаарх сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Хоёр хүртэлх насны хүүхдийн дунд цус багадалт, төмөр, А аминдэм дутал хамгийн өндөр тархалттай байгаа нь тэдэнд нэмэгдэл хоол өгч эхлэхээс өмнө, бага насны хүүхдэд нэн шаардлагатай шимт бодисоор бүрэн хангах боломжтой “эхийн сүүгээр хооллох дадал”-ыг хэвшүүлэх зайлшгүй хэрэгцээ тулгамдаж буйг илтгэх үзүүлэлт юм. Хүүхдийг төрөнгүүт нэн даруй ангир уургаар амлуулах, эхийн сүүгээр дагнан хооллох дадал хангалтгүй байна. Нярай хүүхдийн 25 хувь төрснөөс хойш 1 цагийн дотор ангир уургаа амлаагүй, 6 сар хүртэлх насны хүүхдийн 40 гаруй хувь эхийн сүүгээр дагнан хооллодоггүй зэрэг шалтгааны улмаас эхийн сүүнд агуулагдах шимт бодисыг зохих хэмжээгээр авах, дархлаа дэмжих зэрэг эрүүл мэндийн олон ашиг тусыг хүүхэд бүр хүртэж чадахгүй байна. Нийт бүс нутаг, амьжиргааны аль ч түвшинд байгаа эхчүүдэд “нялх, бага насны хүүхдийн зохистой хооллолтын зөвлөмж”-ийг таниулах, эхийн сүүгээр хооллолтын дадлыг дэмжих, 2 хүртэлх насны хүүхдийг цаг хугацаанд нь зохистой нэмэгдэл хоолоор хооллох талаар зөвлөгөө өгөх, уг асуудлаарх эхчүүдийн ойлголт мэдлэгийг сайжруулах, мөн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн ажилтанд хооллолтын зөвлөгөө өгөх ур чадвар эзэмшүүлэх нь Монгол улсын нэн тэргүүнд хэрэгжүүлбэл зохих чухал үйл ажиллагаа бөгөөд бичил тэжээлийн дутлыг бууруулах үндсэн арга зам болно.

Зөвлөгөө өгөх, ойлголт мэдлэг олгох арга хэмжээг эрчимжүүлэх нь нялх, бага насны хүүхдийн хооллолтын дадлыг сайжруулах, улмаар тэдгээр хүүхдийн хоногийн хоол хүнсээр авах нэн шаардлагатай шимт бодисын хэмжээг нэмэгдүүлэх суурь ач холбогдолтой юм. Гэхдээ хооллох дадлыг өөрчлөхөд цаг хугацаа нэлээд шаарддаг бөгөөд бичил тэжээлийн бодисын байгалийн эх үүсвэр орон нутаг бүрт харилцан адилгүй, өрх бүрт тэгш хүртээмжтэй байх боломжгүй байгаа тул бага насны хүүхдийг зайлшгүй шаардлагатай өндөр эсвэл бага тунтай аминдэм, эрдэсийн бэлдмэлээр хангах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна. Хэдийгээр А аминдэмээр баялаг хүнсний олдоц хангалттай байгаа боловч, 6-59 сартай хүүхдийн дунд А аминдэм дутлын тархалт харьцангуй бага (7.1%) боловч Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас зөвлөсөн “А аминдэмийн бэлдмэлээр хангах” хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шалгуур болсон “5 хувь”-ийн босгыг давсан байв. Иймд ДЭМБ-ын зөвлөмжийн

дагуу, А аминдэмээр баялаг хүнсний хэрэглээг нэмэгдүүлэхийн зэрэгцээ, өндөр тунт А аминдэмийг 6-59 сартай хүүхдэд жилд 2 удаа нэмэлтээр олгох арга хэмжээг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна. А аминдэмтэй харьцуулахад, Монгол Улсад Д аминдэмээр баялаг хүнсний байгалийн эх үүсвэр тун хомс байдаг. Мөн Д аминдэмээр баяжуулсан хүнсний олдоц хангалтгүй байгаагийн зэрэгцээ, нарны туяаны нөлөөгөөр Д аминдэмийг нийлэгжүүлэх боломж хязгаарлагдмал байдаг тул жилийн ихэнхи хугацаанд Д аминдэмийн дуталд өртөх үндсэн нөхцөл бүрдэж байна. Иймд бусад эх үүсвэрээс авах (жич: Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл) Д аминдэмийг бүх хүүхдэд хүртээмжтэй болох хүртэл нялх, бага насны хүүхдийг Д аминдэмийн бэлдмэлээр хангах шаардлагатай байна.

Манай улс бага насны хүүхэд, хөхүүл хүүхэдтэй эх, жирэмсэн эмэгтэйчүүдийг А, Д аминдэм, олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл (ОНБТБ)-ээр хангах арга хэмжээг 2000 оноос Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн дэмжлэгээр хэрэгжүүлж ирсэн. Сүүлийн жилүүдэд олон улсын байгууллагын техникийн дэмжлэг хязгаарлагдаж, засгийн газрын санхүүжилт дутмаг байгаа тул хүүхэд, эмэгтэйчүүдийн ОНБТБ, Д аминдэмийн хангамж тасарсан болно. Эрүүл мэндийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 490 тоот тушаалаар хүүхэд, эмэгтэйчүүдийг аминдэм, эрдсийн бэлдмэл (өндөр тунт А аминдэм, ОНБТБ)-ээр хангах зааврыг шинэчлэн баталсан. Энэхүү тушаал нь хүүхэд, эмэгтэйчүүдийг бичил тэжээлийн дутлаас сэргийлэх, тархалтыг бууруулах хэрэгцээ шаардлагад тулгуурласан болно. Мөн Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 254 / А-562 тоот хамтарсан тушаалаар бичил тэжээлийн бэлдмэлийг худалдан авах зардлыг эрүүл мэндийн анхан шатны байгууллагын нэг иргэнээр тооцсон суурь төсөвт суулгаж, гүйцэтгэлийн шалгуурт ОНБТБ-ээр хангасан хүүхэд, эмэгтэйчүүдийн тоог тусгасан. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нэг иргэнээр тооцсон суурь төсвийг 2021, 2022 онд удаа дараа нэмэгдүүлсэн хэдий ч, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэж буй хоол тэжээлийн суурь тусламж үйлчилгээний чанар, хүртээмж туйлын хангалтгүй байна. Иймээс дээрх тушаал шийдвэрийн хэрэгжилтэд тавих үндэсний болон орон нутгийн хяналт үнэлгээг тогтмолжуулах, ОНБТБ-ийг нийгэмд таниулахын тулд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн боловсролыг дээшлүүлэх, ОНБТБ-ийг өдөр бүр тогтмол хэрэглэх талаар олон нийтийн ойлголтыг сайжруулах мэдээлэл харилцааг эрчимтэй өрнүүлэх, уг бэлдмэлийн гаж нөлөөний талаарх эхчүүдийн буруу ташаа ойлголтыг арилгах чиглэлээр өргөн цар хүрээтэй ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Жирэмсэн эмэгтэйд зориулсан аминдэм, эрдэсийн бэлдмэлийн эрэлт хэрэгцээ өндөр байдаг тул эмэгтэйчүүд өөрсдөө эмийн сангаас худалдан авч хэрэглэж байв. Монгол улсын бараг бүх жирэмсэн эмэгтэйчүүд жирэмсэн үеийн эрүүл мэндийн тусламж (ЖҮЭМТ), хяналтад хамрагдаж

чаддаг тул тэднийг ОНБТБ-ээр хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүрэн боломжтой бөгөөд төмөр, иод, Д аминдэм болон бусад бичил тэжээлийн дутлыг үр дүнтэй бууруулах боломжтой юм. Гэхдээ жирэмсний бүхий л хугацаанд аминдэм, эрдэсийн бэлдмэлийг тогтмол хэрэглэх зааврыг баримталдаггүй, хангамж, хүртээмж тааруу байдаг зэрэг бэрхшээл нь жирэмсэн эмэгтэйчүүдийг ОНБТБ-ээр хангах арга хэмжээ зохих үр дүнд хүрэхгүй байгаа гол шалтгаан болж байна. ЖҮЭМТ-ийн хүрээнд жирэмсэн эмэгтэйчүүдийг ОНБТБ-ээр тэгш, хүртээмжтэй хангах нь Монгол улсад нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ мөн бөгөөд нэмэлтээр түгээж буй бэлдмэлийн зохистой хэрэглээ, гаж нөлөөний талаарх заавар, зөвлөмжөөр тогтмол хангах үйл ажиллагаатай нягт уялдуулан хэрэгжүүлснээр уг арга хэмжээний үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлж чадна. Жирэмсний хяналтын явцад ОНБТБ-ийг түгээхийн зэрэгцээ эмийн сангаар худалдаалж буй болон Засгийн Газрын хөтөлбөрийн хүрээнд үнэ төлбөргүй түгээж байгаа аминдэм, эрдэсийн нэмэлт бэлдмэлд агуулагдах төмөр, фолийн хүчил, Д аминдэм, иод зэрэг бичил тэжээлийн хэмжээг албан журмаар баталсан үндэсний түвшинд баримтлах зөвлөмжийг мөрдөх шаардлагатай юм. ОНБТБ-д агуулагдах аминдэм, эрдэс бодисын талаар хувийн эмнэлгийн эмч, эх барих, эмэгтэйчүүдийн эмч, төрөхийн өмнөх эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэгч бүх этгээд, олон нийтэд сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, мөн жирэмсний үеийн иодын зохистой хэрэглээний талаар жирэмсэн эхчүүдийн ойлголт мэдлэгийг сайжруулах асуудал тулгамдаж байна.

Эмэгтэйчүүдийг жирэмслэхээс өмнө төмөр, фолийн хүчлийн дутлаас сэргийлэх, тэдний дунд тархалтыг бууруулах нэмэлт арга хэмжээ болгон буудайн гурилыг төмөр, фолийн хүчил болон бусад төрлийн бичил тэжээлийн бэлдмэлээр баяжуулж болно. Манай улс хүүхэд, эмэгтэйчүүдийн дундах төмөр, фолийн хүчлийн дутлыг бууруулах, ургын мэдрэлийн сувгийн гажиг үүсэхээс сэргийлэх, жирэмслэхээс өмнө эхийн бие дэх төмрийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор төмөр, фолийн хүчлээр баяжуулсан буудайн гурилыг хязгаарлагдмал хэмжээгээр үйлдвэрлэж байсан туршлагатай. Хүнс баяжуулж, бичил тэжээлийн дутлаас сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэхийн тулд дотоодын үйлдвэрийн болон импортын буудайн гурилыг баяжуулах асуудлыг хуульчлан, албан журмын зохицуулалт бий болгосон. Монгол Улсын ихэнх өрх буудайн гурилыг өдөр тутам хэрэглэдэг тул хүнс үйлдвэрлэгчдийг (жиш: талх, нарийн боов үйлдвэрлэгчид) зөвхөн баяжуулсан гурил хэрэглэхийг албан журмаар зохицуулах замаар хүн амын баяжуулсан бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх нь эрэгтэйчүүдэд төмрийн илүүдлийн эрсдэл учруулахгүйгээр төрөх насны эмэгтэйчүүдийн төмөр, фолийн хүчлийн хэрэглээг дэмжих, ургын тархи, мэдрэлийн гаж хөгжлөөс сэргийлэх ач холбогдолтой юм.

Нийт хүн амын дунд иодоор баялаг хүнсний хангамж, хэрэглээ тааруу байгаа тул хүнсний давсыг иоджуулж, иод дуталтай тэмцэх төлөвлөгөөг одоогийн нөхцөл байдалдаа тохируулан,

холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна. Өнөөгийн байдлаар 5 хүртлэх насны хүүхэдтэй нийт өрхийн 42.2% огт иоджуулаагүй давс хэрэглэж байгаа нь тэднийг иод дуталд өртөх эрсдэлд хүргэж байна. Иоджуулаагүй хямд давс хамгийн элбэг байдаг Баруун, Хангайн бүсэд иоджуулсан давсны хэрэглээ нилээд доогуур байгаа нь эдгээр бүсэд онцгой анхаарал хандуулах, “Баяжуулсан хүнсний тухай” хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатайг илтгэж байв. Монгол хүний иодын хэрэглээг зохистой түвшинд хүргэхийн тулд иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн хувийг нэмэгдүүлэх арга хэмжээг, хүн амын давсны хоногийн дундаж хэрэглээг бууруулах чиглэлээр одоо хэрэгжүүлж буй бодлого, шийдвэртэй нягт уялдуулан зохион байгуулах нь зүйтэй юм.

### **Илүүдэл жин ба таргалалтын тархалт**

Монгол Улсын нийт бүс нутгийн түвшинд илүүдэл жин ба таргалалтын тархалт насанд хүрэгчид болон хүүхдийн дунд өсөн нэмэгдсээр, нийгмийн эрүүл мэндэд тулгарч буй хамгийн том асуудал болсон хэвээр байна. Илүүдэл жин ба таргалалтаас сэргийлэх асуудал хүний амьдралын бүхий л хугацаанд буюу жирэмсэн үе, нярай, бага нас, өсвөр үе, насанд хүрсний дараа ч хувь хүний хоол тэжээлийн байдалд байнга анхаарал хандуулахыг шаарддаг, бүхэл бүтэн цогц арга хэмжээ байдаг. Монгол Улсад тулгарч буй хамгийн ноцтой асуудлын нэг бол хүүхдүүд илүүдэл жинтэй болоод зогсохгүй таргалалт руу шилжих үйл явц түгээмэл ажиглагдах болсон явдал юм. Иймд хоол хүнсний нэр төрөл, хэрэглээг өөрчлөх, идэвхтэй хөдөлгөөнийг нэмэгдүүлэх замаар хүүхдийн дундах илүүдэл жингийн тархалтыг бууруулах, цаашид жин нэмэх, насанд хүрсэн хойноо илүүдэл жин ба таргалалттай холбоотой архаг өвчлөлд өртөх эрсдэлээс сэргийлэх асуудал тулгамдаж байна. Хэрэв энэхүү буруу дадал, хандлагыг өөрчлөхгүй бол илүүдэл жин ба таргалалт нь улс орны эрүүл мэндийн зардлыг нэмэгдүүлэх, ажлын бүтээмжийг бууруулах гол шалтгаан болж болзошгүй байна.

ДЭМБ-ын “Хүүхдийн таргалалтаас ангижрах” зөвлөмжид тусгасан “хэт таргалалтаас сэргийлэх” арга хэмжээг манай улс бэлэн загвар болгон ашиглах боломжтой юм. Хүүхдэд эрүүл хооллолт, идэвхтэй хөдөлгөөний ач холбогдолын талаар зохих мэдлэг олгох, сургуулийн орчинд түргэн хоол худалдаалахыг хориглох замаар эрүүл бус хоол хүнс, зуушны хэрэглээг бууруулах, идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамираар хичээллэх таатай орчин бүрдүүлэх зэрэг олон төрлийн давуу тал, боломжийг харгалзан ерөнхий боловсролын сургуульд анхаарал хандуулахыг зөвлөсөн байдаг. Чихэр, өөх тосны агууламж өндөртэй хоол хүнснийг зах зээлд борлуулах, сурталчлах үйл ажиллагаанд албан журмын хязгаарлалт тавих зэрэг олон нийтэд түшиглэсэн арга хэрэгслийг ашиглан хүүхдийг эдгээр төрлийн эрүүл бус хоол хүнсэнд татагдах, хэт дурлах хандлагыг бууруулах боломжтой юм. Түүнчлэн чихэр, өөх тосны агууламж өндөртэй хүнсний

татварыг нэмэгдүүлэх чиглэлээр бодлого боловсруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, зарим төрлийн эрүүл бус хүнсний хүртээмжийг тодорхой хэмжээгээр хязгаарлах нь эрүүл бус хоол, хүнсний хэрэглээг бууруулах стратегийн нэг бүрэлдэхүүн хэсэг болгох боломжтой байна. Түүнчлэн хүүхдийн илүүдэл жин ба таргалалтыг бууруулахад эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлэх, гэр бүлд тулгуурласан эрүүл хооллолт, идэвхтэй хөдөлгөөн, биеийн жингээ тогтмол хянах, хэвийн хэмжээнд барих арга хэрэгслийг ашиглах нь зүйтэй болно. Үүний зэрэгцээ, хооллолтын болон хөдөлгөөний буруу дадлыг өөрчлөх чиглэлээр олон нийтэд зориулсан мэдээлэл харилцааг эрчимжүүлэх шаардлага тулгамдаж байна.

### **Ядуурлыг бууруулах стратеги нь Монгол Улсад хоол тэжээлээс хамааралт эмгэгийг бууруулах арга хэмжээний салшгүй хэсэг мөн**

Монгол улсад илүүдэл жин, таргалалтын тархалт өндөр байгаа хэдий ч, хүнсний баталгаат байдал (ХББ) алдагдах үзэгдэл улс орныг хамарсан асуудал хэвээр байна. Хүн бүр аюулгүй, шим тэжээллэг хоол хүнсээр хангагдах эрхтэй бөгөөд идэвхтэй амьдрахад шаардлагатай, хэрэгцээт хоол хүнс хангалттай хэмжээтэй, бэлэн байх нөхцөл бүрдсэн үед “хүнсний баталгаат байдал” хангагдсан гэж үздэг. Хүнсний баталгаат байдал (ХББ)-д нийгэм, улс төрийн хямрал, дайн дажин, байгалийн гамшиг (ган, зуд), эдийн засгийн хямрал, хүнсний үнийн өсөлт зэрэг гадаад, дотоод олон хүчин зүйл нөлөөлдөг. Илчлэг, шим тэжээллэг, олон нэр төрлийн хоол хүнсний хүртээмж хангалтгүй байхыг “хүнсний баталгаат байдлын алдагдал” (ХББА) гэж тооцдог. ХББА нь хоол тэжээлийн дутлын эмгэгүүд үүсэх шалтгаан, нөхцөл болдог. Сүүлийн жилүүдэд дэлхийн олон улс орнууд хувь хүн, өрхийн түвшинд хүнсний аюулгүй байдлыг хянах зорилгоор тохиолдолд суурилсан хүнсний баталгаат бус байдлын хэмжүүр (FIES)-ийг ашиглан ТХЗ-ын 2.1.2 шалгуур үзүүлэлтийг тооцох, үр дүнг улс орны хүнсний аюулгүй байдлын бодлогод тусган ажиллаж байна. НҮБ-ын ХХААБ хүнсний баталгаат байдлын дунд болон хүнд хэлбэрийн алдагдалд өртсөн хүн амын тархалт (FIES)-ыг 8 багц асуултын тусламжтайгаар өрхөд суурилсан судалгаанд тусгахыг 2020 онд дэлхийн улс орнуудад зөвлөсөн байдаг. Иймд энэхүү судалгааны өрхийн асуулгад эдгээр 8 асуултыг оруулж, 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн хүнсний баталгаат байдлыг Үндэсний сататистикийн хорооны даргын 2023 оны А/165 тушаалаар батлагдсан “Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал” -д заасан түвшнээр ангилан үнэлсэн. Тав хүртэлх насны хүүхэдтэй нийт өрхийн 75.2% ХББ хангагдсан эсвэл хөнгөн зэргийн алдагдалтай, 18.9% ХББ дунд зэрэг алдагдсан, 2.7% ХББ хүнд буюу ноцтой алдагдсан байгааг энэхүү судалгаагаар тогтоосон. Хүн амын хоол тэжээл, өрхийн ХББ-ын үзүүлэлтүүд бүс нутгийн түвшинд ихээхэн ялгаатай байгааг судалгаагаар тогтоосон бөгөөд хамгийн муу үзүүлэлт Хангай, Баруун бүс, Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхөд илэрсэн болно. Хүнсний хомсдолын үед эмзэг бүлгийн өрхийн өртөмтгий байдлыг бууруулахад

ээрэг нөлөө үзүүлдэг болох нь нэгэнт батлагдсан, нийгмийн эмзэг давхаргад чиглэсэн ХББ, хоол тэжээлийн асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий нийгмийн хамгааллын хөтөлбөрийг (жиш: хүнсний талон) цаашид шинэчлэн сайжруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, ялангуяа 5 хүртэлх насны хүүхэдтэй ядуу өрхийг хамруулахад онцгой анхаарах шаардлагатай байна. Монгол улсад элбэг тохиолддог улирлын чанартай хүнсний хомсдол, байгалийн гамшигт үзэгдлийн үед эмзэг бүлгийн хүн амыг хамгаалахад энэ төрлийн нийгмийн хамгааллын арга хэрэгслийг ашиглах нь зүйлтэй болно.

Монгол улсын хүн амын дунд түгээмэл тохиолдож буй хоол тэжээлээс хамааралт эмгэгээс ангижрах, тархалтыг бууруулахад хоол хүнсний хэрэглээнд тулгуурласан арга хэрэгслийг ашиглах нь үр дүнтэй боловч, жирэмсэн эмэгтэйчүүд болон бага насны хүүхдийн дундах цус багадалтын бараг тал хувь нь архаг үрэвсэлтэй холбоотой байгааг анхаарах шаардлагатай байна. Ундны усны сайжруулсан эх үүсвэр, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлж, халдварын тархалтыг бууруулах замаар архаг үрэвслийг багасгах, ялангуяа хөдөө орон нутаг, гэр хороололд эдгээр байгууламжийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээг хоол тэжээлийн талаар баримтлах үндэсний цогц стратегийн салшгүй нэг хэсэг болгох шаардлагатай байна. Хөдөөгийн хүн амын 12 орчим хувь аюлгүйн шаардлага хангаагүй усны эх үүсвэр ашигладаг, сайжруулсан ариун цэврийн байгууламж байдаггүй зэрэг нь хүүхдийн хоол тэжээлийн дуталтай шууд хамааралтай шалгуур үзүүлэлт юм. Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөр, арга хэмжээ нь Монгол Улсад хоол тэжээлээс хамааралт эмгэгийн давхар дарамтыг бууруулах хоол тэжээлийн мэдрэмжтэй цогц арга хэмжээний салшгүй нэг хэсэг байвал зохино.



1. FAO, *Current Usage of Terminology. Paragraph 17. Food Security*, in *Committee on World Food Security*. 2012: Rome, Italy.
2. FAO, I., UNICEF, WFP, WHO, *Repurposing food and agricultural policies to make healthy diets more affordable*. The State of Food Security and Nutrition in the World (SOFI). 2022, Rome, Italy: FAO, IFAD, UNICEF, WFP, WHO.
3. Economic Research Service (2021), U.S.D.o.A. *Ranges of food security and food insecurity*. 2021 [cited 2021 22 Dec]; Available from: <https://www.ers.usda.gov/topics/food-nutrition-assistance/food-security-in-the-u-s/definitions-of-food-security/#ranges>.
4. Baquedano, F.G.Z., Yacob Abrehe & Valdes, Constanza & Ajewole, Kayode, *International Food Security Assessment 2021-31*. p. Food Security Assessment Situation and Outlook No. (GFA-32) 98 pp.
5. Institute for Health Metrics and Evaluation, *Mongolia Country Profile 2021*. <http://www.healthdata.org/mongolia>.
6. Монгол Улс, “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай” хууль, <https://legalinfo.mn/mn/detail/14523>.
7. Монгол Улс, “Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай” хууль, <https://legalinfo.mn/mn/detail/12654>.
8. FAO. 2021, *Minimum dietary diversity for women (MDD-W)*. Rome. <https://doi.org/10.4060/cb3434en>.
9. Монгол Улсын Их Хурал, 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын хүрээнд 2021-2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа. ([legalinfo.mn](https://legalinfo.mn)).
10. Үндэсний Статистикийн хороо, *Хүн амын хүнсний баталгаат байдлын алдагдал. Судалгааны урьдчилсан тайлан*. 2022: УБ.
11. НҮБ-ын ХХААБ, “Өрхийн хэрэглээ, зардлын судалгааг ашиглан хоол, хүнсний мэдээллийг цуглуулах аргачлал” Бага, дунд орлоготой улс, орнуудад зориулсан гарын авлага. .
12. Үндэсний статистикийн хороо, *Монгол Улсад оршин суугаа хүн амын тоо, насны бүлэг, баг/хороогоор*, 2023. <https://www.1212.mn>.
13. Global Diet Quality Project, *Diet quality questionnaire (DQQ)*, in *Indicator guide, version 11, updated Nov 2023*. 2023.
14. Монгол Улс, “Хүнсний тухай” хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=8912>.
15. ЭМЯ, CDC, ДЭМБ, МСС, НЭМҮТ, “ЕБС-ийн сурагчдын эрүүл мэндийн зан үйл” Дэлхий дахины сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгаа, 2013. Монгол Улс, Улаанбаатар хот, 2014 он. : ЭМЯ, CDC, ДЭМБ, МСС, НЭМҮТ.
16. Erhardt J, E.J., Pfeiffer C, et al., *Combined measurement of ferritin, soluble transferrin receptor, retinol binding protein, and C-reactive protein by an inexpensive, sensitive, and simple sandwich enzyme-linked immunosorbent assay technique*. . J Nutr 2004; 134(11):3127–32. .
17. Thurnham DI, M.L., Haldar S, et al. , *Adjusting plasma ferritin concentrations to remove the effects of subclinical inflammation in the assessment of iron deficiency: a meta-analysis*. Am J Clin Nutr. 2010 92(3):546-55.
18. Thurnham, D., Northrop-Clewes CA, Knowles J, *The use of adjustment factors to address the impact of inflammation on Vitamin A and iron status in humans*. J Nutr 2015;145(5):1137S–1143S.
20. WHO, *Haemoglobin concentrations for the diagnosis of anaemia and assessment of severity*. Vitamin and Mineral Nutrition Information System. Geneva, World Health Organization, 2011 (<http://www.who.int/vmnis/indicators/haemoglobin.pdf>).
21. Shelor CP, D.P., *Review of analytical methods for the quantification of iodine in complex matrices*. Analytica Chimica Acta, 2011;702(1):16-36.

22. WHO, *Assessment of iodine deficiency disorders and monitoring their elimination*. Geneva, World Health Organization, 2007, ([http://apps.who.int/iris/bitstream/10665/43781/1/9789241595827\\_eng.pdf](http://apps.who.int/iris/bitstream/10665/43781/1/9789241595827_eng.pdf)).
23. Centers for Disease Control and Prevention; World Health Organization; Nutrition International, U., *Micronutrient survey manual*. Geneva: World Health Organization; 2020. Licence: CC BY-NC-SA 3.0 IGO.
24. National Statistics Office, *Mongolia Social Indicator Sample Survey (MICS)*. 2013.
25. FAO, *Food insecurity experience scale Survey Module (FIES-SM)* <https://www.fao.org/in-action/voices-of-the-hungry/background/en/>.
26. Global Diet Quality Project 2022, *Measuring what the world eats: Insights from a new approach*. Geneva: GAIN; Boston, MA: Harvard T.H. Chan School of Public Health, Department of Global Health and Population. <https://doi.org/10.36072/dqq2022>
27. WHO, *Global school-based student health survey – Mongolia, 2010*.
28. WHO, *Infant and young child feeding: Model chapter for textbooks for medical students and allied health professionals: Indicators for assessing infant and young child feeding practices*. Geneva: World Health Organization, 2009. .
29. WHO Multicentre Growth Reference Study Group, *WHO Child Growth Standards: Length/height-for-age, weight-for-age, weight-for-length, weight-for-height and body mass index-for-age: Methods and development*. Geneva: World Health Organization, 2006.
30. WHO Multicentre Growth Reference Study Group, *WHO Growth Reference for 5-19 years*. Geneva: World Health Organization, 2007.
31. WHO, *Global database on body mass index*. Geneva: World Health Organization, 2000.
32. Global diet quality project 2023, *Diet quality questionnaire (DQQ)*. Indicator guide, version 11, updated Nov 2023.
33. Cook JD, Skikne BS, Baynes RD., *Serum transferrin receptor*. . Annu Rev Med 1993;44:63–74.
34. Thomas C, Thomas L, *Biochemical markers and hematologic indices in the diagnosis of functional iron deficiency*, Clin Chem 2002;48(7):1066-76.
35. ЭМЯ, НЭМҮТ, НҮБХС 2017, *Монгол улсын хүн амын хоол тэжээлийн байдал, үндэсний V судалгааны тайлан*. НЭМҮТ 2018 он.
36. FAO, *Food insecurity experience scale (FIES) survey module*. FAO 2022.
37. Үндэсний Статистикийн хороо, *Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал, 2023*. <https://www.1212.mn/mn/methodology/list/72197101>
38. WHO, *Assessment of iodine deficiency disorders and monitoring their elimination: a guide for programme managers*. – 3rd ed. 2007. [https://iris.who.int/bitstream/handle/10665/43781/9789241595827\\_eng.pdf](https://iris.who.int/bitstream/handle/10665/43781/9789241595827_eng.pdf).
39. Улс, М., *Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2013*. Монгол улсын Үндэсний Статистикийн хороо. Бит пресс ХХК;УБ:2014. .
40. Coates, Jennifer, Anne Swindale and Paula Bilinsky, *Household Food Insecurity Access Scale (HFIAS) for Measurement of Household Food Access: Indicator Guide (v. 3)*. 2007. Washington, D.C.: FHI 360/FANTA.
41. Үндэсний Статистикийн хороо, *Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтүүд 2022*
42. НЭМҮТ, ЭМЯ, ШУТС, УНТЭ, *Монгол орны хүн амын дундах бамбай булчирхайн өвчлөл, түүнд нөлөөлөх иод болон эрсдэлт хүчин зүйлийг судлах нь*. Улаанбаатар хот, 2022.
43. ДЭМБ, *Бага жинтэй төрсөн хүүхэд*. <https://www.who.int/data/nutrition/nlis/info/low-birth-weight>
44. WHO, *Malnutrition, Fact sheet*. updated 1 March, 2024, <https://www.who.int/news-room/fact-sheets/detail/malnutrition>.
45. ДЭМБ, *Төмрийн бэлдмэл нялх, бага насны хүүхдэд хэрэглэх зөвлөмж*. [https://iris.who.int/bitstream/handle/10665/204712/9789241549523\\_eng.pdf?sequence=1](https://iris.who.int/bitstream/handle/10665/204712/9789241549523_eng.pdf?sequence=1)

46. Sommer A, West KP Jr, *Vitamin A deficiency: health, survival, and vision*. New York, Oxford University Press, 1996. .
47. Yeste D, Carrascosa A, *Nutritional rickets in childhood: analysis of 62 cases*. Med Clin (Barc). 2003;121(1):23-7.
48. Kreiter SR, Schwartz RP, Kirkman HN, Jr., Charlton PA, Calikoglu AS, Davenport ML, *Nutritional rickets in African American breast-fed infants*. J Pediatr. 2000;137(2):153-7.
49. Shah M, Salhab N, Patterson D, Sieikaly M, *Nutritional rickets still afflict children in northern Texas*. Tex Med. 2000;96(6):64-8.
50. Binet A, Kooh SW, *Persistence of Vitamin D-deficiency rickets in Toronto in the 1990s*. Can J Public Health. 1996;87(4):227-30.
51. Haworth JC, Dilling LA, *Vitamin-D-deficient rickets in Manitoba, 1972-84*. CMAJ. 1986;134(3):237-41.
52. Beck-Nielsen S, Jacobsen B, Gram J, Brixen K, Jensen T, *Incidence and prevalence of nutritional and hereditary rickets in southern Denmark*. Eur J Endocrinol. 2008.
53. Cook JD, Flowers CH, Skikne BS, *The quantitative assessment of body iron*. Blood 2003; 101:3359–64.
54. Эрүүл мэндийн яам, Аминдэм, эрдсийн бэолдмэл хэрэглэх заавар. ЭМС-ын 2020.10.20, А/490 тоот тушаал.
55. ЭМХТ ба ДЭМБ, Эрүүл мэндийн үзүүлэлт – 2023. <http://hdc.gov.mn/media/files/2023%20uzuulelt.pdf>
56. Washington: Pan American Health Organization-World Health Organization, *Guiding principles for complementary feeding of the breastfed child*. 2003 ([https://www.who.int/nutrition/publications/guiding\\_principles\\_compfeeding\\_breastfed.pdf](https://www.who.int/nutrition/publications/guiding_principles_compfeeding_breastfed.pdf), accessed 31 August 2020).
57. World Health Organization, *Guiding principles for feeding non-breastfed children 6–24 months of age*. Geneva: World Health Organization; 2005.
58. WHO, *Indicators for Assessing Infant and Young Child Feeding Practices - Part 1 (Definitions)*. Geneva: World Health Organization; 2008. .
59. WHO, *Indicators for Assessing Infant and Young Child Feeding Practices - Part 1 (Measurement)*. Geneva: World Health Organization; 2010.
60. WHO, UNICEF, *Indicators for assessing infant and young child feeding practices: definitions and measurement methods*. Geneva: World Health Organization and the United Nations Children’s Fund (UNICEF), 2021. Licence: CC BY-NC-SA 3.0 IGO; <https://creativecommons.org/licenses/by-nc-sa/3.0/igo>.
61. ДЭМБ, *Нялх, бага насны хүүхдийн хооллолтын дэлхийн стратеги*. ДЭМБ: Женев, 2003.
62. WHO, *Healthy diet*. Updated 29 April 2020 <https://www.who.int/news-room/fact-sheets/detail/healthy-diet>
63. WHO, *Exclusive breastfeeding for optimal growth, development and health of infants*. Last updated: 9 August 2023, <https://www.who.int/tools/elena/interventions/exclusive-breastfeeding>.
64. WHO, *Guideline for complementary feeding of infants and young children 6–23 months of age*. Geneva: World Health Organization; 2023. Licence: CC BY-NC-SA 3.0 IGO.
65. de Onis M, Borghi E, Arimond M, Webb P, Croft T, Saha K et al, *Prevalence thresholds for wasting, overweight and stunting in children under 5 years*. Public Health Nutrition. 2018;1–5. doi:10.1017/S1368980018002434. .
66. UNICEF, WHO, World Bank Group, *Joint Child Malnutrition Estimates*. 2023 edition, <https://www.who.int/data/gho/data/themes/topics/joint-child-malnutrition-estimates-unicef-who-wb>
67. World Health Organization, Centers for Disease Control and Prevention, *Worldwide prevalence of anaemia 1993–2005*. WHO Global Database on Anaemia. Geneva: World Health Organization; 2008 (51).

68. WHO, *Nutritional anaemias: tools for effective prevention and control*. Geneva: World Health Organization; 2017.
69. WHO, *Haemoglobin concentrations for the diagnosis of anaemia and assessment of severity. Vitamin and Mineral Nutrition Information System*. Geneva, World Health Organization, 2011 WHO/NMH/NHD/MNM/11.1.  
(<http://www.who.int/vmnis/indicators/haemoglobin.pdf>, accessed Oct 15, 2024).
70. WHO, *Guideline on use of ferritin concentrations to assess iron status in individuals and populations*. Geneva: World Health Organization; 2020. Licence: CC BY-NC-SA 3.0 IGO.
71. WHO, *Serum transferrin receptor levels for the assessment of iron status and iron deficiency in populations. Vitamin and Mineral Nutrition Information System*. Geneva: World Health Organization; 2014 (WHO/NMH/NHD/MNM/14.6;  
[http://apps.who.int/iris/bitstream/10665/133707/1/WHO\\_NMH\\_NHD\\_EPG\\_14.6\\_eng.pdf?ua=1](http://apps.who.int/iris/bitstream/10665/133707/1/WHO_NMH_NHD_EPG_14.6_eng.pdf?ua=1)).
72. ХХААБ ба FHI 360, *Эмэгтэйчүүдийн хоногт хэрэглэвэл зохих хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хамгийн бага шаардлага, 2016: Хэмжих аргачлал*. Ром: ХХААБ.